

ҮНЭТ ЦААСНЫ IPO ТАНИЛЦУУЛГА

Үнэт цаас
Гаргагч:

ГОЛОМТ БАНК
Сайн сайхны санхүүжүүлэгч

Үндсэн
Андеррайтер:

InvesCore
КАПИТАЛ ҮЦК ХХК

Туслах
Андеррайтер:

Golomt Capital
Delivering diversity

ҮНЭТ ЦААС ГАРГАХ ҮЙЛ АЖИЛЛАГААНД ОРОЛЦСОН БАЙГУУЛЛАГУУД

Үндсэн андеррайтер



"ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК" ХХК

✉ info@icapital.mn

☎ + 976-7709 0077 - /2/

🌐 www.icapital.mn

Туслах андеррайтер



"ГОЛОМТ КАПИТАЛ ҮЦК" ХХК

✉ info@golomtcapital.com

☎ + 976-7012 1530

🌐 www.golomtcapital.com

Аудитын компани



"ПРАЙСУОТЕРХАУСКУПЕРС АУДИТ" ХХК

☎ + 976-7000 9089

🌐 www.pwc.com/mn/mn

Хуулийн фирм



"ӨМГӨӨЛЛИЙН САНХҮҮГИЙН ЗӨВЛӨХ" ХХК

✉ info@flc.com

☎ + 976-7000 6967

🌐 www.flc.mn

Үнэлгээний компани



"КЭЙ ПИ ЭМ ЖИ АУДИТ" ХХК

✉ mn-fm-info@kpmg.com

☎ + 976-7011 8101

🌐 www.kpmg.com/mn



ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГЫН МЭНДЧИЛГЭЭ

Та бүхэнд энэ өдрийн мэнд дэвшүүлье.

Монголын банкны салбарын ууган гишүүдийн нэг Голомт банк нээлттэй хувьцаат компани болох бодлогыг дэмжсээр ирсэн бөгөөд арилжааны банкууд олон нийтэд нээлттэй, хувьцаат компани болсноор банкны салбар бүхэлдээ ил тод, хүртээмжтэй болох, Монголын банк, санхүү болон хөрөнгийн зах зээлийн цаашдын өсөлт хөгжилд эерэгээр нөлөөлөх, дараагийн шинэ шатанд гаргах зэрэг томоохон алхмуудын эхлэл болно гэдэгт итгэлтэй байдаг.

Бид “Сайн сайхныг санхүүжүүлнэ” уриатайгаар улс эх орондоо хөгжил дэвшил авчрах, үйлдвэрлэл бүтээн байгуулалтыг өрнүүлэх, бизнес эрхлэгчдийг чадавхжуулах, хийж бүтээх чин сэтгэл, ёс зүйтэй, шилдэг бизнесүүдийг санхүүжүүлж, байгаль орчин, нийгэмд ээлтэй үйл ажиллагааг тасралтгүй дэмжин ажилласаар ирсэн. Энэхүү үзэл баримтлалдаа бат зогсож, дэлхийн 130 банкны хамтаар НҮБ-ын Байгаль орчны хөтөлбөрийн санхүүгийн санаачилгад нэгдэж, Монгол Улсаа төлөөлөн “Хариуцлагатай банкны зарчмууд”-ыг үндэслэгч, цор ганц банк болсноор уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг тогтвортой хөгжлийн зорилтуудыг үйл ажиллагаандаа тусган хэрэгжүүлж байна.

“Дэлхийн жишиг Монголын банк” болох Голомт банкны алсын хараа нь зөвхөн бизнесийн үйл ажиллагаагаар хязгаарлагдалгүй, засаглалын тогтолцоогоороо ч салбартаа тэргүүлэн зөв жишгийг нийгэмдээ үлгэрлэж, дэлхийн улс орнуудын шилдэг туршлагыг хэрэгжүүлэн үлгэр дуурайл үзүүлэх зорилт тавин ажилладаг. Тухайлбал, бид Монгол Улсад анх удаа “Дотоод аудитын мэргэжлийн практик олон улсын стандарт, ёс зүйн кодтой бүрэн нийцсэн” гэх үнэлгээг авсан нь Монголын банк, санхүү болон Дотоод аудитын салбарын хөгжлийн түүхэнд нэгэн шинэ хуудас эргүүлснийг онцлох нь зүйтэй. Эдгээр нь банкны сайн засаглал, тогтвортой, урт хугацааны хөгжлийн бодлого үр дүнгээ өгснийг, мөн гаргасан шийдвэр, хийсэн үйл бүхэн дэлхийн жишигт хүрэх зорилгод бүрэн нийцэж буйн илрэл юм.

Голомт банк дотоодын кредит картын зах зээлийн 33 хувь, алтны арилжааны 64 хувь, импортын аккредитивийн 40 хувь, гадаад баталгааны тоогоор 67 хувь болон Монгол Улсын банкны системийн 20 орчим хувийг дангаар бүрдүүлдэг нөлөө бүхий банкуудын нэгд зүй ёсоор тооцогддог. Бид үүсгэн байгуулагдсан цагаасаа анхны олон улсын төлбөрийн картын систем, Интернэт банк, Смарт банк, SocialPay дижитал хэтэвч зэргээр Монголын банкны салбар, дотоодын зах зээлд олон шинэ дэвшлүүдийг нэвтрүүлснээр анхдагч алдрын титмийг олонтаа хүртсэн. Дижиталчлалын эрин үед банкны бүтээгдэхүүн, үйлчилгээ хиймэл оюун ухаанд суурилан хурдацтайгаар хувьсан өөрчлөгдөж буйг бид соргогоор мэдэрч, бизнес стратеги төлөвлөгөөнийхөө дагуу энэ чиглэлд томоохон хөрөнгө оруулалтуудыг хийж, инноваци нэвтрүүлэлтээрээ салбартаа тэргүүлсээр байна. Бидний хичээл зүтгэлийг үнэлэн



дэлхийд нэр хүндтэй The Banker сэтгүүлээс “Монгол Улсын Шилдэг Банк”-аар долоо дахь удаагаа, мөн Global Finance сэтгүүлээс гурван жил дараалан “Монгол Улсын Шилдэг Дижитал Банк”-аар тус тус нэрлэсэн нь эрхэм харилцагч, түнш байгууллагууд, нийт ажилтнуудын харилцан итгэлцэл, хамтын ажиллагааны үр дүн билээ.

Өнгөрсөн хугацаанд хоёргүй сэтгэл, хувиршгүй итгэлээр үргэлж хамт байсан харилцагчдадаа талархал илэрхийлье. Цаашид ч хамтдаа эх орны хөгжил цэцэглэлтийн гол тулгуур нь байж, манлайлагч байр сууриа хадгалан урагшлахын сацуу эрхэмлэн мөрддөг үнэт зүйлсээ үйл бүхэндээ шингээн, тууштай ажиллах болно. Та бүхнийг сайн сайхан ирээдүйнхээ төлөө Голомт банканд хөрөнгө оруулан хамтын ажиллагаагаа улам бэхжүүлж, үр өгөөж хүртэхээс гадна эдийн засгийг хүчирхэгжүүлэх, өөрчлөлт шинэчлэлийн их үйлсэд гар бие оролцохыг урьж байна.



Хүндэтгэсэн,

Төлөөлөн Удирдах Зөвлөлийн Дарга

Чүлтэмийн Мөнхцэцэг



ГҮЙЦЭТГЭХ УДИРДЛАГЫН ХАРИУЦЛАГЫН МЭДЭГДЭЛ

Үнэт цаас гаргагч нь Санхүүгийн Зохицуулах Хорооны "Үнэт цаасны бүртгэлийн журам", Монголын Хөрөнгийн Биржийн "Үнэт цаасны бүртгэлийн журам" болон бусад холбогдох хууль тогтоомжийн хүрээнд Үнэт цаасыг олон нийтэд санал болгож бүртгүүлэх, хөрөнгө оруулагчдад танилцуулахтай холбогдсон шаардлагатай бүхий л баримт бичгийг үнэн зөвөөр бүрдүүлсэн болно.

Үнэт цаас гаргагч нь энэхүү үнэт цаасны танилцуулгад хавсаргасан аливаа мэдээ мэдээлэл, баримт материалыг үнэн зөвөөр холбогдох хууль тогтоомжийн дагуу бүрэн гүйцэд бүрдүүлсэн бөгөөд энэхүү танилцуулгад тусгагдсан мэдээлэл, баримт бичигтэй зөрчилдсөн эсхүл хуурамчаар бүрдүүлсэн ямарваа баримт бичиг байхгүй гэдгийг илэрхийлж энэхүү хариуцлагын мэдэгдлийг гарган баталгаажуулж байна.

Гүйцэтгэх захирал
Норихико Като





ГОЛОМТ БАНК
Сайн сайхны санхүүжүүлэгч

НЭГ.

ҮНЭТ
ЦААСНЫ
ТАНИЛЦУУЛГЫН
ХУРААНГУЙ



1.2 Үнэт цаас гаргагчийн тухай

Бидний тухай	Харилцагч төвтэй Голомт банк нь 1995 оны 3 сарын 6-ны өдөр 4 ажилтантайгаар үүсгэн байгуулагдсан бол өдгөө банкны салбарын нийт активын 20 орчим хувь, кредит картын зах зээлийн 33 хувийг дангаар эзэлдэг ба 100 гаруй салбар нэгж, 2,220 орчим шилдэг банкируудаараа дамжуулан эх орныхоо өнцөг булан бүрт хүрч, 900 мянга гаруй харилцагчдадаа дэлхийн жишиг үйлчилгээг хүргэж байна.																		
Алсын хараа, стратеги	Алсын хараа: Дэлхийн жишиг Монголын банк Эрхэм зорилго: Хөгжлийн Голомт Стратеги: Харилцагч төвтэй банк Уриа: Сайн сайхныг санхүүжүүлнэ																		
Хувьцаа эзэмшил	Нийт 59 хувьцаа эзэмшигчидтэй, хувь нийлүүлсэн хөрөнгө 179.0 тэрбум төгрөг байна.																		
Сайн засаглал	"Голомт банкны засаглалын кодекс" баталж, үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байгаа ба засаглалын иж бүрэн үнэлгээг ОУСК (IFC)-аар хийлгэж байсан ба сайн засаглалыг хэрэгжүүлсэн тэргүүлэгч банкуудын нэг билээ.																		
Зээлжих зэрэглэл	Арилжааны банкны зээлжих зэрэглэл нь тухайн банк гадаад санхүүгийн байгууллагуудаас эх үүсвэр бүрдүүлэх, хамтын ажиллагаа эхлүүлэхэд чухал үзүүлэлт болдог. Голомт банк нь олон улсын нэр хүндтэй гурван зэрэглэл тогтоогч байгууллагын хоёр байгууллагаар зээлжих зэрэглэлээ тогтоолгосон. Зээлжих зэрэглэл нь Монгол улсын засгийн газрын зээлжих зэрэглэлээр хязгаарлагдаж байгаа буюу одоогоор Монгол улсын аж ахуйн нэгжийн авч болох хамгийн дээд зэрэглэлтэй байна: <table border="1" data-bbox="568 1491 1409 1731"> <thead> <tr> <th>Ангилал</th> <th>"Moody's" үнэлгээ</th> <th>"S&P" үнэлгээ</th> </tr> </thead> <tbody> <tr> <td>Зээлжих зэрэглэлийн үнэлгээ</td> <td>B3</td> <td>B/Stable/B</td> </tr> <tr> <td>Төлөв</td> <td>Stable</td> <td>Stable</td> </tr> <tr> <td>Эрсдэлийн үнэлгээ - Гадаад валют</td> <td>B3/NP</td> <td>B</td> </tr> <tr> <td>Эрсдэлийн үнэлгээ - Дотоод валют</td> <td>B2/NP</td> <td>B+</td> </tr> <tr> <td>Зээлжих чадварын суурь үнэлгээ</td> <td>B3</td> <td></td> </tr> </tbody> </table>	Ангилал	"Moody's" үнэлгээ	"S&P" үнэлгээ	Зээлжих зэрэглэлийн үнэлгээ	B3	B/Stable/B	Төлөв	Stable	Stable	Эрсдэлийн үнэлгээ - Гадаад валют	B3/NP	B	Эрсдэлийн үнэлгээ - Дотоод валют	B2/NP	B+	Зээлжих чадварын суурь үнэлгээ	B3	
Ангилал	"Moody's" үнэлгээ	"S&P" үнэлгээ																	
Зээлжих зэрэглэлийн үнэлгээ	B3	B/Stable/B																	
Төлөв	Stable	Stable																	
Эрсдэлийн үнэлгээ - Гадаад валют	B3/NP	B																	
Эрсдэлийн үнэлгээ - Дотоод валют	B2/NP	B+																	
Зээлжих чадварын суурь үнэлгээ	B3																		



**Банкны үйл
ажиллагаа**

(2021 оны 12 сарын
31-ны байдлаарх)

Голомт банк нь байгуулагдсан цагаасаа хойш иргэд болон байгууллагад чиглэсэн банкны үйлчилгээг хослуульж ирсэн:

Байгууллагын бизнес

- Татан төвлөрүүлсэн эх үүсвэр – 2.3 их наяд төгрөг
- Зээлийн багц – 2.1 их наяд төгрөг
- Харилцагч байгууллагуудын тоо – 81,000+
- 15 брокерийн компанитай хамтран ажиллаж, дотоодын 1,338 гаруй, гадаадын томоохон 15 харилцагч, хөрөнгө оруулалтын 10 гаруй сан буюу зах зээлийн 60 гаруй хувьд кастодиан банкны үйлчилгээг үзүүлдэг.

Иргэдийн бизнес

- Татан төвлөрүүлсэн эх үүсвэр – 3.2 их наяд төгрөг
- Зээлийн багц – 1.3 их наяд төгрөг
- Харилцагчдын тоо – 860,000+
- Кредит картын зах зээлийн 33 хувийг бүрдүүлэгч, хамгийн олон брэндийн картуудыг нэвтрүүлэгч

Дижитал банкны бизнес

- Нийт гүйлгээний 97% нь дижитал сувгаар хийгдэж байна
- Нийт харилцагчдын 65% нь дижитал сувгаар банкны үйлчилгээг тогтмол авч байна
- Хиймэл оюун ухаанд суурилсан "Дижитал банк 5.0" шинэчлэгдсэн хувилбарыг нэвтрүүлж 120 гаруй үйлчилгээг харилцагчдадаа санал болгож байна
- SocialPay харилцагчдын тоо 290,000-т хүрсэн
- Анхны Виртуал картыг зах зээлд нэвтрүүлсэн ба 3 жилийн дотор 87,000 гаруй Виртуал карт хэрэглэгчидтэй болсон

Олон улсын бизнес

- Олон улсын нэр хүнд бүхий 142 банк, санхүүгийн байгууллагуудтай хамтын ажиллагааг бий болгосон
- Банкны салбарын гадаад гүйлгээний 21%-ийг гүйцэтгэсэн
- Томоохон санхүүгийн байгууллагуудаас нийт 600 гаруй сая ам.долларын дүнтэй, 1-ээс 8 жилийн хугацаатай шууд болон зорилтот зээлүүдийг татан төвлөрүүлсэн.

**Дижитал банкны
үйлчилгээгээр
тэргүүлэгч**


Олон улсын банк санхүүгийн Global Finance сэтгүүлээс Монгол Улсын Шилдэг Дижитал банкаар 2011 оноос хойш 7 удаа шалгарсан ба инновацлаг, олон улсын шилдэг туршлагыг нэвтрүүлсэн дижитал бүтээгдэхүүнүүдээрээ Монгол улсын банк санхүүгийн салбарын финтек дэвшлийг тодорхойлж байна.



Гадаад худалдааны санхүүжилтийн тэргүүлэгч

Монгол Улсын хэмжээнд импортын аккредитивын 40 хувь, гадаад баталгааны тоогоор зах зээлийн 67 хувийг дангаар гүйцэтгэсэн. Олон улсын банк санхүүгийн байгууллагуудын харилцаа, санхүүжилтийн нөхцөлөөр зах зээлийг тэргүүлж байна.

Гадаад баталгааны тоогоор банкны системд эзлэх хувь



Монгол Улсын экспортын гол нэрийн бүтээгдэхүүн болох нүүрсний экспортыг дэмжих үүднээс экспортын өмнөх санхүүжилтийг БНХАУ болон Сингапур улсын банкуудтай хамтран олгож байна.

Шилдэг байгууллагын банк

Үнэт цаас гаргагч нь байгууллагын зах зээлд санхүүгийн цогц шийдлийг агуулсан бүтээгдэхүүнийг санал болгодог шилдэг байгууллагын банк юм. 2021 оны жилийн эцсийн байдлаар Голомт банк нь 1.2 их наяд төгрөгийн эх үүсвэрийг корпорэйт байгууллагын харилцагчдаас бүрдүүлж, 1.2 их наяд төгрөгийн зээлийн багцын үлдэгдэлтэй байна.



Олон улсын банк санхүүгийн салбарт нэр хүнд бүхий сэтгүүл болох Global Banking & Finance Review-с Голомт банкыг Монгол улсын шилдэг байгууллагын банкаар тодруулсан.

Алт арилжаа

Голомт банк нь алтны арилжааны зах зээлд тэргүүлэгч банк юм. Тодруулбал, 2021 оны жилийн эцсийн байдлаар Монголбанканд тушаасан нийт алтны 64 хувийн төлбөр тооцоог дангаар гүйцэтгэсэн.

Тогтвортой санхүүжилтээр манлайлагч

Голомт банк нь анх 2017 онд UNEP FI-ийн банкны хороонд нэгдэж "Хариуцлагатай банкны зарчмууд"-ыг боловсруулах ажлын багт оролцон эдгээр зарчмуудыг үндэслэгч анхны 30 банкны нэг.




ТоС Холбооны 2021 оны Манлай байгууллага, 2020 оны “Онцлох Тос Банк” -аар байгаль орчин, нийгмийн эрсдэлийн удирдлага, ногоон зээл, ТоС-ийн сургалт хөгжил зэрэг ажлуудаараа манлайлан шалгарсан.

Ногоон зээл

2018 оны 3 дугаар улирлын байдлаар ногоон зээлийн багц нийт зээлийн багцын 2 хувийг эзэлж байсан бол 2019, 2020 онд 5 хувиар өссөн байна. 2021 оны жилийн эцсийн байдлаар Голомт банкны ногоон зээлийн багцын үлдэгдэл 97.8 тэрбум төгрөгт хүрсэн нь нийт багцын 3 хувийг эзэлж байна.

Ногоон зээлийн багц (тэрбум төг.)



1.3 Үнэт цаас гаргагчийн санхүүгийн гол үзүүлэлтүүд

Системийн нөлөө бүхий банк

Голомт банк нь бизнесийн сегментүүд дээрээ тогтвортой, тэнцвэртэй өсөлтийн бодлого баримталж ирсэн бөгөөд Монгол улсын банкны системийн нөлөө бүхий банк юм.

Банкны салбарын нийт зээлийн бүтэц



Банкны салбарын нийт харилцах, хадгаламжийн бүтэц



Банкны салбарын тогтвортой өсөлт

Топ-5 банкны хөрөнгийн өсөлт



Топ-5 банкны цэвэр зээлийн өсөлт



Санхүүгийн тогтвортой өсөлт

Үзүүлэлт	тэрбум төгрөг				
	2017	2018	2019	2020	2021
Бэлэн мөнгө, банкин дахь хөрөнгө	1,209.7	1,699.3	2,308.7	2,077.9	2,028.7
Хөрөнгө оруулалт	1,245.7	724.6	311.6	1,393.9	1,997.9
Харилцагчдад олгосон зээл ба урьдчилгаа	2,318.1	3,183.7	3,306.7	3,031.3	3,339.2
Бусад хөрөнгө	276.9	329.2	547.7	604.1	447.4
Үндсэн хөрөнгө, биет бус хөрөнгө	154.2	144.3	168.4	170.8	180.9
Нийт хөрөнгө	5,204.6	6,081.1	6,643.1	7,278.0	7,994.1



Харилцагчдын харилцах, хадгаламж	3,453.9	4,402.6	4,900.6	5,285.7	5,463.5
Банк, СБ-аас татсан эх үүсвэр	1,193.4	1,016.0	993.8	1,237.0	1,748.1
Бусад өр төлбөр	165.5	149.4	286.2	123.8	123.7
Нийт өр төлбөр	4,812.9	5,568.0	6,180.6	6,646.4	7,335.4
Дүрмийн сан ба НТК	98.7	235.7	193.0	350.4	354.5
Хуримтлагдсан ашиг	218.5	202.8	197.4	210.9	242.4
Өмчийн бусад хэсэг	74.4	74.5	72.1	70.3	61.7
Нийт эзэмшигчдийн өмч	391.7	513.1	462.5	631.6	658.7
Нийт өр төлбөр ба эзэмшигчдийн өмч	5,204.6	6,081.1	6,643.1	7,278.0	7,994.1

Ашигт ажиллагаа

Үзүүлэлт	2017	2018	2019	2020	2021
Хүүгийн болон бусад адилтгах орлого	409.2	494.0	577.9	570.1	554.8
Хүүгийн болон бусад адилтгах зардал	287.2	323.3	366.0	365.8	272.8
Хүүгийн цэвэр орлого	122.0	170.7	211.9	204.4	282.0
Цэвэр хүүгийн бус орлого	8.1	135.6	81.0	82.5	48.6
Үйл ажиллагааны орлого	130.1	306.3	292.9	286.9	330.5
Удирдлагын болон үйл ажиллагааны бусад зардал	85.6	110.1	122.0	121.0	137.1
Үйл ажиллагааны ашиг	44.5	196.2	170.9	165.9	193.4
Сангийн үнэлгээний зардал	36.4	94.0	146.0	143.4	140.8
Үндсэн хөрөнгийн үнэ цэнийн бууралтын гарз	20.2	26.6	-	-	-
Татварын өмнөх ашиг	(12.1)	75.6	24.9	22.5	52.6
Орлогын албан татварын зардал (кредит)	(6.9)	22.1	8.6	12.1	26.6
Тайлант жилийн ашиг	(5.2)	53.5	16.3	10.4	25.9

Зохистой харьцааны шалгуур үзүүлэлт

Монголбанкнаас тогтоосон зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүдийг тогтмол хангаж ирсэн ба системийн нөлөө бүхий банкны хувьд салбарын сайн жишиг болсоор ирсэн.

Зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүд	Байвал зохих	Голомт банк
Нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө болон эрсдэлээр жигнэсэн активын зохистой харьцаа	> 9%	15.0%
Өөрийн хөрөнгө болон эрсдэлээр жигнэсэн активын зохистой харьцаа	>12%	15.4%
Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын үзүүлэлт	>25%	41.1%
Гадаад валютын нээлттэй позиц болон өөрийн хөрөнгийн харьцаа (нэгж валютаар)	<±15%	10.0%
Гадаад валютын нээлттэй позиц болон өөрийн хөрөнгийн харьцаа (нийт)	<±30%	12.6%



1.4 Бизнес төлөвлөгөө, өгөөжийн төсөөлөл

Доорх санхүүгийн болон бизнесийн төсөөлөл нь Үнэт цаас гаргагчийн гаргасан таамаглалд суурилсан төсөөлөл ба уг төсөөлөлд аудитын болон аливаа гуравдагч байгууллага дүгнэлт гаргаагүй болохыг анхаарна уу.

Банкны бизнесийн өсөлт, эдийн засгийн өсөлт, мөн өөрийн хөрөнгө нэмэгдсэнтэй холбогдуулан зээл олголт идэвхэжсэнээр нийт хөрөнгөд эзлэх цэвэр зээлийн хувийг 40%-иас 49%-д хүргэхээр төлөвлөсөн.

тэрбум төг.

Зээлийн багцын өсөлтийн төсөөлөл



Орлогын төсөөлөл



Хөрөнгө оруулалтын өгөөж, ашигт ажиллагааны төсөөлөл

Цэвэр ашгийн өсөлтийн төсөөлөл




	2022T	2023T	2024T	2025T	2026T
Цэвэр хүүгийн ахиуц	4.1%	4.1%	4.3%	4.4%	4.3%
Цэвэр ашгийн ахиуц	10.4%	14.9%	16.4%	18.2%	19.1%
Зардал орлогын харьцаа	50.4%	46.0%	44.0%	42.2%	42.4%
Өөрийн хөрөнгийн өгөөж	11.5%	15.7%	17.0%	18.0%	18.0%
Нийт хөрөнгийн өгөөж	0.9%	1.3%	1.6%	1.8%	1.9%

Банкны ашгийг зохистой хэмжээнд хувьцаа эзэмшигчдэд шууд хуваарилах, нөгөө талаас банкны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүдийг ханган, байгууллагын ирээдүйн өсөлтийг бий болгох гэсэн хоёр үндсэн зорилтын тэнцвэртэй байдлыг хангахуйц ногдол ашиг хуваарилахаар төсөөлсөн.

тэрбум төгрөг

Ногдол ашгийн төсөөлөл

Ногдол ашгийн төсөөлөл



АГУУЛГА

1. ҮНЭТ ЦААСНЫ ТАНИЛЦУУЛГЫН ХУРААНГУЙ	8
1.1 Үнэт цаасны хураангуй танилцуулга	8
1.2 Үнэт цаас гаргагчийн тухай	9
1.3 Үнэт цаас гаргагчийн санхүүгийн гол үзүүлэлтүүд	13
1.4 Бизнес төлөвлөгөө, өгөөжийн төсөөлөл	15
ХҮСНЭГГИЙН ЖАГСААЛТ	19
СХЕМИЙН ЖАГСААЛТ	20
ГРАФИКИЙН ЖАГСААЛТ	21
ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ	25
2 ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ТУХАЙ	27
2.1 Үнэт цаас гаргагчийн товч танилцуулга	27
2.2 Үнэт цаас гаргагчийн хуулийн этгээдийн бүртгэл	28
2.3 Үнэт цаас гаргагчийн хаяг байршил	29
2.4 Үнэт цаас гаргагчийн хувьцаа эзэмшигчид, холбоотой этгээд	30
2.5 Үнэт цаас гаргагчийн засаглалын тогтолцоо	37
2.6 Үнэт цаас гаргагчийн бүтэц, зохион байгуулалт	51
2.7 Эрх бүхий албан тушаалтан, эзэмшиж буй хувьцааны тоо хэмжээ	64
2.8 Үнэт цаас гаргагчийн хэлцлүүд	65
3 ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТУХАЙ	72
3.1 Банкны үйл ажиллагаа, онцлог	72
3.2 Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаа, онцлог	76
3.3 Үнэт цаас гаргагчийн бүтээгдэхүүн үйлчилгээ	89
3.4 Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаа явуулж буй бизнесийн салбар	102
3.5 Үнэт цаас гаргагчийн хүний нөөцийн бодлого	113
3.6 Үнэт цаас гаргагчийн тогтвортой хөгжлийн бодлого	117
3.7 Үнэт цаас гаргагчийн нийгмийн хариуцлагын хүрээнд хэрэгжүүлсэн ажлууд	118
3.8 Эрсдэлийн удирдлага	125



3.9	Үнэт цаас гаргагчийн санхүүгийн шинжилгээ	140
4	ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ТУХАЙ	175
4.1	Монгол Улсын эдийн засгийн төлөв байдал	175
4.2	Монгол Улсын хөрөнгийн зах зээлийн төлөв байдал	175
4.3	Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаа явуулж буй зах зээл	200
4.4	Монгол Улсын банкны салбарын хэтийн төлөв, багтаамж	227
4.5	Дунд хугацааны стратеги, бизнес төлөвлөгөө	233
4.6	Санхүүгийн төсөөлөл	240
5	ҮНЭТ ЦААСНЫ ТУХАЙ	258
5.1	Нийтэд санал болгох үнэт цаасны тухай	258
5.2	Хувь нийлүүлсэн хөрөнгийн өөрчлөлт	259
5.3	Нийтэд санал болгох үнэ тогтоосон үндэслэл	259
5.4	Үнэт цаас гарган татан төвлөрүүлэх хөрөнгийн зарцуулалт	263
5.5	Үнэт цаасаар гэрчлэгдэх үүрэг	264
5.6	Ногдол ашгийн бодлогын төсөл	266
5.7	Анхдагч зах зээлд байршуулах төлөвлөгөө	269
5.8	Үнэ тогтворжуулах хөтөлбөр	273
5.9	Ажилтанд хувьцаа эзэмшүүлэх хөтөлбөр	274
6	ҮНЭТ ЦААС ГАРГАХ АЖИЛЛАГААНД ОРОЛЦСОН БАЙГУУЛЛАГУУД	278
6.1	Үндсэн андеррайтерийн танилцуулга, гэрээний тухай	278
6.2	Туслах андеррайтерийн танилцуулга, гэрээний тухай	281
6.3	Аудитын байгууллагын танилцуулга, гэрээний тухай	283
6.4	Хуулийн байгууллагын танилцуулга, гэрээний тухай	284
6.5	Үнэлгээний байгууллагын танилцуулга, гэрээний тухай	286
7	ХАВСРАЛТ	291



ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. Үнэт цаас гаргагчийн хуулийн этгээдийн бүртгэл.....	28
Хүснэгт 2. Үнэт цаас гаргагчийн хаяг, байршил.....	29
Хүснэгт 3. Хувьцааны бүтэц.....	30
Хүснэгт 4. Хувьцаа эзэмшигчдийн мэдээлэл.....	30
Хүснэгт 5. Хувьцаа эзэмшигчдийн бүтцийн төлөвлөгөө.....	32
Хүснэгт 6. Голомт Файнэншил Групп ХХК-ийн охин компаниуд.....	32
Хүснэгт 7. Монголмасс Медиа ХХК-ийн охин компаниуд /Д.Баясгалан - 100%/.....	33
Хүснэгт 8. Бодь Интернэшнл ХХК-ийн охин компаниуд /Д.Баясгалан - 77%/.....	34
Хүснэгт 9. Бодь Интернэшнл ХХК-ийн хараат компаниуд.....	35
Хүснэгт 10. Бодь Интернэшнл ХХК-ийн охин компанийн эзэмшлийн компаниуд ...	35
Хүснэгт 11. Бодь Интернэшнл ХХК-ийн хараат компанийн эзэмшлийн компаниуд	36
Хүснэгт 12. Бодь Интернэшнл ХХК-ийн бусад холбоотой тал.....	36
Хүснэгт 13. ТУЗ-ийн хороодын бүрэлдэхүүн.....	49
Хүснэгт 14. Эрх бүхий албан тушаалтны мэдээлэл.....	64
Хүснэгт 15. ХНХ-ийн тав болон түүнээс дээш хувьтай тэнцэх хэмжээний хэлцлийн мэдээлэл.....	66
Хүснэгт 16. Зээлжих зэрэглэлийн үнэлгээ.....	76
Хүснэгт 17. Үнэт цаас гаргагчийн санхүүгийн байдлын тайлан /тэрбум төгрөг/ ...	140
Хүснэгт 18. Үнэт цаас гаргагчийн орлогын тайлан /тэрбум төгрөг/.....	142
Хүснэгт 19. Үнэт цаас гаргагчийн мөнгөн гүйлгээний тайлан /тэрбум төгрөг/.....	144
Хүснэгт 20. Үнэт цаас гаргагчийн өмчийн өөрчлөлтийн тайлан 2018-2019 /тэрбум төгрөг/.....	148
Хүснэгт 21. Үнэт цаас гаргагчийн өмчийн өөрчлөлтийн тайлан 2020-2021 /тэрбум төгрөг/.....	149
Хүснэгт 22. Үнэт цаас гаргагчийн санхүүгийн байдлын тайлан /тэрбум төгрөг/ ...	150
Хүснэгт 23. Үнэт цаас гаргагчийн хураангуй орлогын тайлан /тэрбум төгрөг/.....	150
Хүснэгт 24. Үнэт цаас гаргагчийн хураангуй мөнгөн гүйлгээний тайлан /тэрбум төгрөг/.....	151
Хүснэгт 25. Зохистой харьцаан үзүүлэлт.....	171
Хүснэгт 26. Бодит ДНБ-ний өсөлтийн төсөөлөл, хувиар.....	179
Хүснэгт 27. Инфляцын төсөөлөл, хувиар.....	180
Хүснэгт 28. Монгол Улсын гадаад зах зээлд арилжаалагдаж буй Засгийн газрын бондууд.....	187
Хүснэгт 29. Гол түүхий эдийн экспортолсон хэмжээ.....	190
Хүснэгт 30. Макро эдийн засгийн таамаглал.....	194
Хүснэгт 31. Хөрөнгийн зах зээлийн голлох үзүүлэлтүүд.....	194
Хүснэгт 32. Санхүүгийн салбарын нийт хөрөнгө, тэдгээрийн эзлэх хувь /тэрбум төгрөг/.....	203



Хүснэгт 33. Банкны салбарын голлох үзүүлэлтүүд.....	205
Хүснэгт 34. Зээлийн үлдэгдэл, чанарын ангиллаар.....	207
Хүснэгт 35. Ипотекийн зээлийн үзүүлэлт.....	218
Хүснэгт 36. Зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүд.....	226
Хүснэгт 37. Банкны салбарын голлох үзүүлэлтүүдийн таамаглал /тэрбум төгрөг/	231
Хүснэгт 38. Үнэт цаас гаргагчийн санхүүгийн байдлын тайлангийн төсөөлөл 2022- 2026 /тэрбум төгрөг/.....	240
Хүснэгт 39. Үнэт цаас гаргагчийн зээлийн багцын өсөлт 2022-2026.....	242
Хүснэгт 40. Үнэт цаас гаргагчийн харилцах, хадгаламжийн өсөлт.....	246
Хүснэгт 41. Үнэт цаас гаргагчийн орлогын тайлангийн төсөөлөл 2022-2026 /тэрбум төгрөг/.....	247
Хүснэгт 42. Эрсдэлийн сангийн зардлын төсөөлөл /тэрбум төгрөг/.....	252
Хүснэгт 43. Үнэт цаас гаргагчийн харьцаан үзүүлэлт 2022-2026.....	254
Хүснэгт 44. Үнэт цаас гаргагчийн зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүд 2022- 2026.....	255
Хүснэгт 45. Үнэт цаасны мэдээлэл.....	258
Хүснэгт 46. Үнэт цаас гаргагчийн хувьцаа эзэмшигчдийн бүтэц.....	259
Хүснэгт 47. Хөндлөнгийн үнэлгээний Үнэлгээний үр дүн.....	263
Хүснэгт 48. Зээл олголтын төлөвлөгөө.....	264
Хүснэгт 49. Үнэт цаас гаргагчийн хувьцааг үнэ тогтворжуулах хөтөлбөрийг хэрэгжүүлэх нөхцөл.....	273
Хүснэгт 50. Үнэт цаас гаргагчийн хувьцаа нэмж гарган ажилтнууддаа опцион хэлбэрээр эзэмшүүлэх нөхцөл.....	275
Хүснэгт 51. Үндсэн андеррайтерийн товч танилцуулга.....	278
Хүснэгт 52. Туслах андеррайтерийн товч танилцуулга.....	281
Хүснэгт 53. Аудитын байгууллагын товч танилцуулга.....	283
Хүснэгт 54. Хуулийн компанийн товч танилцуулга.....	284
Хүснэгт 55. Үнэлгээний байгууллагын товч мэдээлэл.....	286

СХЕМИЙН ЖАГСААЛТ

Схем 1. Хувьцаа эзэмшигчдийн бүтэц.....	31
Схем 2. Үнэт цаас гаргагчийн засаглалын тогтолцоо.....	38
Схем 3. Үнэт цаас гаргагчийн бүтэц зохион байгуулалт.....	51
Схем 4. Үнэт цаас гаргагчийн түүхэн товчоон.....	73
Схем 5. Дижитал банкны онцлох үзүүлэлтүүд.....	85
Схем 6. Үнэт цаас гаргагчийн эрсдэлийн удирдлагын тогтолцоо.....	127



Схем 7. Эрсдэлийн удирдлагын үйл явц	128
Схем 8. Анхдагч зах зээлийн арилжааны төлөвлөгөө	269
Схем 9. Үнэт цааны анхдагч зах зээлийн арилжаанд оролцох заавар	272

ГРАФИКИЙН ЖАГСААЛТ

График 1. Зээлийн бүтэц /тэрбум төгрөг/	89
График 2. Бизнесийн зээлийн багцын үлдэгдэл /тэрбум төгрөг/	90
График 3. Төслийн зээлийн багцын үлдэгдэл /тэрбум төгрөг/	91
График 4. Хэрэглээний зээлийн багцын үлдэгдэл /тэрбум төгрөг/	92
График 5. Орон сууцны зээлийн багцын үлдэгдэл /тэрбум төгрөг/	93
График 6. Гадаад баталгааны тоогоор банкны системд эзлэх хувь	94
График 7. Алтны арилжааны зах зээлд эзлэх хувь	100
График 8. Нийт хөрөнгө /тэрбум төгрөг/	152
График 9. Нийт хөрөнгийн бүтэц	153
График 10. Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө /тэрбум төгрөг/	154
График 11. Бусад банкуудад байршуулсан хөрөнгө /тэрбум төгрөг/	154
График 12. Хөрөнгө оруулалт /тэрбум төгрөг/	155
График 13. Нийт зээлийн үлдэгдэл/тэрбум төгрөг/	155
График 14. Нийт зээлийн бүтэц	156
График 15. Чанаргүй зээлийн үлдэгдэл /тэрбум төгрөг/	157
График 16. Зээлийн эрсдэлийн сан /тэрбум төгрөг/	157
График 17. Өмчлөх бусад хөрөнгө /тэрбум төгрөг/	157
График 18. Биет, биет бус хөрөнгө /тэрбум төгрөг/	158
График 19. Нийт өр төлбөр /тэрбум төгрөг/	159
График 20. Харилцагчдаас татсан эх үүсвэр /сегментээр/	159
График 21. Харилцагчдаас татсан эх үүсвэр бүтэц /тэрбум төгрөг/	159
График 22. Иргэд болон бусад эх үүсвэр /тэрбум төгрөг/	160
График 23. ААН-ийн харилцах, хадгаламж /тэрбум төгрөг/	160
График 24. Бусад зээлийн эх үүсвэр /тэрбум төгрөг/	161
График 25. БСБ-аас татсан эх үүсвэр, репо хэлцэл /тэрбум төгрөг/	161
График 26. Эздийн өмч /тэрбум төгрөг/	161
График 27. Эздийн өмчийн бүтэц	162
График 28. Хүүгийн орлого /тэрбум төгрөг/	162
График 29. Хүүгийн орлогын бүтэц	163
График 30. Хүүгийн зардал /тэрбум төгрөг/	162
График 31. Хүүгийн зардлын бүтэц	163
График 32. Цэвэр хүүгийн орлого /тэрбум төгрөг/	164
График 33. Цэвэр хүүгийн бус орлого /тэрбум төгрөг/	165
График 34. Үйл ажиллагааны зардал /тэрбум төгрөг/	165



График 35. Эрсдэлийн сан, үнэлгээний зардал /тэрбум төгрөг/	166
График 36. Цэвэр ашиг /тэрбум төгрөг/	166
График 37. Цэвэр мөнгөн урсгал /тэрбум төгрөг/	168
График 38. Цэвэр хүүний ахиуц.....	168
График 39. Цэвэр ашиг /тэрбум төгрөг/, цэвэр ашгийн ахиуц.....	169
График 40. Эздийн өмч, нийт хөрөнгийн өгөөж.....	169
График 41. Ду-Понт шинжилгээ	169
График 42. Зардал орлогын харьцаа	170
График 43. Өөрийн хөрөнгийн хүрэлцээний харьцаа үзүүлэлт.....	171
График 44. Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцаа үзүүлэлт.....	172
График 45. Гадаад валютын позицын харьцаа үзүүлэлт.....	172
График 46. Зээлийн төвлөрлийн харьцаа үзүүлэлт	173
График 47. Нэрлэсэн ДНБ /их наяд төгрөг/, өсөлт.....	177
График 48. Нэрлэсэн ДНБ, Салбараар /их наяд төгрөг/.....	178
График 49. Бодлогын хүү болон инфляц	179
График 50. Монгол Улсын ажиллах хүчний тоо /сая хүн/.....	181
График 51. Ажиллах хүчний оролцооны төвшин %	181
График 52. Ажилгүйдлийн тэтгэмжийн хэмжээ /тэрбум төгрөг/	181
График 53. Хөдөлмөр эрхлэлт, ажилгүйдлийн төвшин	181
График 54. Бодлогын хүү.....	182
График 55. Мөнгөний секторийн үзүүлэлт /их наяд төгрөг/	183
График 56. Хадгаламж болон зээлийн хэмжээ /их наяд төгрөг/	184
График 57. Гадаад валютын албан нөөц /сая ам.доллар/ төгрөгийн эсрэг ам.долларын албан ханш.....	184
График 58. Төсвийн тэнцэл /их наяд төгрөг/	185
График 59. Төлбөрийн тэнцэл /сая ам.доллар/	186
График 60. Монгол Улсын гадаад өрийн хэмжээ /сая ам.доллар/.....	187
График 61. Гадаад худалдааны тэнцэл /тэрбум төгрөг/.....	188
График 62. Импорт, хэрэглээний зориулалтаар	189
График 63. Нүүрсний дундаж үнэ, ам.доллар/тонн.....	192
График 64. Зэсийн үнэ, ам.доллар/тонн.....	191
График 65. Хөрөнгийн зах зээлийн үнэлгээ ДНБ-нд эзлэх хувь, хэмжээ	196
График 66. МХБ-ийн индексүүд, оны эхэн үетэй харьцуулахад (оны эхнээс)	196
График 67. Хөрөнгө оруулалтын хэрэгслүүд арилжааны дүнгээр	197
График 68. Өдрийн дундаж арилжаа /сая төгрөг/.....	197
График 69. Хувьцааны арилжааны ДНБ-нд эзлэх хувь, хэмжээ.....	197
График 70. ДНБ-д харьцуулсан хөрөнгийн зах зээлийн арилжаа.....	198
График 71. ДНБ-д харьцуулсан хөрөнгийн зах зээлийн үнэлгээ /олон улс/	198
График 72. Олон улсын банкны салбарын зах зээлийн үнэлгээ /их наяд ам.доллар/	200
График 73. Улс орнуудын бодлогын хүү.....	202



График 74. ДНБ-д санхүүгийн салбарын эзлэх хувь хэмжээ	203
График 75. Банк, үнэт цаас, даатгалын салбарын өсөлт.....	204
График 76. Санхүүгийн салбарын цэвэр ашгийн хэмжээ /тэрбум төгрөг/	205
График 77. Банкны салбарын нийт актив ба ДНБ-д эзлэх хувь.....	206
График 78. Банкны салбарын активын бүтэц	207
График 79. Банкны салбарын цэвэр зээл /их наяд төгрөг/.....	208
График 80. Зээл олголт, төлөлт /их наяд төгрөг/	208
График 81. 2021 оны зээл олголт, төлөлт /их наяд төгрөг/, салбараар	208
График 82. Чанаргүй зээлийн хэмжээ /их наяд төгрөг/	209
График 83. Чанаргүй зээлийн хувь салбараар	210
График 84. Төв банкны үнэт цаас /их наяд төгрөг/.....	210
График 85. Банкны салбарын пассивын бүтэц.....	211
График 86. Банкны салбарын нийт хадгаламж /их наяд төгрөг/	212
График 87. Банкны салбарын нийт харилцах /их наяд төгрөг/.....	212
График 88. Банкны салбарын нийт орлого /их наяд төгрөг/.....	213
График 89. Нийт орлогын өсөлт.....	213
График 90. Зардлын өсөлт.....	214
График 91. Банкны салбарын нийт зардал.....	214
График 92. Банкны салбарын ашигт ажиллагаа.....	215
График 93. Иргэдийн харилцах, хадгаламжийн хүү	216
График 94. Иргэдийн харилцах, хадгаламжийн дүн /их наяд төгрөг/	216
График 95. Иргэдийн зээлийн үлдэгдэл /их наяд төгрөг/, чанаргүй зээлийн хувь	217
График 96. Зээлийн үлдэгдэл төрлөөр	217
График 97. Байгууллагын харилцах, хадгаламжийн дүн /их наяд төгрөг/.....	219
График 98. Байгууллагын харилцах хадгаламжийн хүү	219
График 99. Байгууллагын зээлийн дүн /их наяд төгрөг/, чанаргүй зээлд эзлэх хувь	220
График 100. ЖДҮ зээлд эзлэх хувь, 2021 он салбараар.....	220
График 101. ААН, Иргэдийн зээлийн үлдэгдэл, NPL	220
График 102. Үнэт цаас гаргагчийн нийт харилцах хадгаламж, зах зээлд эзлэх хувь	221
График 103. Үнэт цаас гаргагчийн нийт зээл, зах зээлд эзлэх хувь	221
График 104. Үнэт цаас гаргагчийн нийт хөрөнгө, зах зээлд эзлэх хувь	221
График 105. Үнэт цаас гаргагчийн байгууллагын зээлийн зах зээлд эзлэх хувь..	222
График 106. Үнэт цаас гаргагчийн байгууллагын харилцах, хадгаламжийн зах зээлд эзлэх хувь	222
График 107. Үнэт цаас гаргагчийн иргэдийн эх үүсвэрийн зах зээлд эзлэх хувь ..	223
График 108. Үнэт цаас гаргагчийн иргэдийн зээлийн зах зээлд эзлэх хувь.....	223
График 109. Үнэт цаас гаргагчийн орон сууцны зээлийн зах зээлд эзлэх хувь	223
График 110. Топ-5 банкны хөрөнгийн өсөлт.....	224
График 111. Топ-5 банкны цэвэр зээлийн өсөлт	224



График 112. Нийт харилцах хадгаламж, өсөлт.....	226
График 113. Өөрийн хөрөнгө, өсөлт.....	224
График 114. Хүүгийн орлого, өсөлт	225
График 115. Эрсдэлийн сангийн зардлын өмнөх үйл ажиллагааны ашиг	225
График 116. Банкуудын цэвэр ашиг, ашгийн өсөлт.....	226
График 117. Банкны нийт активын ДНБ-д эзлэх хувь	227
График 118. Эдийн засгийн өсөлт болон зээлийн хамаарал	229
График 119. Нийт олгосон ногоон зээлийн хэмжээ /тэрбум ам.доллар/, олон улс	231
График 120. Үнэт цаас гаргагчийн нийт хөрөнгө, хөрөнгийн бүтэц /тэрбум төгрөг/	241
График 121. Үнэт цаас гаргагчийн нийт зээл /тэрбум төгрөг/	243
График 122. Үнэт цаас гаргагчийн зээлийн харьцаан үзүүлэлт	244
График 123. Үнэт цаас гаргагчийн нийт өр төлбөр, өр төлбөрийн бүтэц /тэрбум төгрөг/	245
График 124. Үнэт цаас гаргагчийн харилцах хадгаламжийн хэмжээ /тэрбум төгрөг/	245
График 125. Үнэт цаас гаргагчийн эздийн өмч, эздийн өмчийн бүтэц /тэрбум төгрөг/	246
График 126. Үнэт цаас гаргагчийн хүүгийн орлогын төсөөлөл /тэрбум төгрөг/	247
График 127. Үнэт цаас гаргагчийн хүүгийн зардлын төсөөлөл /тэрбум төгрөг/	248
График 128. Үнэт цаас гаргагчийн цэвэр хүүгийн орлогийн төсөөлөл /тэрбум төгрөг/	249
График 129. Үнэт цаас гаргагчийн хүүгийн бус орлогийн төсөөлөл (своп хэлцлүүдийн нөлөө ороогүй) /тэрбум төгрөг/.....	250
График 130. Үнэт цаас гаргагчийн хүүгийн бус зардлын төсөөлөл /тэрбум төгрөг/	250
График 131. Үнэт цаас гаргагчийн цэвэр хүүгийн бус орлогийн төсөөлөл /тэрбум төгрөг/	251
График 132. Үнэт цаас гаргагчийн цэвэр ашгийн төсөөлөл /тэрбум төгрөг/.....	253
График 133. Ногдол ашгийн төсөөлөл /тэрбум төгрөг/.....	253
График 134. Төсөөлөлд суурилсан Ду-Понт шинжилгээ	255



ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

Товч үг	Тайлбар
ХХК	Хязгаарлагдмал Хариуцлагатай Компани
АТМ	Автомат Мөнгөний Машин (Automatic teller machine)
БНХАУ	Бүгд Найрамдах Хятад Ард Улс
ХК	Хувьцаат Компани
АНУ	Америкийн Нэгдсэн Улс
ТУЗ	Төлөөлөн Удирдах Зөвлөл
ХБНГУ	Холбооны Бүгд Найрамдах Герман Улс
МУИС	Монгол Улсын Их Сургууль
СЭЗДС	Санхүү Эдийн Засгийн Дээд Сургууль
ОХУ	Оросын Холбооны Улс
МХЗЭ	Монголын Хувьсгалт Залуучуудын Эвлэл
БНСУ	Бүгд Найрамдах Солонгос Улс
ШУТИС	Шинжлэх Ухаан Технологийн Их Сургууль
ХУИС	Хүмүүнлэгийн Ухааны Их Сургууль
ББСБ	Банк Бус Санхүүгийн Байгууллага
ААН	Аж Ахуйн Нэгж
УИХ	Улсын Их Хурал
ХҮТ	Харилцагчийн Үйлчилгээний Төв
БНМАУ	Бүгд Найрамдах Монгол Ард Улс
ЗХУ	Зөвлөлт Холбоот Улс
БНФУ	Бүгд Найрамдах Франц Улс
НҮБ	Нэгдсэн Үндэсний Байгууллага
МҮОНР	Монголын Үндэсний Орон Нутгийн Радио
СТОУС	Санхүү Тайлагналын Олон Улсын Стандарт
БСБ	Банк Санхүүгийн Байгууллага
ОУВС	Олон Улсын Валютын Сан
ДНБ	Дотоодын Нийт Бүтээгдэхүүн
МХБ	Монголын Хөрөнгийн Бирж
ХБҮЦ	Хөрөнгөөр Баталгаажсан Үнэт Цаас
ХОС	Хөрөнгө Оруулалтын Сан
ТБҮЦ	Төв Банкны Үнэт цаас
ХАА	Хөдөө Аж Ахуй
АХБ	Азийн Хөгжлийн Банк
ҮЦК	Үнэт Цаасны Компани
ЗГҮЦ	Засгийн Газрын Үнэт Цаас
СЗХ	Санхүүгийн Зохицуулах Хороо
НХЗНББЗ	Нийтээр Хүлээн Зөвшөөрсөн Нягтлан Бодох Бүртгэлийн Зарчим





ГОЛОМТ БАНК
Сайн сайхныг санхүүжүүлнэ

ХОЁР.

ҮНЭТ ЦААС

ГАРГАГЧИЙН
ТУХАЙ



2 ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ТУХАЙ

2.1 Үнэт цаас гаргагчийн товч танилцуулга

Эх орны хөгжлийн түүчээ, иргэн бүрийн аз жаргалтай амьдралын төлөө "Сайн сайхныг санхүүжүүлнэ" уриан дор үйл ажиллагаагаа явуулдаг Голомт банк ХХК (Үнэт цаас гаргагч) нь 1995 оны 3-р сарын 06-ны өдөр үүсгэн байгуулагдсан бөгөөд Монгол Улсын ууган арилжааны банкуудын нэг юм. Өдгөө Үнэт цаас гаргагч нь арилжааны болон хөрөнгө оруулалтын банкны үйлчилгээг бизнес эрхлэгч, хөрөнгө оруулагч, дотоод гадаадын харилцагч, түншүүдэд мэргэжлийн өндөр түвшинд хүргэн ажиллаж байна.

Үнэт цаас гаргагч нь бүх түвшний үйл ажиллагаандаа харилцагчдынхаа эрэлт хэрэгцээ, хүсэл сонирхлыг эрхэмлэж, харилцагчдадаа тав тухтай, тохилог орчинд, орчин үеийн банкны шилдэг үйлчилгээг хүргэн сэтгэл ханамжийг өндөр байлгах тогтмол хөгжүүлэлт хийж, "Харилцагч төвтэй банк"-ны стратегийг хэрэгжүүлэн ажилладаг.

Голомт банк нь дээрх стратегийн хүрээнд алсын харааг "Дэлхийн жишиг Монголын банк" хэмээн тодорхойлсон.

Голомт банкны алсын хараа нь дараах түлхүүр хүчин зүйлсэд тулгуурладаг. Үүнд:

- Өнөөг хүртэл олон улсын шилдэг туршлагаас суралцан, нэвтрүүлэгч байсан бол цаашид жишиг тогтоогч шилдэг үйл ажиллагааг явуулахаар тэмүүлж;
- Банкны салбарт бизнесийн шинэ стандартыг тогтоож, бусдыг манлайлан үлгэр жишээ үзүүлж;
- Бизнесийн салбарын үйл ажиллагаа бүрд шилдэг нь байхад оршдог.

Үнэт цаас гаргагч нь иргэд болон аж ахуй нэгжийн өдөр тутмын амьдрал, үйл ажиллагаанд банкны шилдэг бүтээгдэхүүн, үйлчилгээгээр дамжуулан хувь нэмрээ оруулах, дэмжлэг үзүүлдэг "Хөгжлийн Голомт" нь байх эрхэм зорилгын хүрээнд үйл ажиллагаа явуулдаг.



Зураг 1. Үнэт цаас гаргагчийн алсын хараа, стратеги



2.2 Үнэт цаас гаргагчийн хуулийн этгээдийн бүртгэл

1995 оны 3-р сарын 6-ны өдөр Монгол Улсын Банкны тухай хуулийн 18 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, Монголбанкны Ерөнхийлөгчийн 2000 оны 375 тоот тушаалаар батлагдсан “Банк, түүний нэгж байгуулах зөвшөөрлийн журам”-ыг үндэслэн Бодь интернэшнл ХХК-д Голомт хэмээх оноосон нэр бүхий арилжааны банк байгуулах албан ёсны зөвшөөрлийг олгосон.

Хүснэгт 1. Үнэт цаас гаргагчийн хуулийн этгээдийн бүртгэл

Оноосон нэр	Голомт банк
Компанийн хэлбэр	Хязгаарлагдмал Хариуцлагатай Компани
Байгуулагдсан огноо	1995 он 3-р сарын 6-ны өдөр
Улсын бүртгэлийн дугаар	9016001014
Регистрийн дугаар	2075377



Үйл ажиллагааны чиглэл	Монголбанкнаас олгосон тусгай зөвшөөрөл:
	<ul style="list-style-type: none"> ▪ Мөнгөн хадгаламж; ▪ Зээл; ▪ Төлбөр тооцооны үйл ажиллагаа; ▪ Гадаад валют худалдах, худалдан авах хадгалах, хадгалуулах; ▪ Үнэт металл, эрдэнийн чулуу худалдан авах, худалдах, хадгалах, хадгалуулах; ▪ Гадаад төлбөр тооцоо хийх; ▪ Гадаад төлбөр тооцооны бүх төрлийн үйлчилгээ; ▪ Үнэт зүйл хадгалах; ▪ Өөрийн нэрийн өмнөөс гуравдагч этгээдэд баталгаа, батлан даалт гаргах; ▪ Үнэт цаас гаргах, худалдах, худалдан авах; ▪ Санхүүгийн түрээсийн үйл ажиллагаа; ▪ Картын үйл ажиллагааны зөвшөөрөл
	СЗХ-ноос олгосон тусгай зөвшөөрөл:
	<ul style="list-style-type: none"> ▪ Даатгалын зуучлагчийн үйл ажиллагаа; ▪ Андеррайтерийн үйлчилгээ; ▪ Зээл болон санхүүгийн хэрэгслийг худалдах, худалдан авах үйл ажиллагаа /Факторингийн үйлчилгээ/; ▪ Үнэт цаасны тухайлсан бүртгэлийн үйл ажиллагаа; ▪ Кастодианы үйл ажиллагаа
Хувьцаа эзэмшигчийн тоо	59*
Өөрийн хөрөнгө	658.7 тэрбум төгрөг (2021/12/31 аудитлагдсан)
Үйл ажиллагаа эрхлэх хугацаа	Хугацаагүй

Эх сурвалж: Үнэт цаас гаргагчийн мэдээлэл

2.3 Үнэт цаас гаргагчийн хаяг байршил

Хүснэгт 2. Үнэт цаас гаргагчийн хаяг, байршил

Хаяг	Голомт банк, Голомт банкны төв байр, Сүхбаатарын талбай 5, Ш/-22, Улаанбаатар 15160, Монгол Улс
Утас	7011-1646
Факс	11-313155
И-мэйл	mail@golomtbank.com
Вэб хуудас	www.golomtbank.com

Эх сурвалж: Үнэт цаас гаргагчийн мэдээлэл

* Нийтэд санал болгож буй үеийн байдлаар



2.4 Үнэт цаас гаргагчийн хувьцаа эзэмшигчид, холбоотой этгээд

Хувьцааны бүтэц

Үнэт цаас нийтэд санал болгох үеийн байдлаар Үнэт цаас гаргагч нь нийт 179,048,538,000 төгрөгийн хувь нийлүүлсэн хөрөнгөтэй байна.

Хүснэгт 3. Хувьцааны бүтэц

Хувьцааны төрөл	Нэгж үнэ (төгрөг)	Нийт зарласан хувьцаа (А)	Нийт гаргасан хувьцаа (Б)	Нийт үнэ /мянган төгрөг/
Энгийн хувьцаа	250	800,000,000	716,194,152	179,048,538
Нийт				179,048,538

Эх сурвалж: Үнэт цаас гаргагчийн мэдээлэл

Хувьцааг олон нийтэд санал болгон арилжаалсны дараах хувьцаа эзэмшлийн бүтцийг 5.2 Хувь нийлүүлсэн хөрөнгийн өөрчлөлт хэсгээс харна уу.

Энгийн хувьцаа эзэмшигчид

Хүснэгт 4. Хувьцаа эзэмшигчдийн мэдээлэл

Хуулийн этгээдийн нэр	Регистрийн дугаар	Хувьцааны тоо, ширхэг	Эзэмшлийн хувь	Нэрлэсэн үнэ /төгрөг/	Нийт үнэ /мянган төгрөг/
Голомт Файнэншил Групп	5845742	624,240,527	87.16%	250	156,060,132
Свисс-Мо Инвестмент Эй Жи	СНО-350.3.011.021- 1	42,120,816	5.88%	250	10,530,204
Бодь Интернэшнл	2040433	27,661,497	3.86%	250	6,915,374
Голомт Инвестмент Лимитэд	1818358	20,800,000	2.90%	250	5,200,000
Голомт банкны ажилтанууд		1,371,312	0.19%	250	342,828
Нийт		716,194,152	100%		179,048,538

Эх сурвалж: Үнэт цаас гаргагчийн компанийн дүрэм

Хувьцааг олон нийтэд санал болгон арилжаалсны дараах хувьцаа эзэмшлийн бүтцийг 5.2 Хувь нийлүүлсэн хөрөнгийн өөрчлөлт хэсгээс харна уу.

Голомт Файнэншил Групп ХХК

Голомт Файнэншил Групп ХХК нь 2014 онд үүсгэн байгуулагдсан бөгөөд санхүүгийн салбарт тэргүүлэгч Голомт банк ХХК, Голомт Капитал ҮЦК ХХК, Мандал Даатгал ХК, Голомт Ассет Менежмент ХОМК ХХК-уудыг эгнээндээ нэгтгэсэн Монголын санхүүгийн зах зээлд тэргүүлэгч санхүүгийн нэгдэл компани юм.



Свисс-Мо Инвестмент Эй Жи

Свисс-Мо Инвестмент Эй Жи хөрөнгө оруулалтын сан нь Швейцарын Холбооны Улсад байрлалтай бөгөөд тус сангийн гол хувьцаа эзэмшигч нь Швейцар улсын иргэн, бизнесмен, филантропч ноён Урс И.Шварценбах юм. Тус сан нь валют арилжаа, нисэх онгоцны буудал, агаарын тээвэр болон зочид буудлын бизнест хувьцаа эзэмшдэг.

Бодь Интернэшнл ХХК

Бодь Интернэшнл компани нь үл хөдлөх хөрөнгийн хөгжүүлэлт, удирдлага, барилга, эрчим хүч, уул уурхай, амралт аялал жуулчлалын салбарт амжилттай үйл ажиллагаа явуулж буй 10 гаруй охин болон хараат компанийг удирдан ажиллаж байна.

Голомт Инвестмент Лимитэд

Голомт Инвестмент Лимитэд нь Монголын анхны томоохон групп компани болох Бодь Интернэшнл ХХК-ийн хөрөнгө оруулалттайгаар 2014 онд үүсгэн байгуулагдсан.

Голомт банкны ажилтнууд

Ажилтанд хувьцаа эзэмшүүлэх хөтөлбөрийн хүрээнд Голомт банкны нийт 55 ажилтан хувьцаа эзэмшдэг буюу Үнэт цаас гаргагчийн нийт хувьцааны 0.19 хувийг эзэмшдэг.

Схем 1. Хувьцаа эзэмшигчдийн бүтэц



Эх сурвалж: Үнэт цаас гаргагчийн компанийн төлөвлөгөө



Хүснэгт 5. Хувьцаа эзэмшигчдийн бүтцийн төлөвлөгөө

Хувьцаа эзэмшигчийн нэр	Хувьцааны тоо, ширхэг	Эзэмшлийн хувь
Голомт Файнэншил Групп	624,240,527	78.36%
Свисс-Мо Инвестмент Эй Жи	42,120,816	5.29%
Голомт Инвестмент Лимитэд	20,800,000	2.61%
Голомт банкны ажилтанууд	1,371,312	0.17%
Бодь Интернэшнл ХХК	27,661,497	3.47%
Олон нийт	80,402,743	10.09%
Нийт	796,596,895	100%

Эх сурвалж: Үнэт цаас гаргагчийн компанийн төлөвлөгөө

Холбоотой этгээд

Үнэт цаас гаргагчийн хувьцаа эзэмшигчдийн холбоотой этгээд болон хараат, хамааралтай талуудыг Монгол Улсын Банкны тухай хуулийн 3.1. дэх заалтаар тодорхойлдог. Тус хуулийн дагуу Үнэт цаас гаргагчийн холбоотой этгээдийн мэдээлэл дараах байдалтай байна. Үүнд:

Хүснэгт 6. Голомт Файнэншил Групп ХХК-ийн охин компаниуд

№	Нэр	Регистрийн дугаар	Хувьцаа эзэмшигч	Үйл ажиллагаа
1	Голомт Файнэншил Групп ХХК	5845742	Д.Баясгалан - 100%	Менежментийн компани
2	Мандал Даатгал ХК	5473489	Голомт Файнэншил Групп ХХК - 40.85%	Даатгалын компани
3	Голомт Капитал ҮЦК ХХК	5481589	Голомт Файнэншил Групп ХХК - 100%	Брокер, хөрөнгө оруулалтын зөвлөх, андеррайтерийн компани
4	Голомт Лизинг ХХК	5980755	Голомт Файнэншил Групп ХХК - 100%	Санхүүгийн түрээсийн үйлчилгээ үзүүлэгч компани
5	Голомт Ассет Менежмент ХОМК ХХК	6011888	Голомт Файнэншил Групп ХХК - 100%	Хөрөнгө оруулалтын менежментийн компани

Эх сурвалж: Үнэт цаас гаргагчийн мэдээлэл



Хүснэгт 7. Монголмасс Медиа ХХК-ийн охин компаниуд /Д.Баясгалан - 100%/

№	Нэр	Регистрийн дугаар	Хувьцаа эзэмшигч	Үйл ажиллагаа
1	Монголмасс Медиа ХХК	2854724	Д.Баясгалан - 100%	Сонин хэвлэн нийтлэх, гадаад худалдаа
2	Монголиа Медиа Корпорэшн ХХК	2691728	Монгол Масс Медиа ХХК - 100%	Телевиз радиогийн нэвтрүүлэг, хэвлэлт, зар сурталчилгаа
3	Ийгл Бродкастинг ХХК	2764792	Монгол Медиа Корпорэшн ХХК - 100%	Хэвлэл мэдээлэл, радио телевиз, сонин сэтгүүл, электрон хэвлэл, зар сурталчилгаа
4	Ардын Эрхийн Элч ТББ	8189463	Монгол Медиа Корпорэшн ХХК - 100%	Хэвлэл мэдээллийн салбарыг хөгжүүлэх, сэтгүүлчдийн сэтгүүл зүйн мэргэжил, ур чадварыг дээшлүүлэхэд дэмжлэг үзүүлэх
5	Шууд Ти Ви ХХК	5388112	Монгол Медиа Корпорэшн ХХК - 100%	Кабелийн сувгийн үйлчилгээ
6	Тойм-Инк ХХК	5107385	Монгол Медиа Корпорэшн ХХК - 100%	Гадаад худалдаа
7	Гэр Контент Групп ХХК	6020127	Монгол Масс Медиа ХХК - 100%	Гадаад худалдаа
8	Меүви Бокс ХХК	5488036	Гэр Контент Групп ХХК - 100%	Гадаад худалдаа, дуу дүрс бичлэг
9	Медиа Боловсрол Суваг ХХК	5719739	Гэр Контент Групп ХХК - 100%	Гадаад худалдаа
10	Эйшн Бокс ХХК	5471346	Гэр Контент Групп ХХК - 100%	Гадаад худалдаа, дуу дүрс бичлэг
11	Хүлэгү Пикчерс ХХК	5815452	Гэр Контент групп ХХК - 100%	Дуу дүрс бичлэг хийх, гадаад худалдаа, кино хийх
12	Мюзик Бокс ХХК	5488028	Монгол Масс Медиа ХХК - 100%	Дуу дүрс бичлэг хийх, гадаад худалдаа

Эх сурвалж: Үнэт цаас гаргагчийн мэдээлэл



Хүснэгт 8. Бодь Интернэшнл ХХК-ийн охин компаниуд /Д.Баясгалан - 77%/

№	Нэр	Регистрийн дугаар	Хувьцаа эзэмшигч	Үйл ажиллагаа
1	Бодь Интернэшнл ХХК	2040433	Д. Баясгалан - 77%	Үл хөдлөх хөрөнгийн түрээс, гадаад худалдаа, хөрөнгө оруулалт
2	Монгол Лизинг ХХК	2559927	Бодь Интернэшнл ХХК - 100%	Санхүүгийн түрээс
3	Бодь Пропертиз ХХК	2549883	Бодь Интернэшнл ХХК - 100%	Үл хөдлөх хөрөнгийн зуучлал, худалдаа
4	Ито Инвест ХХК	5262895	Бодь Интернэшнл ХХК - 100%	Гадаад худалдаа
5	Бодь Хотел ХХК	5177618	Бодь Интернэшнл ХХК - 100%	Зочид буудал, аялал жуулчлал
6	Өндөр Улаан Трэвел ХХК	2782111	Бодь Интернэшнл ХХК - 96%	Зочид буудал, баар, ресторан, аялал жуулчлал
7	Инкон ХХК	2074931	Бодь Интернэшнл ХХК - 100%	Барилга угсралт, гадаад худалдаа, худалдааны зуучлал, барилгын материал бэлдэх, тээвэрлэх, барилгын засвар үйлчилгээ
8	Адис Майнинг ХХК	5562589	Бодь Интернэшнл ХХК - 100%	Гадаад худалдаа
9	Экос ХХК	2108488	Бодь Интернэшнл ХХК - 51%	Байгаль орчны нөлөөлөх байдлын үнэлгээ хийх, экологийн сан байгуулах, мэдээлэл дамжуулах, инженер гидрогеологийн урьдчилсан судалгаа, усны аж ахуйн барилгын иж бүрдэл, зураг төсөл
10	Голомт Инвестмент Лимитэд	1818358	Бодь Интернэшнл ХХК - 100%	Хөрөнгө оруулалт
11	Хуланконтент ХХК	5796768	Бодь Интернэшнл ХХК - 70%	Программ хангамжийн үйлчилгээ
12	Бодь Интернэшнл Трэйдинг ХХК	6569331	Бодь Интернэшнл ХХК - 100%	Худалдааны зуучлал, уул уурхайн чиглэлийн зөвлөгөө өгөх
13	Просетрийл Эстэйт ХХК	5391229	Бодь Интернэшнл ХХК - 100%	Үл хөдлөх хөрөнгийн худалдаа, зуучлал



14	Хөвсгөл Хөгжил ХХК	5031729	Бодь Интернэшнл ХХК - 100%	Үл хөдлөх хөрөнгийн зуучлал, гадаад худалдаа, аялал жуулчлал
----	--------------------	---------	----------------------------	--

Эх сурвалж: Үнэт цаас гаргагчийн мэдээлэл

Хүснэгт 9. Бодь Интернэшнл ХХК-ийн хараат компаниуд

№	Нэр	Регистрийн дугаар	Хувьцаа эзэмшигч	Үйл ажиллагаа
1	Домогт Шарын Гол ХХК	2151693	Бодь Интернэшнл ХХК - 23%	Худалдаа, мод бэлтгэх, зүсвэрлэх, боловсруулах, мод үржүүлэг, нөхөн сэтгээлт, ойжуулалт, тарьц ургуулах
2	Мөнгөн гүүр Хоспитал ХХК	5387795	Бодь Интернэшнл ХХК - 38.49%	Гадаад худалдаа, үл хөдлөх хөрөнгийн тоног төхөөрөмжийн түрээсийн үйлчилгээ
3	Мөнгөн гүүр ББСБ	2769859	Бодь Интернэшнл ХХК - 40%	Цахим төлбөр тооцоо, мөнгөн гуйвуулгын үйлчилгээ

Эх сурвалж: Үнэт цаас гаргагчийн мэдээлэл

Хүснэгт 10. Бодь Интернэшнл ХХК-ийн охин компанийн эзэмшлийн компаниуд

№	Нэр	Регистрийн дугаар	Хувьцаа эзэмшигч	Үйл ажиллагаа
1	Үндэсний Соёл Амралтын Хүрээлэн ХХК	5033438	Ито Инвест ХХК - 74%	Соёл урлаг, амралтын цогцолбор, тоглоомын төв, гадаад худалдаа
2	Санзай Төв ХХК	2651696	Бодь Пропертиз ХХК - 100%	Гадаад худалдаа
3	Хөвсгөл Давлагаа ХХК	5063876	Хөвсгөл Хөгжил ХХК - 100%	Аялал жуулчлал, үл хөдлөх хөрөнгийн худалдаа, гадаад худалдаа
4	Грийнсити Гарден ХХК	5284333	Өндөр Улаан Трэвел ХХК - 100%	Газар тариалан эрхлэх, худалдааны зуучлал
5	Суперпроб ХХК	5344883	Мөнгөн гүүр хоспитал ХХК - 100%	Гадаад худалдаа, Эмнэлэгийн багаж, тоног төхөөрөмж, дагалдах хэрэгслийн худалдаа, дүрс оношлогоо

Эх сурвалж: Үнэт цаас гаргагчийн мэдээлэл



Хүснэгт 11. Бодь Интернэшнл ХХК-ийн хараат компанийн эзэмшлийн компаниуд

№	Нэр	Регистрийн дугаар	Хувьцаа эзэмшигч	Үйл ажиллагаа
1	Рэд Рок Катеринг ХХК	6502873	Өндөр Улаан Трэвел ХХК - 100%	Авто машины ачаа тээвэр, агуулахын үйл ажиллагаа, барилгын засвар, бичиг хэрэгслийн худалдаа, бизнесийн зөвлөгөө өгөх, дуудлагын өрх гэр, албан байгууллага цэвэрлэх үйл ажиллагаа, түргэн хоолны үйлчилгээ, хүнсний бөөний болон жижиглэнгийн худалдаа, худалдааны зуучлал, катерингийн үйлчилгээ, хими цэвэрлэгээ, цайны газар

Эх сурвалж: Үнэт цаас гаргагчийн мэдээлэл

Хүснэгт 12. Бодь Интернэшнл ХХК-ийн бусад холбоотой тал

№	Нэр	Регистрийн дугаар	Хувьцаа эзэмшигч	Үйл ажиллагаа
1	Цэцэнс Холдинг ХХК	5685311	Д.Баясгалан - 100%	Ашигт малтмалын олборлолт, менежментийн зөвлөгөө өгөх
2	Цэцэнс Майнинг Энд Энержи ХХК	5482046	Цэцэнс Холдинг ХХК - 100%	Ашигт малтмалын хайгуул, эрчим хүчний барилга байгууламж 600 Мвт-ын хүчин чадалтай дулааны цахилгаан станц барих, ашигт малтмалын ашиглалт
3	Бөөрөлжүүт Коул Конвершн ХХК	5981263	Цэцэнс Холдинг ХХК - 100%	Гадаад худалдаа, геологийн суурь судалгаа
4	Коллвэй Консалтинг ХХК	5655803	Ч.Мөнхцэцэг - 100%	Хууль зүйн зөвлөгөө

Эх сурвалж: Үнэт цаас гаргагчийн мэдээлэл



2.5 Үнэт цаас гаргагчийн засаглалын тогтолцоо

Үнэт цаас гаргагч нь бүхий л үйл ажиллагааг “Дэлхийн жишиг Монголын банк” хэмээх алсын хараан дор нийцүүлж ажилладаг. Тодруулбал, Голомт банкны засаглалын тогтолцоо нь зохистой удирдлагын арга барил, үр дүнтэй дотоод хяналт, хүчирхэг эрсдэлийн соёл болон оролцогч талуудын өмнө хүлээх хариуцлага зэрэгт төвлөрдөг.

Түүнчлэн үнэт цаас гаргагчийн засаглалын тогтолцоо нь Монголбанкны “Банкны засаглалын зохистой зарчмыг хэрэгжүүлэх журам”, Санхүүгийн Зохицуулах Хорооны “Монголын компанийн засаглалын кодекс” болон Эдийн засгийн хамтын ажиллагаа болон хөгжлийн байгууллагын “Компанийн засаглалын зарчмууд” зэрэгт бүрэн нийцсэн бөгөөд хууль зүйн дүгнэлтэд дурьдагдсан болно.


Үнэт цаас гаргагчийн Төлөөлөн Удирдах Зөвлөл (ТУЗ) нь оролцогч талуудын хүлээлтэд нийцсэн засаглалын зарчмуудыг тогтоох, хэрэгжүүлэхэд манлайлж, банкны үйл ажиллагаанд эрх мэдлийн зохистой хуваарилалт, хариуцлагын тогтолцоо болон хараат бус шийдвэр гаргах тогтолцоог бүрдүүлсэн байдаг.

Мэргэжлийн өндөр ур чадвар бүхий ТУЗ, оролцогч талуудын нийт төлөөллийг (цөөнх хувьцаа эзэмшигчид/ажилтанууд) ханган бүрдүүлсэн байдал, нарийвчилсан үүрэг бүхий байнгын үйл ажиллагаатай хороод, дотоод аудитын үйл ажиллагааг олон улсын стандартад нийцүүлж, бүрэн хараат бусаар баталгаажуулан ажиллаж байгаа зэрэг нь засаглалын шилдэг туршлагыг нэвтрүүлэн хэвшүүлсний илрэл юм.



Схем 2. Үнэт цаас гаргагчийн засаглалын тогтолцоо

ГОЛОМТ БАНКНЫ ЗАСАГЛАЛЫН ТОГТОЛЦОО



Зохистой Засаглалын Кодекс, Ёс Зүйн Дүрэм,
Дотоод Бодлого, Дүрэм Журам

← Сонгох/томилох → Тайлагнах/мэдээлэх

Хувьцаа эзэмшигчдийн хурал

Хувьцаа эзэмшигчдийн хурал нь банкны эрх барих дээд байгууллага бөгөөд үнэт цаас гаргагч нийт хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг хангасан мэдээлэл, тайлагналын тогтолцоог бүрдүүлэн ажиллаж байна.



Төлөөлөн Удирдах Зөвлөл

Төлөөлөн Удирдах зөвлөл (ТУЗ) нь Монгол Улсын хууль тогтоомж болон Үнэт цаас гаргагчийн дүрмээр Хувьцаа эзэмшигчдийн хурлын бүрэн эрхэд хамааруулснаас бусад бүх асуудлаар банкны ерөнхий удирдлагыг хэрэгжүүлдэг. ТУЗ-ийг банк, санхүү, эрсдэлийн удирдлагаар мэргэшсэн, мэдлэг ур чадвар бүхий туршлагатай, нийт оролцогч талуудын төлөөллийг оролцуулсан, эрх ашгийг тэнцвэржүүлсэн багаар бүрдүүлсэн байдаг.

ТУЗ нь 3 хараат бус гишүүн, нийт 9 гишүүний бүрэлдэхүүнтэй, Эрсдэлийн удирдлагын хороо (ЭУХ), Засаглал, Ёс зүй, Цалин урамшуулал, Нэр дэвшүүлэх хороо (ЗЁЦУНДХ), Аудитын хороо (АХ) гэсэн байнгын хороодтой, нээлттэй хувьцаат компани болоход бэлтгэх үүрэг бүхий түр хороотой үйл ажиллагаа явуулдаг. Мөн ТУЗ-ийн Нарийн бичгийн даргаас гадна, Аудит хариуцсан захирал нь ямар нэгэн хязгаарлалтгүйгээр ТУЗ-ийн болон түүний хороодын хуралд оролцдог.

ТУЗ нь дараах голлох чиг үүргийн дагуу үйл ажиллагаагаа хэрэгжүүлдэг. Үүнд:

- Банкны стратеги чиглэл, урт хугацааны зорилго, бизнес төлөвлөгөөг батлах, түүнийг хэрэгжүүлэхэд шаардлагатай нөөцийн зохистой хуваарилалтыг хийх;
- ТУЗ-ийн хороодын хэрэгжүүлэх чиг үүргийг тодорхойлж, түүний хэрэгжилтэд хяналт тавих;
- Эрсдэлийг тодорхойлох, удирдах тогтолцоог бий болгох, хянах;
- Төсөв төлөвлөгөө болон гүйцэтгэх удирдлагын гүйцэтгэлийг үнэлэх, үйл ажиллагаанд хяналт тавих;
- Банкны үнэт зүйл, ёс зүйн кодыг тодорхойлж, хэрэгжилтэд хяналт тавих;
- ТУЗ-ийн гишүүд, Гүйцэтгэх удирдлагын залгамжийн бодлогыг тодорхойлж, хэрэгжүүлэх;
- Тогтвортой хөгжлийн асуудлууд банкны стратегид туссан эсэхийг хянаж, баталгаажуулах;
- Дотоод аудитын газрыг удирдаж хянах замаар банкны үйл ажиллагаанд зохистой байдлаар хяналт хийгдэж буйг хянаж, баталгаажуулах.

Дээрх чиг үүргийн хүрээнд Голомт банк нь өнгөрсөн жилүүдэд сайн засаглалын зарчмуудыг хэрэгжүүлж, зохистой засаглалын тогтолцоог бий болгоход онцгой анхаарч ажилласан бөгөөд хэрэгжүүлсэн томоохон үйл ажиллагаануудаас дурдвал:

- Банкны засаглалд оролцогч талууд болох Хувьцаа эзэмшигчид, Төлөөлөн удирдах зөвлөл, Гүйцэтгэх удирдлага, Дотоод ба хөндлөнгийн аудит, тайлагналын эрх, үүрэг, хариуцлага болон банкны ажилтны ёс зүйн код, авилгын эсрэг бодлого, сонирхлын зөрчилтэй асуудлыг шийдвэрлэх журам, мэдээллийн тэнцвэртэй байдлын бодлого, луйврын эсрэг бодлого, улс



төрийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх бодлого, зөрчлийг мэдээлэх бодлого зэргийг багтаасан засаглалын суурь баримт бичиг болох **"Голомт банкны Засаглалын Кодекс"-ийг баталж, үйл ажиллагаандаа мөрдөж ажиллаж байна.**

- Дэлхийн банкны группийн харьяа болох **Олон Улсын Санхүүгийн Корпорацаар (International Finance Corporation) 2016 онд Засаглалын иж бүрэн үнэлгээг хийлгэсэн.** Уг үнэлгээг хийхдээ Олон Улсын Санхүүгийн Корпорацийн "Ази Номхон далайн орнуудын засаглалын хөтөлбөр"-ийн экспертүүд Голомт банканд бүтэн жилийн турш ажиллаж, бүхий л баримт бичигтэй танилцах, оролцогч талуудтай уулзах зэргээр ажиллаж дүгнэлт гаргасан. Уг ажлын хөтөлбөрийн хүрээнд ТУЗ-ийн нийт гишүүд, дээд удирдлагын захирлууд хяналт, засаглалын болон аудитын хорооны сургалтуудад хамрагдсан. Мөн 2018 он хүртэл хугацаанд сайжруулах шаардлагатай баримт бичиг, үйл ажиллагааг Олон Улсын Санхүүгийн Корпорацийн экспертүүдийн дэмжлэгтэй бүрэн засаж, сайжруулсан.
- ТУЗ-ийн хяналтын чиг үүргийг сайжруулах, олон улсын стандарт, сайн туршлага, засаглалын зарчмуудад нийцүүлж Аудитын хороо, Эрсдэлийн удирдлагын хороо, Засаглал, ёс зүй, цалин урамшуулал, нэр дэвшүүлэх хороодын дүрмийг шинэчилж, үйл ажиллагаандаа ашиглаж байна.
- Дотоод аудитын үйл ажиллагааг Гүйцэтгэх удирдлагаас бүрэн хараат бус байдлаар зохион байгуулж, олон улсын стандарт, сайн туршлагад нийцсэн үйл ажиллагааг явуулдаг тогтолцоог бий болгосон.
- 2018 онд Олон Улсын Санхүүгийн Корпорацийн хүсэлтээр Бутаны Вант улсын томоохон банк болох Бутаны Үндэсний Банканд засаглал, аудит, эрсдэлийн удирдлага, дотоод хяналтын чиглэлээр газар дээрх зөвлөх үйлчилгээ үзүүлсэн.
- 2019 онд PricewaterhouseCoopers Česká republika s.r.o-ийн олон улсын экспертүүдийн хамт банкны эрсдэлийн удирдлага, СТОУС 9, зээлийн скоринг, рейтинг тогтоох ажиллагаанд ко-соурсэд дотоод аудит хийж, үйл ажиллагааг сайжруулсан.
- 2021 онд Олон улсын нэр хүнд бүхий байгууллагаар өөрсдийн үйл ажиллагааг олон улсын стандартыг хангаж, сайн туршлагыг хэрэгжүүлж буйг баталгаажуулах хараат бус, хөндлөнгийн чанарын баталгаажуулалт хийлгэж, **Олон Улсын стандарт, сайн туршлагыг бүрэн хангаж байна гэдэг үнэлгээ авсан.**



ТУЗ-ийн гишүүдийн мэдээлэл

ТУЗ-ийн дарга Ч.Мөнхцэцэг



Хатагтай Ч.Мөнхцэцэг нь 1988 онд Зөвлөлтийн 3 дугаар бүрэн дунд сургууль, 1993 онд Политехникийн их сургуулийг Уул уурхайн цахилгаан механикийн инженер, 2001 онд АНУ-ын Жон Хопкинсийн их сургуулийг (John Hopkins University) Бизнесийн удирдлагын магистрын (MBA) зэрэгтэй төгссөн.

Тэрээр 2015 онд Англи Улсын Оксфордын их сургууль, 2016 онд АНУ-ын Харвардын их сургуулиудад тус тус мэргэжил дээшлүүлсэн.

Хатагтай Ч.Мөнхцэцэг нь ажлын гараагаа 1996 онд Монголын Хөрөнгийн Биржээс эхэлж, Дэлхийн банк, Азийн сан, Тойм сэтгүүл, Nerko Publishing хэвлэлийн компани зэрэг газруудад ажилласан туршлагатай.

Тэрээр 2004 оноос эхлэн олон улсын болон дотоодын байгууллагуудын Удирдах зөвлөлд томилогдон ажиллаж байсан бөгөөд 2012 оноос Голомт банкны ТУЗ-ийн гишүүнээр, 2013 оноос Голомт банкны ТУЗ-ийн даргаар томилогдон ажиллаж байна.

**ТУЗ-ийн гишүүн
Урс.Э.Шварценбах**



Ноён Урс.Э.Шварценбах нь Швейцар Улсын Зюрих хотын Худалдааны коллежийг дүүргэж, 1968 онд Зюрих, 1972 онд Лондон дахь Юнион банканд тус тус ажиллаж, 1976 оноос хувийн бизнесээ эхлүүлсэн.

Тэрээр 2000 онд Канадын Номв Скотиагийн Сант Францисийн Зевиер их сургуулийн Хүндэт доктор цолоор шагнагдсан. Ноён Урс.Э.Шварценбах нь 2010 оны 1-р сард Швейцар улсад амьдарч буй ХБНГУ-ын иргэдийг төлөөлөн Монгол Улсын хүндэт консулаар өргөмжлөгдсөн.

Ноён Шварценбахын 99 хувийг эзэмшдэг Свисс-Мо хөрөнгө оруулалтын сан нь Голомт банканд 2011 онд хөрөнгө оруулалт хийснээс хойш банкны ТУЗ-ийн гишүүнээр томилогдон ажиллаж байна.



ТУЗ-ийн гишүүн Ж.Үнэнбат



Ноён Ж.Үнэнбат нь 1985 онд Москвагийн Эдийн засаг статистикийн дээд сургуулийг, 1994 онд АНУ-ын Нью-Йоркийн Колумбын их сургуулийг (Columbia University) магистрын зэрэгтэй төгссөн.

Тэрээр 1996 оноос Монголбанканд ажиллаж эхэлсэн бөгөөд мөнгөний бодлого, судалгааны чиглэлээр олон ажлыг туурвин, банк санхүүгийн чиглэлээр арвин их туршлагатай.

Ноён Ж.Үнэнбат нь 2000-2006, 2015-2020 онуудад Монголын Банкны Холбооны Гүйцэтгэх захирлаар ажиллаж байсан. Тэрээр Компанийн Засаглалын Хөгжлийн Төвийн (КЗХТ) Гүйцэтгэх захирал, СЭЗИС-д Санхүүгийн тэнхимийн эрхлэгчээр ажиллаж байсан туршлагатай.

Эдүгээ тэрээр КЗХТөвийн Зөвлөхийн ажлыг хийдэг ба 2010 онд Голомт банкны ТУЗ-ийн Хараат бус гишүүнээр томилогдож, 2020 оноос ТУЗ-ийн гишүүнээр ажиллаж байна.

ТУЗ-ийн гишүүн Д.Мөнхтөр



Ноён Д.Мөнхтөр нь 1997 онд МУИС-ийн Эдийн засгийн сургуулийг Санхүүгийн удирдлагын бакалавр зэрэгтэй, 2009 онд АНУ-ын Оклахомагийн Их Сургуулийг (University of Oklahoma) Бизнесийн удирдлагын магистрын зэрэгтэй төгссөн.

Тэрээр 1996 оноос Голомт банканд Туслах ажилтнаас эхлэн Эдийн засагч, Зээлийн газрын захирал, Бүртгэл тооцооны газрын захирал, 2011 оноос Тэргүүн дэд захирлаар ажилласан туршлагатай.

Ноён Д.Мөнхтөр нь эдүгээ Цэцэнс Майнинг Энд Энержи ХХК-д Гүйцэтгэх удирдлагын үүрэгт ажлыг гүйцэтгэж байна. Тэрээр Ажилтанд хувьцаа эзэмшүүлэх хөтөлбөрийн хүрээнд хувьцаа эзэмшигч болсон бөгөөд 55 цөөнх хувьцаа эзэмшигчийг төлөөлөн 2012 оноос ТУЗ-ийн гишүүнээр томилогдон ажиллаж байна.



ТУЗ-ийн гишүүн Л.Болормаа



Хатагтай Л.Болормаа нь МУИС-ийг Банк санхүүгийн чиглэлээр бакалавр, Virginia Polytechnic Institute and State их сургуулийг Олон улсын эдийн засагч, Японы Олон улсын их сургуулийг Бизнесийн удирдлагын магистрын зэрэгтэй дүүргэсэн. Олон Улсын Мэргэшсэн санхүүгийн шинжээч /CFA/ зэрэгтэй.

Тэрээр ажлын гараагаа 1992 онд Ард банкнаас эхэлж, Герман улсын Deutsche банкны АНУ-ын Нью Йорк хот болон Японы Токио хот дахь салбаруудад хөрөнгө оруулалт, олон улсын зах зээл, эрсдэлийн удирдлага чиглэлээр ажиллаж байсан.

Хатагтай Л.Болормаа нь 2015 оноос Голомт Файнэншил Групп ХХК-д ажиллаж байсан ба банк санхүүгийн салбарт ажилласан 20 гаруй жилийн туршлагатай. 2020 оноос Голомт банкны ТУЗ-ийн гишүүнээр томилогдон ажиллаж байна.

**ТУЗ-ийн хараат бус гишүүн
Жэймс Б.Двайер**



Ноён Жэймс Б.Двайер нь Notre Dame их сургуулийг Бизнесийн удирдлагын бакалавр, Колумбын их сургуулийг (Columbia University) Бизнесийн удирдлагын магистрын зэрэгтэй төгссөн бөгөөд тус сургуулийн 40,000 гишүүнтэй Төгсөгчдийн холбооны ерөнхийлөгчөөр улиран сонгогдож ирсэн.

Тэрээр 2001 онд Худалдаа хөгжлийн банк болон Хаан банкны хувьчлалын үйл ажиллагаанд оролцож байсан бөгөөд Хойд Америкийн Бизнесийн зөвлөлд Үйл ажиллагаа хариуцсан захирлаар ажиллаж байсан.

Эдүгээ Ноён Жэймс Б.Двайер нь Мандал Даатгал ХК болон Mongolia Growth Group ХХК-д ТУЗ-ийн хараат бус гишүүн, Mongoljin Private Capital сангийн ТУЗ-ийн Дэд дарга, Монголын боловсролын сангийн ТУЗ-ийн дарга, Ерөнхийлөгчийн албыг хашдаг. 2018 оноос Голомт банкны ТУЗ-ийн Хараат бус гишүүнээр томилогдон ажиллаж байна.



ТУЗ-ийн хараат бус гишүүн
А.Лопез Абелло



Ноён А.Лопез Абелло нь Испанийн Барселонагийн их сургуулийг хуульч, IESE бизнесийн сургуулийг Бизнесийн удирдлагын магистрын зэрэгтэй төгссөн. Олон Улсын Мэргэшсэн санхүүгийн шинжээч /CFA/ зэрэгтэй.

Тэрээр Барселонагийн хуулийн холбооны Мэргэшсэн хуульчийн зэрэгтэй. Ноён А.Лопез Абелло нь Credit Suisse, Goldman Sachs, BNP Paribas зэрэг банкуудад бонд болон хөрөнгийн санхүүжилт хариуцсан удирдах албан тушаалуудыг хашиж байсан туршлагатай.

Тэрээр Сингапур болон Лондон хотын хөрөнгө оруулалтын тэргүүлэгч банкуудад 20 гаруй жил ажилласан, олон улсад өндрөөр үнэлэгддэг туршлагатай банкируудын нэг бөгөөд Turms Advisors LLP фирмийг үүсгэн байгуулагч, партнераар ажилладаг. 2014 оноос Голомт банкны ТУЗ-ийн Хараат бус гишүүнээр томилогдон ажиллаж байна.

ТУЗ-ийн хараат бус гишүүн
Александр Пикер



Ноён Александр Пикер нь Австри улсын Салзбургийн их сургуулийг бизнес, хуулийн чиглэлээр магистр болон докторын зэрэгтэй төгссөн.

Анх 1989 онд ажлын гараагаа одоогийн Австри банкнаас эхлүүлж, Die ERSTE bank, International Moscow Bank (IMB), Unicredit Bank, JSC ATF Bank Hypo Alpe-Adria Bank, HBI Bundesholding AG зэрэг банкуудад эрсдэл хариуцсан захирал, үйл ажиллагаа хариуцсан захирал, гүйцэтгэх захирал зэрэг гүйцэтгэх удирдлагын албан тушаалуудыг хашсан олон жилийн туршлагатай банкир юм.

Тэрээр одоо Дэлхийн банкны томоохон төслүүдэд ахлах зөвлөх, Узбекистаны Ипотека банкны Хяналтын зөвлөлийн даргын албан тушаалыг хашиж байна.

2021 оноос Голомт банкны ТУЗ-ийн Хараат бус гишүүнээр томилогдон ажиллаж байна.



ТУЗ-ийн гишүүн О.Ганжолоо



Ноён О.Ганжолоо нь ХБНГУ-ын Берлин хотын Чөлөөт Их Сургуулийг эдийн засгийн онолын чиглэлээр магистр болон докторын зэрэгтэй төгссөн. Олон улсын мэргэшсэн нягтлан бодогчийн зэрэгтэй.

Тэрээр 2016 оноос Голомт Файнэншил Групп ХХК-ийн гүйцэтгэх захиралын албан тушаалыг хашиж байна. Өмнө нь Бодь Интернэшнл ХХК-ийн Санхүү эрхэлсэн захирал, мөн PwC олон улсын аудитын компанийн ХБНГУ болон Монгол дахь салбар компаниудад ажиллаж байсан туршлагатай.

2022 оноос Голомт банкны ТУЗ-ийн гишүүнээр томилогдон ажиллаж байна.

**Аудит хариуцсан захирал
А.Одонбаатар**



Ноён А.Одонбаатар нь 2008 онд МУИС-ийн Эдийн засгийн сургуулийг Банкны менежментийн бакалавр, 2013 онд Энэтхэг улсын Bangalore их сургуулийг (Bangalore University) Санхүүгийн удирдлага, Маркетингийн удирдлагын магистрын зэрэгтэй төгссөн.

Тэрээр 2008-2014 онд Голомт банкны Дотоод аудитын газарт аудитор, 2014-2015 онд Зайсан скүэр тооцооны төвийн захирал, 2015-2016 онд Дотоод аудитын газрын Мэдээллийн технологи, Гүйцэтгэлийн аудитын хэлтэст захирлаар тус тус ажилласан туршлагатай.

2016 оноос хойш Голомт банкны Аудит хариуцсан захирлаар томилогдон ажиллаж байна.



**ТУЗ-ийн нарийн бичгийн дарга
З.Солонго**



Хатагтай З.Солонго нь 2003 онд Энэтхэг улсын Гужарат мужийн Сардар Пател (Sardar Patel) их сургуулийг бакалавр, 2017 онд СЭЗИС-ийг Компанийн засаглалаар мэргэшсэн Бизнес удирдлагын магистрын зэрэгтэй төгссөн.

Тэрээр 2017 онд Олон улсын санхүүгийн корпорациас (IFC) Сингапур улсад зохион байгуулсан Ази бүсийн ТУЗ-ийн Нарийн бичгийн даргын мастер хөтөлбөрт хамрагдаж, мэргэжил дээшлүүлсэн. 2007 оноос хойш Голомт банканд ажиллаж байгаа бөгөөд Гүйцэтгэх захирлын Нарийн бичгийн дарга, Туслахын албан тушаал хашсан туршлагатай

2015 оноос хойш Голомт банкны ТУЗ-ийн Нарийн бичгийн даргаар томилогдон ажиллаж байна.

ТУЗ-ийн дэргэдэх хороод

ТУЗ-ийн дэргэд Эрсдэлийн удирдлагын хороо (ЭУХ), Засаглал, Ёс зүй, Цалин урамшуулал, Нэр дэвшүүлэх хороо (ЗЁЦУНДХ) болон Аудитын хороо (АХ) зэрэг байнгын хороод үйл ажиллагаа явуулдаг.

Эрсдэлийн Удирдлагын Хороо

Эрсдэлийн удирдлагын хороо нь 3 хараат бус гишүүн, нийт 6 гишүүнтэй бөгөөд даргаар нь ТУЗ-ийн хараат бус гишүүн Жеймс Б.Двайер, нарийн бичгийн даргаар ТУЗ-ийн нарийн бичгийн дарга З.Солонго ажилладаг.

Уг хороо нь дараах чиг үүрэгтэй бөгөөд сар бүр хуралдаж, ТУЗ, Гүйцэтгэх удирдлагын багт шаардлагатай асуудлуудаар зөвлөмж хүргүүлдэг:

- Эрсдэлийн аппетитын бодлого, эрсдэлийн лимит, эрсдэлийг удирдах стратеги, зээлийн бодлого, зээлийн хорооны дүрэм, комплаенсын бодлого, засаглалын кодексын бодлогын баримт бичгийг хэлэлцэж, батлах саналыг ТУЗ-д гаргах, Гүйцэтгэх удирдлагад хэрэгжүүлэх чиг үүрэг өгч, хянах;
- Гүйцэтгэх удирдлагын Эрсдэлийн удирдлагын хорооны тайлан, Эрсдэлийн удирдлагын тайланг хэлэлцэх, хянах;



- Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхийн эсрэг Банкны баримтлах бодлогыг батлах, түүний хэрэгжилтийг хянах ба энэ талаарх үйл ажиллагааны улирлын тайланг хянах;
- Гүйцэтгэх удирдлагын баталсан тодорхой дүнгээс дээш зээл болон түүнтэй адилтгах хөрөнгийн үүрэг хүлээсэн групп компаниудын зээлийн шийдвэрийг хянах;
- Засаглалын дүрэм зарчмууд, гадаад дотоодын зохицуулалтын хууль журмуудад нийцэж ажиллаж байгаа эсэхэд хяналт тавих.

Эрсдэлийн удирдлагын хороо нь Гүйцэтгэх захирлын удирддаг Зээлийн хорооны шийдвэрийг хянаж хэт эрсдэлтэй бол тус шийдвэрт хориг тавих эрхтэй бөгөөд банкны бүхий л томоохон эрсдэлүүдэд анхаарч, чиглэл өгч, удирдан ажилладаг.

Засаглал, Ёс зүй, Цалин урамшуулал, Нэр дэвшүүлэх хороо

Үнэт цаас гаргагчийн Засаглал, Ёс зүй, Цалин урамшуулал, Нэр дэвшүүлэх хороо нь 4 гишүүний бүрэлдэхүүнтэй. Тус хороог ТУЗ-ийн дарга Ч.Мөнхцэцэг удирдан ажилладаг.

Засаглал, Ёс зүй, Цалин урамшуулал, Нэр дэвшүүлэх хороо нь банкны үйл ажиллагаа өргөжиж, бизнесийн цар хүрээ тэлж, зах зээлийн орчин өөрчлөгдөх хэрээр түүнд нийцүүлж банкны бүтэц зохион байгуулалт, хүний нөөц, цалин урамшууллын бодлогыг тогтмол сайжруулж ирсэн.

Уг хороо нь дараах чиг үүрэгтэй бөгөөд улирал бүр хуралддаг:

- Засаглалын кодекс болон түүнд багтсан бүх бодлогын хэрэгжилтийг хянаж, Гүйцэтгэх удирдлагыг сонгон шалгаруулах, томилох, чөлөөлөх, цалин хөлс, урамшууллын системийг боловсруулах, батлахад ТУЗ-д санал, зөвлөмж өгөх;
- ТУЗ-ийн гишүүдийг сонгон шалгаруулах, томилох, буцаан татах, цалин хөлс, урамшууллын хэмжээг тогтоох;
- Гүйцэтгэх захирал, гүйцэтгэх удирдлагыг сонгон шалгаруулах, томилох, буцаан татах, цалин хөлс, урамшууллыг тогтоох;
- Гүйцэтгэх захирал ба гүйцэтгэх удирдлагын ажлын гүйцэтгэлийг үнэлж дүгнэх;
- Банкны хүний нөөцийн бодлогын хэрэгжилтийг хангахтай холбоотой журам дүрэмтэй танилцаж, хянан хэлэлцэж, банкны борлуулалт болон төвийн нэгжийн цалингийн систем, тэдгээрийн гүйцэтгэлд суурилсан урамшууллын систем, сонгон шалгаруулалтын журам, ажилтанд хөнгөлөлттэй нөхцөлөөр зээл олгох журам, ажилтнуудын халамж тэтгэмжийн журам зэрэг бичиг баримтуудыг хянаж, тогтмол сайжруулах;



- Гүйцэтгэх захирлын залгамж халааг төлөвлөж, ГУ-ын багийн залгамж халааны төлөвлөлт, хэрэгжилтийг хянах.

Аудитын хороо

Үнэт цаас гаргагчийн Аудитын хороо нь 6 гишүүний бүрэлдэхүүнтэйгээс 3 нь хараат бус гишүүн юм. Тус хороог ТУЗ-ийн Хараат бус гишүүн Жеймс Б.Двайер удирдан, нарийн бичгийн даргаар Аудит хариуцсан захирал А.Одонбаатар ажилладаг.

Уг хороо нь дараах чиг үүрэгтэй бөгөөд сар бүр хуралдаж, ТУЗ, Гүйцэтгэх удирдлагын багт шаардлагатай асуудлуудаар зөвлөмж хүргүүлдэг.

- Жилийн болон сар бүрийн санхүүгийн тайлан, санхүүгийн үзүүлэлтүүдийг санхүүгийн тайлагналын олон улсын стандартууд болон эрх зүйн бусад актуудтай нийцэж байгаа эсэхийг хянах;
- Банкны дотоод хяналтын тогтолцооны үр дүнтэй байдалд анхаарч, үнэлэлт, дүгнэлт өгөх, Банкны эрсдэлийн удирдлагын тогтолцоо, гол эрсдэлүүд, түүнийг хэрхэн удирдаж буй талаар чиглэл өгөх;
- Банкны эрсдэлийн удирдлагын тогтолцоо, гол эрсдэлүүд, түүнийг хэрхэн удирдаж буй талаар чиглэл өгөх;
- Банкны Зөрчлийг мэдээлэх (шүгэл үлээх) үр дүнтэй тогтолцооны хэрэгжилтийг хянах, холбогдох этгээдийн болон сонирхлын зөрчилтэй хэлцэлд хяналт тавих, дүгнэлт гаргах;
- Аудит хариуцсан захирлыг сонгон шалгаруулах, томилох, буцаан татах, цалин, урамшууллыг тогтоох;
- Дотоод аудитын хараат бус байдлыг хангах, төсвийг батлах, удирдах, гүйцэтгэлийг хянах, дотоод аудитын тайланг хэлэлцэх;
- Хөндлөнгийн аудитын байгууллагыг сонгох, чөлөөлөх, гүйцэтгэлийг үнэлж холбогдох саналыг ТУЗ-д хүргүүлэх.

Аудитын хороо нь шаардлагатай тохиолдолд хорооны эрхлэх асуудлын хүрээнд тусгайлсан хяналт, шалгалтын ажлыг зохион байгуулах, банкны нууцад хамаарах баримт, материалтай танилцах, холбогдох албан тушаалтнаар мэдээлэл гаргуулах эрхтэй.



Хүснэгт 13. ТУЗ-ийн хороодын бүрэлдэхүүн

ТУЗ-ийн хороодын гишүүд	Гишүүдэд тавих үндсэн шаардлага	Бусад шаардлага
<p>Эрсдэлийн удирдлагын хороо</p> <ul style="list-style-type: none"> - Жэймс Б.Двайер* /дарга/ - А.Лопез Абелло* - Александр Пикер* - Ч.Мөнхцэцэг - Л.Болормаа - З.Солонго /НБД/ 	<p>Хорооны гишүүн нь ТУЗ-ийн гүйцэтгэх бус гишүүн байх ба нийт гишүүдийн 1/3-ээс доошгүй Хараат бус гишүүд байна.</p>	<p>Гишүүн тус бүр банкны үйл ажиллагаа болон эрсдэлийн удирдлагын талаар хангалттай мэдлэгтэй байх.</p> <p>Хорооны гишүүд нийтдээ банкны томоохон эрсдэлүүдийг мэддэг, банкны эрсдэлийн удирдлагын системийн үр дүнтэй байдлыг дүгнэх чадвартай, мөн сайжруулах боломжуудийг ТУЗ-д зөвлөх мэдлэгтэй байна.</p> <p>Хорооны ажилд дэмжлэг болох шаардлагатай сургалтад хамруулна.</p>
<p>Аудитын хороо</p> <ul style="list-style-type: none"> - Жэймс Б. Двайер* /дарга/ - А.Лопез Абелло* - Александр Пикер* - Ч.Мөнхцэцэг - Д.Мөнхтөр - А.Одонбаатар /НБД/ 	<p>Хорооны гишүүн нь ТУЗ-ийн гүйцэтгэх бус гишүүн байх ба нийт гишүүдийн олонх болон хорооны дарга нь ТУЗ-ийн хараат бус гишүүн байна.</p>	<p>Санхүүгийн тайлагнал, нягтлан бодох бүртгэлийн өндөр мэдлэг, ур чадвартай хүнийг сонгох бөгөөд банк хорооны гишүүнийг тодорхой давтамжтайгаар мэргэжлийн болон шаардлагатай сургалтад хамруулна.</p>
<p>Засаглал, Ёс зүй, Цалин урамшуулал, Нэр дэвшүүлэх хороо</p> <ul style="list-style-type: none"> - Ч.Мөнхцэцэг /дарга/ - Жэймс Б. Двайер* - Ж.Үнэнбат - З.Солонго /НБД/ 	<p>Хорооны гишүүн нь ТУЗ-ийн гүйцэтгэх бус гишүүн байх ба нийт гишүүдийн 1/3-ээс доошгүй Хараат бус гишүүд байна.</p>	<p>Сайн засаглалын тогтолцоог бүрдүүлэн ажиллахад дэмжлэг болж, зохистой засаглал, ёс зүй, цалин урамшуулал, нэр дэвшүүлэхтэй холбоотой үйл ажиллагааг удирдан явуулахад ТУЗ-д дэмжлэг болох мэдлэг, чадвар туршлагаас бүрдэнэ.</p>

* - ТУЗ-ийн хараат бус гишүүн

Дотоод хяналтын тогтолцоо

ТУЗ нь Дотоод хяналтын тогтолцоог Аудитын хороо, Эрсдэлийн хороогоор дамжуулан бий болгож, хэрэгжүүлдэг бөгөөд ингэхдээ Олон Улсын Дотоод аудиторуудын институтийн Гурван шугамын загварыг амжилттай нэвтрүүлэн, ашиглаж байна. Уг загвар нь эрсдэл, дотоод хяналт нь ажилтан бүрийн хариуцлага гэдэг зарчимд төвлөрдөг бөгөөд Гүйцэтгэх удирдлага нь нэгдүгээр болон хоёрдугаар шугамыг үр дүнтэй удирдах, ТУЗ нь гуравдугаар шугамын нэгж буюу дотоод болон гадаад аудитаар дамжуулан хяналтыг хэрэгжүүлж, дотоод хяналт, эрсдэлийн удирдлагын тогтолцоог хянаж, сайжруулдаг.



1. Нэгдүгээр шугам

Харилцагчид шууд үйлчилж буй бизнесийн болон түүнд дэмжлэг үзүүлж буй нэгжүүд нь батлагдсан дүрэм, журам, зааврын дагуу давхар болон дараалсан хяналтыг хэрэгжүүлж, өөрсдийн эрсдэлийг удирддаг. Уг зарчмын хүрээнд эрсдэл, хяналт нь ажилтан бүрийн хариуцлага гэдэг ойлголт банкны ажилтнуудад сууж, үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн ажиллаж байна.

2. Хоёрдугаар шугам

Нэгдүгээр шугамын хяналтыг хэрэгжүүлж, эрсдэлийг удирдахад дэмжлэг үзүүлэх үүрэг бүхий бодлогын болон хяналтын нэгжүүд уг хэсэгт хамаарагддаг. Үнэт цаас гаргагч нь өнгөрсөн жилүүдэд бизнес олон улсын стандартыг нэвтрүүлэх, процессын дахин загварчлал хийх, дижиталчлал хийх замаар хоёрдугаар шугамын функцийг хүчирхэгжүүлсэн байна.

3. Гуравдугаар шугам

Нэг болон хоёрдугаар шугамыг үр дүнтэй ажиллаж байгааг дотоод аудитын нэгж нь хараат бус, бие даасан байдлаар баталгаажуулдаг. Мөн эрсдэлд суурилсан, хараат бус, бодит баталгаажуулалт хийх, зөвлөх үйлчилгээ үзүүлэх замаар банк, түүний нэгж, үйл ажиллагааг сайжруулж, үнэ цэнийг нэмэгдүүлдэг.

Түүнчлэн ТУЗ нь дотоод аудитын нэгжийг Олон Улсын стандарт, сайн туршлагын дагуу ажиллах, хараат бус байдлыг хангахад онцгой анхаарч ажилладаг. Энэ нь бүс нутгийн банканд үзүүлсэн зөвлөх үйлчилгээ, гадаад экспертүүдийг аудитын багтаа ажиллуулсан, хөндлөнгийн чанарын баталгаажуулалтыг амжилттай хийлгэсэн зэрэг банкны салбартаа төдийгүй Монгол Улсын хэмжээнд анх удаа хийгдсэн ажлуудаар баталгаажиг байна.

Хөндлөнгийн аудитын тогтолцоо


Үнэт цаас гаргагчийн ТУЗ нь Аудитын хороогоор дамжуулж, хөндлөнгийн аудитын байгууллагыг сонгох, хараат бус байдлыг хангах, аудитын хамрах хүрээг батлах, арга аргачлалыг хянах зэрэг бүхий л үйл ажиллагааг удирддаг. Үнэт цаас гаргагчийн СТОУС дагуу бэлтгэгдсэн санхүүгийн тайлангийн аудитаар ПрайсуотерхаусКуперс Аудит ХХК нь 2019 болон 2021 онуудад, Мэдээлэл аудит ХХК болон ПрайсуотерхаусКупер ХХН-ийн хамтарсан консорциум 2020 онд ажилласан.




2.6 Үнэт цаас гаргагчийн бүтэц, зохион байгуулалт

Үнэт цаас гаргагч нь анх 4 ажилтантайгаар үйл ажиллагааг эхлүүлж байсан бол Үнэт цаасны танилцуулга бэлтгэх өдрийн байдлаар нийт 13 газар, 2,226 ажилтантай болж өргөжин тэлжээ. Үнэт цаас гаргагчийн өдөр тутмын бизнесийн тасралтгүй, хэвийн үйл ажиллагааг Гүйцэтгэх захирал, түүний удирдлагын баг ханган ажилладаг.

Схем 3. Үнэт цаас гаргагчийн бүтэц зохион байгуулалт





Удирдлагын баг



**Гүйцэтгэх захирал
Норихико Като**

Норихико Като нь 1981 онд Токиогийн их сургуулийг эдийн засгийн бакалавр, 1988 онд UCLA-Андерсон их сургуулийг бизнесийн удирдлагын магистрын зэрэгтэй дүүргэсэн.

Ажлын гараагаа Bank of Tokyo (одоогийн MUFG)-оос эхлүүлж, Токио, Нью Йорк, Амстердам, Бахрейнд Байгууллагын банк, Хүний нөөц, Байгууллагын төлөвлөлт зэрэг удирдлагын бүх шатанд ажилласан.

Туршлага

- 2009-2016 онд Хаан банканд Гүйцэтгэх захирлын орлогч, Гүйцэтгэх захирал, Монголын Банкны холбоонд Дэд ерөнхийлөгч
- 2016-2019 онд Камбож улсын Сатапана банкны Гүйцэтгэх захирал, Sathapana Bank PLC арилжааны банкны үүсгэн байгуулагчдын нэг

Ноён Норихико Като нь банк санхүүгийн салбарт 30 гаруй жил ажилласан туршлагатай ба 2019 оноос Голомт банкны Гүйцэтгэх захирлаар томилогдон ажиллаж байна.



**Ерөнхийлөгч
Г.Ганболд**

Г.Ганболд нь 1983 онд ОХУ-ын Эрхүү хотын Улс Ардын Аж Ахуйн дээд сургуулийг Инженер, эдийн засагчийн бакалавр, 2000 онд тус сургуулийг Эдийн засгийн магистрын зэрэгтэй төгссөн.

Туршлага

- 1983-1989 онд МХЗЭ-ийн төв хорооны Референт, Хэлтсийн эрхлэгч, Нарийн бичгийн дарга
- 1987-1997 онд Монголын Оюутны Холбооны Дэд дарга, Монголын Залуучуудын Холбооны Тэргүүлэгч
- 1998-2000 онд Монгол Улсын Засгийн газрын хэрэг эрхлэх газарт Тэргүүн дэд дарга
- 2000-2007 онд Голомт банкны Ерөнхий зохицуулалтын газрын захирал
- 2007-2012 онд Голомт банкны Тэргүүн дэд захирал
- 2012-2015 онд Голомт банкны Гүйцэтгэх захирал
- 2015-2016 онд Монгол Улсын Засгийн газрын хэрэг эрхлэх газарт Дэд дарга

2016 оноос Голомт банкны Ерөнхийлөгчөөр томилогдон ажиллаж байна.





**Гүйцэтгэх захирлын орлогч
бөгөөд Эрсдэл хариуцсан
захирал
Т.Нямсүрэн**

Т.Нямсүрэн нь 2001 онд МУИС-ийн Эдийн засгийн сургуулийг Банкны эдийн засагч мэргэжлээр бакалавр, 2007 онд БНСУ-ын Хандонг Глобал их сургуулийг Бизнесийн удирдлагын магистрын зэрэгтэй дүүргэсэн.

Туршлага

- 2001-2005 онд Голомт банкны Санхүүгийн мэдээлэл хяналтын газрын Эрсдэлийн удирдлагын албанд эдийн засагч
- 2005-2007 онд Санхүүгийн мэдээлэл хяналтын газрын Эрсдэлийн удирдлагын албанд Ахлах эдийн засагч
- 2007-2009 онд Эрсдэлийн удирдлагын газрын Зээлийн эрсдэлийн удирдлагын хэлтэст Ахлах менежер
- 2009-2012 онд Эрсдэлийн удирдлагын газрын Зээлийн эрсдэлийн удирдлагын хэлтсийн захирал
- 2012-2014 онд Зээлийн газрын захирал
- 2014-2016 онд Зээлийн газрын Дэд захирал
- 2016-2020 онд Гүйцэтгэх захирлын орлогч бөгөөд Зээл хариуцсан захирал

2021 оноос Голомт банкны Гүйцэтгэх захирлын орлогч бөгөөд Эрсдэл хариуцсан захирлаар томилогдон ажиллаж байна.



**Гүйцэтгэх захирлын орлогч
бөгөөд Бизнес хариуцсан
захирал
Д.Бадрал**

Д.Бадрал нь 2005 онд Худалдаа Үйлдвэрлэлийн дээд сургуулийг Эдийн засгийн мэдээлэл боловсруулалтын бакалавр, 2009 онд МУИС-ийг Бизнесийн удирдлагын магистрын зэрэгтэй төгссөн.

Туршлага

- 2005-2006 онд Голомт банкны Картын төвийн Харилцагчийн үйлчилгээний хэлтсийн Картын ажилтан, Харилцагчийн үйлчилгээний ажилтан
- 2006-2007 онд Картын төвийн Эрсдэлийн удирдлагын албанд Эдийн засагч, Бүтээгдэхүүн борлуулагч зээлийн эдийн засагч
- 2007-2015 онд Байгууллагын банкны газарт Ажилтан, Харилцааны менежер, Хэлтсийн захирал
- 2015-2020 онд Байгууллагын банкны газрын захирал

2021 оноос Голомт банкны Гүйцэтгэх захирлын орлогч бөгөөд Бизнес хариуцсан захирлаар ажиллаж байна.





**Мэдээлэл технологи
хариуцсан захирал
М.Сайнбилэг**

М.Сайнбилэг нь 2004 онд ШУТИС-ийг Программ хангамжийн инженер, 2010 онд Голланд улсын HAN University of Applied Science их сургуулийг Компьютерийн ухааны магистрын зэрэгтэй төгссөн. Тэрээр АНУ-ын Калифорнийн их сургуульд (UC Беркли) мэргэжил дээшлүүлсэн.

Туршлага

- 2004-2005 онд Старсофт ХХК-д Ахлах программ хөгжүүлэгч
- 2005-2009 онд Голомт банканд Программ хөгжүүлэгч
- 2010 онд Голланд улсын QOSQO-т Өгөгдлийн шинжээч
- 2010-2013 онд Австрали улсын ACER-д Системийн шинжээч, Өгөгдлийн шинжээч, Программ хөгжүүлэгч
- 2013-2016 онд Голомт банканд Системийн хэлтсийн захирал
- 2016-2019 онд Мэдээллийн технологийн газрын захирал

2019 оноос Голомт банкны Мэдээллийн технологи хариуцсан захирлаар томилогдон ажиллаж байна.



**Санхүү удирдлагын газрын
захирал
С.Мөнхтуяа**

С.Мөнхтуяа нь 2000 онд СЭЗДС-ийг Санхүүч, зээлийн эдийн засагч мэргэжлээр бакалавр, 2005 онд БНСУ-ын Хандонг Глобал их сургуулийг Бизнесийн удирдлагын магистр, 2016 онд Виржиниа олон улсын их сургуулийг Олон улсын эдийн засагч мэргэжлээр магистрын зэрэгтэй дүүргэсэн.

Туршлага

- 2000-2002 онд Голомт банкны Картын хэлтэст Нягтлан бодогч
- 2002-2004 онд Санхүүгийн мэдээлэл хяналтын газрын Тайлан бүртгэл санхүүгийн хэлтэст Эдийн засагч
- 2004-2007 онд Санхүүгийн мэдээлэл хяналтын газрын Тайлан бүртгэл санхүүгийн хяналтын хэлтэст Ахлах эдийн засагч
- 2007-2020 онд Санхүү Удирдлагын Газрын Бүртгэлийн бодлого, хяналтын хэлтсийн захирал

2020 оноос Голомт банкны Санхүүгийн удирдлагын газрын захирлаар томилогдон ажиллаж байна.





**Зээлийн газрын захирал
М.Наранхүү**

М.Наранхүү нь 2004 онд МУИС-ийн Эдийн засгийн сургуулийг Бизнесийн удирдлага, менежмент мэргэжлээр төгссөн.

Туршлага

- 2004-2007 онд Анод банкны Салбар, Байгууллагын банк, Эрсдэлийн удирдлагын газруудад зээлийн болон эрсдэл хариуцсан Эдийн засагч
- 2007-2010 онд Тээвэр хөгжлийн банкны Төлөвлөлт судалгааны хэлтэст Ерөнхий мэргэжилтэн, Эрсдэлийн удирдлагын албаны орлогч дарга, Зээлийн газрын захирал
- 2010-2012 онд Голомт банкны Иргэдийн банкны газрын Бүтээгдэхүүн хөгжлийн менежер, Ахлах менежер
- 2012-2016 онд Иргэдийн банкны газрын Бизнесийн удирдлагын хэлтсийн захирал, Жижиг дунд бизнесийн хэлтсийн захирал
- 2013-2016 онд Зээлийн батлан даалтын сан, Батлан даалтын хорооны гишүүн
- 2016-2017 онд Голомт банкны Салбарын бизнес процессыг дахин загварчлах төслийн удирдагч
- 2017-2018 онд Голомт банкны Төвлөрсөн үйлчилгээний төвийн захирал
- 2018-2021 онд Бизнес процесс менежментийн газрын захирал

2021 оноос Голомт банкны Зээлийн Газрын захирлаар томилогдон ажиллаж байна.



**Эрсдэлийн удирдлагын
газрын захирал**

Т.Отгон нь 2003 онд МУИС-ийн Бизнесийн удирдлагын магистр, 2009 онд ХУИС-ийг Англи хэлний орчуулагч мэргэжлээр тус тус төгссөн.

Туршлага

- 2001-2006 онд АБТС ББСБ-т Ерөнхий нягтлан бодогч, Гүйцэтгэх захирал
- 2006-2008 онд Голомт банкны Зээлийн газрын ААН-ийн зээлийн хэлтсийн зээлийн эдийн засагч
- 2008-2012 онд Байгууллагын банкны газрын Төслийн санхүүжилтийн хэлтсийн захирал
- 2014-2020 онд Байгууллагын банкны газрын Бизнес хамтын ажиллагааны хэлтсийн захирал

2020 оноос Голомт банкны Эрсдэлийн удирдлагын газрын захирлаар томилогдон ажиллаж байна.





**Байгууллагын банкны газрын
захирал**

З.Мягмардорж

З.Мягмардорж нь 2007 онд ХУИС-ийг Бизнесийн удирдлага санхүү, хятад хэлний мэргэжлээр дүүргэсэн.

Туршлага

- 2007-2012 онд Голомт банканд Москва салбарын Харилцагчийн зөвлөх, Харилцааны менежер, Харилцааны ахлах менежер
- 2012-2015 онд Байгууллагын банкны газарт Бизнес хөгжлийн менежер
- 2015-2021 онд Байгууллагын банкны газрын Байгууллагын хэлтэс, Үйлдвэр худалдааны хэлтсийн захирал

2021 оноос Голомт банкны Байгууллагын банкны газрын захирлаар томилогдон ажиллаж байна.



**Иргэдийн банкны газрын
захирал**

Ц.Байгалмаа

Ц.Байгалмаа нь 2002 онд СЭЗДС-ийг бизнесийн удирдлагын бакалавр, АНУ-ын Миннесота бизнесийн сургуулийг бизнесийн удирдлагын магистр зэрэгтэй тус тус дүүргэсэн.

Туршлага

- 2002 онд Монгол Шуудан банканд Нягтлан бодогч
- 2003-2004 онд Голомт банканд Зээлийн эдийн засагч
- 2004-2007 онд Салбар нэгжийн удирдлагын хэлтэст Эдийн засагч
- 2007-2012 онд Бүтээгдэхүүн хөгжлийн хэлтсийн захирал
- 2012-2014 онд Банкны үндсэн систем төслийн нэгжийн менежер
- 2014-2015 онд Бизнес хөгжлийн газрын Иргэдийн бизнесийн хэлтсийн захирал
- 2017-2018 онд Инновацийн хэлтсийн захирал
- 2018-2019 онд Дижитал банкны газрын Дижитал банкны хэлтсийн захирал
- 2019-2020 онд Иргэд, жижиг дунд банкны газрын захирал

2021 оноос Голомт банкны Иргэдийн банкны газрын захирлаар томилогдон ажиллаж байна.





**Нөөцийн удирдлагын газрын
захирал
Э.Төрболд**

Э.Төрболд нь 2012 онд Япон улсын Киотогийн их сургуулийг Эдийн засагч мэргэжлээр бакалавр, 2014 онд Токиогийн их сургуулийг Санхүүгийн Инженерчлэл мэргэжлээр магистрын зэрэгтэй төгссөн.

Туршлага

- 2014-2016 онд Худалдаа хөгжлийн банкны Токиогийн төлөөлөгчийн газар болон Олон Улсын Банкны газарт Менежер
- 2016-2018 онд Худалдаа хөгжлийн банкны Хөрөнгө зохицуулалтын газарт Дилер
- 2018-2020 онд Япон улсын Софтбанк группийн хөрөнгө оруулалттай Клин Энержи Ази ХХК-д Санхүү эрхэлсэн захирал
- 2020-2021 онд Голомт банкны Нөөцийн удирдлагын газрын Актив пассивын удирдлагын хэлтсийн захирал

2021 оноос Голомт банкны Нөөцийн Удирдлагын Газрын захирлаар томилогдон ажиллаж байна.



**Хүний нөөцийн удирдлагын
газрын захирал
Г.Уянга**

Г.Уянга нь 2001 онд МУИС-ийн Эдийн засгийн сургуулийг Эдийн засаг, бизнесийн удирдлагын бакалавр, 2005 онд Удирдлагын академийг Бизнесийн удирдлагын магистрын зэрэгтэй дүүргэсэн. Англи, БНСУ, Сингапур, БНХАУ, Фижи зэрэг 10 гаруй оронд сургалт, судалгааны чиглэлээр суралцсан.

Туршлага

- 2007-2012 онд Харилцаа холбооны зохицуулах хороонд Хүний нөөцийн мэргэжилтэн
- 2015-2018 онд АПУ Трейдинг ХХК-д Хүний нөөц хөгжлийн газрын дарга, Үндэсний хөгжлийн хүрээлэн, Стратеги судалгааны хүрээлэн зэрэг байгууллагуудад Хүний нөөцийн зөвлөх
- 2018 онд Голомт банкны Хүний нөөцийн хэлтсийн захирал

2019 оноос Голомт банкны Хүний нөөцийн удирдлагын газрын захирлаар томилогдон ажиллаж байна.





**Маркетинг, олон нийттэй
харилцах газрын захирал
Н.Очирхуяг**

Н.Очирхуяг нь 2004 онд МУИС-ийн Эдийн засгийн сургуулийг Бизнесийн удирдлага, маркетингийн мэргэжлээр бакалавр, 2016 онд АНУ-ын Globe University Minneapolis их сургуулийг Бизнесийн удирдлагын магистрын зэрэгтэй төгссөн.

Туршлага

- 2004-2005 онд Зоос банкны Картын төвийн ахлах нягтлан бодогч
- 2006-2008 онд Жи Мобайл компанийн Борлуулалтын хэлтсийн захирал
- 2008-2014 онд Голомт банкны Маркетингийн хэлтсийн ахлах менежер, Захирал
- 2017 онд EBRD-MonSeff төслийн Маркетингийн зөвлөх
- 2017-2019 онд Голомт банкны Branchless Bank төслийн удирдагч
- 2019-2021 онд Маркетингийн хэлтсийн захирал

2021 оноос Голомт банкны Маркетинг, олон нийттэй харилцах газрын захирлаар ажиллаж байна.



**Бүртгэл тооцооны газрын
захирал
Ё.Пүрэвбат**

Ё.Пүрэвбат нь 2003 онд МУИС-ийн Эдийн засгийн сургуулийг Нягтлан бодогч мэргэжлээр дүүргэсэн.

Туршлага

- 2003-2004 онд Голомт банкны Тооцооны хоёрдугаар төвд Нягтлан бодогч
- 2004-2006 онд Дотоод Хяналтын хэлтэст Хянан шалгагч
- 2006-2007 онд Үйлчилгээ харилцагчийн газарт Ахлах нягтлан бодогч
- 2007 онд Дотоод Хяналтын хэлтэст Хянан шалгагч
- 2007-2008 онд Тооцооны 22-р төвийн эрхлэгч
- 2008-2012 онд VIII салбарын захирал

2012 оноос Голомт банкны Бүртгэл тооцооны газрын захирлаар томилогдон ажиллаж байна.





**Мэдээлэл технологийн
газрын захирал
О.Батцэнгэл**

О.Батцэнгэл нь 2011 онд ШУТИС-ийн ХоМТС-ийг Мэдээллийн сүлжээний инженер мэргэжлээр сурч төгссөн.

Туршлага

- 2011-2016 онд Голомт банкны Мэдээллийн технологийн газрын Системийн хэлтэст систем Администратор
- 2016-2018 онд Мэдээллийн аюулгүй байдлын хэлтэст Мэдээллийн аюулгүй байдлын шинжээч, Ахлах ажилтан, Хэлтсийн захирал

2019 оноос Голомт банкны Мэдээллийн технологийн газрын захирлаар томилогдон ажиллаж байна.



**Захиргааны газрын захирал
Х.Пүрэвдорж**

Х.Пүрэвдорж нь 2002 онд УБ Эрдэм дээд сургуулийг Банкны эдийн засагч мэргэжлээр бакалавр, 2010 онд Япон улсын Рицүмэйкан их сургуулийг Эдийн засгийн ухааны магистрын зэрэг, 2018 онд Удирдлагын академийг Бизнесийн удирдлагаар төгссөн.

Туршлага

- 2011-2015 онд Голомт банкны Дотоод аудитын газарт Аудитор
- 2015-2016 онд Захиргааны газрын Санхүү аж ахуйн хэлтэст Ахлах менежер
- 2016-2019 онд Захиргааны газрын Санхүү аж ахуйн хэлтсийн захирал

2019 оноос Голомт банкны Захиргааны газрын захирлаар томилогдон ажиллаж байна.





**Бизнес процесс
менежментийн газрын
захирал
А.Нямсүрэн**

А.Нямсүрэн нь 2006 онд МУИС-ийн Эдийн засгийн сургуулийг Банк санхүүгийн мэргэжлээр бакалаврын зэрэгтэй төгссөн.

Туршлага

- 2006-2007 онд Голомт банкны Картын төвийн Эрсдэлийн удирдлагын албанд Эдийн засагч
- 2007-2008 онд Нэгдүгээр салбарын Зээлийн ажилтан
- 2008-2011 онд Төв салбарын Ахлах зээлийн ажилтан
- 2011-2016 онд Төв бизнес төвийн захирал
- 2016-2021 онд Зээлийн төв бизнес төвийн захирал

2021 оноос Голомт банкны Бизнес процесс менежментийн газрын захирлаар томилогдон ажиллаж байна.

Бүтэц зохион байгуулалт

Үнэт цаас гаргагч нь нийт 13 газар, 50 гаруй хэлтэстэйгээр өдөр тутмын үйл ажиллагааг явуулж байна. Үүнд:



Нөөцийн удирдлагын газар

Нөөцийн удирдлагын газар нь Банкны актив, пассивын бодлого, эрсдэлийн удирдлагын стратеги бодлогыг хэрэгжүүлэх, банкны төлбөр түргэн гүйцэтгэх чадвар, нөөцийн үзүүлэлт, шаардлагыг өдөр тутамд ханган ажилладаг.

Санхүүгийн удирдлагын газар

Санхүүгийн удирдлагын газар нь Банкны нэгдсэн стратегийн зорилтыг хүрээнд санхүүгийн зорилт, төлөвлөгөө, төсвийг тодорхойлон боловсруулах, гүйцэтгэлийг хянах, банкнаас баримтлах нягтлан бодох бүртгэлийн бодлогыг боловсруулж, түүнд тавих хяналтыг гүйцэтгэх, дотоод гадаад хэрэглэгчдийг санхүүгийн бодит үнэн зөв мэдээлэл, судалгаагаар хангах, банкны бүтээгдэхүүн үйлчилгээ, хөрөнгө оруулалтын үр өгөөжийг тооцдог.

Зээлийн газар

Зээлийн газар нь Банкны зээлийн үйл ажиллагааны бодлого, зохицуулалт болон өдөр тутмын удирдлага, зохион байгуулалтаар хангах, гүйцэтгэлийн чанарыг хянаж, зээлийн багцын чанар, үр ашгийг зорилтод түвшинд хангах зорилготой.

Бизнес процесс менежментийн газар

Бизнес процесс менежментийн газар нь Банкны бизнес процессыг үнэ цэнтэй, үр ашигтай байхаар газар, нэгжүүдийн процессын уялдаа холбоог сайжруулах, хөгжүүлэх, загварчлах хамтран хэрэгжүүлэх, хяналт тавих мөн банкны зээлийн үйл ажиллагааг дэмжих зорилготой.

Дижитал банкны газар

Дижитал банкны газар нь Банкны дижитал шилжилтийг нэгдсэн бодлого, стратегиар ханган удирдах, дижитал бизнес, картын бизнес түүнтэй холбоотой бүтээгдэхүүн, үйлчилгээг хөгжүүлэх, сайжруулах, зах зээлд нэвтрүүлэх, борлуулах, харилцагчийн ашиглаж буй дижитал, онлайн болон электрон сувгийн менежментийг нэгдсэн бодлого, стратегиар ханган удирдах, сувгуудаар хийгдэж буй үйл ажиллагааг өргөжүүлэх, үйлчилгээг харилцагч төвтэй хүргэдэг.

Иргэдийн банкны газар

Иргэдийн банкны газар нь Банкны салбар тооцооны төвүүдийн үйл ажиллагааг нэгдсэн бодлогоор удирдах, харилцагчдад банкны бүтээгдэхүүн, үйлчилгээг хүргэх,



харилцагчдын дуу хоолойг түргэн шуурхай, тасралтгүй хүлээн авч шийдвэрлэхтэй холбоотой үйл ажиллагааг хэрэгжүүлдэг.

Байгууллагын банкны газар

Байгууллагын банкны газар нь байгууллагын болон жижиг дунд бизнес эрхлэгчдийн эрэлт хэрэгцээнд тулгуурласан банкны бүх төрлийн бүтээгдэхүүн үйлчилгээг үзүүлдэг.

Хүний нөөцийн удирдлагын газар

Хүний нөөцийн удирдлагын газар нь Банкны хүний нөөцийн удирдлагын нэгдсэн бодлого, стратеги, талант менежмент, сургалт хөгжлийн үйл ажиллагааг олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн стандартын түвшинд хэрэгжүүлдэг.

Эрсдэлийн удирдлагын газар

Эрсдэлийн удирдлагын газар нь Банкны эрсдэл даах чадварын хүрээнд стратегийн зорилго, бизнес төлөвлөгөөнд хүрэхийн тулд хүлээн зөвшөөрөх эрсдэлийн төрөл, хэм хэмжээ, орчин нөхцөлөөс хамаарсан эрсдэлийн нөлөөллийг удирдах замаар банкны ашигт ажиллагаа, өгөөжийг хамгийн өндөр түвшинд хүргэдэг.

Мэдээллийн технологийн газар

Мэдээллийн технологийн газар нь Банкны бизнесийн болон үйл ажиллагааны шаардлагад нийцсэн, шинэ боломжийг эрэлхийлсэн, хэрэглэгчийн туршлага, технологийн судалгаа, хөгжүүлэлт бүхий МТ-ийн цогц үйлчилгээ нийлүүлэх, програм хөгжүүлэх, нийлүүлэх болон төслийн удирдлага, чанарын удирдлагын тогтолцоо хэрэгжүүлэх замаар банкны систем, дагалдах тоног төхөөрөмж, дэд бүтцийн найдвартай хэвийн ажиллагааг хангадаг.

Бүртгэл тооцооны газар

Бүртгэл тооцооны газар нь Банкны гадаад болон дотоодын банк хоорондын төлбөр тооцоо, картын төлбөр тооцоо, зээлийн төлбөр тооцоог хийж гүйцэтгэх, хяналт тавих, бэлэн мөнгөний нөөцийг хадгалах, бүртгэлийг хөтлөх, салбар нэгжийг бэлэн мөнгө, валютаар хангах, салбарын бүртгэлийн үйл ажиллагаанд баримтын болон зайны хяналтыг хийдэг.



Маркетинг, олон нийттэй харилцах газар

Маркетинг, олон нийттэй харилцах газар нь Банкны маркетинг, олон нийттэй харилцах бодлого стратегийг тодорхойлох, удирдан зохион байгуулж хэрэгжүүлэх, иргэд рүү чиглэсэн бүтээгдэхүүн үйлчилгээний менежментийг нэгдсэн бодлого, стратегиар ханган, бүтээгдэхүүн үйлчилгээг хөгжүүлэх, шинэчлэх, зах зээлд нэвтрүүлэх, идэвхжүүлэх зорилготой.

Захиргааны газар

Захиргааны газар нь Банкны санхүү, аж ахуйн үйл ажиллагааг нягтлан бодох бүртгэлийг стандартын дагуу хөтлөх, хяналт тавих, салбар нэгжийн бизнесийн хэвийн тасралтгүй үйл ажиллагааг дэмжин ажиллах, хөрөнгийн болон бусад худалдан авалтын процессыг удирдан зохион байгуулж, гүйцэтгэж, хяналт тавьдаг.

2.7 Эрх бүхий албан тушаалтан, эзэмшиж буй хувьцааны тоо хэмжээ

Үнэт цаас гаргагчийн дүрмийн 12.4 дэх зүйлд банкны эрх бүхий албан тушаалтан нь ТУЗ-ийн дарга, гишүүн, нарийн бичгийн дарга, Гүйцэтгэх захирал, Ерөнхийлөгч, Гүйцэтгэх захирлын орлогчид, газрын захирлууд байхаар заагдсан. Үнэт цаасны танилцуулга бэлтгэх өдрийн байдлаар Үнэт цаас гаргагчийн эрх бүхий албан тушаалтнууд дараах байдалтай байна. Үүнд:

Хүснэгт 14. Эрх бүхий албан тушаалтны мэдээлэл

№	Албан тушаал	Овог нэр
1	ТУЗ-ийн дарга	Ч.Мөнхцэцэг
2	ТУЗ-ийн гишүүн	Урс.Э.Шварценбах
3	ТУЗ-ийн гишүүн	Д.Мөнхтөр
4	ТУЗ-ийн гишүүн	Ж.Үнэнбат
5	ТУЗ-ийн гишүүн	Л.Болормаа
6	ТУЗ-ийн гишүүн	О.Ганжолоо
7	ТУЗ-ийн хараат бус гишүүн	Жэймс Б.Двайер
8	ТУЗ-ийн хараат бус гишүүн	А.Лопез Абелло
9	ТУЗ-ийн хараат бус гишүүн	Александр Пикер
10	ТУЗНБ-ийн дарга	З.Солонго
11	Гүйцэтгэх захирал	Норихико Като
12	Ерөнхийлөгч	Г.Ганболд
13	Гүйцэтгэх захирлын орлогч	Т.Нямсүрэн
14	Гүйцэтгэх захирлын орлогч	Д.Бадрал
15	Мэдээлэл технологи хариуцсан захирал	М.Сайнбилэг



16	Аудит хариуцсан захирал	А.Одонбаатар
17	Газрын захирал	С.Мөнхтуяа
18	Газрын захирал	М.Наранхүү
19	Газрын захирал	Т.Отгон
20	Газрын захирал	Ц.Байгалмаа
21	Газрын захирал	З.Мягмардорж
22	Газрын захирал	Г.Уянга
23	Газрын захирал	Н.Очирхуяг
24	Газрын захирал	Ё.Пүрэвбат
25	Газрын захирал	Х.Пүрэвдорж
26	Газрын захирал	О.Батцэнгэл
27	Газрын захирал	А.Нямсүрэн

Эх сурвалж: Үнэт цаас гаргагчийн мэдээлэл

Үнэт цаас гаргагчийн ТУЗ-ийн гишүүн Д.Мөнхтөр нь 88,000 ширхэг, Гүйцэтгэх захирлын орлогч Д.Бадрал нь 54,400 ширхэг, Бүртгэл тооцооны газрын захирал Ё.Пүрэвбат нь 40,000 ширхэг хувьцааг эзэмшдэг.

2.8 Үнэт цаас гаргагчийн хэлцлүүд

Их хэмжээний хэлцэл

Үнэт цаас гаргагчийн ирүүлсэн бичиг баримтаас үзэхэд 2018 оны 1-р сарын 1-нээс 2021 оны 12 дугаар сарын 31 хооронд их хэмжээний хэлцэл байгуулаагүй байна.

Сонирхлын зөрчилтэй хэлцэл

2021 оны 12-р сарын 31-ны өдрөөр гаргасан Голомт банкны холбогдох этгээдийн мэдээ, тайланд тусгагдсанаар Үнэт цаас гаргагч нь нийт 74 этгээдийг холбогдох этгээдээр тогтоон Монголбанканд тайлагнажээ.

Үнэт цаас гаргагч нь 2018-2021 онд байгуулсан нийт 98 ширхэг сонирхлын зөрчилтэй хэлцлийн талаар мэдээлэл ирүүлсэн байна. Тодруулбал, эдгээр нь бүгд зээлийн эсхүл зээлтэй адилтгах банкны бусад үйлчилгээтэй холбоотой гэрээ байна. Үүнээс хамгийн их дүнтэй нь банкны нэгдлийн оролцогч компаниудтай байгуулсан гэрээ байх ба дараах 9 компанитай давхардсан тоогоор нийт 31 ширхэг хэлцэл байгуулсан байна. Үүнд:

- Бодь Интернэшнл ХХК;
- Бодь Пропертиз ХХК;
- Медиа Боловсрол Суваг ХХК;
- Мөнгөн Гүүр Хоспитал ХХК;



- Өндөр Улаан Трэвел ХХК;
- Хүннү Эйр ХХК;
- Цэцэнс Майнинг Энд Энержи ХХК;
- Цэцэнс Холдинг ХХК;
- Голомт файнэншил групп ХХК

Үнэт цаас гаргагчийн эрх бүхий албан тушаалтнууд болон тэдгээрийн нэгдмэл сонирхолтой этгээдүүд буюу нийт 32 иргэн, 2 компанитай байгуулсан давхардсан тоогоор 67 гэрээ байна. Үнэт цаас гаргагч нь зээлийн үйл ажиллагаан дахь сонирхлын зөрчлийг шийдвэрлэхдээ хууль, тогтоомжид заасан журмаас гадна дараах дотоод дүрэм журмуудыг батлан хэрэгжүүлж байна. Үүнд:

- Сонирхлын зөрчилтэй асуудлыг шийдвэрлэх журам;
- Зээлийн бодлого;
- Зээлийн хорооны дүрэм;
- Зээлийн дэд хорооны дүрэм.

Хууль зүйн дүгнэлтийн 8.2 дахь хэсэгт заасны дагуу сонирхлын зөрчилтэй хэлцлүүд нь хууль тогтоомжийг зөрчөөгүй байна гэж дүгнэжээ.

Хувь нийлүүлсэн хөрөнгийн тав болон түүнээс дээш хувьтай тэнцэх хэмжээний үнийн дүн бүхий үүрэг хүлээсэн гэрээ хэлцэл

Үнэт цаас гаргагчийн байгуулсан хувь нийлүүлсэн хөрөнгийн 5 болон түүнээс дээш хувьтай тэнцэх хэмжээний үнийн дүн бүхий бусдын өмнө хүлээсэн гэрээ 10 ширхэг байх бөгөөд тэдгээр гэрээ нь бүгд дамжуулан зээлдүүлэх үйл ажиллагаатай холбоотой байна.

Тэдгээр гэрээ нь их хэмжээний хэлцэл болон сонирхлын зөрчилтэй хэлцэлд хамаарахгүй байх ба Хууль зүйн дүгнэлтэд Үнэт цаас гаргагч нь гэрээний хэрэгжилтийг зөрчөөгүй тухай тусгажээ.

Хүснэгт 15. ХНХ-ийн тав болон түүнээс дээш хувьтай тэнцэх хэмжээний хэлцлийн мэдээлэл

№	Гэрээний нөгөө тал	Гэрээ, хэлцэл	Гэрээний огноо, дугаар	Гэрээгээр хүлээсэн үүрэг	Хэрэгжилт
1.	Монголбанк /Алт/	Урт хугацаат санхүүжилтийн ерөнхий гэрээ	2021.04.12 0520/784, 0520/785	Голомт банк нь Монголбанкнаас гаргасан жагсаалтын дагуу алтны салбарын аж ахуйн нэгжүүдэд бизнесийн үйл ажиллагаа өргөжүүлэхэд	Гэрээний хүрээнд 2021 оны 12-р сарын 31-ны байдлаар зээлийн үлдэгдэл 56.9 тэрбум төгрөг



	Урьдчилгаа төлбөрийн санхүүжилтийн ерөнхий гэрээ		дэмжлэг үзүүлэх зорилгоор 3 хүртэл жилийн хугацаатай, жилийн 3% (эргэлт), бодлогын хүү+3% (хөрөнгө оруулалт)-н хүүтэй зээлийг дамжуулан зээлдүүлэх, үүнтэй холбоотой авсан эх үүсвэрийг жилийн 3%-ийн зардалтайгаар хуваарийн дагуу сар бүр төлөх үүрэг хүлээн ажиллаж байна.	бөгөөд зээл эргэн төлөх хугацаа 3 жил хүртэл	
2.	Сангийн яам, Хүнс хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн яам /JICA/	Эрх шилжүүлэх гэрээ	2020.08.24 103,200824/ 03/300	Голомт банк нь Жижиг дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх, байгаль орчныг хамгаалах үндсэн зориулалтын хүрээнд 10 жилийн хугацаатай, жилийн 7%-ийн хүүтэй хоёр үе шаттай төслийн зээлийг дамжуулан зээлдүүлэх, үүнтэй холбоотой авсан эх үүсвэрийг хуваарийн дагуу жилийн 3%-ийн зардалтайгаар хуваарийн дагуу сар бүр төлөх үүрэг хүлээж байгаа.	Гэрээний хүрээнд 2021 оны 12-р сарын 31-ны байдлаар зээлийн үлдэгдэл 6.03 тэрбум төгрөг бөгөөд зээл эргэн төлөх хугацаа 2031 оны 1 сар хүртэл
3.	Worldbusiness capital, INC	Зээлийн гэрээ	2017.09.14 & 2021.06.21	АНУ-ын Засгийн газрын харъяа Гадаадын хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтын агентлаг болох Overseas Private Investment Corporation (DFC)-ын баталгаатай, Хөдөө аж ахуйн салбар, жижиг дунд бизнес ("ЖДБ") эрхлэгчдийг дэмжих 15 сая ам.долларын дамжуулан зээлийн гэрээг АНУ-ын World Business Capital Inc-тай байгуулж 2025 оны 9 дүгээр сар хүртэл дамжуулан зээлдүүлэх	Гэрээний хүрээнд 2021 оны 12 дүгээр сарын 31-ний байдлаар зээлийн үлдэгдэл 30.30 тэрбум төгрөг /10,636,897 ам.доллар/ бөгөөд зээл эргэн төлөх хугацаа 2025 оны 9 сар хүртэл



				мөн улирал бүр хуваарийн дагуу эргэн төлөх үүрэг хүлээн ажиллаж байна.	
4.	Сангийн яам, Хүнс хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн яам	Дамжуулан зээлдүүлэх гэрээ	2016.05.09 76	Голомт банк нь ХАА-н салбарын Жижиг, дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх зорилтын хүрээнд 7 жилийн хугацаатай, жилийн 8 хувийн хүүтэй хоёр үе шаттай төслийн зээлийг дамжуулан зээлдүүлэх, үүнтэй холбоотой авсан эх үүсвэрийг хуваарийн дагуу жилийн 4.5 хувийн зардалтайгаар хуваарийн дагуу сар бүр төлөх үүрэг хүлээж байгаа.	Гэрээний хүрээнд 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар зээлийн үлдэгдэл 28.40 тэрбум төгрөг бөгөөд зээл эргэн төлөх хугацаа 2028 оны 11 сар хүртэл
5.	Сангийн яам, Хүнс хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн яам	Эрүүл мэндээ хамгаалах ХАА-н дэд салбар хөтөлбөрийн зээл	2021.04.23 240423/06-258	Голомт банк нь ХАА-н салбарын бизнес эрхлэгчдэд ноолуур, ноос, хаврын тариалалт, арьс шир бэлтгэх, худалдан авахад нь зориулж 1 жилийн хугацаатай, жилийн 3 хувийн хүүтэй зээлийг олгох, үүнтэй холбоотойгоор Засгийн газраас 7.65 хувийн хүүгийн дэмжлэгийг сар бүр нэхэмжилж авах эрхтэй ажиллаж байна.	Гэрээний хүрээнд 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар зээлийн үлдэгдэл 31.92 тэрбум төгрөг бөгөөд зээл эргэн төлөх хугацаа 2022 оны 9 сар хүртэл
6.	Сангийн яам, Хүнс хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн яам	Эрүүл мэндээ хамгаалах, эдийн засгаа сэргээх Ажлын байр дэмжих зээл	2021.05.11 74/210511/ 05-295 0521/87-02	Голомт банк нь ЖДБ эрхлэгчдийн бизнесийн үйл ажиллагааг хэвийн явуулахад нь зориулж 3 жилийн хугацаатай, жилийн 3 хувийн хүүтэй зээлийг олгож, үүнтэй холбоотойгоор Засгийн газраас 6-7 хувийн хүүгийн дэмжлэгийг сар бүр нэхэмжилж авах эрхтэй ажиллаж байна	Гэрээний хүрээнд 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар зээлийн үлдэгдэл 240.25 тэрбум төгрөг бөгөөд зээл эргэн төлөх хугацаа 3 жил хүртэл




7.	Enabling Capital /EMF microfinance fund AGmVК /	Зээлийн гэрээ	2020.09.04 & 2021.06.17	Голомт банк (зээлдэгч) нь нийт 15 сая.ам долларын (1 удаагийн санхүүжилт 5 сая.ам доллар) зээлийг жилийн 5 хувийн хүүтэйгээр, 3 жилийн хугацаатай, бичил санхүүгийн зээлийн багцыг өргөжүүлэх зорилготойгоор EMF microfinance fund AGmVК (зээлдүүлэгч)-ээс авсан. Зээлдэгч нь зээлийн хүүг хагас жил тутамд төлөх ба үндсэн төлбөрийг 2022 оны 12 дугаар сараас эхлүүлэн хагас жил тутамд төлөх үүрэг хүлээсэн.	Гэрээний хүрээнд 2021 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар зээлийн үлдэгдэл 28.6 тэрбум төгрөг бөгөөд зээл эргэн төлөх хугацаа 2024 оны 6 сар хүртэл. Зээлийн эргэн төлөгдөж дуусах хугацаа: 1 Tranche – 2023 2 Tranche – 2024
8.	JPMORGAN CHASE BANK, N.A., HONG KONG BRANCH	USD 100 million Term Loan facility	2018.09.27 0101821-0000011 НК:2558648 7.4	Голомт банк (зээлдэгч) нь урт хугацааны своп хэлцэл хийхтэй холбогдуулан үүгээр хязгаарлагдахгүй, байгууллагын хүрээнд зээлсэн бүх дүнг аж ахуйн нэгжийн ерөнхий зориулалтаар ашиглах зорилготойгоор JPMORGAN CHASE BANK, N.A., HONG KONG BRANCH (зээлдүүлэгч)-ээс 2018 оны 9 дүгээр сарын 27-ны өдөр 100 сая.ам долларын зээлийг жилийн 2.2 хувийн хүүтэйгээр гэрээ байгуулсан байна.	Гэрээ хэрэгжсэн ба зээлийн эргэн төлөгдөх хугацаа 2025 он. Гэрээний хүрээнд 2021 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар зээлийн үлдэгдэл 557 тэрбум төгрөг
9.	Micro Small Medium Enterprises Bonds SA (Servicer: Symbiotics SA)	Зээлийн гэрээ	2021.12.21 Term loan facility agreement	Голомт банк (зээлдэгч) нь нийт 8 + 7.75 = 15.75 сая.ам долларын зээлийг жилийн 5 хувийн хүүтэйгээр, 2.5 жилийн хугацаатай, бичил санхүүгийн зээлийн багцыг өргөжүүлэх зорилготойгоор Micro Small Medium Enterprises	Гэрээний хүрээнд 2021 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар зээлийн үлдэгдэл 22.6 тэрбум төгрөг бөгөөд зээл эргэн төлөх хугацаа 2024 оны 12 сар хүртэл



				Bonds SA (зээлдүүлэгч)-ээс авсан. Зээлдэгч нь зээлийн хүүг хагас жил тутамд төлөх ба үндсэн төлбөрийг зээлийн эргэн төлөгдөж дуусах өдөр төлнө төлөх үүрэг хүлээсэн	
10	International Investment Bank	Зээлийн гэрээ	2021.06.21 Facility Agreement	Голомт банк (зээлдэгч) нь нийт 10 сая ам долларын зээлийг жилийн LIBOR6M + 5 хувийн хүүтэйгээр, 5 жилийн хугацаатай, бичил санхүүгийн зээлийн багцыг өргөжүүлэх зорилготойгоор International Investment Bank (зээлдүүлэгч)-ээс авсан. Зээлдэгч нь зээлийн хүүг хагас жил тутамд төлөх ба үндсэн төлбөрийг зээлийн эргэн төлөгдөж дуусах өдөр төлнө төлөх үүрэг хүлээсэн	Гэрээний хүрээнд 2021 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар зээлийн үлдэгдэл 33.5 тэрбум төгрөг бөгөөд зээл эргэн төлөх хугацаа 2026 оны 06 сар хүртэл.

Үнэт цаас гаргагчийн **Хууль зүйн дүгнэлт**-ийн дэлгэрэнгүйг Хавсралтаас үзнэ үү.





ГОЛОМТ БАНК
Сайн сайхныг санхүүжүүлнэ

ГУРАВ.

ҮНЭТ ЦААС
ГАРГАГЧИЙН ҮЙЛ
АЖИЛЛАГААНЫ
ТУХАЙ

"ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК" ХХК
InvesCore
CAPITAL
6317839 ±1119277129
УЛААНБААТАР ХОТ

- 71 -

МОНГОЛ УАС
ГОЛОМТ БАНК
ТТГ 075 ± 2075377
ГОЛОМТ БАНК

3 ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТУХАЙ

3.1 Банкны үйл ажиллагаа, онцлог

Банк нь хувьцаа эзэмшигчдийн хувь нийлүүлсэн хөрөнгө, харилцагчдын мөнгөн хадгаламжийг өөрийн нэрийн өмнөөс бусдад зээлдүүлэх, төлбөр тооцоо хийх зэрэг санхүүгийн зуучлалын үйл ажиллагаа явуулдаг ашгийн төлөө байгууллага бөгөөд эдийн засагт үүссэн хуримтлалыг мөнгөн хөрөнгийн дутагдалтай хэсэгт хуваарилах замаар эдийн засгийн эргэцийг хэвийн явагдахад чухал үүрэг гүйцэтгэж, оролцогч талуудын зардал, цаг хугацааг хэмнэж, эрсдэлийг бууруулах боломжийг олгон, санхүүгийн тогтвортой байдлыг хангадаг нийгмийн чухал институт юм.

Монгол Улсын арилжааны банкууд нь Төв банк буюу Монголбанкнаас олгогдсон тусгай зөвшөөрөл, хяналт дор үйл ажиллагаа явуулдаг. Банк нь олон төрлийн үйл ажиллагаа эрхэлдэг ч үндсэн чиг үүрэг нь харилцагчдаас эх үүсвэр буюу харилцах, хадгаламж татаж, эх үүсвэр шаардлагатай хэсэгт зээл болгон олгох юм. Өөрөөр хэлбэл, банкууд харилцах, хадгаламж эзэмшигчид (банканд мөнгө зээлдүүлэгчид) болон зээлдэгчид (банкнаас мөнгө зээлдэгчид)-ийн хооронд зуучлагчийн үүрэг гүйцэтгэдэг. Банк нь зээлийн хүүгээс олсон орлогоос харилцах, хадгаламж эзэмшигчдийн хүүг төлөх бөгөөд тэдгээрийн зөрүү нь банкны орлогын үндсэн эх үүсвэр нь болдог. Тус орлогод банкны үндсэн үйл ажиллагааг хэвийн явуулахад шаардлагатай үйл ажиллагааны зардал, зээлийн эрсдэлийн сан болон банк урт хугацаанд тогтвортой ажиллахад шаардлагатай ашгийг багтаадаг.

Хувь хүн болон бизнесийн байгууллагууд мөнгөн хөрөнгөө удирдахаас гадна өдөр тутамд төлбөр тооцоо хийх, мөнгө шилжүүлэх, орлого хүлээн авах зэрэг олон төрлийн санхүүгийн үйлчилгээ авах хэрэгцээ гардаг бөгөөд Банк нь харилцагчдын эдгээр хэрэгцээ шаардлагад нийцсэн санхүүгийн олон төрлийн бүтээгдэхүүн үйлчилгээг үзүүлж, харилцагчдын мөнгөн хөрөнгийн аюулгүй байдлыг ханган ажилладаг.


1990 оны 8-р сарын 24-ний өдөр Монгол Улсад Сайд Нарын Зөвлөлийн 422 дугаар тогтоолоор Аж ахуйн банк байгуулах болон түүний үйл ажиллагааны нийтлэг дүрмийг батлан мөрдүүлж, улмаар 1991 оны 4-р сард Улсын Бага Хурлаар Банкны тухай хуулийг баталснаар Монгол Улсад хоёр шатлалт банкны тогтолцоо үүсэх суурь тавигдаж, арилжааны 31 банк үүсгэн байгуулагдсан. 2021 оны жилийн эцсийн байдлаар Монгол Улсад нийт 11 арилжааны банк үйл ажиллагаа явуулж байгаагаас төрийн өмчийн (Төрийн банк) нэг банк байна.




Голомт банкны түүхэн товчоон

Схем 4. Үнэт цаас гаргагчийн түүхэн товчоон

**Голомт банкны
ТҮҮХЭН ТОВЧООН**





Голомт банкны ололт амжилтууд

Үнэт цаас гаргагч нь өнгөрсөн 27 жилийн хугацаанд Монгол Улсын банк, санхүүгийн салбарын хөгжлийг түүчээлэн үргэлж шинийг санаачлагч, нэвтрүүлэгч байсаар ирсэн ба санхүүгийн тогтвортой өсөлт, үйл ажиллагааны үзүүлэлтээрээ тэргүүлж дотоод, гадаадын нэр хүндтэй байгууллагуудын шагналын эзнээр тодорсоор ирсэн.

Зураг 2. Голомт банкны ололт, амжилт

 Монгол Улсын Шилдэг Банк 2004, 2009, 2011, 2012, 2014, 2018, 2021	 Монгол Улсын Шилдэг Дижитал Банк 2011, 2013, 2014, 2015, 2019, 2020, 2021	 Монгол улсын шилдэг корпорайт банк 2021	 Монгол Улсын Шилдэг Банк 2011	 Монгол улсын шилдэг иргэдийн банк 2014, 2019
 Хамгийн Инновацилаг Дижитал Банк 2018	 Шилдэг Хамтрагч, Бүтээгдэхүүн Нэвтрүүлэгч Байгууллага 2002, 2003, 2007, 2008	 Шилдэг Инновацитай Бүтээгдэхүүн 2002, 2003, 2005, 2016	 Шилдэг Шинийг Санаачлагч агент 2010, 2012, 2014	 Шилдэг Бүтээгдэхүүн 2019, 2020, 2021
 Гадаад Худалдааны Санхүүжилтийн Шилдэг Хамтрагч Банк 2011, 2018				
 Монгол улсын ТОП-100 ААН 2000, 2003, 2015, 2016, 2020, 2019, 2018, 2017	 Монгол улсын ТОП 5 Банк 2005, 2008, 2010, 2011, 2012	 Оны Онцлох Аж Ахуйн Нэгж 2000, 2012, 2013	 Шилдэг Инноваци Нэвтрүүлэгч Онцлох Энтрепренер 2016	 Нийгмийн хариуцлагыг хэрэгжүүлэгч байгууллага 2008, 2009, 2013, 2014
 Харилцагч төвтэй салбарын бизнес модел нэвтрүүлэх төсөл 2017	 Үндэсний шилдэг татвар төлөгч 2007, 2012, 2015, 2017, 2020	 Шилдэг ажил олгогч 2020	 Хөрөнгө оруулалтын элч 2011	 Шилдэг дижитал үйлчилгээ 2016, 2019
 Шилдэг ажил олгогч байгууллага 2013		 Шилдэг Инноваци 2018		
 "ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК" ХХК InvesCore CAPITAL 6317639 д.т 119277128 УЛААНБААТАР ХОТ		 МОНГОЛ УЛС ГОЛОМТ БАНК ТТГ 02000-2075377 БАНК		

Голомт банкны зээлжих зэрэглэлийн үнэлгээ

Олон улсын нэр хүнд бүхий зээлжих зэрэглэл тогтоогч байгууллагууд болох Мүүдис (Moody's Investors Service), Стандарт энд Пүүрс (S&P Global Ratings) агентлагуудаас Голомт банкны зээлжих зэрэглэл В буюу тогтвортой гэж үнэлсэн байна.

Энэ нь Монгол Улсад үйл ажиллагаа явуулж буй аж ахуй нэгж, байгууллагуудын хувьд хамгийн боломжит өндөр үнэлгээ юм.

Хүснэгт 16. Зээлжих зэрэглэлийн үнэлгээ

Ангилал	"Moody's" үнэлгээ	Ангилал	"S&P" үнэлгээ
Зээлжих зэрэглэлийн үнэлгээ	B3	Зээлжих зэрэглэлийн үнэлгээ	B/Stable/B
Төлөв	Stable	Төлөв	Stable
Эрсдэлийн үнэлгээ-Гадаад валют	B3/NP	Үнэт цаасны үнэлгээ	B
Эрсдэлийн үнэлгээ-Дотоод валют	B2/NP	Хөрвөх чадварын үнэлгээ	B+
Зээлжих чадварын суурь үнэлгээ	B3		

Эх сурвалж: Moody's, S&P

3.2 Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаа, онцлог

Хүртээмжтэй банк

Үнэт цаас гаргагч нь үүсгэн байгуулагдсан цагаасаа хойш банк санхүүгийн салбарт тэргүүлэгчийн байр сууриа бататган харилцагч төвтэй буюу харилцагчдад ойлгомжтой, хүртээмжтэй, түргэн шуурхай үйлчилгээг салбар, тооцооны төв болон интернет банкны үйлчилгээгээр дамжуулан хүргэж байна.

Үнэт цаасны танилцуулга бэлтгэх үеийн байдлаар Үнэт цаас гаргагч нь нийт 77 салбар, 24 хадгаламжийн кассстайгаар үйл ажиллагаа явуулж, харилцагчдын эрэлт хэрэгцээнд нийцсэн бүтээгдэхүүн үйлчилгээг санал болгон зөвлөгөө мэдээллээр ханган ажиллаж байна.

Мөн орон нутгийн иргэдэд банк санхүүгийн бүтээгдэхүүн үйлчилгээг хүргэх, харилцагчдад улам ойртох зорилтын хүрээнд Монгол Улсын 14 аймагт салбар нээн үйлчилгээ үзүүлж байна.

Эдгээрээс 5 аймагт орчин үеийн банкны оффисын барилгыг ашиглалтад оруулсан нь орон нутагт томоохон хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалт болж чадсан бөгөөд



харилцагчид тав тухтай тохилог орчинд банкны үйлчилгээг авах нөхцөлийг бүрдүүлсэн.

Зураг 3. Голомт банкны орон нутгийн салбарууд



Голомт банк нь гадаад харилцагчдад хүрч үйлчлэх зорилгоор 8 салбараар дамжуулан Англи, Орос, Хятад, Япон, Солонгос хэлээр үйлчилж, банкны бүх төрлийн үйлчилгээг хүргэн ажилладаг.

Түүнчлэн Голомт банк нь салбарын өргөжилтийн хүрээнд Монголд анхдагч олон алхмыг хийж, инновацлаг бүтээгдэхүүн үйлчилгээг үзүүлэн банкны салбарыг түүчээлэн ажиллаж байна. Үнэт цаас гаргагчийн санхүүгийн бүтээгдэхүүн үйлчилгээ үзүүлж буй онцлох салбаруудаас дурдвал:

Бизнес төвүүд

Үнэт цаас гаргагч нь 2012 оноос жижиг дунд бизнес эрхлэгчдийг дэмжих, банк санхүүгийн цогц бүтээгдэхүүн үйлчилгээг тэр дундаа бизнесийн зөвлөх үйлчилгээг нэг цэгээс хүргэх зорилгоор Бизнес төвүүдийг бүсчлэн байгуулсан.

Үнэт цаасны танилцуулга бэлтгэх өдрийн байдлаар Улаанбаатар хотод 6 Бизнес төвтэй ба Дархан, Орхон, Өмнөговь аймгууд дахь Бизнес төвүүд нь жижиг дунд бизнес эрхлэгчдэд тусгайлан зориулсан үйлчилгээг үзүүлж байна.



Салбар, тооцооны төв

Голомт банк нь 1995 онд анхны салбараа нээснээс хойш Монгол Улсын 14 аймаг болон Улаанбаатар хотод салбар, тооцооны төвүүдийг нээж, харилцагчдад Дэлхийн жишигт нийцсэн орчин үеийн банк санхүүгийн үйлчилгээг тав тухтай тохилог орчинд үзүүлж байна.

24/7 цагийн үйлчилгээтэй салбар


Үнэт цаас гаргагч нь 1997 онд Монгол Улсад анх удаа 24/7 цагийн үйлчилгээтэй банкны салбарыг нээсэн нь харилцагч цаг хугацаанд баригдалгүйгээр санхүүгийн үйлчилгээг түргэн шуурхай авах боломжийг бүрдүүлсэн. Мөн технологийн дэвшилд тулгуурласан 24 цагийн үйлчилгээтэй Өөртөө үйлчлэх цэгээр дамжуулан бүтээгдэхүүн үйлчилгээг үзүүлж байна.

Homeland орон сууцны төв

Голомт банк нь Homeland орон сууцны төвийг үл хөдлөх хөрөнгийн төслүүдийн өрсөлдөх чадварын үнэлгээг тогтоох, өрсөлдөхүйц төслүүдийг нээн илрүүлж, тэдэнтэй хамтын ажиллагааг өргөжүүлэх, харилцагчдад орон сууцны үйлчилгээтэй холбоотой цогц бүтээгдэхүүн үйлчилгээг хүргэх зорилгоор үүсгэн байгуулсан.

Тус төв нь харилцагчдад үл хөдлөх хөрөнгийн талаар мэдээлэл зөвлөгөө өгөх, орон сууц худалдан авахад мэргэжлийн туслалцаа үзүүлэхээс гадна бизнесийн байгууллагуудтай харилцан ашигтай хамтын ажиллагааг өрнүүлэх боломжийг бүрдүүлдэг.

Зураг 4. Голомт банкны Homeland орон сууцны төв



Хувийн банкны салбар

Тусгайлан бэлтгэгдсэн, мэргэшсэн банкируудаас бүрдсэн Хувийн банкны салбар нь вип харилцагчдын хэрэгцээ шаардлагад нийцсэн бүтээгдэхүүн үйлчилгээг мэргэжлийн өндөр түвшинд хүргэж ажилладаг.

Зураг 5. Хувийн банкны салбар



Дижитал салбар

Голомт банк нь банкны бүтээгдэхүүн үйлчилгээг харилцагчийн хүссэн цагт хүргэх зорилгоор дижитал салбарыг Улаанбаатар, Дархан, Эрдэнэт хотуудад жишиг болгон байгуулсан. Дижитал салбар нь дэвшилтэт технологид суурилан харилцагч өөртөө үйлчлэх бүх сувгийг нэгтгэж, жилийн 365 хоног, 24 цагийн турш нээлттэй үйлчилдгээрээ онцлог юм. Мөн харилцагчийн аюулгүй байдлыг хангах үүднээс 24 цагийн харуул хамгаалалтаар ханган ажилладаг.



Зураг 6. Голомт банкны дижитал салбар



Харилцагч төвтэй банк

Үнэт цаас гаргагч нь 2016 оноос эхлэн салбар, тооцооны төвүүдийн үйл ажиллагаанд Харилцагч төвтэй банкны стратегийг хэрэгжүүлэн ажиллаж байна. Тус стратегийн хүрээнд банкны бүхий л үйл ажиллагааг харилцагчийн өнцгөөс харж, харилцагчийн сэтгэл зүйг мэдрэн, сэтгэл ханамжтай байдлыг дээшлүүлэх, урт хугацаанд үнэнч тууштай харилцааг бий болгох, тэдний эрэлт хэрэгцээнд нийцсэн борлуулалтыг хийх, харилцан үр ашигтай хамтран ажиллах боломжийг бүрдүүлэхэд чиглэсэн олон ажлуудыг хэрэгжүүлсэн.

Тухайлбал, харилцагч төвтэй банк нь үүднээсээ эхлэн харилцагчдад өөрт хэрэгтэй үйлчилгээг хаанаас авахыг нь тодорхойлсон схемчилсэн тэмдэглэгээгээр газарчлахаас гадна кофе, цайгаар үйлчлүүлэн, номын сангаар зочлох боломжтой тав тухтай орчныг бүрдүүлж, тусгай хэрэгцээтэй иргэд болон тэргэнцэртэй иргэдэд зориулсан ая тухтай үйлчилгээ авах боломжийг бүрдүүлсэн.



Зураг 7. Голомт банкны харилцагчдад үйлчлэх салбар



Харилцагч төвтэй стратегийн хүрээнд харилцагч төвтэй бизнес загварыг хэрэгжүүлснээр харилцагчийн цаг хугацааг хэмнэж, зардлыг бууруулан, санхүүгийн цогц үйлчилгээг нэг дороос авах боломжийг бүрдүүлснээс гадна банкны үйлчилгээний ойлгомжтой, хүртээмжтэй байдлыг нэмэгдүүлсэн. Улмаар харилцагчийн үйлчилгээ авах хурд 27 хувиар өссөн.

Тус бизнес загварын хүрээнд банкны хэмжээнд бизнес процесс ре-инженеринг хийж, харилцагчтай харилцахгүйгээр хийгдэх боломжтой, дахин давтагдахгүй бүхий л ажлыг төвлөрүүлж, дотоод процессыг сайжруулсан ба үүний үр дүнд салбарын ажилтнуудын ачаалал багасч, борлуулалт руу чиглэсэн үйл ажиллагаа идэвхэжсэнээр борлуулалт хоёр дахин өсөж, зардал орлогын харьцаа 30 хувиар буурч, ажилтнуудын сэтгэл ханамж 30 хувиар өссөн байна.

Түүнчлэн Голомт банк нь харилцагч төвтэй банкны стратегийг бүх түвшний үйл ажиллагаанд нэвтрүүлэх, харилцагчийн туршлага, үйлчилгээний чанараар тэргүүлэх байр суурийг бататгах зорилгоор Харилцагчийн үйлчилгээний төвийг байгуулж,



Харилцагч төвтэй банкны засаглалыг нэвтрүүлсэн. Тус төвд 2021 оны жилийн эцсийн байдлаар нийт 700 мянган харилцагч хандаж өөрт хэрэгтэй бүтээгдэхүүн үйлчилгээ, мэдээллийг хүлээж авсан байна.

Зураг 8. Үнэт цаас гаргагчийн харилцагчийн үйлчилгээ



Цаашид Үнэт цаас гаргагч нь Харилцагч төвтэй банкны стратегийг үргэлжлүүлэн банкны зайнаас үйлчлэх сувгуудыг олон улсын жишигт нийцүүлэхээр зорьж байна. Тус зорилтын хүрээнд харилцагчийн олон төрлийн сувгаас ирж буй санал хүсэлтийг түргэн шуурхай шийдвэрлэх нэгдсэн удирдлагыг хэрэгжүүлэх, QR санал хүсэлт авах сувгийг салбар бүрт ажиллуулах, харилцагч төвтэй үйлчилгээг чатботоор авах боломжийг нэвтрүүлэн ажиллаж байна.



Дижитал банк

Голомт банк нь Монголын зах зээлд технологийн дэвшил, хиймэл оюун ухаанд суурилсан алгоритмын шинэчлэлт, хөгжүүлэлтийг тогтмол нэвтрүүлж, банкны бүтээгдэхүүн, үйлчилгээний автоматжуулалт, хэрэглээний хялбар шийдлийг бий болгож, инноваци шингэсэн бүтээгдэхүүн үйлчилгээг анхлан нэвтрүүлж ирсэн Монгол Улсын шилдэг дижитал банк юм.

		
<p>Олон улсын банк санхүүгийн салбарын нэр хүндийг тодорхойлогч Global Finance сэтгүүлээс Монгол Улсын Шилдэг Дижитал банк</p>	<p>Олон улсын AmChamRepresent Awards арга хэмжээний Digital Transformation (MNC) төрөлд технологийн шинэчлэл, дижитал шилжилтээр шилдэг банк</p>	<p>Infosys Client Innovation Award-2020 арга хэмжээний Modern Technologies Led innovation төрөлд Дижитал банк 5.0 болон UFC системээр шилдэг банк</p> <p>“COVID Response Innovation” төрөлд SocialPay дижитал хэтэвч болон Робот процесс автоматжуулалтын системээр шилдэг банк</p>
<p>2011, 2013, 2014, 2015, 2019, 2020, 2021 он</p>	<p>2021 он</p>	<p>2019, 2020, 2021 он</p>

2019 онд Үнэт цаас гаргагч нь харилцагчдад зориулсан дижитал банкны үйлчилгээ болох ахисан түвшний анализад суурилсан нэмэлт функцийг ашиглан, харилцагчийн зан төлөв, хэрэгцээ шаардлагад нийцсэн үйлчилгээ авах, төлбөр тооцоог хялбар



гүйцэтгэх боломжийг бүрдүүлсэн Дижитал банк 5.0 шинэ хувилбарыг зах зээлд амжилттай нэвтрүүлсэн.

Зураг 9. Дижитал банкны шинэчлэл



Дижитал банкаар түүчээлэгч

<p>Шинийг санаачлагч, нэвтрүүлэгч буюу технологид суурилсан бүтээгдэхүүн, үйлчилгээгээр түүчээлэгч</p>	<p>Үнэт цаас гаргагчийн МУ-н банкны зах зээлд анхлан нэвтрүүлсэн шийдлүүд:</p> <ul style="list-style-type: none"> • Олон улсын карт • Телефон банк • Цахим банк • Интернет банк • Интернет худалдаа • NFC төлбөр тооцоо • Динамик QR төлбөр тооцоо • Өөртөө үйлчлэх банк • Смарт банк • Дижитал банк • Дижитал хэтэвч • Нээлттэй банк
<p>Дижитал бүтээгдэхүүн, үйлчилгээ, автоматжуулалт</p>	<ul style="list-style-type: none"> • Хамгийн цөөн салбараар хамгийн олон харилцагчдад хүрч үйлчилдэг • Хамгийн олон Дижитал бүтээгдэхүүн, үйлчилгээтэй • Хамгийн олон дижитал сувагтай • Онлайн худалдааны төлбөр тооцоогоор тэргүүлэгч



	<ul style="list-style-type: none"> • Хамгийн цөөн салбараар хамгийн олон харилцагчдад хүрч үйлчилдэг • Corporate, SME, Retail бөх сегмэндэт хүрсэн дижитал шийдэл • Бүх салбарын байгууллага болон төрийн байгууллага, Стартапп, Технологийн компаниудын системтэй холбогдсон, хамтарсан, багц дижитал бүтээгдэхүүн үйлчилгээ, нээлттэй банкны дэд бүтэцтэй
<p>Дэлхийн стандартад нийцсэн дижитал систем, дэд бүтэц, хамтын ажиллагаа</p>	<ul style="list-style-type: none"> • Банкны үндсэн систем: Дэлхийн топ гурван банкны системийн нэг болох Infosys Limited-ийн Finacle банкны үндсэн болон дижитал банкны систем • Хамгийн олон төрлийн карт гаргагч, төлбөр тооцоо хүлээн авагч VISA, Master, AMEX, UPI, ₮ card, Wechat, AliPay, WU, SWIFT • Шинэ үеийн технологийн шийдлүүдийг нэвтрүүлсэн NFC payment, Dynamic QR, Дижитал хэтэвч, Виртуал карт, AI, RPA, Blockchain

Схем 5. Дижитал банкны онцлох үзүүлэлтүүд

ДИЖИТАЛ БАНКНЫ ОНЦЛОХ ҮЗҮҮЛЭЛТҮҮД



Эх сурвалж: Үнэт цаас гаргагчийн мэдээлэл

Нээлттэй банк

Үнэт цаас гаргагч нь 2020 оноос Нээлттэй банкны бизнес загварыг банк, санхүүгийн салбарт цогцоор нь нэвтрүүлж, байгууллага болон иргэдэд санхүүгийн хэрэгцээг нэг дороос хүссэн үедээ хаанаас ч авах буюу орон зай, цаг хугацааны хязгаарлалтгүйгээр хүлээн авах боломжийг нэвтрүүлж эхэлсэн.



Нээлттэй банкны бизнес загвар нь харилцагч бүрийн хэрэгцээ шаардлагаас хамаарч санхүүгийн байгууллага болон гуравдагч байгууллагын дундах хамтын мэдээллийн санг бий болгож, нэгдсэн сүлжээг бий болгодгоороо онцлогтой. Тус бизнес загвар нь банк, санхүүгийн салбарт шинэ өнгө төрхийг тодорхойлох инновацийн үндэс суурь болж байна.

Голомт банк нь олон улсын банк санхүүгийн салбарын жишиг нээлттэй банкны бүтээгдэхүүнийг Монголдоо анхлан нэвтрүүлж бизнесийн болон харилцагчийн онцлогт тохирсон 3 төрлийн багц үйлчилгээг API (Application programming interfaces)-р дамжуулан хүргэж байна.

Иргэдийн төлбөр тооцооны гарц /Retail gateway/

Үнэт цаас гаргагч нь 2021 онд финтек болон технологид суурилсан байгууллагуудтай хамтран харилцагчдын өдөр тутмын санхүүгийн хэрэгцээг хангах зорилго бүхий retail gateway үйлчилгээг нэвтрүүлсэн. Тус үйлчилгээгээр дамжуулан харилцагч өдөр тутмын төлбөр тооцоо болон банкны бүтээгдэхүүн үйлчилгээг хялбар, шуурхай авах боломжоор хангагдсан. Мөн хурдацтай хөгжиж буй платформ бизнесүүдтэй хамтран шинэлэг шийдлийг хэрэгжүүлж, банкны бүтээгдэхүүн үйлчилгээг харилцагчдад улам ойртуулан ажиллаж байна.

Байгууллагын төлбөр тооцооны гарц /Corporate Gateway/

Байгууллагын төлбөр тооцооны гарц нь томоохон байгууллагын санхүүгийн хэрэгцээг хангахаас гадна байгууллагын ажилтнуудын санхүүгийн хэрэгцээг хангахад чиглэсэн үйлчилгээ юм. Улмаар банк нь тухайн байгууллагын дотоод системүүдтэй интеграц хийх боломж бүрддэг. Тухайлбал, байгууллагууд ERP системээр дамжуулан дансаа удирдах, төлбөр тооцоо хийх боломжтой болохоос гадна байгууллагын ажилчид банкны бүтээгдэхүүн, үйлчилгээг тус системээр дамжуулан авах боломж бүрдсэн.

Төлбөр тооцооны гарц /Payment Gateway/

Технологид суурилсан хурдан шуурхай, хялбар төлбөрийн шийдлийг харилцагчид санал болгож байна.

Дижитал төлбөр тооцоо

Үнэт цаас гаргагч нь 2019 онд харилцагчдад зориулсан дижитал банкны үйлчилгээ болох Дижитал Банк 5.0-ийг зах зээлд амжилттай нэвтрүүлсэн. Голомт банк нь Смарт банк (мобайл), Интернет банк, SocialPay, картын бүтээгдэхүүний үйлчилгээг



дигиталаар үзүүлдэг бөгөөд харилцагчийн нийт гүйлгээний 97 хувийг дижитал сувгуудаар хийх боломжтой.

Интернет банк: Голомт банк нь харилцагчдад орон зай, цаг хугацаанаас үл хамааран интернетэд холбогдсон дурын төхөөрөмжийг ашиглаж, egolomt.mn сайтаар дамжуулан банкны бүх төрлийн үйлчилгээг авах боломжийг бүрдүүлсэн.

Смарт банк (мобайл): Голомт банкны харилцагчдад банкны бүх төрлийн үйлчилгээг ухаалаг гар утсанд суурилсан Смарт банк аппликэйшнээр дамжуулан авах боломжийг бүрдүүлсэн.

Зураг 10. Дижитал банк



SocialPay дижитал хэтэвч

Монголын анхны дижитал хэтэвч болох SocialPay нь банк санхүүгийн салбарт хамгийн өргөн хэрэглэгддэг, төлбөр тооцоо хийхээс гадна харилцагчийн хэрэгцээ шаардлагад нийцсэн олон төрлийн үйлчилгээг санал болгодог бүтээгдэхүүн юм.

SocialPay дижитал хэтэвч нь худалдан авалт хийх, карт захиалах, 50 гаруй улс оронд төлбөр тооцоо хийх, мастер болон UnionPay сүлжээний виртуал карт, лоялти картыг орлох лоялти платформ, корпорэйт виртуал картын үйлчилгээг тус тус үзүүлж байна.




Socialpay хэтэвчид UBCab, Onefit, Skygo, LookTV, Skytel, Mobicom, MonPay, Mongolchat, Toki, Hippocards, Tomyo, Toktok, ENomin, Emart, Storepay зэрэг 500 гаруй үйлчилгээний байгууллагын аппликейшнийн төлбөр тооцоог гүйцэтгэдэг картын холболтыг хийх боломжтойгоос гадна зорчигч тээвэр, онлайн дэлгүүр, кино тасалбар, үзвэр үйлчилгээ, хандив, амралт, зугаалга, хувьцааны арилжаа, татвар торгууль болон даатгалын үйлчилгээг үзүүлдэг юм.

Үнэт цаас гаргагч нь тус хэтэвчийг аль ч банкны картаар төлбөр тооцоо хийхэд шууд ашиглах боломжтой байдлаар шийдсэнээрээ банкны салбартаа анхдагч болж байна.

2021 оны жилийн эцсийн байдлаар SocialPay хэтэвч нь 290 мянга гаруй харилцагчтай болж, өмнөх оны мөн үетэй харьцуулахад 26 хувиар, идэвхтэй харилцагчийн тоо 59 хувиар, SocialPay үйлчилгээгээр хийгдсэн нийт гүйлгээний тоо 37 хувиар тус тус өссөн байна.

Зураг 11. SocialPay хэтэвч



3.3 Үнэт цаас гаргагчийн бүтээгдэхүүн үйлчилгээ


Үнэт цаас гаргагч нь банкны үндсэн үйл ажиллагааны хүрээнд дараах тусгай зөвшөөрлийн эрхийг эзэмшиж, харилцагчдад бүтээгдэхүүн үйлчилгээг хүргэж байна. Үүнд:

- Зээл, төлбөр тооцооны үйл ажиллагаа эрхлэх;
- Мөнгөн хадгаламжийн үйлчилгээ эрхлэх;
- Гадаад төлбөр тооцооны бүх төрлийн үйлчилгээ эрхлэх;
- Үнэт зүйл хадгалах;
- Үнэт металл, эрдэнийн чулуу худалдан авах, худалдах, хадгалах, хадгалуулах;
- Андеррайтер, үнэт цаас гаргах, худалдах, худалдан авах үйл ажиллагаа эрхлэх;
- Кастодиан банкны үйл ажиллагаа;
- Банкны даатгалын зуучлалын үйлчилгээ;
- Өөрийн нэрийн өмнөөс гуравдагч этгээдэд баталгаа, батлан даалт гаргах;
- Гадаад валют худалдах, худалдан авах, хадгалах, хадгалуулах.

Зээлийн үйлчилгээ

Зээл нь иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад ирээдүйн орлогоос нь тодорхой хүүгийн хамт эргүүлэн төлөх нөхцөлтэйгөөр санхүүжилт олгох Банкны үндсэн бүтээгдэхүүн юм. 2021 оны жилийн эцсийн байдлаар Үнэт цаас гаргагч нь зээлийн зориулалт болон эргэн төлөгдөх эх үүсвэрт нийцсэн нийт 70 гаруй зээлийн бүтээгдэхүүнийг харилцагчдад санал болгож байна.

График 1. Зээлийн бүтэц /тэрбум төгрөг/



Эх сурвалж: Үнэт цаас гаргагчийн мэдээлэл



Бизнесийн зээл

Үнэт цаас гаргагч нь Монгол Улсын эдийн засгийг хөдөлгөгч гол хүч болсон уул уурхай, хөдөө аж ахуй, боловсруулах үйлдвэрлэл, худалдаа үйлчилгээ зэрэг салбаруудын аж ахуй нэгж байгууллага, групп компани болон бизнес эрхлэгч иргэдийн санхүүгийн хэрэгцээнд нийцсэн 27 төрлийн бизнесийн зээлийн бүтээгдэхүүн үйлчилгээг санал болгодог. Үүнээс голлох бүтээгдэхүүнийг дурдвал:

Хөрөнгө оруулалтын зээл: Бизнес эрхлэгч иргэн, аж ахуй нэгж байгууллагын үйлдвэрлэл, үйлчилгээг өргөтгөх, техник технологийг сайжруулах, тоног төхөөрөмж худалдан авах, шинэчлэх, үйл ажиллагааны ашиг орлогыг нэмэгдүүлэх, бүтээгдэхүүн үйлчилгээний чанарыг сайжруулах зорилго бүхий хөрөнгө оруулалтад зориулсан санхүүжилтийн бүтээгдэхүүн

Ажлын байрыг дэмжих зээл: Жижиг, дунд үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдийн бизнесийн үйл ажиллагааг тогтвортой явуулахад шаардлагатай эргэлтийн хөрөнгийг бий болгох, ажлын байрыг хадгалахад зориулсан санхүүжилтийн бүтээгдэхүүн

Бизнес эрхлэгч эмэгтэйчүүдийг дэмжих зээл: Бизнес эрхлэгч эмэгтэйчүүдийн санхүүгийн чадавхыг сайжруулах, үйлдвэрлэл үйлчилгээг идэвхтэй эрхлэхэд дэмжлэг үзүүлэх зорилготой санхүүгийн тусгай хөтөлбөр, хөнгөлөлттэй зээлийн бүтээгдэхүүн

2017-2020 онуудад Үнэт цаас гаргагчийн бизнесийн зээлийн багц жилд дунджаар 9.3 хувиар өсөж 2020 оны байдлаар 1.76 их наяд төгрөгт хүрсэн. 2020 онд Ковид-19 цар тахлын нөлөөгөөр бизнесийн зээлийн эрэлт буурч байсан бол 2021 оны жилийн байдлаар 1.77 их наяд төгрөгийн зээлийн багцын үлдэгдэлтэй байна.

График 2. Бизнесийн зээлийн багцын үлдэгдэл /тэрбум төгрөг/



Эх сурвалж: Үнэт цаас гаргагчийн мэдээлэл



Хэрэглээний зээл

Үнэт цаас гаргагч нь харилцагчдын тав тухтай амьдралын хэрэгцээ болон өдөр тутамд тулгарч буй санхүүгийн бэрхшээлийг шийдвэрлэхэд нь туслах үүднээс хэрэглээний зээлийн бүтээгдэхүүний хүртээмжийг сайжруулж, олон улсын жишигт нийцүүлэн хөгжүүлж, өрхийн болон хувь хүний хэрэгцээг санхүүжүүлэхэд зориулсан 11 төрлийн зээлийн бүтээгдэхүүнийг санал болгож байна. Үүнээс голлох бүтээгдэхүүнийг дурдвал:


Цалингийн зээл: Цалин олгогч байгууллага, аж ахуй нэгжийн ажилтнуудад зориулсан зээл

Дижитал зээл: Дижитал сувгаар буюу интернет банк, смарт банк ашиглан авах боломжит зээл

Автомашинны зээл: Хувийн хэрэгцээнд зориулж автомашин авах гэж буй харилцагчдад зориулсан зээл

2017-2020 онд Үнэт цаас гаргагчийн хэрэглээний зээлийн багц жилд дунджаар 15.9 хувиар өсөж 2019 оны байдлаар 888 тэрбум төгрөгт хүрсэн. 2020 онд Ковид-19 цар тахлын улмаас бизнесийн үйл ажиллагаанд тасалдал үүссэнээр иргэдийн орлого буурсан болон зээлийн эрсдэлийн бодлогын өөрчлөлтөөс үүдэн зээл олголт багассан. Улмаар 2021 оны жилийн эцсийн байдлаар Үнэт цаас гаргагчийн хэрэглээний зээлийн багцын үлдэгдэл 722 тэрбум төгрөг байна.

График 4. Хэрэглээний зээлийн багцын үлдэгдэл /тэрбум төгрөг/



Эх сурвалж: Үнэт цаас гаргагчийн мэдээлэл



Орон сууцны зээл

Үнэт цаас гаргагч нь үүсгэн байгуулагдсан цагаас эхлэн иргэдийг орон сууцжуулах, тав тухтай орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлэхэд онцгойлон анхаарч ирсэн. Тус зорилтын хүрээнд Засгийн газрын болон банкны өөрийн эх үүсвэрт тулгуурласан орон сууцны зориулалттай 13 зээлийн бүтээгдэхүүнийг санал болгож байна. Үүнээс голлох бүтээгдэхүүнийг дурдвал:


6 хувийн хүүтэй орон сууцны зээл: Монголбанк арилжааны банкуудтай хамтран хэрэгжүүлж буй орон сууцны хөтөлбөрийн зээл;

Өөрийн эх үүсвэрийн орон сууцны зээл: Иргэдийг орон сууцжуулах зорилго бүхий зээлийн эргэн төлөлтийн уян хатан нөхцөлтэй, урт хугацаат орон сууцны зээл;

Ногоон зээл буюу эрчим хүчний хэмнэлттэй амины орон сууцны зээл: Гэр хорооллын бүсэд амьдарч буй иргэдэд урьдчилгаа төлбөрийн тодорхой хувийг буцалтгүй тусламж хэлбэрээр олгож эрчим хүчний хэмнэлттэй амины орон сууцтай болгоход зориулсан зээл;

Үнэт цаас гаргагч нь орон сууцны зээл олгож эхэлснээс хойш нийт 39,770 харилцагчид 2.26 их наяд төгрөгийн зээл олгож, 139,195 иргэн буюу нийт хүн амын 4.2 хувийг орон сууцтай болоход хувь нэмрээ оруулсан орон сууцны зээлээр зах зээлд тэргүүлэгч банк юм. 2017-2020 онд Үнэт цаас гаргагчийн орон сууцны зээлийн багц жилд дунджаар 11.1 хувиар өсөж, 2021 оны жилийн эцсийн байдлаар 647 тэрбум төгрөгт хүрсэн байна.

График 5. Орон сууцны зээлийн багцын үлдэгдэл /тэрбум төгрөг/



Эх сурвалж: Үнэт цаас гаргагчийн мэдээлэл




Гадаад худалдааны санхүүжилтийн үйлчилгээ

2021 оны жилийн эцсийн байдлаар Үнэт цаас гаргагч нь олон улсын 142 банк, санхүүгийн байгууллагуудтай шууд болон зорилтот зээл, худалдааны санхүүжилт, Экспортын Санхүүжилтийн Агентлагтай хамтарсан баталгаа, аккредитив, гадаад төлбөр тооцоо, валют арилжаа, зузаатгал болон бусад чиглэлээр идэвхтэй хамтран ажиллаж, 180 гаруй сая ам.долларын зээлийн шугамыг батлуулсан.

Үнэт цаас гаргагч нь харилцагч байгууллагуудын гадаад худалдааны бараа эргэлтийг сайжруулах, санхүүжилтийн өртгийг бууруулахад дэмжлэг үзүүлэн ОХУ, БНСУ, Япон, БНХАУ, БНФУ, Сингапур, Испани, Турк, Хонконг зэрэг орнуудтай хийж буй худалдан авалтыг аккредитив, гадаад баталгааны үйлчилгээгээр дамжуулан гүйцэтгэдэг.

Тодруулбал, Голомт банк нь Монгол Улсын хэмжээнд импортын аккредитивын 40 хувь, гадаад баталгааны тоогоор зах зээлийн 67 хувийг дангаар гүйцэтгэсэн нь гадаад худалдааны санхүүжилтийн үйлчилгээгээр тэргүүлэгч болохыг илтгэж байна.

График 6. Гадаад баталгааны тоогоор банкны системд эзлэх хувь



Эх сурвалж: Үнэт цаас гаргагчийн мэдээлэл

Голомт банк нь гадаадын нэр хүндтэй банкуудын баталгаанд үндэслэн, дотоодын давхар баталгаа өгөх үйлчилгээ үзүүлж, Монгол Улсын томоохон бүтээн байгуулалт, дэд бүтцийн төсөл, хөтөлбөрт оролцогч гадаадын аж ахуй нэгж байгууллагуудад тендер болон урьдчилгаа төлбөрийн баталгаа, гүйцэтгэлийн баталгаа нээх үйлчилгээг түргэн, шуурхай үзүүлдэг.

Монгол Улсын экспортын гол нэрийн бүтээгдэхүүн болох нүүрсний экспортыг дэмжих үүднээс экспортын өмнөх санхүүжилтийг БНХАУ болон Сингапур улсын банкуудтай хамтран олгож байна.

Үнэт цаас гаргагч нь гадаадын түнш банкуудтай хамтран импортын барааны худалдан авалтыг санхүүжүүлэхээс гадна гадаад валютын ханшийн эрсдэлээс хамгаалах зорилготой өртөг багатай төгрөгийн зээлийг олгодог. Тус санхүүжилтийн



хүрээнд Голомт банк нь 2021 оны жилийн эцсийн байдлаар 48.1 тэрбум төгрөгийн зээлийн үлдэгдэлтэй байна.

Голомт банк нь ХБНГУ-ын Commerzbank, Япон улсын Sumitomo Mitsui Banking Corporation (SMBC), АНУ-ын JP Morgan, ОХУ-ын Москвагийн Кредит (МКВ) болон VTB банк, Унгар улсад төвтэй International Investment Bank, АНУ-ын Cargill International, WorldBusinessCapital Inc, Enabling Capital AG, Lendahand зэрэг томоохон санхүүгийн байгууллагаас нийт 600 гаруй сая ам.долларын дүнтэй, 1-8 жилийн хугацаатай шууд болон зорилтот зээлүүдийг татан төвлөрүүлсэн. Энэ нь гадаадын банк санхүүгийн байгууллагуудын Голомт банканд итгэх итгэл жилээс жилд өсөж буйн илрэл юм.

Харилцах, хадгаламжийн үйлчилгээ

Үнэт цаас гаргагч нь Монгол Улсын эдийн засгийг дэмжих, үндэсний хуримтлалыг нэмэгдүүлж, иргэдийн хуримтлуулах зуршлыг дэмжих зорилгоор Хуримтлалыг зуршил болгоё уриан дор Үндэсний хуримтлалын хөтөлбөр, Санхүүгийн дархлаатай иргэн уриан дор ВитаминҮ аяныг хэрэгжүүлсэн. Мөн дэлхийн хуримтлалын өдрийг тохиолдуулж, олон нийтэд зориулсан арга хэмжээг тогтмол зохион байгуулдаг.

Дээрх зорилтын хүрээнд Голомт банк нь харилцагч бүрийн онцлог, хэрэгцээ шаардлагад нийцсэн төрөл бүрийн уян хатан нөхцөл бүхий 15 төрлийн харилцах, хадгаламжийн бүтээгдэхүүнийг санал болгодог. Үүнээс голлох бүтээгдэхүүнийг дурдвал:

Үндэсний хуримтлалын хөтөлбөр

Үнэт цаас гаргагч нь 2015 онд иргэдийг хуримтлалтай болгох, хуримтлуулах зуршлыг нь дэмжих зорилгоор Монголын банк санхүүгийн салбарт анх удаа Үндэсний хуримтлалын хөтөлбөрийг санаачилж хэрэгжүүлсэн.

Үндэсний хуримтлалын хөтөлбөр нь харилцагчдад сонгосон мөнгөн дүнгээр сар бүр тогтмол орлого хийж өндөр өгөөж авах боломжийг бүрдүүлсэн бөгөөд тус хөтөлбөрт нийт 250 мянга гаруй хуримтлал үүсжээ.



Зураг 12. Үндэсний хуримтлалын хөтөлбөр



Алтантүлхүүр хүүхдийн хадгаламж

Алтантүлхүүр хадгаламж нь эцэг эхчүүдэд үр хүүхдийнхээ ирээдүйд хөрөнгө оруулалт хийн, урт хугацаанд хамгийн өндөр өгөөж хүртэх боломжийг олгодог бүтээгдэхүүн юм. Энэхүү хадгаламжийн бүтээгдэхүүний давуу тал нь хүүгийн орлогын жилийн 1 хувийг Алтантүлхүүр санд хандивладаг. Тус сан нь Алтантүлхүүр хадгаламж эзэмшигчидтэй хамтран хүүхдийн сайн сайхны төлөө чиглэсэн төсөл хөтөлбөрийг санхүүжүүлж, дэмжлэг үзүүлдэг.

Зураг 13. Алтантүлхүүр хүүхдийн хадгаламж



Гибрид хадгаламж

Үнэт цаас гаргагч нь харилцагчийн мөнгөн хөрөнгийг өсгөх зорилгоор олон улсад хөрөнгө оруулах боломжтой Гибрид хадгаламжийн бүтээгдэхүүнийг санал болгодог. Тус бүтээгдэхүүн нь олон улсын хөрөнгийн зах зээлд төгрөгөөр хөрөнгө оруулж, түүхий эд, валют, хувьцаа зэрэг санхүүгийн бүтээгдэхүүний ханшийн хэлбэлзлээс өгөөж хүртэх боломжийг олгодгоороо онцлогтой.

Харилцах данс

Харилцах данс нь хугацааны хязгаарлалтгүй, өдөр тутмын төлбөр тооцоо гүйцэтгэхэд зориулсан данс юм. Голомт банкны харилцах дансны бүтээгдэхүүн нь нээхэд шимтгэлгүй бөгөөд гадаад, дотоодын шилжүүлэг, бэлэн мөнгөний орлого зарлагын гүйлгээ хийх, 24/7 цагаар дижитал үйлчилгээг ашиглаж дансаа хянах, төрөл бүрийн валют худалдах, худалдан авах боломжтой.

Төлбөр тооцооны үйлчилгээ

Үнэт цаас гаргагч нь Монголын банкны салбарт картын үйлчилгээгээр анхдагч бөгөөд UPI, Master, AMEX, VISA зэрэг хамгийн олон картын бүтээгдэхүүнийг зах зээлд гаргаж тэргүүлэгч байр суурьтай ажиллаж ирсэн. Тодруулбал, 1999 онд Монгол Улсад анх удаа нэрийн мастер картыг зах зээлд гаргасан төдийгүй виза картыг амжилттай нэвтрүүлсэн юм.

Түүнчлэн Монгол Улсад анх удаа буюу 2008 онд төлбөрийн картын системийн аюулгүй байдлын №1 стандартад нийцсэн EMV CHIP карт бүхий виза болон мастеркарт брэндийн картыг нэвтрүүлснээр харилцагчдын санхүүгийн аюулгүй байдлыг хангах гол нөхцөл бүрдсэн.

Үнэт цаас гаргагч нь шинэ харилцагчийг зайнаас бүртгэх, салбарт ирүүлэхгүйгээр карт захиалах үйлчилгээ (SocialPay, Cards.mn) болон анхны босоо загварын картыг зах зээлд анхлан нэвтрүүлсэн гэх мэт картын зах зээлд анхдагч тодотголтой олон шинэлэг бүтээгдэхүүнийг гаргасан туршлагатай. Мөн Зэс брэндийн картыг гаргаснаар кредит картыг бүх нийтийн хэрэглээнд амжилттай нэвтрүүлсэн юм.

Үнэт цаас гаргагч нь дэлхийд өндөр нэр хүндтэй Американ Экспресс брэндийн карт гаргах, хүлээн авах эрхтэй Монголын цорын ганц банк төдийгүй мастер брэндийн карт, хосолсон валюттай карт гаргагч цорын ганц банк (Американ Экспресс кредит карт) юм.

Голомт банк нь Монголын анхны виртуал дебит картыг зах зээлд таниулсан. Тус карт нь дижитал хувьслын өнөө үед харилцагчдын хэрэгцээг бүрэн хангасан



бүтээгдэхүүн болсон учраас 2018-2021 онд нийт 87,000 харилцагч тус картын хэрэглэгч болж, виртуал гүйлгээний тоо 13 дахин өссөн байна.

Үнэт цаасны танилцуулга бэлтгэх өдрийн байдлаар Голомт банк нь иргэдэд зориулсан нийт 7 төрлийн кредит, 9 төрлийн дебит карт, байгууллагад зориулсан дебит, кредит картын бүтээгдэхүүнийг санал болгож байна. Мөн байгууллагуудын хүсэлт, хэрэгцээ шаардлагад тулгуурласан хамтарсан ко-брэнд картын бүтээгдэхүүнийг гаргадаг.

2021 оны жилийн эцсийн байдлаар Голомт банкны дебит картыг 547 мянга орчим, кредит картыг 30 мянга орчим харилцагч эзэмшиж байна. Үнэт цаас гаргагч нь нийт онлайн худалдааны гүйлгээний тоогоор зах зээлийн 50 хувийг эзэлж байна.

Зураг 14. Үнэт цаас гаргагчийн картын бүтээгдэхүүнүүд




Голомт банк нь 2012 оноос картын эрсдэлтэй гүйлгээг 24/7 хянаж, харилцагчдад мэдээлэх, шийдвэрлэх, таслан зогсоох үйлчилгээг үзүүлж ирсэн бөгөөд 2016 онд төлбөрийн картын олон улсын мэдээллийн аюулгүй байдлын стандартыг бүрэн хангасан батламжийг авсан.

Үнэт цаас гаргагч нь жил бүр Thales group-ийн аудитад хамрагдан PCI-DSS буюу олон улсын картын аюулгүй байдлын стандартыг хангаж сертификатаар баталгаажуулан ажилладаг. Мөн PCI-DSS картын үйлчилгээний эрсдэлийг бууруулах яаралтай арга хэмжээг олон улсын Gemini Advisory: Fraud Intelligence байгууллагатай хамтран түргэн шуурхай хэрэгжүүлж, найдвартай байдлыг өндөр түвшинд ханган ажилладаг.



Түүнчлэн ATM, CDM, CRM зэрэг биет цахим сувгаар дамжуулан харилцагчдын бэлэн мөнгөний орлого, зарлага болон бусад дансны үйлчилгээг (үлдэгдэл шалгах, шилжүүлэг хийх, пин код солих гэх мэт) түргэн шуурхай үзүүлж байна.

Зураг 15. Үнэт цаас гаргагчийн цахим төлбөр тооцооны сувгууд



Гадаад төлбөр тооцоо

Үнэт цаас гаргагч нь олон улсын нэр хүнд бүхий 28 арилжааны банкин дахь 50 орчим дансаар дамжуулан, 14 төрлийн валютаар гадаад төлбөр тооцооны үйлчилгээг үзүүлдэг.

2020 онд банкны системийн хэмжээнд нийт 8.4 тэрбум ам.долларын дүн бүхий 205,887 гадаад шилжүүлэг хийгдсэнээс 40.5 хувь буюу 3.4 тэрбум ам.долларын гүйлгээг Голомт банк нь дангаар гүйцэтгэж, зах зээлд тэргүүлэх байр суурийг эзэлж байна.

2021 оны жилийн эцсийн байдлаар банкны системийн хэмжээнд нийт 10.8 тэрбум ам.долларын дүнтэй гадаад гүйлгээ илгээсэн бөгөөд үүний 37 хувь буюу нийт 4 тэрбум ам.долларын гүйлгээг Үнэт цаас гаргагч нь дангаар гүйцэтгэсэн. Тодруулбал: Австрали улс руу хийгдсэн гүйлгээний дүнгийн 48 хувь, Солонгос руу хийгдсэн гүйлгээний дүнгийн 44 хувийг амжилттай хийж гүйцэтгэсэн байна.

Банкны системийн хэмжээнд нийт 10.5 тэрбум ам.долларын дүнтэй гадаад гүйлгээ хүлээн авсан бөгөөд үүний 25 хувь буюу нийт 2.7 тэрбум ам.долларын гүйлгээг Үнэт цаас гаргагч нь дангаар гүйцэтгэсэн. Тодруулбал, Австрали улсаас Монгол улс руу хийгдсэн нийт гүйлгээний дүнгийн 64 хувь, БНХАУ-с хийгдсэн гүйлгээний 40 хувь,



БНСУ-с хийгдсэн гүйлгээний 39 хувийг дангаар гүйцэтгэж гадаад төлбөр тооцооны үзүүлэлтээр банкны салбарт тэргүүлсэн байна.

Үнэт цаас гаргагч нь харилцагчдын өсөн нэмэгдэж буй гадаад валютын хэрэгцээ шаардлагыг хангах зорилгоор Герман улсын Commerzbank, БНХАУ-ын Bank of China HK, Дани Улсын Saxo Bank, АНУ-ын StoneX, Interactive brokers, Travelex, Raiffeisen Bank зэрэг томоохон банк, санхүү, арилжаа, зузаатгалын байгууллагатай хамтын ажиллагааг өргөжүүлж, жилд дунджаар 0.8 тэрбум орчим ам.доллартой тэнцэхүйц хэмжээний валют арилжааг гүйцэтгэдэг.

Алтны арилжааны үйлчилгээ

Голомт банк нь алтны арилжааны зах зээлд тэргүүлэгч банк юм. Тодруулбал, 2021 оны жилийн эцсийн байдлаар Монголбанканд тушаасан нийт алтны 64 хувийн төлбөр тооцоог дангаар гүйцэтгэсэн.

Мөн харилцагчийн хөрөнгө оруулалтын сувгийг нэмэгдүүлэх зорилгоор биет бус алтны арилжааг нэвтрүүлж, харилцагч өөрийн нэр дээр алт эзэмших, хөрөнгө оруулах боломжийг бүрдүүлсэн.

Уул уурхай тэр дундаа алтны салбарт үйл ажиллагаа явуулдаг харилцагчдыг санхүүгийн үүсмэл хэрэгсэл ашиглан алтны ханшийн уналтаас хамгаалах, эрсдэлийг хязгаарлагдмал түвшинд барих үйлчилгээг Үнэт цаас гаргагч нь 2018 оноос хойш үзүүлж байна.

График 7. Алтны арилжааны зах зээлд эзлэх хувь



Эх сурвалж: Үнэт цаас гаргагчийн мэдээлэл

Даатгалын зуучлалын үйлчилгээ

Үнэт цаас гаргагч нь харилцагчдад учирч болох эрсдэлийг бууруулах зорилгоор Монгол Улсад тэргүүлэгч даатгалын компаниудтай хамтарсан даатгалын бүтээгдэхүүнийг зах зээлд санал болгож, даатгалын зуучлалын үйлчилгээг



үзүүлдэг. Үүнд, ипотека, хүнд болон тусгай зориулалтын машин механизм, тээврийн хэрэгсэл, аялал, гэнэтийн ослын болон хөрөнгийн даатгалын үйлчилгээ багтдаг.

2021 оны жилийн эцсийн байдлаар Үнэт цаас гаргагч нь 139,975 харилцагчийг даатгалд хамруулж, 6.8 тэрбум төгрөгийн хураамжийн орлогыг татан төвлөрүүлснээр банкны салбарын даатгалын зуучлалын үйлчилгээний 23.6 хувийг дангаар гүйцэтгэсэн.

Кастодиан банкны үйлчилгээ

Үнэт цаас гаргагч нь 15 брокерийн компанитай хамтран ажиллаж, дотоодын 1,338 гаруй, гадаадын томоохон 15 харилцагч, хөрөнгө оруулалтын 10 гаруй сан буюу зах зээлийн 60 гаруй хувьд кастодиан банкны үйлчилгээг үзүүлж байна. Мөн дэлхийд тэргүүлэгч JP Morgan банкны Монгол дахь цорын ганц Саб-кастодиан банк юм.

Голомт банк нь дэлхийн тэргүүлэх зэрэглэлийн систем нийлүүлэгч Номура Судалгааны Институтийн (NRI) кастодиан банкны системийг нэвтрүүлэн, жил бүр шинэчлэн сайжруулахын зэрэгцээ API фрэймворк, маржин санхүүгийн модулийг шинээр нэвтрүүлэн системийг өргөжилтийг хийснээр харилцагчдад хөрөнгө оруулалтын сангийн цогц үйлчилгээг үзүүлэх нөхцөлийг бүрдүүлсэн.

Мөн 2017 оны 12-р сарын 15-нд үнэт цаасны тухайлсан бүртгэлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг авснаар харилцагчийн нэгж эрхийн тухайлсан бүртгэлийг хөтлөх үйлчилгээг үзүүлэх болсон.

2021 оны жилийн эцсийн байдлаар Үнэт цаас гаргагчийн кастодиан банкны хадгалж буй хөрөнгийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 392.5 хувиар өссөн байна.

Үнэт зүйл хадгалах үйлчилгээ

Үнэт цаас гаргагч нь Монгол Улсад анх удаа өндөр зэрэглэлийн гурван давхар хамгаалалт бүхий олон улсын стандартад нийцсэн үнэт зүйл хадгалах үйлчилгээг нэвтрүүлсэн.

Үнэт зүйл хадгалах үйлчилгээ нь цор ганц дахин давтагдашгүй баталгаа болох харилцагчийн хурууны хээ болон олон төрлийн түлхүүрээр давхар хамгаалагддаг тул харилцагчдад үнэт зүйлээ найдвартай хадгалах боломжийг олгодгоороо давуу талтай.

Тус үйлчилгээ нь харилцагчдын бичиг баримт, үнэт зүйлс, үнэт металл, нөхөн сэргээх эсвэл орлуулах боломжгүй эд зүйлс, мөнгөн хөрөнгө зэргийг гал усны аюулгүй байдлыг бүрэн хангасан нөхцөлд устаж үгүй болох, хулгайд алдагдах зэрэг эрсдэлээс сэргийлдгээрээ онцлогтой.



3.4 Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаа явуулж буй бизнесийн салбар

Байгууллагын зах зээл

Үнэт цаас гаргагч нь байгууллагын зах зээлд санхүүгийн цогц шийдлийг агуулсан бүтээгдэхүүнийг санал болгодог шилдэг байгууллагын банк юм. Тодруулбал, байгууллагын харилцагчийн бизнес санааг цаасан дээр байхаас нь амжилттай хэрэгжиж, үр дүнгээ өгөх хүртэлх шаардлагатай зөвлөгөө мэдээллээр тогтмол хангах, санхүүжилт олгох, болзошгүй эрсдэлийг бууруулах шийдлийг хэрэгжүүлэх зэргээр бүх шатны санхүүгийн зөвлөх үйлчилгээг үзүүлдэг нь харилцагчдад өгч буй хамгийн том үнэ цэн юм.



Голомт банк нь өндөр ашигтай, өсөлттэй салбарт хөрөнгө оруулахаас илүүтэйгээр байгаль орчин, нийгэмд ээлтэй, зэрэг өөрчлөлт авчрах, нийгмийн хариуцлагыг хэрэгжүүлэгч төсөл хөтөлбөрийг дэмжиж, харилцагчийн санхүүгийн боловсролыг дээшлүүлэхэд онцгойлон анхаардаг.

Зураг 16. Шилдэг байгууллагын банк шагнал



Олон улсын банк санхүүгийн салбарт нэр хүнд бүхий сэтгүүл болох Global Banking & Finance Review-с Голомт банкыг Монгол улсын шилдэг байгууллагын банкаар тодруулсан.

2021 оны жилийн эцсийн байдлаар Голомт банк нь 1,400 гаруй корпорэйт харилцагчидаас 1.2 их наяд төгрөгийн эх үүсвэрийг бүрдүүлж, 1.2 их наяд төгрөгийн зээлийн багцын үлдэгдэлтэй байна.



Голомт банкны санхүүжүүлсэн голлох төсөл хөтөлбөрөөс дурдвал:

Дэд бүтцийн салбарт:

- М Си Эс Кока Кола ХХК, М Си Эс Интернэйшнл ХХК-иудын хамтран хэрэгжүүлсэн хийн түлшээр ажилладаг уурын зуух бүхий Монгол Улсын анхны хүнсний үйлдвэрийг ашиглалтад оруулахад аккредитивийн санхүүжилтийг олгосон. Улмаар жилд 7,000 орчим тонн түүхий нүүрсний хэрэглээг зогсоож, агаарын бохирдлыг бууруулахад хувь нэмрээ оруулсан.
- Гэр хорооллын 20,602 айл өрхийг цахилгаан халаагуураар халаах 110/10 кV-ын хүчин чадал бүхий Хүчит Шонхор дэд станцыг барихад зориулан 17 тэрбум төгрөгийн санхүүжилтийг олгосон.
- М Си Эс Интернэйшнл ХХК-ийн Хөшигтийн хөндий дэх Бөхөг 15 Мвт-ийн хүчин чадалтай Монгол Улсын хоёр дахь том нарны станцыг барихад санхүүжилт олгосон.
- Цогтцэций суманд баригдаж буй Оюутолгой, Таван толгой, Ухаа худаг, Цагаан суварга зэрэг томоохон уурхайг цахилгаанаар хангах боломжтой 50 Мвт хүчин чадал бүхий Монгол Улсын 2 дахь том салхин цахилгаан станцын ерөнхий, туслан гүйцэтгэгч үндэсний болон гадаадын компаниудын төлбөр тооцоо, мөнгөн урсгалын менежментийн шийдэл, худалдааны санхүүжилтийн цогц үйлчилгээг үзүүлж, сэргээгдэх эрчим хүчний салбарыг дэмжин ажилласан.
- Монгол Улс нь нийт 14,919 км бүхий олон улс, улсын чанартай авто замын сүлжээтэй бөгөөд үүний 48.5 хувь буюу нийт 7,228 км нь хатуу хучилттай зам юм. Үүнээс 2200 орчим км авто замыг Үнэт цаас гаргагчийн санхүүжилтээр байгуулсан.



Зураг 17. Дэд бүтцийн салбарт санхүүжүүлсэн томоохон төсөл хөтөлбөрүүд



Худалдаа үйлчилгээний салбарт:

- БНСУ-ын франчайз И-март сүлжээ дэлгүүрийг 2016 онд стандартын дагуу Монгол Улсад нээсэн. И-март төслийг хэрэгжүүлж эхэлсэн цагаас хойш Үнэт цаас гаргагч нь санхүүжүүлэгч банкаар ажиллан, хамтын ажиллагаагаа дараагийн түвшинд хүргэн ажиллаж өдгөө сүлжээ супермаркетын зах зээлийн 20 хувийг эзэлж байна.
- 2018 онд үндэсний соёл амралтын Зайсан хилл цогцолборыг бүрэн ашиглалтад оруулах төслийн санхүүжилтийг олгосноор иргэдэд амралт, чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх боломжийг бүрдүүлсэн.
- 2020 онд улсын хэмжээнд 1.6 сая тонн орчим шатахууныг 1.1 тэрбум ам.доллараар импортлоход Үнэт цаас гаргагч нь 800 сая ам.долларын баталгаа гаргаж, 280 сая ам.долларын буюу 25.4 хувийг дангаар санхүүжүүлсэн.
- 2019 онд Ажил хэрэгч хотын хэв маягт тохирсон "CU конвениенс" сүлжээ дэлгүүрт санхүүжилт олгосон.



Зураг 18. Худалдааны салбарт санхүүжүүлсэн томоохон төсөл хөтөлбөрүүд



Үйлдвэрлэлийн салбарт:

- Үндэсний манлай үйлдвэрлэгч Тэсо ХХК-ийн охин компани болох Милко ХХК-тай хамтран хоногт 12 тонн хуурай сүү үйлдвэрлэх хүчин чадалтай Милко үйлдвэрийг ашиглалтад оруулснаар дотоодын хуурай сүүний хэрэгцээг бүрэн хангаад зогсохгүй, экспортлох боломжийг бүрдүүлсэн.
- Монгол Улсын хэмжээнд 2020 онд хүн амын гурилын хэрэгцээнд 487,600 тонн улаан буудай хурааснаас Үнэт цаас гаргагч нь тус хэрэгцээний 22 хувийг дангаар хангах санхүүжилтийг олгосон.

Агаарын тээврийн салбарт:

- Монгол Улсын үндэсний агаарын тээвэрлэгч МИАТ компанийн Боинг 767-300ER онгоцны зээлийг өөрийн эх үүсвэрээр дахин санхүүжүүлж, агаарын тээврийн салбарын хүчин чадлыг нэмэгдүүлсэн.
- Хүннү Эйр ХХК-ийн шинэ Embraer-190 маркын хөлөг онгоцны санхүүжилтыг олгосон.

Зураг 19. Агаарын тээврийн салбарт санхүүжүүлсэн томоохон төсөл хөтөлбөрүүд




Эрүүл мэндийн салбарт:

- Хүн амын эрүүл мэндийг сахин хамгаалах, Монгол Улсын эрүүл мэндийн салбарын хөгжлийг дэлхийн жишигт нийцүүлэх зорилгоор Интермед эмнэлгийн төслийг санхүүжүүлсэн.

Уул уурхайн салбарт:

- Оюутолгойн төсөлд туслан гүйцэтгэгч, бэлтгэн нийлүүлэгчээр ажиллаж буй харилцагч байгууллагуудад хэрэгцээтэй санхүүжилтийг нь олгож, урт хугацаанд тогтвортой хамтран ажиллаж байна. 2020 оны байдлаар жилд дунджаар нийт 100 орчим харилцагчид 80 орчим тэрбум төгрөгийн санхүүжилтийг олгосон байна.
- Монгол Улсад анх удаа ХБНГУ-ын Sennebogen Maschinenfabrik үйлдвэрийн 875R маркын нүүрс ачигчийг Голомт банк ХБНГУ-ын Euler HERMES даатгалтай Commerzbank AG-ийн урт хугацаатай зээлээр санхүүжүүлэв. Тус нүүрс ачигч нь байгаль орчинд ээлтэй, орчны тоосжилт үүсгэхгүй, түлшийг 80 хувь үр ашигтай зарцуулах өндөр бүтээмжтэй цоо шинэ технологийг дотоодын уул уурхайн салбарт нэвтрүүлсэн.

Зураг 20. Уул уурхайн салбарт санхүүжүүлсэн томоохон төсөл хөтөлбөрүүд



Жижиг, дунд бизнесийн зах зээл

Үнэт цаас гаргагч нь улс орны эдийн засгийн гол тулгуур болсон баялаг бүтээгч жижиг, дунд бизнес эрхлэгчдийг тууштай дэмжиж, тэдгээрийн эрэлт хэрэгцээнд нийцсэн санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээг түргэн шуурхай үзүүлдэг.

2021 оны жилийн эцсийн байдлаар Голомт банк нь Монгол Улсад үйл ажиллагаа явуулж буй жижиг дунд бизнес эрхлэгчдийн 16 гаруй хувьд зээлийн үйлчилгээ үзүүлсэн байна.



Үнэт цаас гаргагч нь харилцагчдын хувьд жендер, түүнийг дагасан эдийн засгийн хөгжлийн асуудлыг анхааран ажилладаг. Тус зорилгын хүрээнд бизнес эрхлэгч эмэгтэйчүүдийг дэмжих санхүүгийн чадавхийг нь сайжруулах, үйлдвэрлэл үйлчилгээ эрхлэх боломжоор хангах зорилготой санхүүгийн хөтөлбөрийг хэрэгжүүлж, санхүүжилт олгодог.

Голомт банк нь бизнес эрхлэгч эмэгтэйчүүдийг дэмжиж хөнгөлөлттэй зээл олгохоос гадна бизнесийг өргөжүүлэн тэлэхэд шаардлагатай мэргэжлийн сургалт, мэдлэг болон санхүүгийн дэмжлэг туслалцааг хүргэх, олон улсын байгууллагуудтай харилцаа холбоо тогтооход нь дэмжин ажиллах, нийгмийн сайн сайхны төлөө чиглэсэн үйл ажиллагааг идэвхтэй хэрэгжүүлэх зорилго бүхий Жендерийн тэгш байдлын хороог байгуулсан.

Улмаар 2015-2020 онд Голомт банкны харилцагч бизнес эрхлэгч эмэгтэйчүүдэд олгосон зээлийн тоо 20 хувь, зээлийн дүн 30 хувиар өссөн байна.

Мөн 2017 онд АНУ-ын Олон Улсын Хөгжлийн агентлаг (USAID)-ийн санхүүжилттэй Хөгжлийн шийдэл ТББ-тай хамтран Бизнесийн тогтвортой хөгжлийг сайжруулах, ил тод байдлыг нэмэгдүүлэх хөтөлбөрөөр дамжуулан жижиг дунд бизнес эрхлэгчдийг чадавхжуулах зөвлөх үйлчилгээг үзүүлдэг.

2021 оны жилийн эцсийн байдлаар Голомт банк нь 80,000 гаруй жижиг, дунд, байгууллагын харилцагчдаас 1,059 тэрбум төгрөгийн эх үүсвэрийг бүрдүүлж, 909 тэрбум төгрөгийн зээлийн багцын үлдэгдэлтэй байна.

Үнэт цаас гаргагч нь жижиг дунд бизнес эрхлэгчдэд санхүүгийн тусламж, дэмжлэг үзүүлж хөнгөлөлттэй зээл олгохоос гадна тэдгээрийн мэдлэг чадварыг нэмэгдүүлэх, бизнест нь бодитой хувь нэмрээ оруулах зорилтын хүрээнд жил бүр томоохон арга хэмжээг зохион байгуулдаг.


Financial management convention (FMC) форум

Голомт банк нь эдийн засгийн өнөөгийн болон ирээдүйн чиг хандлагыг тодорхойлох Financial Managers convention санхүүчдийн чуулга уулзалтыг 2019-2021 онд тогтмол зохион байгуулсан. FMC чуулга уулзалтад 400 гаруй компанийн 500 орчим санхүүчид оролцдог.

Тус чуулга уулзалтад эдийн засаг, санхүүгийн үр дүн, түүнд нөлөөлөх хүчин зүйлсийг дүгнэн хэлэлцэж, туршлага хуваалцаад зогсохгүй ирэх жилүүдийн эдийн засгийн төлөв байдлын таамаглал, хариу авах арга хэмжээг дэвшүүлж, харилцагчдад бодит зөвлөгөө өгдгөөрөө онцлогтой.



Зураг 21. Financial Management convention арга хэмжээ



Next champions форум

Үнэт цаас гаргагч нь харилцагч бүрийн онцлогт тохирсон шинэ мэдлэг, мэдээллийг хүргэх, бизнест нь бодитой хувь нэмэр оруулах, олон улсад өрсөлдөхүйц хэмжээнд чадавхжуулах зорилгоор Next champions арга хэмжээг 2018-2019 онд зохион байгуулсан.

Тус арга хэмжээ нь жижиг дунд бизнес эрхлэгчдэд дэвшилтэт технологид суурилсан, дижиталчлагдсан бизнесийн загварыг бий болгож цаг хугацаа, зардлыг хэмнэх, ирээдүйд учирч болох эрсдэлээс хамгаалах боломжийг олгодгоороо онцлогтой. Тус арга хэмжээнд Монголын ТОП-600 аж ахуй нэгж хамрагдаж, Монголын бизнесийн шилдэг лидерүүд өөрсдийн менежментийн ухаан, ажлын арга барил, ололт амжилт, туршлага, ур чадвараас хуваалцдаг.




Зураг 22. Next Champions арга хэмжээ



Business conference форум

Голомт банк нь Монгол Улсын эдийн засгийн хөгжлийг түүчээлэгч аж ахуйн нэгжүүд, бизнесийн салбарынханд зориулан Business Conference форумыг Шинэ хандлага-Шинэ боломж нэрийн дор зохион байгуулсан. Чуулга уулзалтад Монгол улсын эдийн засгийг тодорхойлогч, бизнесийн салбарын 1,000 гаруй аж ахуйн нэгж, тэдгээрийн удирдлагууд оролцсон. Чуулга уулзалтаар салбарын шинжээчид Монгол Улсын макро эдийн засгийн тойм, Монгол Улсын эдийн засаг, санхүүгийн салбар дахь дижиталчлалын нөлөө зэрэг өргөн цар хүрээ бүхий сэдвийн хүрээнд туршлага солилцдог.

Зураг 23. Business Conference форум



Иргэдийн банкны зах зээл

Үнэт цаас гаргагч нь Монгол Улсын өнцөг булан бүрт харилцагч төвтэй банкны үйлчилгээг нэвтрүүлснээр 800,000 гаруй харилцагчийн хэрэгцээ шаардлагад нийцсэн бүтээгдэхүүн үйлчилгээг өөрийн салбар, тооцооны төв болон онлайн сувгуудаар хүргэж буй иргэдийн банкны зах зээлд тэргүүлэгчдийн нэг юм.

Голомт банк нь 2021 онд бүтээгдэхүүн үйлчилгээний чанарын моделийг шинээр нэвтрүүлж, чанарын хяналт, сайжруулалтыг тогтмол гүйцэтгэж эхэлсэн. Улмаар харилцагчийг таних, тэдгээрийн хэрэгцээ шаардлагыг тодорхойлж дүн шинжилгээ хийснээр чанартай, хурдтай, мэргэжлийн өндөр түвшний үйлчилгээг үзүүлэх боломж бүрдсэн.

2021 оны жилийн эцсийн байдлаар Голомт банк нь 3.2 их наяд төгрөгийн эх үүсвэрийг иргэдийн банкны буюу ритэйл харилцагчдаас бүрдүүлж, 1.3 их наяд төгрөгийн зээлийн багцын үлдэгдэлтэй байна.

Түүнчлэн, Үнэт цаас гаргагч нь иргэдийн санхүүгийн боловсролыг дээшлүүлэх, санхүүгийн сахилга батыг бий болгох, үнэнч хэрэглээг урамшуулах зэрэг иргэдэд чиглэсэн үйл ажиллагааг тогтмол зохион байгуулдаг. Тодруулбал:

Дэлхийн хуримтлалын өдөр арга хэмжээ

Дэлхийн улс орнуудын эдийн засгийн тусгаар тогтнолын баталгаа нь үндэсний хуримтлалын түвшнөөр тодорхойлогддог. Иймд Голомт банк нь урт хугацаанд Монгол Улсын эдийн засгийн дархлааг нэмэгдүүлэх зорилгоор Үндэсний хуримтлалын хөтөлбөрийг 2016 оноос хэрэгжүүлж эхэлсэн Тус хөтөлбөр нь иргэдийн санхүүгийн боловсролыг дээшлүүлэх зорилгоор ирээдүйд зориулан хуримтлал бий болгохын ач тусыг сурталчлан таниулдгаараа онцлогтой.

Зураг 24. Дэлхийн хуримтлалын өдөр арга хэмжээ



Luxlife өндөр зэрэглэлийн орон сууцны өдөрлөг

Luxlife буюу Өндөр зэрэглэлийн орон сууцны өдөрлөг нь Улаанбаатар хотын өндөр зэрэглэлийн орон сууцны төслүүдийг нэг дор төвлөрүүлэн иргэдэд хэрэгцээтэй мэдээ мэдээлэл өгөх, харьцуулан сонголт хийх боломжийг олгодгоороо ач холбогдолтой арга хэмжээ юм. Үнэт цаас гаргагч нь 2019-2020 онд тус арга хэмжээг амжилттай зохион байгуулсан.

Тус өдөрлөг нь зах зээлд нийлүүлэгдэж байгаа сүүлийн үеийн технологи нэвтрүүлсэн, сайн менежменттэй, сонин содон шийдэл гаргасан, жишиг болохуйц шинэ төслүүдийг танилцуулдгаараа онцлогтой.

Зураг 25. Lux life арга хэмжээ



ICT Expo арга хэмжээ

Үнэт цаас гаргагч нь харилцагчдын цаг завьг хэмнэх, амьдралын хэв маягт нь нийцэх хиймэл оюун ухаанд суурилсан дижитал шилжилтийн эхлэлийг тавьж, банкны салбарт технологийн хувьслыг өрнүүлж буй бүтээгдэхүүн үйлчилгээг ICT EXPO арга хэмжээнд тогтмол танилцуулдаг. Мөн дижитал шилжилт хурдасч буйтай холбогдуулан Монгол улсын техник, технологийн салбарын хөгжлийг тодорхойлох Digital Nation-2021 арга хэмжээг хамтран зохион байгуулагчаар ажилласан.




Зураг 26. ICT Expo арга хэмжээ



Үнэнч хэрэглээг урамшуулсан Лоялти хөтөлбөрүүд

Үнэт цаас гаргагч нь үнэнч харилцагчдыг урамшуулах, тэмдэглэлт баяруудыг угтан худалдан авалтын үнийн дүнгээс бэлэн мөнгөний урамшуулал, оноо, урамшууллын эрх олгох зэрэг төрөл бүрийн урамшуулалт хөтөлбөрүүдийг тогтмол хэрэгжүүлдэг.

Зураг 27. Голомт Лоялти платформ



3.5 Үнэт цаас гаргагчийн хүний нөөцийн бодлого

Үнэт цаас гаргагч нь хүний нөөцийн менежментийн нэгдсэн бодлого, стратеги, талант менежмент, сургалт хөгжлийн үйл ажиллагааг олон улсын чиг хандлагад нийцүүлэн хэрэгжүүлдэг.

Голомт банк нь хүний нөөцийн бодлого, тэргүүлэх туршлагаар Монгол Улсад манлайлах, чадварлаг, зөв багийг бүрдүүлж тасралтгүй хөгжүүлэх замаар банкны бизнесийн зорилтыг амжилттай хэрэгжүүлэх, өгөгдөлд суурилсан хүний нөөцийн удирдлагыг Дэлхийн жишигт нийцүүлэн амжилттай хэрэгжүүлэх зорилготой ажилладаг.

Түүнчлэн хүний нөөцийн бүхий л үйл ажиллагаа буюу томилгоо, цалин хөлс, урамшууллын тогтолцоо нь шударга тодорхой байх, ажилтан болон ажил горилогчдод ойлгомжтой байх, удирдлагын бүхий л үйл ажиллагааг тасралтгүй сайжруулах зарчмыг баримталдаг.

Үнэт цаас гаргагч нь хүний нөөцийн бодлогын хүрээнд хөдөлмөр эрхлэлтийн оролцогч талуудад дараах давуу тал, боломжийг олгодог. Үүнд:

- Байгууллагын тогтсон соёл болон сайн засаглал;
- Байгууллагын түвшний тогтвортой хөдөлмөр эрхлэлт;
- Хүний нөөцийн үл ялгаварлах бодлого буюу бүх шийдвэр гаргалт, үйл ажиллагаанд мерит систем;
- Цалин хөлс, шагнал, урамшуулал, хөнгөлөлт хангамжийн багц;
- Сургалт хөгжлийн модельд суурилсан нэгдсэн сургалтын систем;
- Тасралтгүй сурч, хөгжих, карьераа удирдах боломж;
- Ажилтан, тэдний гэр бүлийн сайн сайхан байдал, бие болон сэтгэл зүйн эрүүл мэндэд чиглэсэн төсөл, хөтөлбөр;
- Хариуцлагатай банкны зарчмын хүрээнд Тогтвортой хөгжлийн зорилтууд - 2030-тай уялдсан нийгмийн хариуцлагын хөтөлбөр, арга хэмжээ;
- Гибрид ажлын байр болон уян хатан ажлын цаг;
- Бүтээлч, өндөр гүйцэтгэл бүхий шилдэг, залуу хамт олон.

Үнэт цаасны танилцуулга бэлтгэх өдрийн байдлаар Голомт банк нь нийт 2,226 ажилтантай үйл ажиллагаа явуулж буйгаас 72 хувийг нь 35-аас доош насны залуус бүрдүүлж байна. Жендерийн тэгш байдлыг хангах бодлогын хүрээнд нийт ажилтнуудын 69 хувь, удирдах албан тушаалтнуудын 47 хувийг эмэгтэй ажилтнууд бүрдүүлдэг.



Шагнал урамшуулал

Голомт банк нь ажил үйлсээрээ манлайлсан шилдэг ажилтнуудыг урамшуулах, дэмжлэг үзүүлэх бодлогыг баримталдаг. Тодруулбал, 2021 онд Төрийн дээд одон медал болох Алтангадас, Хөдөлмөрийн хүндэт медаль болон Монголбанкны нэрэмжит шагналаар нийт 600 гаруй ажилтан шагнагдсан.

Түүнчлэн 2007 оноос эхлэн шилдгийн шилдэг буюу Од ажилтныг шалгаруулж, тэдгээрийг орон сууц, автомашин болон мөнгөн шагналаар урамшуулж ирсэн. Мөн ажилтны чадамжийн удирдлагыг амжилттай хэрэгжүүлж, ажилтнуудын цалинг тасралтгүй нэмэгдүүлж байна.

Зураг 28. Ажилтнуудын шагнал урамшуулал



Ажилтнуудын эрүүл мэнд, хувь хүний хөгжилд чиглэсэн ажлууд

Үнэт цаас гаргагч нь ажилтнуудын гэр бүлд зориулж жил бүр Ойн булаг зуслангийн хөтөлбөр, жирэмсний амралтаа авсан, хүүхдээ асарч байгаа ажилтнуудын хувийн хөгжил, гэр бүлийн харилцаанд зориулсан G-Mommy-2.0 хөтөлбөрийг амжилттай хэрэгжүүлж байна.

Ковид-19 цар тахлын үед Үнэт цаас гаргагч нь зайнаас ажиллаж буй ажилтнуудын биеийн болон сэтгэл зүйн эрүүл мэндийг хамгаалах, ажилтны идэвх оролцоог нэмэгдүүлэх, сурч хөгжих боломжийг нэмэгдүүлэх зорилготой цуврал сургалт, хөтөлбөрийг хэрэгжүүлж, банкны харилцагчдад үйлчилгээ үзүүлдэг салбар тооцооны төвийн нийт ажилтнуудыг Ковид-19 даатгалд хамруулж, эрүүл мэндийг нь хамгаалан ажиллаж байна.



Зураг 29. Ажилтнуудын эрүүл мэнд, сайн сайхан байдалд чиглэсэн ажлууд



Ёс зүйг дээшлүүлэх хүрээнд чиглэсэн ажлууд

Голомт банк нь ажилтны ёс зүйн хэм хэмжээг дээшлүүлэхэд онцгойлон анхаарч ажилладаг. 2020 оноос ёс зүйн хэм хэмжээг сахиулах, зөв хандлагыг төлөвшүүлэх зорилтын хүрээнд Зөв ажилтан байя нөлөөллийн аяныг хэрэгжүүлж эхэлсэн. Мөн ажилтны ёс зүйн зөрчлөөс үүдэлтэйгээр үйл ажиллагаанд учирч болох аливаа эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор Ёс зүйн цуврал сургалтыг тогтмол зохион байгуулдаг.

Карьер, сонгон шалгаруулалт

Үнэт цаас гаргагч нь жилд 250 гаруй шинэ ажилтныг хүлээн авдаг бөгөөд ажилтанд өөрийн карьер төлөвлөлтөд нийцсэн ажлын шилжилт хөдөлгөөнийг хийх боломжийг олгодог.

2005 оноос оюутан залуусын онолын мэдлэгийг ажлын байранд бататгах, банкны үйл ажиллагаатай холбоотой судалгааны ажилд биечлэн оролцуулах зорилгоор Golomt-Internship хөтөлбөрийг хэрэгжүүлж эхэлсэн.

Тус хөтөлбөр нь оюутнуудад бизнесийн бодит төслийг хэрэгжүүлэхэд хамтран ажиллаж, өөрийгөө сорих, шинэ мэдлэг эзэмших, туршлага суух боломж бүхий цогц хөгжлийн сургалтуудад хамрагдах, өөрийгөө сорих, цалинтай ажиллах боломжийг бүрдүүлсэн.

Сургалт хөгжил

Үнэт цаас гаргагч нь ажилтан бүрт тасралтгүй суралцах, өөрийгөө хөгжүүлэх нөхцөлийг бүрдүүлэх үүднээс Голомт банкны Сургалтын академийг үүсгэн байгуулсан. Мөн Ажилтан-Та хөгжлийн голомт уриан доор банкны сургалт, хөгжлийн модельд үндэслэсэн хөтөлбөрийг тогтмол хэрэгжүүлдэг.



Түүнчлэн удирдах ажилтны залгамж халааг тасралтгүй бэлдэх зорилгоор ирээдүйн удирдагчдад зориулсан Удирдах ажилтан бэлтгэх хөтөлбөрийг хэрэгжүүлдэг нь үйл ажиллагааны тасралтгүй байдлыг хангахад чухал түлхэц болдог.

2021 онд нийт удирдах ажилтнуудыг Non HR manager сургалт, Англи улсад төвтэй Global growth institute-Гүрэн академитай хамтарсан World class manager, Executive development program, ажлын байран дахь коучинг, олон улсын мэргэжлийн байгууллагын гишүүнчлэл болон илтгэх ур чадварын сургалт зэрэг хөтөлбөрүүдэд хамруулсан.

Зураг 30. Үнэт цаас гаргагчийн сургалт хөгжлийн үйл ажиллагааны хүрээнд хийгдсэн ажлууд



Тэтгэврийн хуримтлалын тогтолцоо

Үнэт цаас гаргагч нь ажилтнуудаа Тэтгэврийн ууган санд (ТУС) элсүүлэн, ажилтан, ажил олгогч тэнцүү хувиар хувийн тэтгэврийн хуримтлалыг бий болгож ажилтнуудынхаа ирээдүйг баталгаажуулж байна.

“Тэтгэврийн Ууган сан” нь 2010 оны 7 сарын 2-ны өдөр Голомт банк болон ажилтнуудын хамтын санаачлагаар Монгол улсын тэтгэврийн тогтолцоонд шинэчлэл хийж, хувийн тэтгэврийн системийг бий болгох замаар ажилтнуудыг тэтгэврийн насанд хүрэхэд нэмэлт тэтгэврийн орлогыг хангалттай бүрдүүлсэн байх зорилготойгоор анхлан байгуулагдаж үйл ажиллагаагаа явуулж эхэлсэн.

2021 оны жилийн эцсийн байдлаар 1,300 гаруй ажилтнууд тус санд элссэн байна.



3.6 Үнэт цаас гаргагчийн тогтвортой хөгжлийн бодлого

Үнэт цаас гаргагч нь 2015 оноос Тогтвортой санхүүжилтийн бодлогыг хэрэгжүүлж ирсэн. 2019 онд Тогтвортой хөгжлийн бодлого болгон өөрчилснөөр зөвхөн санхүүжилт бус банкны бүх шатны үйл ажиллагаанд тогтвортой хөгжлийн зорилтыг нутагшуулан ажиллаж байна.

Үүнд банкны стратегийн үндсэн чиглэл болох тогтвортой үйл ажиллагаа явуулах, нийгэм, байгаль орчны асуудалд анхаарал хандуулах, тогтвор суурьшилтай, сэтгэл ханамжтай ажлын байрыг нэмэгдүүлэх зэрэг багтана.

Голомт банк нь бүтээгдэхүүн, үйлчилгээгээр дамжуулан уур амьсгалын өөрчлөлтийн тэнцвэрт байдлыг хангах, хүрээлэн буй орчин, нийгэмд ээлтэй төсөл хөтөлбөрийг дэмжин ажилладаг.

Тогтвортой Санхүүжилтийн Холбоо (ТоС Холбоо)

ТоС Холбоо нь Монгол Улсын санхүүгийн болон бизнесийн байгууллагын үйл ажиллагаанд байгаль орчин, нийгэмд ээлтэй тогтвортой санхүү, ногоон зээл, хөрөнгө оруулалтыг хийх дэд бүтцийг бүрдүүлэх, тогтвортой хөгжил, ногоон эдийн засгийн өсөлтийг дэмжих зорилгоор үүсгэн байгуулагдсан.

Үнэт цаас гаргагч нь ТоС Холбооны үндсэн гишүүний хувьд Монгол Улсын тогтвортой санхүүжилтийн 8 зарчмыг дэмжин, хэрэгжүүлж буй төсөл хөтөлбөр, сургалтуудад идэвхтэй оролцож тогтвортой санхүүжилтийн бодлогыг үйл ажиллагаанд нэвтрүүлэн ажилладаг.

Голомт банк нь ТоС Холбооны 2021 оны Манлай байгууллага, 2020 оны "Онцлох Тос Банк" -аар байгаль орчин, нийгмийн эрсдэлийн удирдлага, ногоон зээл, ТоС-ийн сургалт хөгжил зэрэг ажлуудаараа манлайлан шалгарсан.

НҮБ-ын Байгаль Орчны Хөтөлбөр

Голомт банк нь анх 2017 онд UNEP FI-ийн банкны хороонд нэгдэж "Хариуцлагатай банкны зарчмууд"-ыг боловсруулах ажлын багт оролцон эдгээр зарчмуудыг үндэслэгч анхны 30 банкны нэг болсон.

2019 оны 9-р сард НҮБ-ын Байгаль Орчны Хөтөлбөр Санхүүгийн Санаачилгаас гаргасан Хариуцлагатай Банкны Зарчмуудад албан ёсоор нэгдэж, НҮБ-ын тогтвортой хөгжлийн зорилтууд болон Парисын хэлэлцээрийн зорилтуудтай өөрийн үйл ажиллагааг уялдуулан, уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг хувь нэмрээ оруулан ажиллаж байна.



Байгаль орчин, нийгмийн эрсдэлийн үнэлгээ

Үнэт цаас гаргагч нь тогтвортой хөгжлийн бодлогын хүрээнд зээл, төслийн шийдвэр гаргалтад байгаль орчин, нийгмийн эрсдэлийг харгалзан, удирдах боломжтой гэж үзсэн тохиолдолд төслийг санхүүжүүлэх зарчмыг баримтлан ажилладаг.

2019 оны 9-р сард байгаль орчин, нийгмийн эрсдэлийн мэргэшсэн үнэлгээг зээлийн үйл ажиллагаанд нэвтрүүлж, байгаль орчин, нийгмийн эрсдэлийн үнэлгээний аргачлалыг тогтвортой хөгжлийн зарчмуудад тусгаж шинэчилсэн. Үүнд байгаль орчин, хүний эрх, нийгмийн эрх ашиг, соёлын өвийг хамгаалах, ёс зүйтэй санхүүжилт, компанийн засаглалыг дэмжих, манлайлан үлгэрлэх зэрэг зарчмууд багтана.

Ногоон зээл

2019 оны 4 дүгээр улирлаас эхлэн Монгол Улсын арилжааны банкууд ногоон зээлийг ангилан, Монголбанканд сайн дураар тайлагнаж эхэлсэн. Тус жишгийн дагуу Үнэт цаас гаргагч нь улирал бүр ногоон зээлийн багцыг тайлагнаж, хэмжээг нь жил бүр нэмэгдүүлж байна.

2018 оны 3 дугаар улирлын байдлаар ногоон зээлийн багц нийт зээлийн багцын 1.7 хувийг эзэлж байсан бол 2019, 2020 онд 5 хувиар өссөн байна. 2021 оны жилийн эцсийн байдлаар Голомт банкны ногоон зээлийн багцын үлдэгдэл 97.8 тэрбум төгрөгт хүрсэн нь нийт багцын 3 орчим хувийг эзэлж байна.

3.7 Үнэт цаас гаргагчийн нийгмийн хариуцлагын хүрээнд хэрэгжүүлсэн ажлууд

Үнэт цаас гаргагч нь бүтээгдэхүүн үйлчилгээний чанар хүртээмжээр банкны салбарт манлайлахаас гадна иргэдийн хувийн санхүү, эрүүл мэнд, боловсрол, байгаль орчин зэрэг нийгэм, эдийн засгийн хөгжилд үнэтэй хувь нэмэр оруулж ирсэн.

Боловсролыг дэмжих хүрээнд

Монгол Улсын ирээдүйн хөгжил цэцэглэлт нь өндөр ур чадвар, өргөн мэдлэг, зөв хандлагатай, боловсролтой залуусаас шалтгаалдаг гэсэн зарчмын дор Үнэт цаас гаргагч нь үйл ажиллагааны бүхий л түвшинд боловсролын салбарыг дэмжиж ирсэн. Үүнээс дурдвал:

- Бизнесийн байгууллагаас анх удаа оюутанд зориулсан багц хөтөлбөрийг санаачлан хэрэгжүүлсэн. Тус хөтөлбөрийн хүрээнд нийт 1,500 оюутанд 1 тэрбум гаруй төгрөгийн тэтгэлэг олгосон.



- Алтантүлхүүр хүүхдийн хадгаламжийн хүүний 1 хувийг жил бүр хүүхдийн сайн сайхныг санхүүжүүлэхэд зориулан Алтантүлхүүр санд хуримтлуулдаг.
- Харилцагчдад санхүүгийн боловсрол олгох зорилгоор МҮОНРТ-тэй хамтран Харилцагчийн санхүүгийн боловсролд нэвтрүүлгийг бэлтгэн хүргэсэн.
- Эдийн засгийн мэдлэг мэдээлэл олгох, хувь хүний болон өрхийн санхүүгийн хэрэгцээг хэрхэн шийдвэрлэх талаарх мэдлэгийг олгох зорилгоор Бизнес радио 98.9 радиотой хамтран Таны санхүүгийн боловсролд нэвтрүүлгийг бэлтгэн хүргэсэн.
- Монголбанк, Монголын банкны холбоо, ХБНГУ-ын Шпаркасэ банктай хамтран зохион байгуулдаг Дэлхийн хуримтлалын өдөр-2020 аяны хүрээнд иргэдийн санхүүгийн боловсролыг нэмэгдүүлэх, хуримтлуулах зуршлыг төлөвшүүлэхэд манлайлан ажилласан.
- Орон сууцны зээлийн талаар зөв мэдлэг, мэдээлэл өгөх зорилгоор Моргэйжийн боловсрол хөтөлбөрийг анх удаа санаачлан хэрэгжүүлж, 2,500 гаруй хүнийг сургалт, уулзалт, арга хэмжээнд хамруулан мэдлэг түгээсэн.
- Санхүүгийн цогц боловсрол олгох FINEDU вебсайт /www.finedu.mn/ болон Монголдоо анхдагч эдийн засгийн судалгааны DUA вебсайт /www.dua.golombank.com/ платформуудыг танилцуулсан.

Зураг 31. Үнэт цаас гаргагчийн боловсролыг дэмжих бодлогын хүрээнд хийгдсэн ажлууд



Спорт, соёл урлагийг дэмжих хүрээнд

Спорт, соёл, урлагын салбар нь Монгол Улсын хөгжил дэвшлийг илтгэдэг онцгой салбар гэж үзэн Үнэт цаас гаргагч нь олимпийн наадамд оролцож буй баг тамирчдыг дэмжин ивээн тэтгэж ирсэн.

Улс хоорондын найрамдалт харилцааг бэхжүүлэхэд хувь нэмрийг оруулах зорилгоор Голомт банк нь элчин сайдын яамдын дунд нөхөрсөг хөлбөмбөгийн тэмцээнийг тогтмол зохион байгуулдаг. Мөн Монгол үндэстний соёлын их өв болсон язгуур урлагийг түгээн дэлгэрүүлэхэд үйл ажиллагааг чиглүүлэн ажилладаг. Тодруулбал:

- Бразил улсад зохиогдсон Зуны Олимпийн XXXI, Пара-олимпийн XV наадамд Монгол Улсыг төлөөлөн оролцох баг тамирчдыг дэмжин ажилласан.
- Монгол Улсад зохион байгуулагдсан Ази тивийн Оюутны сагсан бөмбөгийн аварга шалгаруулах 6 дахь удаагийн тэмцээнийг ивээн тэтгэсэн.
- Монголын Хүүхэд Залуучуудын Соробан Сампингийн холбооноос зохион байгуулдаг Соробаны баяр, Соробан сампингийн үндэсний аварга шалгаруулах тэмцээнийг ивээн тэтгэсэн.
- Монгол үндэстний язгуур урлагийг түгээн дэлгэрүүлэх, дэлхий дахинд сурталчлах үйлсэд хувь нэмрээ оруулан Монгол Улсын морин хуурын чуулгатай 8 дахь жилд хамтран ажилладаг.
- Сонгодог урлагийн боловсролыг олгох, түгээх, сурталчлах зорилгоор Дуурь Бүжгийн Эрдмийн Театрын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэн ажилладаг.

Зураг 32. Үнэт цаас гаргагчийн соёл урлагийг дэмжих хүрээнд хийгдсэн ажлууд



Нийгэмд чиглэсэн ажлын хүрээнд

Үнэт цаас гаргагч нь нийгмийн сайн сайхан байдлыг хангах зорилгоор нийгэмд чиглэсэн төсөл хөтөлбөрийг тогтмол хэрэгжүүлдэг. Тодруулбал:

- Алтантүлхүүр хүүхдийн сангаар дамжуулан 2020 оноос Зүрх мартаггүй төслийг дэмжин ажиллаж нийт 170 хүүхдэд амьдрал бэлэглэх үйлсэд нэгдсэн.
- 2020 онд иргэдийн санхүүгийн дархлааг дэмжих ВитаминҢ аяныг таван сарын турш хэрэгжүүлснээр 400,000 гаруй харилцагчийг хуримтлалтай болгосон.
- Эх дэлхийгээ хайрлая уриан дор мод тарих аяныг сүүлийн хоёр жил зохион байгуулж, 500 гаруй ширхэг гацуур мод тарьсан.
- Хайраа хуваалцъя сайн үйлсийн аяныг санаачлан хэрэгжүүлснээр Эрдэнэт хотын хүүхдийн асрамжийн газар, Хүүхдийн сурган хүмүүжүүлэх төв, Өнөр бүл асрамжийн газар, ХУД-ийн хүүхдийн хүчирхийллийн хохирогчдод үйлчилгээ үзүүлэх түр байр, Хүрээ амаржих газруудад дэмжлэг үзүүлэн, нийт 250 хүүхэд, 50 гаруй нярай болон амаржсан ээжүүдэд зориулсан сайн үйлсийн ажлыг зохион байгуулсан.
- “Ид шидийн орон” төсөлд нэгдэн хүүхдийн аюулгүй, тав тухтай орчинд сурах, хөгжих, хүмүүжих нөхцөлийг бүрдүүлэхэд хувь нэмэр оруулан ажиллаж байна.



Зураг 33. Үнэт цаас гаргагчийн нийгмийн хариуцлагын хүрээнд хийгдсэн ажлууд



Хууль эрх зүйн орчин ба Банкны хуулийн шинэчлэл

Үнэт цаас гаргагчийн үндсэн үйл ажиллагаа нь дараах хууль тогтоомжийн холбогдох хэсгээр зохицуулагдаж байна. Үүнд:

- Иргэний хууль;
- Банкны тухай хууль;
- Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, мөнгөн хөрөнгийн шилжүүлэг, зээлийн үйл ажиллагааны тухай хууль;
- Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль;
- Банкин дахь мөнгөн хадгаламжийн даатгалын тухай хууль;
- Банкны салбарын тогтвортой байдлыг хангах тухай хууль;
- Валютын зохицуулалтын тухай хууль;
- Үнэт цаасны зах зээлийн тухай хууль;

- Компанийн тухай хууль;
- Татварын ерөнхий хууль;



- Хөдөлмөрийн тухай хууль;
- Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хууль;
- Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль;
- Коронавирус халдвар /Ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хууль.

Мөн Үнэт цаас гаргагч нь зохицуулалттай үйл ажиллагаа эрхэлдэг тул төрийн эрх бүхий байгууллагаас баталсан дүрэм, журмыг дагаж мөрддөг. Үүнд тухайлбал:

Монголбанкнаас батлагдсан голлох ач холбогдол бүхий журмууд

- Монголбанкны Ерөнхийлөгчийн 2019 оны 03-р сарын 22-ны өдрийн А-82 тоот тушаалаар баталсан "Банкны үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн журам";
- Монголбанкны Ерөнхийлөгчийн 2014 оны 09-р сарын 30-ны өдрийн А-51 тоот тушаалаар баталсан "Банкны зохистой засаглалыг хэрэгжүүлэх журам";
- Монголбанкны Ерөнхийлөгчийн 2019 оны 05-р сарын 23-ны өдрийн А-138 тоот тушаалаар баталсан "Банкны үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тогтоох, түүнд хяналт тавих журам";
- Монголбанкны Ерөнхийлөгчийн 2019 оны 03-р сарын 22-ны өдрийн А-82 тоот тушаалаар баталсан "Банкны хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, бүтцэд өөрчлөлт оруулах зөвшөөрлийн журам";
- Монголбанкны Ерөнхийлөгчийн 2012 оны 07-р сарын 03-ны өдрийн А-99 тоот тушаалаар баталсан "Банкны нэгжийн журам";

Санхүүгийн Зохицуулах Хорооноос батлагдсан голлох ач холбогдол бүхий журмууд

- Санхүүгийн Зохицуулах Хорооны даргын 2019 оны 01-р сарын 09-ний өдрийн 04 тоот тушаалаар баталсан "Үнэт цаасны зах зээлд зохицуулалттай үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн журам";
- Санхүүгийн Зохицуулах Хорооны даргын 2014 оны 07-р сарын 03-ны өдрийн 85 тоот тушаалаар баталсан "Кастодианы тусгай зөвшөөрлийн болон үйл ажиллагааны журам";
- Санхүүгийн Зохицуулах Хорооны даргын 2019 оны 01-р сарын 09-ний өдрийн 04 тоот тушаалаар баталсан "Хөрөнгийн зах зээлийн зохицуулалттай этгээдээс мэдээлэл ирүүлэх, түүнд хяналт тавих журам";
- Санхүүгийн Зохицуулах Хорооны даргын 2019 оны 01-р сарын 09-ний өдрийн 04 тоот тушаалаар баталсан "Зохицуулалттай этгээдийн эрсдэлийн сангийн журам".

Банкны тухай хуулийн шинэчлэл

Монгол Улсын Их Хурлаас 2021 оны 1-р сарын 29-ны өдөр Банкны тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулсан бөгөөд арилжааны банкуудын хувьцаа эзэмшил,



удирдлагын төвлөрсөн байдлаас үүдэлтэй эрсдэлийг бууруулах зорилгоор банкны системд нөлөө бүхий банк нь нээлттэй хувьцаат компани, бусад банк нь хувьцаат компанийн хэлбэртэй байх шаардлагыг тогтоож өгсөн юм.

Тус нэмэлт өөрчлөлттэй хамт Банкны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийг баталж, банкуудад хуульд заасан шаардлагыг хэрэгжүүлэх хугацаа, үнэт цаасаа нийтэд нээлттэй болон хаалттай хүрээнд санал болгох төлөвлөгөө, хувьцааны үнийн төсөөлөл, боломжит хөрөнгө оруулагчдын тандан судалгаа зэргийг тусгасан төлөвлөгөөг батлан 2021 оны 07-р сарын 01-ний дотор Монголбанк, Санхүүгийн Зохицуулах Хороонд хүргүүлэх болон 2023 оны 06-р сарын 30-ны өдрийн дотор хувьцаат компанийн хэлбэртэй болох үүрэг ногдуулсан байна.

Дээрх хууль тогтоомжийг хэрэгжүүлэх зорилгоор Монголбанкны Ерөнхийлөгч, Санхүүгийн Зохицуулах Хорооны даргын 2021 оны 03-р сарын 26-ны өдрийн А-90/85 тоот тушаалаар “Банкийг хувьцаат компани хэлбэртэйгээр өөрчлөн байгуулах, хувьцаа эзэмшигчдийн бүтэц, хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг өөрчлөх төлөвлөгөөг боловсруулах, хэрэгжүүлэх, тайлагнах, хянах түр журам”, 2021 оны 03-р сарын 26-ны өдрийн А-90/85 тоот тушаалаар “Хувьцаат компани хэлбэртэй банкны хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, хувьцаа эзэмшигчдийн бүтэцэд өөрчлөлт оруулах зөвшөөрлийн журам”-ыг тус тус баталжээ.

Банкыг өөрчлөн байгуулах төлөвлөгөө

Үнэт цаас гаргагч нь дээрх хууль тогтоомжид заасны дагуу “Нээлттэй хувьцаат компани болох, хувьцаа эзэмшигчдийн бүтэц, бүрэлдэхүүн, хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээнд өөрчлөлт оруулах төлөвлөгөө”-г боловсруулж хүргүүлсэн бөгөөд уг төлөвлөгөөний хэрэгжилтийн талаарх тайланг мөн эрх бүхий байгууллагаас тогтоосон шаардлагыг хангасан байдлаар хүргүүлсэн болно. Үнэт цаас гаргагч нь уг төлөвлөгөөний дагуу хувьцааг олон нийтэд санал болгон арилжаалж, нээлттэй хувьцаат компанийн хэлбэртэй болохтой холбоотой арга хэмжээнүүдийг цаг хугацаанд авч хэрэгжүүлэн ажиллаж байна.



3.8 Эрсдэлийн удирдлага

Эрсдэлийн хүчин зүйлс

Үнэт цаастай холбоотой эрсдэл

<p>Хувьцааны хөрөнгө оруулалттай холбоотой эрсдэл</p>	<p>Хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүн бүр эрсдэлтэй байдаг ба үүнд хувьцааны үнийн хэлбэлзэл багтана. Үнэт цаас гаргагч нь нээлттэй зах зээл дээрх үнийн амлалт, баталгаа гаргаж өгөхгүй ба хувьцааны эрэлт, нийлүүлэлт болон зах зээлийн хандлагаас шалтгаалж үнэ тогтоно.</p>
<p>Хөрвөх чадварын эрсдэл</p>	<p>Хувьцааны эрэлт, нийлүүлэлтээс шалтгаалж хувьцааны арилжааны идэвх тогтдог ба хувьцааны идэвхийн тухай Үнэт цаас гаргагч баталгаа гаргахгүй. Хөрөнгө оруулагч ялангуяа их хэмжээний арилжаа хийх тохиолдолд тухайн үеийн арилжааны идэвхтэй холбоотойгоор хүссэн хэмжээгээр, эсхүл хүссэн үнэ ханшаар зарах, худалдан авах боломжгүй байж болзошгүй.</p>
<p>Ногдол ашигтай холбоотой эрсдэл</p>	<p>Ногдол ашигтай холбоотой шийдвэрийг Төлөөлөн удирдах зөвлөл гаргаж, Хувьцаа эзэмшигчдийн хурлаар баталдаг бөгөөд ирээдүйд ногдол ашиг тараахгүй байх, хөрөнгө оруулагчийн хүлээлтээс багаар ногдол ашиг тараах зэрэг эрсдэлийн хүчин зүйлс байгааг анхаарна уу.</p>

Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд учирч болзошгүй эрсдэлүүд

<p>Макро эдийн засгийн эрсдэл</p>	<p>Макро эдийн засгийн хүчин зүйлс болох гадаад, дотоодын зах зээлийн эдийн засгийн нөхцөл байдал, санхүүгийн зах зээлийн чиг хандлага Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд шууд болон шууд бусаар нөлөөлдөг.</p>
<p>Хууль эрх зүйн орчин, хяналт зохицуулалтын эрсдэл</p>	<p>Үнэт цаас гаргагч нь Монгол улсын хууль эрх зүйн хүрээ болон Олон улсын стандарт, гэрээ хэлцлүүдийн хүрээнд үйл ажиллагаагаа явуулдаг ба эдгээр хууль, хяналт зохицуулалтын өөрчлөлт Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд нөлөөлдөг.</p>
<p>Салбарын эрсдэл</p>	<p>Банкны салбарын томоохон, нөлөө бүхий банкны үйл ажиллагааны доголдол, санхүүгийн байдал нь Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд нөлөөлөх эрсдэлтэй байдаг.</p>
<p>Зээлийн эрсдэл</p>	<p>Зээлийн эрсдэлд зээлдэгч гэрээний үүргээ биелүүлэх, зээлийн үндсэн төлбөр, хүүгийн төлбөрийг цаг хугацаанд нь төлөхгүй байх, зээлийн чанар муудах зэрэг эрсдэл орно. Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаа явуулж буй салбарын</p>



Үйл ажиллагааны эрсдэл	онцлогт энэхүү эрсдэл нь томоохон эрсдэлүүдийн нэг болно. Банкны үйл ажиллагаанд дотоод болон гадаад хүчин зүйлээс шалтгаалж дотоод үйл ажиллагааны, системийн эрсдэлүүд үүсч байдаг ба Үнэт цаас гаргагч эдгээр эрсдэлүүдээ удирдаж, хяналтандаа авч ажилладаг.
Нэр хүндийн эрсдэл	Банкны үйл ажиллагаа, менежмент болон бусад гадаад дотоод үйл ажиллагаанаас үүдэлтэй олон нийтийн дунд сөрөг сэтгэгдэл үүсэх, банкны нэр хүндэд сөрөг нөлөө үзүүлэх нь нэр хүндийн эрсдэл юм.

Үнэт цаас гаргагч нь банкны үйл ажиллагаанд мөрдөх хууль журмын дагуу холбогдох зохицуулалтын шаардлагыг тогтмол ханган биелүүлж, эдийн засгийн таагүй нөхцөл байдлаас үүдэн гарах эрсдэлийг бууруулж, бизнесийн тогтвортой хөгжлийг баталгаажуулан ажилладаг.

Тодруулбал, харилцагч, хадгаламж эзэмшигч, хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалах зорилгоор эрсдэлийн менежментийн нэгдсэн, цогц системийг үйл ажиллагааны бүхий л үе шатанд нэвтрүүлсэн.

Үнэт цаас гаргагчийн эрсдэлийн удирдлагын тогтолцоо нь бизнесийн зорилтод хүрэхийн тулд хүлээн зөвшөөрөх эсвэл зайлсхийх ёстой эрсдэлийн төрөл, тэдгээрийн хэм хэмжээг тодорхойлох, хэрэгжүүлэх, хянахад шаардлагатай бодлого, зохицуулах журам, удирдлагыг хамруулсан, Банкны Хяналт Шалгалтын Базелийн Хорооны (Базел-III) стандартыг жишиг болгон боловсруулсан цогц систем юм.


Эрсдэлийн удирдлагын тогтолцоо нь гурван шугамын аргачлал бүхий эрсдэлийн засаглалын бүтцээс бүрддэг. Үүнд:

<p>Нэгдүгээр шугам Бизнесийн нэгжүүд болон тэдгээрийг дэмжих чиг үүрэгтэй нэгжүүд</p>	<p>Хоёрдугаар шугам Эрсдэлийн удирдлагын тогтолцоо, үйл явц болон эрсдэлийг удирдан чиглүүлэх, нэгжүүдийн эрсдэлийн удирдлагад хяналт тавих нэгжүүд</p>	<p>Гуравдугаар шугам Дотоод аудитын чиг үүрэгтэй нэгжүүд</p>
--	--	---



Эрсдэлийн удирдлагын тогтолцоо нь Банкны стратеги төлөвлөгөө, бизнес төлөвлөгөө, эрсдэлийн аппетитийн¹ мэдэгдэл, стресс тест, өөрийн хөрөнгө болон хөрвөх чадварын хүрэлцээний төлөвлөлт зэргийн хоорондын холбоо, зохицуулалтыг илэрхийлдэг.

Схем 6. Үнэт цаас гаргагчийн эрсдэлийн удирдлагын тогтолцоо



¹ Эрсдэлийн аппетит нь банкны эрсдэл даах чадварын хүрээнд стратегийн зорилго, бизнес төлөвлөгөөнд хүрэхийн тулд хүлээн зөвшөөрөх эрсдэлийн төрөл, хэм хэмжээг илэрхийлдэг.



Үнэт цаас гаргагчийн эрсдэлийн удирдлага нь стратеги төлөвлөгөөтэй нийцтэй байх бөгөөд зах зээлийн хэвийн болон хүндрэлтэй үед Банканд учирч болзошгүй материаллаг эрсдэлүүд болон чанарын хязгаарлалтуудыг авч үздэг. Тус эрсдэлийн удирдлагыг ТУЗ болон гүйцэтгэх удирдлага дараах түвшинд тодорхойлж хэрэгжүүлдэг. Үүнд:

Схем 7. Эрсдэлийн удирдлагын үйл явц



Үнэт цаас гаргагчийн эрсдэлийн удирдлагын үндсэн зорилго нь ТУЗ-өөс баталсан эрсдэлийн аппетитийн хүрээнд Банкны ашигт ажиллагаа, зах зээлд эзлэх байр суурийг тогтвортой өсгөх, хувьсан өөрчлөгдөх бизнесийн орчинд тогтвортой оршин тогтнох эрсдэлийн хүчирхэг тогтолцоог бий болгоход чиглэдэг.

Эрсдэлийн удирдлагын бодлогод Банкны журам, дүрэм, төлөвлөгөөг чанд сахидаг байх, мэргэжлийн ёс суртахуунтай байх, мэргэжлийн ур чадвартай байх, мэдээллийн нууцлал, аюулгүй байдлыг ханган ажиллах, сонирхлын зөрчил, хээл хахуулиас ангид байх зарчмыг баримтлан ажилладаг.

Голомт банкны үйл ажиллагаанд учирч болох үндсэн эрсдэлд зээлийн, зах зээлийн, хөрвөх чадварын, үйл ажиллагааны, мэдээллийн аюулгүй байдлын, нэр хүндийн, комплаенсийн, хууль эрх зүйн болон улс төрийн эрсдэл багтдаг.

Зээлийн эрсдэл, удирдлага

Зээлдэгч гэрээгээр хүлээсэн үүргийг бүхэлд нь эсвэл хэсэгчлэн биелүүлээгүй байх, зээлийн үндсэн төлбөр, хүү, алданги болон бусад зардлыг тогтоосон хугацаанд төлөхгүй байх тохиолдолд зээлийн эрсдэл үүсдэг.

Үнэт цаас гаргагч нь зээлийн үйл ажиллагаанд зохицуулагч байгууллагаас тогтоосон шалгуур үзүүлэлтийг ханган ажиллахын зэрэгцээ зээлийн багцыг эдийн засгийн салбар, зээлдэгч, бүтээгдэхүүн, бизнесийн сегмент тус бүрээр оновчтой тараан байршуулах үүднээс ТУЗ-өөс баталсан бодлогын хүрээнд эрсдэлийн аппетитийг тогтоодог.

Зээлийн эрсдэлийн удирдлагын бодлого нь чанаргүй зээлийн нийт зээлд эзлэх хувийн дээд хязгаарлалтыг ТУЗ-өөс баталсан эрсдэлийн аппетитийн хүрээнд тогтоох, зээлийн эрсдэлийн сангийн хүрэлцээний доод хязгаарлалтыг тогтоох, зээлийн багцыг оновчтой удирдах зарчмыг баримталдаг.

Үнэт цаас гаргагч нь зээлийн эрсдэлийн удирдлагын арга, хэрэгслийг хэрэгжүүлэхэд зээлдэгчийн болон зээлийн багцын гэсэн 2 түвшинд авч үзэж, зээлдэгч бүрийн хувьд зээлийн эрсдэлийг удирдах аргачлалыг хөгжүүлэн, банкны өдөр тутмын зээлийн үйл ажиллагааны процессыг нэг бүрчлэн тодорхойлон, зохион байгуулж ажилладаг.

2016 оноос харилцагчийн мэдээллийн санд тулгуурлан байгууллагын зээлдэгчийн рейтинг тогтоох аргачлал болон бичил зээлдэгчийг зэрэглэх модель, скорингийн загвар, иргэдийн банкны зээлдэгчийн өргөдөл болон зан төлөвийн скорингийн загварыг үйл ажиллагаанд ашиглаж эхэлсэн.

2018 оноос зээлийн үйл ажиллагааны автоматжуулсан систем болох бизнесийн зээл олголтын систем ("CLOS") болон иргэдийн зээл олголтын системийг ("RLOS")



зээлийн үйл ажиллагаанд нэвтрүүлснээр зээл олгох процессын автоматжуулалт болон чанар сайжирсан байна.

Банк 2018 онд СТОУС 9-ийг банканд нэвтрүүлсэнтэй холбогдуулан тус стандартын дагуу зээлийн үнэ цэн бууралтыг тооцох, сан байгуулах, алдагдалд суурилсан (зээлийн түүхэн эрсдэлийн параметрууд болох: зээл чанаргүйдэх магадлал, алдагдал хүлээх магадлал) загварыг амжилттай нэвтрүүлсэн.

Үнэт цаас гаргагч нь зээлийн эрсдэлийг бууруулах зорилгоор зээлийн ангилал тус бүрт тусгайлсан бодлого баримталдаг. Тодруулбал:

Байгууллагын болон жижиг дунд бизнесийн зээлийн бодлого

- Одоогийн багцын зээлийн чанарт онцгой анхаарал хандуулж зөрчлийн хугацааг 90 хоногоос хэтрүүлэхгүй байх;
- Ковид-19 цар тахлын нөлөөнд өртсөн зээлдэгчийн судалгааг нэг бүрчлэн хийж харилцагчийн мөнгөн урсгалтай уялдуулж эргэн төлөлтийн хуваарьт өөрчлөлт оруулах;
- Уул уурхай, боловсруулах үйлдвэр, тээвэр, үл хөдлөх, барилга, боловсрол зэрэг салбарын шинэ харилцагчид зээл олгоход нэмэлт шалгуур тавих;
- Гэрээний орлого, авлага барьцаалсан бүтээгдэхүүнийг сайжруулж, багцыг нэмэгдүүлэх;
- Хөрвөх чадвар өндөртэй бизнесүүдэд богино хугацааны санхүүжилт олгох;
- Томоохон зээлдэгчдэд зээлийн төвлөрлийн хязгаарлалтыг хэрэгжүүлэх;
- Зээлдэгч банк хоёрын харилцаа харилцан ашигтай байх зарчимд суурилах ба тус нөхцөлийг хангахгүй байгаа эсвэл эдийн засгийн мөчлөгт хэт тэсвэргүй зээлдэгчдийг тодорхойлж, шаардлага хангахгүй зээлдэгчтэй харилцааг зогсоох бодлого баримталдаг.

Хэрэглээний зээлийн бодлого

- Цалингийн байгууллагын тоог нэмэгдүүлэх, хамтын ажиллагааг сайжруулах
- Хэрэглээний зээлтэй иргэдийг депозитийн үнэнч харилцагч болгох замаар багцын чанарыг нэмэгдүүлэх;
- Эрсдэлтэй сегмент, сектор, байгууллагын хэрэглээний багцыг бууруулах;
- Кредит карт, ипотекийн зээл, цалингийн зээлийн багцын чанарыг сайжруулахад шаардлагатай үйл ажиллагааг хэрэгжүүлэх бодлого баримталдаг.

Бусад зээлүүдэд баримтлах бодлого

- Бизнесийн хэвийн харилцаагаар төлүүлэх боломжгүй, шүүхийн болон шүүхийн бус замаар төлүүлэх зээлүүдэд мэргэшсэн эрсдэлийн



мэргэжилтнүүд ажиллаж, зээлийн хорооны шийдвэрийг үндэслэн тусгай активын хэлтэс рүү шилжүүлэх, тус нэгж нь өр цуглуулах процессыг тухайн нөхцөл байдлаас хамааруулан дахин бүтэцчилэх тохиолдолд тухайн тусгай актив хамаарах борлуулалтын нэгжтэй нягт хамтран ажиллаж холбогдох зээлийн судалгааны дүгнэлтийг зээлийн хороонд танилцуулж ТУЗ-өөс тогтоосон эрхийн хэмжээнд шийдвэр гаргах;

- Холбоотой талын зээлийн багцын үлдэгдлийг тогтвортой бууруулах;
- Гадаадын байгууллагаас тавигдсан хязгаарлалтын нөхцөлийг нөхцөл байдлаас хамааран дахин шинэчлэх;
- Өмчлөх бусад үл хөдлөх хөрөнгийн хямдруулалтыг тооцож, чанаргүй активыг² худалдан борлуулах;
- Монголбанкны Активыг ангилах, активын эрсдэлийн сан байгуулж, зарцуулах журмыг удирдлага болгон тодорхой шаардлага хангасан актив (360-аас дээш хоносон хугацаа хэтэрсэн зээл, актив барагдуулах үйл ажиллагаа 90-ээс дээш хоногийн хугацаа шаардлагатай гэж дүгнэсэн, банкны чанаргүй зээлийн харьцаанд нөлөөлөх гэх мэт)-ыг эрсдэлийн сангаас хааж, тэнцлийн гадуур бүртгэн, актив барагдуулах ажиллагааг үргэлжлүүлэх бодлого баримталдаг.

Зээлээс бусад авлагын эрсдэлийн удирдлагын бодлого

- Нэг харилцагч байгууллагад ногдох эрсдэлээр жигнэсэн авлагын дээд хэмжээг тухайн харилцагч байгууллагын өөрийн хөрөнгийн 5 хувь эсвэл банкны өөрийн хөрөнгийн 5 хувийн аль багаас нь ихгүй байхаар тогтоох;
- Дотоодын банк, санхүүгийн байгууллагад зээлжих зэрэглэл, санхүүгийн гүйцэтгэл, барьцаанд суурилан хязгаарлалт тогтоох;
- Гадаадын банк, санхүүгийн байгууллагад зээлжих зэрэглэл, эрсдэлийн жигнэсэн авлагад суурилан хязгаарлалт тогтоох бодлого баримталдаг.

Үнэт цаас гаргагч нь зээлийн эрсдэлийг бууруулахын тулд зээл олгосноос төлж дуусах хүртэлх хугацаанд тухайн зээлд тавих зарцуулалтын, явцын, эргэн төлөлтийн болон зээлдэгчийн зээлжих зэрэглэлийн хяналтыг олон улсын дэвшилтэт технологийг ашиглан тогтмол хийдэг.

Мөн зээлийн эрсдэлийг үүссэний дараа арилгах бус үүсэхээс өмнө илрүүлэх зарчмыг баримталдаг. Банкны зээлийн бүх шийдвэр гаргалт нь хамтын шийдвэр байх ба шийдвэр гаргалтаас үүсэх аливаа асуудлыг зээлийн хорооны гишүүд банкны өмнө хариуцдаг. Зээлийн эрсдэлийг удирдахад чиглэсэн үйл ажиллагаа нь аливаа нэг албан тушаалтнаас хараат бус байх зарчмыг баримталдаг.

² Актив нь банкны хөрөнгийг илэрхийлдэг.



Үнэт цаас гаргагч нь зээлийн эрсдэлийг бууруулах зорилгоор зээл, зээлтэй адилтган тооцох бусад актив болон бусад хүлээж болзошгүй үүрэгт зээлдэгч болон гуравдагч этгээдээс үүргийн гүйцэтгэлийг хангуулах баталгаа болгож барьцаа авдаг.

Барьцааны төрөл, онцлогоос хамаарч хөрөнгийн үнэлгээний арга зүй болон үнэлгээний загварыг ашиглаж, хөрөнгийн үнэлгээ хийж буй үнэлгээчдийн хараат бус байдал, баримтлах ёс зүй болон үнэлгээний олон улсын стандартын (IVS) дагуух бусад шаардлагыг хангасан барьцаа хөрөнгийн цогц бодлогыг хэрэгжүүлдэг.

Зах зээлийн эрсдэл, удирдлага

Зах зээл дээрх үнийн өөрчлөлт банкны ашигт ажиллагаа, өөрийн хөрөнгө болон санхүүгийн хэрэгслийн үнэ цэн, хэвийн үйл ажиллагаанд сөрөг нөлөө үзүүлэх тохиолдолд зах зээлийн эрсдэл үүсдэг. Зах зээлийн эрсдэлд хүүний, валютын ханшийн болон хувьцаа, түүхий эдийн үнийн эрсдэл багтдаг.

Үнэт цаас гаргагч нь зах зээлийн эрсдэлийн удирдлагын бодлогын хүрээнд гадаад валютын нээлттэй позицыг Монголбанкнаас тогтоосон хязгаарлалтын хүрээнд удирдан ажиллаж, банкны эрсдэлийн аппетитийн мэдэгдэлд бүрэн нийцүүлэн ажилладаг байна. Валютын ханшийн эрсдэлээс учирч болзошгүй алдагдлыг Value at Risk (VAR) аргачлалаар өдөр бүр тооцон хяналтыг хэрэгжүүлдэг.

Хүүний эрсдэл, удирдлага

Хүүний эрсдэлд хүүний түвшний хэлбэлзлээс үүдэн банкны өөрийн хөрөнгө, өр төлбөр, актив, банкны балансын гадуурх санхүүгийн хэрэгслийн одоогийн болон ирээдүйн үнэ цэнд учрах сөрөг нөлөө багтдаг.

Үнэт цаас гаргагч нь учирч болзошгүй хүүний эрсдэлийг илрүүлэх зорилгоор актив пассивын эргэн төлөгдөх хугацааны GAP шинжилгээ, хүүний мэдрэмтгий байдлын шинжилгээ, өөрийн хөрөнгийн эдийн засгийн үнэ цэнийн шинжилгээ, хүүний эрсдэлийн стресс тест болон өрсөлдөгч банкуудын хүүний харьцуулсан судалгааг тогтмол хугацаанд хийж гүйцэтгэн Актив пассивын хороонд танилцуулан холбогдох шийдвэрийг гаргадаг байна.

Банкны хүүний удирдлагын нарийвчилсан үйл ажиллагааг зохицуулсан журмыг 1 дүгээр шугамын бизнес нэгж болох Нөөцийн удирдлагын газрын Актив пассивын удирдлагын хэлтэс болон бусад холбогдох нэгжүүд өдөр тутмын удирдлагын үйл ажиллагаанд мөрддөг.

Эрсдэлийн удирдлагын газар нь хүүний эрсдэлийн хязгаарлалтуудыг тогтоох, хүүний багцын эрсдэлийн удирдлагын хэрэгжилтэд мониторинг хийх, хараат бусаар ТУЗ-д тайлагнах үйл ажиллагааг хэрэгжүүлдэг.



Валютын ханшийн эрсдэл, удирдлага

Үнэт цаас гаргагч нь валютын үйл ажиллагааг зохицуулах, валютын ханшийн хэлбэлзлээс үүдэх арилжааны алдагдлыг бууруулах, таслан зогсоох үүднээс валют арилжаа (spot, своп, форвард, опцион), маржин арилжаа, үнэт металлын арилжаа, үнэт цаасны арилжааны болон VaR хязгаарлалтыг тус тус баримтлан ажилладаг.

Арилжааны хязгаарлалтыг тогтооход дилерийн ур чадвар болон ажлын туршлага гүйцэтгэлд үндэслэдэг. Арилжааны хяналтыг автомат систем болон гүйцэтгэлийг Нөөцийн удирдлагын газрын Дундын албанаас бодит цаг хугацаанд хэрэгжүүлэн ажилладаг.

Үнэт цаас гаргагч нь банкны зах зээлийн эрсдэлийн хяналтын тогтолцоо, мэдээллийн урсгалыг сайжруулж, үйл ажиллагааны талаар хороо болон удирдлагуудад тогтмол тайлагнаж, батлагдсан хязгаарлалтыг зөрчсөн тохиолдолд нэгжийн гүйцэтгэлийн үнэлгээ болон тухайн дилерт хариуцлага тооцох тогтолцоог зохих журмын дагуу бүрэн зохицуулж, багцын эрсдэлийг удирддаг.

Хувьцаа, түүхий эдийн үнийн эрсдэл, удирдлага

Үнэт цаас гаргагч нь харилцагчаас биет алтыг худалдаж авснаар түүхий эдийн үнийн эрсдэл үүсдэг бөгөөд түүхий эдийн үнийн эрсдэлийг гадаад зах зээлд форвард гэрээ хийх замаар бууруулдаг. Мөн банкны хувьцаа болон таваарын маржин арилжааны эрсдэлийг бууруулах зорилгоор маржин арилжааны лимитийг тогтоож мөрдөн ажилладаг.

Хөрвөх чадварын эрсдэл, удирдлага

Хөрвөх чадварын эрсдэлд банк ирээдүйн өр төлбөрийг хугацаанд нь төлж чадахгүйгээс үүдэн банкны санхүүгийн байдал болон үйл ажиллагаа хэвийн явагдахад учрах эрсдэл багтдаг.

Банкны хөрвөх чадварт нөлөөлөгч хүчин зүйлс нь хөрөнгө болон өр төлбөрийн хугацаа, мөнгөний бодлогын өөрчлөлт (Монголбанкнаас шаарддаг өөрийн хөрөнгийн хүрэлцээний шалгуур үзүүлэлт, төлбөр түргэн гүйцэтгэх чадварын үзүүлэлтийн шаардлагын өөрчлөлт) зэрэг багтдаг.

Үнэт цаас гаргагч нь бэлэн мөнгө болон бусад хөрвөх чадвар өндөртэй хөрөнгөөр санхүүгийн өр төлбөрийг гүйцэтгэх шаардлагатай мөнгөн хөрөнгийн эх үүсвэрийг хангаж ажиллахад чиглэсэн хөрвөх чадварын эрсдэлийн удирдлагын бодлогыг хэрэгжүүлдэг.



Тодруулбал, банкны хяналт шалгалтын Базел-III стандартын дагуу богино хугацааны хөрвөх чадварын эрсдэлийг удирдах, хяналт тавих зорилгоор хөрвөх чадварын хүрэлцээтэй байдлын харьцаа, дунд, урт хугацааны хөрвөх чадварын эрсдэлийг удирдах, хяналт тавих зорилгоор цэвэр тогтвортой санхүүжилтийн харьцааг тогтмол хянаж ажилладаг.

Мөн учирч болзошгүй хөрвөх чадварын эрсдэлийг үнэлж, стресс тестийг тогтмол гүйцэтгэн, үр дүнг нь шийдвэр гаргалтад ашигладаг.

Үнэт цаас гаргагч нь хөрвөх чадварыг хангах зорилгоор өөрийн хөрөнгийн удирдлагад нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгийн хүрэлцээний доод хязгаарлалтыг ТУЗ-өөс баталсан эрсдэлийн аппетитийн хүрээнд тогтоох, хөшүүргийн харьцааны доод хязгаарлалтыг Монголбанкнаас тогтоосон хязгаарлалтын хүрээнд тогтоох, Базел-III стандартын доод шаардлагад нийцүүлэн өөрийн хөрөнгийн хэмжээг хангах зарчмыг баримталдаг.

Өөрийн хөрөнгийн хүрэлцээг тогтооход Монголбанкнаас шаарддаг харьцаа үзүүлэлтээс гадна банкны хяналт шалгалтын Базелийн хорооноос гаргасан зөвлөмжийн жишиг болгон өөрийн хөрөнгийн хүрэлцээний дотоод үнэлгээний аргачлал (ICAAP)-ыг үйл ажиллагаанд хэвшүүлэн ажилладаг.


Үйл ажиллагааны эрсдэл, удирдлага

Үйл ажиллагааны эрсдэлд дотоод үйл ажиллагааны дутагдалтай байдал, системийн хяналтын хангалтгүй байдал, мэдээллийн технологи, дотоод хүчин зүйл, гадаад хүчин зүйлээс шалтгаалан учирч болох эрсдэл багтдаг.

Үнэт цаас гаргагч нь үйл ажиллагааны эрсдэлийг удирдах, хянах зорилгоор эрсдэлийн хяналтын өөрийн үнэлгээний аргачлалаар нэгжийн үйл ажиллагаанд учирч болзошгүй эрсдэлийг тодорхойлон бууруулах арга хэмжээг хэрэгжүүлдэг.

Түүнчлэн банкны нийт салбар тооцооны төвийн үйл ажиллагааны эрсдэлийг метрикс үзүүлэлтээр сар, улирал тутам тогтмол хэмжиж, эрсдэлийг бууруулдаг. Үйл ажиллагааны эрсдэлийг бууруулахын тулд Голомт банк нь нийт ажилтнуудад зориулсан эрсдэлийн удирдлагын суурь ойлголт болон чиглүүлэх сургалтыг тасралтгүй зохион байгуулж, байгууллагын эрсдэлийн соёлыг түгээх, төлөвшүүлэхэд анхаарч ажилладаг.

Үнэт цаас гаргагч нь үйл ажиллагааны эрсдэлийн удирдлагын хүрээнд дараах зорилтыг баримтлан ажилладаг. Үүнд:



- Хүний нөөцийн эргэцийн дээд хязгаарлалтыг ТУЗ-өөс баталсан эрсдэлийн аппетитийн хүрээнд тогтоох бөгөөд албан тушаалын түвшин бүрт дээд хязгаар тогтоох;
- Системийн тасралтгүй ажиллагааны доод хязгаарыг 99.4 хувиар тогтоох;
- Бизнесийн тасралтгүй ажиллагааг олон улсын сайн туршлага, стандартад нийцүүлэн сайжруулах;
- Мэдээллийн технологийн эрсдэлийн удирдлагын сайн туршлага (COBIT5) процессыг шат дараалалтайгаар үйл ажиллагаандаа нэвтрүүлэх;
- Үйл ажиллагааны эрсдэлийн удирдлагын системийг үйл ажиллагаанд нэвтрүүлж, хяналт, тайлагналыг сайжруулах;
- Үйл ажиллагааны эрсдэлийн эрсдэлээр жигнэсэн активын тооцооллыг Базел-III стандартын аргачлалд нийцүүлэх;
- Бүртгэлийн системийн удирдлагын процессыг сайжруулах, хэрэгжилтийг ахиулах зарчмыг баримталдаг.

Мэдээллийн аюулгүй байдлын эрсдэл, удирдлага

Мэдээллийн аюулгүй байдлын эрсдэлд системийн доголдол, дутагдалтай байдлаас үүдэн үйл ажиллагаа тасалдах, харилцагчийн мэдээлэл алдагдах, гадны кибер халдлагад өртөх зэргээс үүдэн учирч болох эрсдэлүүд багтана.

Үнэт цаас гаргагч нь Дэлхийн жишиг Мэдээллийн аюулгүй байдлын тогтолцоог бий болгох зорилтын хүрээнд олон улсын нэр хүнд бүхий мэдээллийн аюулгүй байдлын ISO27001 стандарт, Төлбөрийн картын аюулгүй байдлын PCIDSS стандартууд болон хувь хүний өгөгдөл хамгааллын хуулийн хэрэгжилтийг хангах GDPR буюу Европын холбооны хувь хүний өгөгдөл хамгаалах тухай хуулийн шаардлага тус бүрийг ханган үйл ажиллагаанд нэвтрүүлсэн.

Голомт банк нь системийн аюулгүй байдлыг бүрэн хангаж буй эсэхийг олон улсын хөндлөнгийн мэдээллийн аюулгүй байдлын аудитын үйлчилгээ үзүүлэгч Thales eSecurity байгууллагаар шалгуулж, банкны системийн эмзэг байдлын үнэлгээг тогтмол хийлгэн баталгаажуулдаг. Банкны систем рүү чиглэсэн гадны кибер халдлагаас хамгаалах зорилгоор Security Operations Maturity Model (SOMM) стандартын шаардлагыг бүрэн хангаж, Кибер Аюулгүй Байдлын Удирдлагын төвийг бий болгон ажилладаг.

Түүнчлэн дэлхийн 1100 гаруй байгууллага нэгдсэн кибер аюулгүй байдлын олон улсын хамтын ажиллагааны хамгийн том төсөл болох Парисын кибер орчин дахь аюулгүй байдлыг хангах харилцан итгэлцлийн уриалгад нэгдэн, үйл ажиллагааны зарчмыг баримтлан, мэдээллийн аюулгүй байдлын эрсдэлийг удирддаг.

Үнэт цаас гаргагч нь банкны систем рүү чиглэсэн гадны кибер халдлагаас хамгаалах зорилгоор Security Operations Maturity Model (SOMM) стандартын шаардлагыг бүрэн



хангасан Кибер Аюулгүй Байдлын Удирдлагын төвийг (КАБУТ)-г бий болгон ажилладаг.

Харилцагчдыг цахим залилангаас сэргийлэх, иргэдэд эрх зүйн болон санхүүгийн боловсрол олгох, гэмт хэргийн улмаас учрах хохирол, хор уршгийг багасгахад чиглэсэн арга хэмжээг Голомт банк нь тогтмол хэрэгжүүлдэг. Тодруулбал, Голомт банкны санаачлагаар Цагдаагийн Ерөнхий Газар, Монголбанктай хамтран цахим орчин дахь залилах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилгоор Ятгах тусам нягтал аяныг Залилагчид боломж бүү олго уриатайгаар 2020-2021 онд хамтран зохион байгуулсан.



Нэр хүндийн эрсдэл, удирдлага

Нэр хүндийн эрсдэлд банкны үйл ажиллагаа, менежмент болон бусад гадаад дотоод үйл ажиллагаанаас үүдэлтэй олон нийтийн дунд сөрөг сэтгэгдэл үүсэх, банкны нэр хүндэд сөрөг нөлөө үзүүлэх эрсдэл багтдаг.

Үнэт цаас гаргагч нь нэр хүндийн эрсдэлийг бууруулах зорилгоор банкны зээлжих зэрэглэлийн үнэлгээг Монгол Улсын зээлжих зэрэглэлийн үнэлгээнээс нэг болон түүнээс доош түвшинд үл байлгах, банкны санхүүгийн болон санхүүгийн бус тогтвортой байдалд сөрөг нөлөө үзүүлэхүйц аливаа нэр хүндийн эрсдэлийг гаргахгүй байх, банкны нэр хүндэд нөлөө үзүүлэхүйц аливаа шийдвэр, мэдэгдэл, дүгнэлт, үйл ажиллагааг хориглох зарчмыг баримталдаг.

Голомт банкны Мэдээлэл, олон нийттэй харилцах газар нь олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл дэх банкны талаарх сөрөг мэдээллийг тогтмол хянаж, банкны нэр хүндэд халдах эрсдэлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг авч хэрэгжүүлдэг.

Хүндрэлийн үед авч хэрэгжүүлэх төлөвлөгөөний дагуу шаардлагатай тохиолдолд Актив пассивын хороог хуралдуулан холбогдох арга хэмжээг хэрэгжүүлдэг.

Комплаенсийн эрсдэл, удирдлага

Комплаенсийн эрсдэлд банк болон банкны удирдлага, ажилтнууд заавал баримтлах хууль, дүрэм, журам, олон улсын стандарт шаардлагыг зөрчиж, ёс зүйгүй, зүй бус үйлдэл хийснээр банкны үйл ажиллагаа болон санхүүгийн системд сөргөөр нөлөөлөх эрсдэл багтдаг.

Үнэт цаас гаргагчийн ТУЗ нь ажилтан бүрийн мөрдөн ажиллах ёс зүйн хэм хэмжээг тодорхой заасан ёс зүйн дүрэм бүхий байгууллагын засаглалын кодексыг баталж,



үйл ажиллагаанд тогтмол мөрдөн ажилладаг. Голомт банк нь комплаенсийн эрсдэлийг бууруулах зорилгоор комплаенсийн, авлигын эсрэг, луйврын эсрэг, зөрчлийн тухай бодлогыг үйл ажиллагаанд хэрэгжүүлж байна.

ТУЗ-ийн дэргэдэх Эрсдэлийн удирдлагын болон Аудитын хороо нь комплаенсийн асуудлыг улирал тутам хэлэлцэн холбогдох шийдвэрийг гаргадаг. Гүйцэтгэх захирлын дэргэдэх Эрсдэлийн удирдлагын хороо нь сар бүр комплаенсийн эрсдэлийн асуудлыг хэлэлцэн зохистой арга хэмжээг тодорхойлж, хэрэгжилтэд хяналт тавин ажилладаг.

Комплаенсийн нэгж нь комплаенсийн эрсдэлийг зохистой түвшинд үр дүнтэй удирдах цогц бодлого журмыг боловсруулах, түүнийг хэрэгжүүлэх, дотоод хяналтын хөтөлбөрийг тасралтгүй хөгжүүлэх чиглэлээр ажиллахын сацуу мөнгө угаах терроризмтой тэмцэх чиг үүргийн хүрээнд тогтмол хяналт тавьдаг.

Комплаенсийн бодлого

Үнэт цаас гаргагч нь комплаенсийн эрсдэлийг бууруулах зорилгоор гүйлгээний хяналтыг автоматжуулсан олон улсын систем нэвтрүүлэн, олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн, мэргэшсэн комплаенсийн мэргэжилтнийг бэлтгэн ажиллаж байна.

Комплаенсийн соёлыг бэхжүүлэх, ажилтан бүрийн үүрэг оролцоо, мэдлэгийг нэмэгдүүлэх зорилгоор комплаенсийн төлөөлөгч хөтөлбөрийг хэрэгжүүлж, нэгж бүрээс төлөөлөгч томилж, комплаенсийн үйл ажиллагааг богино хугацаанд үр дүнтэй удирдан ажилладаг.

Үнэт цаас гаргагч нь 2020 оны 10-р сард Олон улсын санхүүгийн гэмт хэрэгтэй тэмцэх байгууллага болох ФАТФ-ын Саарал жагсаалтаас Монгол Улс гарахад өндөр хувь нэмэр оруулсан төдийгүй 2021 онд анх удаа банкны хэмжээнд мөнгө угаах терроризмыг санхүүжүүлэх эрсдэлийн үнэлгээг хийлгэж, Дэлхийн банкны аргачлалыг өөрийн үйл ажиллагаанд нэвтрүүлсэн.

Авлигын эсрэг бодлого

Үнэт цаас гаргагч нь бизнесийн үйл ажиллагаанд ёс суртахууны хэм хэмжээг өндөр түвшинд сахин ажилладаг. Бүх түвшний үйл ажиллагаанд авлига, хээл хахуулийг үл тэвчих зарчмыг баримтлан, бизнесийн бүхий л хамтын ажиллагаа, харилцаа холбоонд мэргэжлийн өндөр түвшинд шударга, үнэнч ажиллахыг эрмэлздэг.

Голомт банкны авлигын эсрэг бодлого нь банкны бүх бизнесийн үйл ажиллагаа авлига, хээл хахуулиас ангид байх, дотоод дүрэм, журам нь бодлогын зорилгод нийцсэн байх, улмаар авлига хээл хахуулийн эсрэг нэгдсэн бодлоготой, санхүүгийн хариуцлагатай банк байхад оршдог.



Луйврын эсрэг бодлого

Голомт банк нь аливаа луйврын шинжтэй үйлдлээс сэргийлэх, илрүүлэх, мэдээлэх чиглэлийг баримталж ажилладаг. Банк нь өөрийн үнэт зүйлсийг бэхжүүлэх, Ёс зүйн кодыг бүхий л ажилтнууд дагаж мөрдөх нөхцөлийг бүрдүүлэхүйц хяналтын тогтолцоог бий болгосон.

Үнэт цаас гаргагч нь банкны нэгж бүрийн удирдлагууд, ажилтнуудыг үнэнч шударгаар ажиллах уур амьсгалыг бүрдүүлж, тухайн нэгжийн өдөр тутмын үйл ажиллагаанд илэрч болох залилангийн, луйврын үйлдлийн эрсдэлийг үнэлж, луйврын шинжтэй үйлдэл гарч болох нөхцөл байдлыг арилгахтай холбоотой хяналтын тогтолцоог бий болгон, луйвар, луйврын шинжтэй үйлдэл гарсан тухай мэдээллийг хүлээн авах, шалгах, мэдээлэх, тухайн үйлдэлтэй холбоотой авах арга хэмжээний талаар зөвлөмж гаргадаг.

Шүгэл үлээх/Зөрчлийг мэдээлэх бодлого

Голомт банкны ажилтан бүр авлига хээл хахууль, ашиг сонирхлын зөрчил, ажлын байран дахь бэлгийн болон бусад төрлийн дарамт, бусад ёс зүйн зарчмын ноцтой зөрчлийг гаргасан Голомт банкны дүрэмтэй үл нийцсэн үйл ажиллагааг мэдээлж ажиллах үүргийг Шүгэл үлээх/Зөрчлийг мэдээлэх бодлогоор тодорхойлсон байдаг.

Хууль зүйн эрсдэл, удирдлага

Хууль зүйн эрсдэлд аливаа нэг хууль эрх зүй, гэрээ, дүрэм, журам, зохицуулалтыг зөрчсөнөөс үүдэх эрсдэл багтдаг. Үнэт цаас гаргагч нь банкны үйл ажиллагааг хууль тогтоомжийн дагуу тасралтгүй, хэвийн явагдах нөхцөлийг бүрдүүлэхэд үүсэж болзошгүй хууль зүйн эрсдэлээс урьдчилан сэргийлэх, хамгаалах зөвлөмжийг тогтмол боловсруулж, үйл ажиллагаанд нэвтрүүлж, эрсдэлийг арилгах талаар алба нэгжүүдтэй хамтран ажиллаж, заавар зөвлөгөө, хууль зүйн дүгнэлтээр хангаж ажилладаг.

Үнэт цаас гаргагчийн Хуулийн хэлтэс нь банкны үйл ажиллагаатай холбоотой бүх төрлийн гэрээг хууль тогтоомжтой нийцсэн эсэх, банкны болон харилцагчийн эрх ашгийг хамгаалж байгаа эсэхийг хянах, стандарт гэрээний загвар боловсруулах, хэрэглээнд нэвтрүүлэх, зөв хэрэглэх талаар нэгжүүдэд заавар зөвлөмж хүргүүлдэг.

Банкны үйл ажиллагаатай холбоотой хууль эрх зүйн орчинд орсон өөрчлөлт болон хууль эрх зүйн аливаа тодорхойгүй шийдвэрлэх асуудлыг Хуулийн хэлтсийн хурлаар авч хэлэлцэх, дотоод хэлэлцүүлэг явуулах, хамааралтай нэгжүүдэд сургалт зохион байгуулах замаар хууль зүйн эрсдэлийг бууруулдаг.



Улс төрийн эрсдэл, удирдлага

Улс төрийн эрсдэлд улс төрийн нөхцөл байдлаас үүдэн банкны хэвийн үйл ажиллагаа алдагдах эрсдэл багтдаг. Улс төрийн эрсдэлээс сэргийлэх зорилгоор Үнэт цаас гаргагч нь шууд болон шууд бус байдлаар улс төрийн намын үйл ажиллагаанд оролцохгүй байх, улс төрийн нам, улс төрч, улс төрийн сонгуульд нэр дэвшигчид төлбөр, хураамж төлөхийг хориглох бодлогыг баримталдаг. Мөн улсын байгууллагатай хийж буй аливаа санхүүгийн хэлцлийг олон улсын стандартын дагуу эрсдэлээр үнэлж тооцдог.



3.9 Үнэт цаас гаргагчийн санхүүгийн шинжилгээ

Үнэт цаас гаргагчийн санхүүгийн тайлан /2018-2021/

Үнэт цаас гаргагчийн 2019 болон 2021 оны жилийн эцсийн СТОУС-н дагуу бэлтгэгдсэн санхүүгийн тайланд ПрайсуотерхаусКуперс Аудит ХХК, 2020 оны жилийн эцсийн СТОУС-н дагуу бэлтгэгдсэн санхүүгийн тайланд ПрайсуотерхаусКуперс ХХК болон Мэдээлэл Аудит ХХК-ний хамтарсан консорциум аудит хийн дүгнэлт гаргасан. Эдгээр аудитлагдсан тайлангуудыг энэхүү ҮЦТ-ын хавсралт №4 хэсэгт хавсаргасан болно.

2021 болон 2020 оны 12 дугаар сарын 31-ээрх Банкны санхүүгийн мэдээллийг өөрөөр заагаагүй бол материаллаг залруулгагүйгээр 2021 оны 12 дугаар сарын 31-нээрх Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт (СТОУС)-ын дагуу тайлагнасан аудитлагдсан санхүүгийн тайлангаас хэсэгчлэн авч үнэт цаасны танилцуулгад тусгасан болно.

2019 оны 12 дугаар сарын 31-ээрх Банкны санхүүгийн мэдээллийг өөрөөр заагаагүй бол материаллаг залруулгагүйгээр 2020 оны 12 дугаар сарын 31-нээрх Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт (СТОУС)-ын дагуу тайлагнасан аудитлагдсан санхүүгийн тайлангаас хэсэгчлэн авч үнэт цаасны танилцуулгад тусгасан болно.

2018 оны 12 дугаар сарын 31-ээрх Банкны санхүүгийн мэдээллийг өөрөөр заагаагүй бол материаллаг залруулгагүйгээр 2019 оны 12 дугаар сарын 31-нээрх Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт (СТОУС)-ын дагуу тайлагнасан аудитлагдсан санхүүгийн тайлангаас хэсэгчлэн авч үнэт цаасны танилцуулгад тусгасан.

Хүснэгт 17. Үнэт цаас гаргагчийн санхүүгийн байдлын тайлан /тэрбум төгрөг/

САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН	2018	2019	2020	2021
ХӨРӨНГӨ				
Бэлэн мөнгө ба төв банкинд байршуулсан мөнгө (заавал байлгах нөөцөөс бусад)	658.1	1,110.3	561.3	695.0
Монголбанкинд байршуулсан заавал байлгах нөөц	455.1	291.9	243.5	277.3
Урвуу репо хэлцэл	100.0	-	-	-
Бусад банкуудад байршуулсан хөрөнгө	586.1	906.6	1,273.1	1,056.4
Өрийн хэлбэрээрх хөрөнгө оруулалт	518.9	286.9	1,364.4	1,979.4
Өмчийн хэлбэрээрх хөрөнгө оруулалт*	105.7	24.7	29.5	18.5
Харилцагчдад олгосон зээл ба урьдчилгаа	3,183.7	3,306.7	3,031.3	3,339.2
Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө	34.3	42.4	39.7	17.4
Бусад хөрөнгө	44.8	158.7	121.3	40.0
Хойшлогдсон татварын хөрөнгө	-	-	-	-
Үүсмэл санхүүгийн хэрэглүүр	125.4	138.1	205.6	208.9



Биет бус хөрөнгө	14.3	14.4	16.8	17.8
Үндсэн хөрөнгө	130.1	147.7	144.1	150.0
Ашиглах эрхтэй хөрөнгө	-	6.3	9.9	13.0
Өмчлөх бусад хөрөнгө	89.9	151.3	210.6	107.0
Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө	34.8	57.1	27.0	74.1
НИЙТ ХӨРӨНГӨ	6,081.1	6,643.1	7,278.0	7,994.1
ӨР ТӨЛБӨР				
Бусад банкуудын байршуулсан хөрөнгө	148.8	52.9	14.6	16.8
Харилцагчдын харилцах, хадгаламж	4,402.6	4,900.6	5,285.7	5,463.5
Бусад зээлийн эх үүсвэр	715.9	916.0	1,202.3	1,509.4
Репо хэлцэл	151.3	24.9	20.1	221.9
Орлогын татварын өглөг	5.0	1.4	-	29.4
Хойшлогдсон татварын өр төлбөр	5.3	-	12.4	9.5
Түрээсийн өр төлбөр	-	6.5	10.6	14.0
Бусад өр төлбөр	46.6	106.2	100.8	70.8
Хоёрдогч өглөг	92.6	172.0	-	-
НИЙТ ӨР ТӨЛБӨР	5,568.0	6,180.6	6,646.4	7,335.4
ЭЗЭМШИГЧДИЙН ӨМЧ				
Давуу эрхтэй хувьцаа	75.8	25.8	16.4	16.4
Хувь нийлүүлсэн хөрөнгө	32.3	32.0	42.2	168.6
Нэмэгдэж төлөгдсөн капитал	127.6	135.2	291.8	169.5
Хуримтлагдсан ашиг	202.8	197.4	210.9	242.4
Өмчийн бусад хэсэг	74.5	72.1	70.3	61.7
НИЙТ ЭЗЭМШИГЧДИЙН ӨМЧ	513.1	462.5	631.6	658.7
НИЙТ ӨР ТӨЛБӨР БА ЭЗЭМШИГЧДИЙН ӨМЧ	6,081.1	6,643.1	7,278.0	7,994.1

Эх сурвалж: Үнэт цаас гаргагчийн санхүүгийн тайлан

*Банк нь 2019 оноос эхлэн өмчийн хэлбэрээрх хөрөнгө оруулалт болон бусад хөрөнгийн толилуулгыг өөрчилсөн тул 2018 оны өмчийн хэлбэрээрх хөрөнгө оруулалт болон бусад хөрөнгийн дүн 2019, 2020 болон 2021 оны дүнтэй харьцуулагдахгүй болно



Хүснэгт 18. Үнэт цаас гаргагчийн орлогын тайлан /тэрбум төгрөг/

Орлого үр дүнгийн болон бусад дэлгэрэнгүй орлогын тайлан	2018	2019	2020	2021
Үр ашигт хүүгийн аргаар тооцсон хүүгийн орлого	463.9	557.0	551.9	526.5
Бусад адилтгах орлого	30.1	20.9	18.3	28.3
Хүүгийн зардал	(323.3)	(365.2)	(364.4)	(271.3)
Бусад адилтгах зардал	-	(0.9)	(1.4)	(1.6)
Хүүгийн цэвэр орлого	170.7	211.9	204.4	282.0
Зээлжих эрсдэлийн сангийн зардал	(66.2)	(135.4)	(93.8)	(35.8)
Зээлжих эрсдэлийн сангийн зардлын дараах хүүгийн цэвэр орлого	104.6	76.4	110.5	246.2
Хураамж, шимтгэлийн орлого	47.4	55.1	49.1	62.5
Хураамж, шимтгэлийн зардал	(12.3)	(17.1)	(15.6)	(21.7)
Ашиг, алдагдлаарх бодит үнэ цэнээр хэмжигдэх санхүүгийн хөрөнгөнөөс үүссэн (гарз)/ олз	(6.3)	2.3	(1.0)	1.7
Хорогдуулсан өртгөөр хэмжигдэх бусад зээлийн эх үүсвэрийн гэрээний өөрчлөлтөөс үүссэн олз	-	-	1.8	3.6
Бусад дэлгэрэнгүй орлогоорх бодит үнэ цэнээр хүлээн зөвшөөрөх санхүүгийн хөрөнгөөс үүссэн олз/ (гарз)	-	(0.0)	2.2	(0.0)
Үүсмэл санхүүгийн хэрэглүүрээс үүссэн олз / (гарз)	93.4	15.0	14.5	(21.8)
Гадаад валют болон үнэт металын арилжаанаас үүссэн олз**	15.7	12.6	26.0	25.2
Ашиг, алдагдлаарх бодит үнэ цэнээр хэмжигдэх зээлийн бодит үнэ цэнийн гарз	-	-	(6.0)	(14.6)
Хорогдуулсан өртгөөр хэмжигдэх санхүүгийн хөрөнгүүдийн өөрчлөлтөөс үүссэн гарз, бүртгэлээс хасагдахгүй	(1.3)	(0.3)	(0.5)	(0.9)
Хорогдуулсан өртгөөр хэмжигдэх өрийн хэлбэрээрх хөрөнгө оруулалтын хүлээгдэж буй алдагдлын сангийн зардлын буцаалт	1.1	0.7	0.0	(0.0)
Бусад дэлгэрэнгүй орлогоор хүлээн зөвшөөрөх өрийн хэлбэрээрх хөрөнгө оруулалтын үнэ цэнийн (бууралт)/өсөлт	(0.8)	1.0	(2.6)	(1.8)
Бусад банкуудад байршуулсан хөрөнгийн эрсдэлийн сангийн зардал/(буцаалт)	-	(0.8)	0.6	0.0
Зах зээлийн хүүгээс бага хүүтэй олгосон санхүүгийн хөрөнгийн анхны хүлээн зөвшөөрөлтөөс үүссэн гарз	(16.9)	(5.3)	(0.9)	(2.6)
Гадаад валютын ханшийн өөрчлөлтийн (гарз)/ олз	(19.0)	12.0	4.2	0.2
Бусад хөрөнгийн эрсдэлийн сангийн зардал	(2.7)	(2.7)	(0.8)	(0.5)
Үндсэн хөрөнгийн үнэ цэнийн бууралтын гарз	(26.6)	-	-	-
Өмчлөх бусад хөрөнгийн бодит үнэ цэнийн бууралтын сангийн зардал болон эрсдэлийн сангийн зардал	(6.5)	(9.6)	(38.2)	(78.9)
Аккредитив, баталгааны эрсдлийн сангийн (зардал)/зардлын буцаалт	0.4	1.5	(1.0)	2.0
Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгийн бодит үнэ цэнийн өөрчлөлтийн (гарз)/ олз	(3.0)	3.2	(1.8)	(7.4)
Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгийн үнэ цэнийн бууралтын сангийн зардал/зардлын буцаалт	1.9	1.8	(0.3)	(4.0)
Ногдол ашгийн орлого	1.8	0.1	0.2	0.2
Үйл ажиллагааны бусад орлого***	15.0	1.0	2.9	3.8



Удирдлагын болон үйл ажиллагааны бусад зардал	(110.1)	(122.0)	(121.0)	(137.1)
Бусад гарз цэвэр дүнгээр***	-	-	-	(1.5)
Татварын өмнөх ашиг	75.6	24.9	22.5	52.6
Орлогын албан татварын зардал	(22.1)	(8.6)	(12.1)	(26.6)
Тайлант жилийн ашиг	53.5	16.3	10.4	25.9
Бусад дэлгэрэнгүй орлого/(алдагдал)				
Ирээдүйд ашиг алдагдалд ангилагдаж болзошгүй зүйлс:				
<i>Бусад дэлгэрэнгүй орлогоорх бодит үнэ цэнээр хүлээн зөвшөөрөгдөх өрийн хэлбэрээрх хөрөнгө оруулалт:</i>				
- Тайлант жилийн олз/(гарз)	-	(0.0)	2.2	2.7
- Худалдан борлуулснаас ашиг алдагдалд дахин ангилагдсан олз/(гарз)	-	0.0	(2.2)	0.0
Бусад дэлгэрэнгүй орлогод бүртгэсэн орлогын албан татвар	-	-	-	(0.7)
Ирээдүйд ашиг алдагдалд ангилагдахгүй зүйлс:				
Бусад дэлгэрэнгүй орлогоорх бодит үнэ цэнээр хүлээн зөвшөөрөх өмчийн хэлбэрээрх хөрөнгө оруулалтаас үүссэн олз/(гарз)	(10.2)	(8.9)	3.9	1.2
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	3.0	1.2	-	-
Бусад дэлгэрэнгүй орлогод бүртгэсэн орлогын албан татвар	2.6	2.2	(1.0)	(0.3)
Бусад дэлгэрэнгүй орлого	(4.7)	(5.5)	2.9	2.9
Тайлант жилийн дэлгэрэнгүй орлого	48.8	10.8	13.3	28.8

Эх сурвалж: Үнэт цаас гаргагчийн санхүүгийн тайлан

**2020 болон 2021 оны гадаад валютын арилжаанаас үүссэн олз болон үнэт металлын арилжаанаас үүссэн олзыг энэхүү ҮЦТ-д хавсаргасан 2019 болон 2018 оны тайлангийн толилуулгад нийцүүлсэн өөрчилсөн тул 2021 оны санхүүгийн тайлантай харьцуулагдахгүй.

***Банк нь 2021 онд үйл ажиллагааны бусад орлого зардлын толилуулгыг өөрчлөн бусад олз/(гарз)-ыг тусад нь харуулан өөрчилсөн тул 2019 болон 2018 оны үйл ажиллагааны бусад орлого, зардал болон бусад олз/(гарз)-ын дүнгүүд нь 2020 болон 2021 оны дүнтэй харьцуулагдахгүй болно



Хүснэгт 19. Үнэт цаас гаргагчийн мөнгөн гүйлгээний тайлан /тэрбум төгрөг/

Мөнгөн гүйлгээний тайлан	2018	2019	2020	2021
Үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ				
Татварын өмнөх ашиг	75.6	24.9	22.5	52.6
Мөнгөн бус орлого, зардлын тохируулгууд:				
Зээлжих эрсдэлийн сангийн зардал	66.2	135.4	93.8	35.8
Бусад дэлгэрэнгүй орлогоорх бодит үнэ цэнээр хүлээн зөвшөөрөх санхүүгийн хөрөнгөөс үүссэн (олз)/гарз	-	0	(2.2)	0
Ашиг, алдагдлаарх бодит үнэ цэнээр илэрхийлэгдэх санхүүгийн хөрөнгөөс үүссэн (олз)/гарз	6.3	(2.3)	1	(1.7)
Хорогдуулсан өртгөөр хэмжигдэх бусад зээлийн эх үүсвэрийн гэрээний өөрчлөлтөөс үүссэн олз	-	-	(1.8)	(3.6)
Үүсмэл санхүүгийн хэрэглүүрээс үүссэн (олз)/гарз	(93.4)	(11.1)	(14.5)	21.8
Хорогдуулсан өртгөөр хэмжигдэх санхүүгийн хөрөнгүүдийн өөрчлөлтөөс үүссэн гарз, бүртгэлээс хасагдахгүй	1.3	0.3	0.5	0.8
Ашиг алдагдлаарх бодит үнэ цэнээр бүртгэгдсэн зээлийн олзоос хасах гарз	-	-	6	14.6
Бусад банкуудад байруулсан хөрөнгийн үнэ цэнийн бууралт/(өсөлт)	-	0.8	(0.6)	(0)
Бусад дэлгэрэнгүй орлогоорх бодит үнэ цэнээр хүлээн зөвшөөрөх өрийн хэлбэрээрх хөрөнгө оруулалтын үнэ цэнийн бууралт/(өсөлт)	0.8	(1)	2.6	1.8
Хорогдуулсан өртгөөр хэмжигдэх өрийн хэлбэрээрх хөрөнгө оруулалтын хүлээгдэж буй алдагдлын сангийн зардал/ зардлын (буцаалт)	(1.1)	(0.7)	(0.0)	0
Зах зээлийн хүүгээс бага хүүтэй олгосон санхүүгийн хөрөнгийн анхны хүлээн зөвшөөрөлтөөс үүссэн гарз	16.9	5.3	0.9	2.6
Үндсэн хөрөнгө борлуулсны (олз)/гарз	2.5	1.5	(0.3)	1.5
Гадаад валютын ханшийн өөрчлөлтийн (олз)/гарз	19.0	(12.0)	(4.2)	(0.2)
Бусад хөрөнгийн эрсдэлийн сангийн зардал	2.7	2.7	0.8	0.5
Үндсэн хөрөнгийн үнэ цэнийн бууралтын гарз	26.6	-	-	-
Аккредитив, баталгааны эрсдэлийн сангийн зардал/зардлын (буцаалт)	(0.4)	(1.5)	(3.2)	1.8
Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгийн дахин үнэлгээний олз/(гарз)	3.0	(3.2)	(3.2)	1.8



	(1.9)	(1.8)	0.3	4
Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгийн бодит үнэ цэнийн өөрчлөлтийн (олз)/гарз	9.8	14.0	20.9	24.6
Элэгдлийн зардал				3.8
Хорогдуулалтын зардал	2.6	2.9	3.3	0
Данснаас хассан үндсэн хөрөнгө	0	0	0.2	0
Өмчлөх бусад хөрөнгийн бодит үнэ цэнийн бууралтаас үүссэн гарз болон үнэ цэнийн бууралтын сангийн зардал	6.5	9.6	38.2	78.9
Хүлээн авсан мөнгөн бус ногдол ашиг	(0.4)	-	-	-
Хүүгийн орлого	(494.0)	(577.9)	(570.1)	(554.8)
Хүүгийн зардал	323.3	366.0	365.8	272.8
Үйл ажиллагааны хөрөнгө, өр төлбөрийн өөрчлөлтийн өмнөх үйл ажиллагаанд зарцуулсан мөнгөн гүйлгээ	(28.0)	(47.9)	(34.3)	(38.7)
Монголбанкинд байршуулсан, заавал байлгах нөөцийн цэвэр (өсөлт)/ бууралт	(60.0)	163.2	48.5	(33.9)
Бусад банкуудад байршуулсан хөрөнгийн цэвэр (өсөлт)	(107.1)	(305.8)	(263.6)	95.9
Ашиг, алдагдлаарх бодит үнэ цэнээр хүлээн зөвшөөрөх өрийн хэлбэрээрх үнэт цаасны цэвэр (өсөлт)/ бууралт	174.5	114.7	39.7	(2.2)
Ашиг, алдагдлаарх бодит үнэ цэнээр хүлээн зөвшөөрөх өмчийн хэлбэрээрх үнэт цаасны цэвэр (өсөлт)/ бууралт	18.2	9.8	(0.5)	1
Харилцагчдад олгосон зээл ба урьдчилгааны цэвэр (өсөлт)	(1,200.3)	(650.2)	(19.8)	(514.7)
Бусад хөрөнгийн цэвэр бууралт/(өсөлт)	0.8	(64.2)	2.6	80.3
Өмчлөх бусад хөрөнгийн цэвэр (өсөлт)/бууралт	1.4	(9.6)	(44.6)	(44.1)
Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгийн цэвэр (өсөлт)/бууралт	12.1	(20.6)	26.1	76.7
Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгийн цэвэр (өсөлт)/бууралт	-	(4.9)	-	-
Бусад банкуудын байршуулсан хөрөнгийн цэвэр (бууралт)/өсөлт	(239.4)	(95.8)	(38.3)	2.1
Харилцагчдын харилцах, хадгаламжийн цэвэр өсөлт	935.8	495.7	389.2	256.9
Бусад өр төлбөрийн цэвэр (бууралт)/өсөлт	(9.1)	61.0	(6.3)	(28)
Татвар болон хүүгийн өмнөх үйл ажиллагаанд зарцуулсан цэвэр мөнгө	(501.1)	(354.5)	98.7	(148.6)
Төлсөн орлогын албан татвар	(6.0)	(15.3)	(2.1)	
Хүлээн авсан хүү	475.3	525.6	508.0	



Ашиг, алдагдлаарх бодит үнэ цэнээр илэрхийлэгдэх хөрөнгө оруулалтаас хүлээн авсан хүүгийн орлого	-	0.2	10.5	8.3
Төлсөн хүү	(323.6)	(339.9)	(357.9)	(382.5)
Үйл ажиллагаанд зарцуулсан цэвэр мөнгө	(355.5)	(183.9)	257.2	33.2
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ				
Бусад дэлгэрэнгүй орлогоорх бодит үнэ цэнээр хүлээн зөвшөөрөх өрийн хэлбэрээрх үнэт цаасны худалдан авалт	(11,354.6)	(4,020.7)	(348.9)	(93.5)
Бусад дэлгэрэнгүй орлогоорх бодит үнэ цэнээр хүлээн зөвшөөрөх өмчийн хэлбэрээрх үнэт цаасны худалдан авалт	(75.2)	(9.0)	-	-
Бусад дэлгэрэнгүй орлогоорх бодит үнэ цэнээр хүлээн зөвшөөрөх өрийн хэлбэрээрх үнэт цаас борлуулсны орлого	11,534.4	4,260.5	200.8	-
Бусад дэлгэрэнгүй орлогоорх бодит үнэ цэнээр хүлээн зөвшөөрөх өмчийн хэлбэрээрх үнэт цаас борлуулсны орлого	0	0.1	27.7	12.8
Хорогдуулсан өртгөөр хэмжигдэх өрийн хэлбэрээрх үнэт цаасны хөрөнгө оруулалтын (худалдан авалт)/ буцаалт	(3.4)	0.4	-	-
Хорогдуулсан өртгөөр хэмжигдэх өрийн хэлбэрээрх үнэт цаас борлуулсны орлого	21.5	34.2	6.6	-
Охин компани борлуулсны цэвэр орлого	0.5	-	-	-
Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө борлуулсны орлого	-	-	7.7	18.6
Үндсэн хөрөнгийн худалдан авалт	(15.1)	(31.3)	(12.2)	(25.8)
Үндсэн хөрөнгө борлуулсны орлого	6.7	0.8	3.3	0.7
Биет бус хөрөнгийн худалдан авалт	(3.2)	(3.0)	(5.7)	(4.9)
Хөрөнгө оруулалтад (зарцуулсан)/орсон цэвэр мөнгө	111.6	232.1	(120.6)	(92.0)
Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ				
Шинээр гаргасан энгийн хувьцаа	75	-	-	-
Шинээр гаргасан давуу эрхтэй хувьцаа	50	-	-	-
Энгийн хувьцааны буцаан худалдан авалт	-	(45)	(1.1)	-
Давуу эрхтэй хувьцааны буцаан худалдан авалт	-	-	(13.5)	-
РЕПО хэлцлээс орж ирсэн орлого	2,066.0	3,439.8	1,822.6	562.6
РЕПО хэлцлийн эргэн төлөлт	(1,967.9)	(3,571.2)	(1,829.7)	(367.6)
Бусад зээлийн эх үүсвэрээс орж ирсэн орлого	527.9	395.2	357.9	1205.5



Бусад зээлийн эх үүсвэрийн эргэн төлөлт	(453.3)	(89.1)	(23.1)	(854.3)
Түрээсийн өр төлбөрийн эргэн төлөлт	-	(4.7)	(5.8)	(5.2)
Хоёрдогч өглөгөөс орж ирсэн орлого	-	80	-	-
Хоёрдогч өглөгийн эргэн төлөлт	0	1.7	0	-
Төлсөн ногдол ашиг	(5.2)	(9.0)	(1.7)	(1.7)
Бусад төлбөр	-	(9.6)	-	-
Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	292.4	188.0	305.6	539.3
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн ханшийн өөрчлөлтийн нөлөө	(6.7)	47.1	39.2	7.5
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн цэвэр өсөлт	41.9	283.2	481.4	487.9
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	1,140.3	1,182.2	1,465.4	1,946.8
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	1,182.2	1,465.4	1,946.8	2,434.7

Эх сурвалж: Үнэт цаас гаргагчийн санхүүгийн тайлан



Хүснэгт 21. Үнэт цаас гаргагчийн өмчийн өөрчлөлтийн тайлан 2020-2021 /тэрбум төгрөг/

Өмчийн өөрчлөлтийн тайлан	Халаасны хувьцаа/Д		Энгийн хувьцаа	Халаасны хувьцаа		Нэмэгдэж төлөгдсөн капитал	БДОБҮЦ үнэт цаасны дахин үнэлгээний нөөц		Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний нөөц		Хуримтлагдасан бусад нөөц ашиг		Нийт эзэмшигчдийн өмч
	Давуу эрхтэй хувьцаа	авуу эрхтэй хувьцаа/		Хувиараа	Хувиараа		БДОБҮЦ үнэт цаасны дахин үнэлгээний нөөц	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдасан бусад нөөц ашиг	Хуримтлагдасан бусад нөөц ашиг			
2020 оны 01 сарын 01-ний үлдэгдэл	25.8	-	32.0	-	135.2	(15.8)	7.7	80.2	197.4	462.5	10.4	10.4	
Тайлант хугацааны ашиг	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	2.9
Бусад дэлгэрэнгүй орлого	-	-	-	-	-	2.9	-	-	-	-	-	-	13.3
2020 оны нийт дэлгэрэнгүй орлого	-	-	-	-	-	2.9	-	-	10.4	13.3	-	-	(14.5)
Халаасны хувьцааны буцаан худалдан авалт	-	(9.4)	-	-	(5.1)	-	-	-	-	-	-	-	171.9
Хоёрдогч өглөгийн хөрвүүлэлт	-	-	10.2	(0.1)	161.8	-	-	-	-	-	-	(1.7)	(1.7)
Зарласан болон төлөгдсөн ногдол ашиг	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	0.3
Хуримтлагдсан ашиг руу шилжүүлсэн үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	-	-	-	-	-	-	(0.3)	-	-	-	-	-	4.5
МБ-ны журмын дагуу бусад нөөц рүү шилжүүлсэн нөөц	-	-	-	-	-	-	-	(4.5)	-	-	-	-	-
Бусад шилжүүлэг	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
2020 оны 12 сарын 31-ний үлдэгдэл	25.8	(9.4)	42.2	(0.1)	291.8	(12.9)	7.5	75.7	210.9	631.6	210.9	210.9	631.6
2021 оны 01 сарын 01-ний үлдэгдэл	25.8	(9.4)	42.2	(0.1)	291.8	(12.9)	7.5	75.7	210.9	631.6	210.9	210.9	631.6
Тайлант хугацааны ашиг	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	25.9
Бусад дэлгэрэнгүй орлого	-	-	-	-	-	2.9	-	-	-	-	-	-	2.9
2021 оны нийт дэлгэрэнгүй орлого	-	-	-	-	-	2.9	-	-	25.9	28.8	-	-	-
Хувьцааны нэрлэсэн үнийн өсөлт	-	-	126.7	(0.2)	(126.5)	-	-	-	-	-	-	-	-
Хуримтлагдсан ашиг руу шилжүүлсэн БДОБҮЦ-ээрх өмчийн үнэт цаасны хөрөнгө оруулалтын дахин үнэлгээний нөөц	-	-	-	-	-	9.3	-	-	-	-	-	(9.3)	-
Зарласан болон төлөгдсөн ногдол ашиг	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	(1.7)
Хуримтлагдсан ашиг руу шилжүүлсэн үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	-	-	-	-	-	-	(0.3)	-	-	-	-	-	0.3
МБ-ны журмын дагуу бусад нөөц рүү шилжүүлсэн нөөц	-	-	-	-	-	-	-	(20.6)	-	-	-	-	-
Бусад	-	-	-	-	4.1	-	-	-	-	-	-	-	-
2021 оны 12 сарын 31-ний үлдэгдэл	25.8	(9.4)	169.0	(0.3)	169.5	(0.7)	7.2	55.1	242.4	658.7	242.4	242.4	658.7

Эх сурвалж: Үнэт цаас гаргагчийн санхүүгийн тайлан



Үнэт цаас гаргагчийн хураангуй санхүүгийн тайлан, шинжилгээ

Хураангуй санхүүгийн тайлан шинжилгээнд харьцуулах зорилгоор 2017 оны санхүүгийн мэдээллийг 2018 оны санхүүгийн тайлангаас бэлтгэсэн бөгөөд 2018 оны жилийн эцсийн тайлан нь энэхүү Үнэт цаасны танилцуулгад хавсрагдаагүй болно.

Хүснэгт 22. Үнэт цаас гаргагчийн санхүүгийн байдлын тайлан /тэрбум төгрөг/

Үзүүлэлт	2017	2018	2019	2020	2021
Бэлэн мөнгө, банкин дахь хөрөнгө	1,209.7	1,699.3	2,308.7	2,077.9	2,028.7
Хөрөнгө оруулалт	1,245.7	724.6	311.6	1,393.9	1,997.9
Харилцагчдад олгосон зээл ба урьдчилгаа	2,318.1	3,183.7	3,306.7	3,031.3	3,339.2
Бусад хөрөнгө	276.9	329.2	547.7	604.1	447.4
Өмчлөх бусад хөрөнгө	47.1	89.9	151.3	210.6	107.0
Бусад	229.8	239.3	396.4	393.5	340.4
Үндсэн хөрөнгө, биет бус хөрөнгө	154.2	144.3	168.4	170.8	180.9
Нийт хөрөнгө	5,204.6	6,081.1	6,643.1	7,278.0	7,994.1
Харилцагчдын харилцах, хадгаламж	3,453.9	4,402.6	4,900.6	5,285.7	5,463.5
Банк, СБ-аас татсан эх үүсвэр	1,193.4	1,016.0	993.8	1,237.0	1,748.1
Бусад өр төлбөр	165.5	149.4	286.2	123.8	123.7
Нийт өр төлбөр	4,812.9	5,568.0	6,180.6	6,646.4	7,335.4
Дүрмийн сан ба НТК	98.7	235.7	193.0	350.4	354.5
Хуримтлагдсан ашиг	218.5	202.8	197.4	210.9	242.4
Өмчийн бусад хэсэг	74.4	74.5	72.1	70.3	61.7
Нийт эзэмшигчдийн өмч	391.7	513.1	462.5	631.6	658.7
Нийт өр төлбөр ба эзэмшигчдийн өмч	5,204.6	6,081.1	6,643.1	7,278.0	7,994.1

Эх сурвалж: Үнэт цаас гаргагчийн санхүүгийн тайлан

Хүснэгт 23. Үнэт цаас гаргагчийн хураангуй орлогын тайлан /тэрбум төгрөг/

Үзүүлэлт	2017	2018	2019	2020	2021
Хүүгийн болон бусад адилтгах орлого	409.2	494.0	577.9	570.1	554.8
Хүүгийн болон бусад адилтгах зардал	287.2	323.3	366.0	365.8	272.8
Хүүгийн цэвэр орлого	122.0	170.7	211.9	204.4	282.0
Нийт хүүгийн бус орлого	17.9	147.9	98.1	98.1	70.3
Хүүгийн бус орлого	83.2	54.5	83.1	83.6	92.1
Үүсмэл санхүүгийн хэрэглүүрээс үүссэн олз / (гарз)	(65.3)	93.4	15.0	14.5	(21.8)
Хүүгийн бус зардал	9.8	12.3	17.1	15.6	21.7
Цэвэр хүүгийн бус орлого	8.1	135.6	81.0	82.5	48.6
Үйл ажиллагааны орлого	130.1	306.3	292.9	286.9	330.5



Удирдлагын болон үйл ажиллагааны бусад зардал	85.6	110.1	122.0	121.0	137.1
Үйл ажиллагааны ашиг	44.5	196.2	170.9	165.9	193.4
Сангийн үнэлгээний зардал	36.4	94.0	146.0	143.4	140.8
Үндсэн хөрөнгийн үнэ цэнийн бууралт	20.2	26.6	-	-	-
Татварын өмнөх ашиг	(12.1)	75.6	24.9	22.5	52.6
Орлогын албан татварын зардал (кредит)	(6.9)	22.1	8.6	12.1	26.6
Тайлант жилийн ашиг	(5.2)	53.5	16.3	10.4	25.9

Эх сурвалж: Үнэт цаас гаргагчийн санхүүгийн тайлан

Хүснэгт 24. Үнэт цаас гаргагчийн хураангуй мөнгөн гүйлгээний тайлан /тэрбум төгрөг/

Үзүүлэлт	2017	2018	2019	2020	2021
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	804.6	1,140.3	1,182.2	1,465.4	1,946.8
Үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ					
Монголбанкинд байршуулсан, заавал байлгах нөөцийн цэвэр (өсөлт)/ бууралт	(79.4)	(60.0)	163.2	48.5	(33.9)
Банк санхүүгийн байгууллагад байршуулсан хөрөнгө	444.4	(346.5)	(401.7)	(301.9)	98.0
Үнэт цаас	44.7	192.7	124.5	39.2	(1.2)
Харилцагчдад олгосон зээл ба урьдчилгааны цэвэр (өсөлт)	(503.0)	(1,200.3)	(650.2)	(19.8)	(514.7)
Өмчлөх бусад хөрөнгө болон түүнтэй адилтгах хөрөнгө	9.5	13.5	(35.0)	(18.5)	32.6
Бусад хөрөнгийн цэвэр бууралт/(өсөлт)	(15.7)	0.8	(64.2)	2.6	80.3
Харилцагчдын харилцах, хадгаламжийн цэвэр өсөлт	634.2	935.8	495.7	389.2	256.9
Бусад өр төлбөрийн цэвэр (бууралт)/өсөлт	18.2	(9.1)	61.0	(6.3)	(28.0)
Үйл ажиллагааны хөрөнгө, өр төлбөрийн өөрчлөлтийн өмнөх үйл ажиллагаанд зарцуулсан мөнгөн гүйлгээ	(30.3)	(28.0)	(47.9)	(34.3)	(38.7)
Хүү	153.7	151.7	185.8	160.6	182.9
Төлсөн орлогын албан татвар	6.9	(6.0)	(15.3)	(2.1)	(1.1)
Үйл ажиллагаанд зарцуулсан цэвэр мөнгө	683.2	(355.5)	(183.9)	257.2	33.2
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ					
Үнэт цаас	(5.6)	122.8	265.5	(113.8)	(80.6)
Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө борлуулсны орлого	-	-	-	7.7	18.6
Үндсэн хөрөнгө	(11.6)	(8.5)	(30.5)	(8.9)	(25.1)
Биет бус хөрөнгийн худалдан авалт	(1.3)	(3.2)	(3.0)	(5.7)	(4.9)
Охин компани борлуулсны цэвэр орлого	-	0.5	-	-	-



Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	(18.4)	111.6	232.1	(120.6)	(92.0)
Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ					
Энгийн хувьцаа	-	75.0	(45.0)	(1.1)	-
Давуу эрхтэй хувьцаа	-	50.0	-	(13.5)	-
Төлсөн ногдол ашиг	-	(5.2)	(9.0)	(1.7)	(1.7)
Репо хэлцэл	9.9	98.0	(131.4)	(7.1)	195.0
Зээлсэн эх үүсвэр	(354.8)	74.6	306.1	334.8	351.2
Хоёрдогч өглөг	11.2	(0.0)	81.7	(0.0)	-
Бусад	-	-	(14.4)	(5.8)	(5.2)
Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	(333.8)	292.4	188.0	305.6	539.3
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн ханшийн өөрчлөлтийн нөлөө	4.7	(6.7)	47.1	39.2	7.5
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	1,140.3	1,182.2	1,465.4	1,946.8	2,434.7

Эх сурвалж: Үнэт цаас гаргагчийн санхүүгийн тайлан



Санхүүгийн байдлын тайлан, шинжилгээ


Нийт хөрөнгө (актив)

2017-2021 онд Үнэт цаас гаргагчийн нийт хөрөнгө дунджаар 11.3 хувиар өсөж 2021 оны байдлаар 8.0 их наяд төгрөгт хүрсэн. Нийт хөрөнгийн 42 хувийг цэвэр зээл, 25 хувийг үнэт цаасаарх хөрөнгө оруулалт, 13 хувийг бусад банк санхүүгийн байгууллагад байршуулсан хөрөнгө, 12 хувийг мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө, 2 хувийг үндсэн хөрөнгө, үлдсэн 6 хувийг бусад хөрөнгө эзэлж байна.

График 8. Нийт хөрөнгө /тэрбум төгрөг/



График 9. Нийт хөрөнгийн бүтэц



Эх сурвалж: Үнэт цаас гаргагчийн тооцоолол

Бэлэн мөнгө, бусад банканд дахь хөрөнгө

Түүхэн жилийн хугацаанд нийт хөрөнгөд эзлэх мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн хэмжээ 2019 онд хамгийн өндөр түвшинд буюу нийт хөрөнгийн 21 хувьд буюу 1.4 их наяд төгрөгт хүрсэн. Үүнд, тайлант хугацаанд 100 сая ам.долларын свопын хэлцэл хийгдэж, Монголбанкинд байршуулсан хөрөнгө өссөн нь голлох нөлөө үзүүлжээ. 2021 оны байдлаар Үнэт цаас гаргагчийн мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө 972 тэрбум төгрөгөөр хэмжигдэж байна.

Үнэт цаас гаргагчийн бусад банкуудад байршуулсан хөрөнгийн хэмжээ 2020 онд хамгийн өндөр түвшинд буюу 1.3 их наяд төгрөгт хүрч, нийт хөрөнгийн 17 хувийг эзэлж байсан. Энэ нь Ковид-19 цар тахлын үед Монголбанкнаас баримталж буй мөнгөний зөөлөн бодлогын нөлөөгөөр мөнгөний нийлүүлэлт нэмэгдэж, бизнесийн үйл ажиллагаа зогсонги байдалд орсноор зээлийн эрэлт буурснаас үүдэлтэй.



2021 оны жилийн эцсийн байдлаар бусад банкуудад байршуулсан хөрөнгийн хэмжээ 1.1 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны эцэстэй харьцуулахад 17 хувиар буурсан. Энэ нь Үнэт цаас гаргагчийн зээлийн үйл ажиллагаа идэвхжиж эхэлсэнтэй холбоотой юм.

График 10. Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө /тэрбум төгрөг/




График 11. Бусад банкуудад байршуулсан хөрөнгө /тэрбум төгрөг/



Эх сурвалж: Үнэт цаас гаргагчийн тооцоолол

Үнэт цаасаарх хөрөнгө оруулалт


Үнэт цаас гаргагч нь 2017 оноос хойш мөнгөн хөрөнгийн зохистой бодлого, зохицуулалтын хүрээнд илүүдэл мөнгөн хөрөнгөөр хөрөнгө оруулалтыг идэвхтэй хийж эхэлсэн.

2018-2019 онуудад бодлогын хүү 3 нэгж хувиар буурч 11 хувьд хүрснээр үнэт цаас гаргагчийн Монголбанкны үнэт цаасанд оруулсан хөрөнгө оруулалт буурсан.

Харин 2020 он гарснаар Ковид-19 цар тахлын нөхцөл байдлаас үүдэн зээл олголт хумигдаж үнэт цаасаарх хөрөнгө оруулалт огцом өсөж 1.4 их наяд төгрөгт хүрсэн бол нийт хөрөнгө оруулалтын 98 хувийг өрийн хэлбэрээрх хөрөнгө оруулалт эзэлж байна. 2021 оны байдлаар нийт хөрөнгө оруулалт өмнөх оны мөн үеийн үзүүлэлтээс 43.3 хувиар өсөж 2.0 их наяд төгрөгт хүрсэн.



График 12. Хөрөнгө оруулалт /тэрбум төгрөг/



Эх сурвалж: Үнэт цаас гаргагчийн тооцоолол

Зээл

2017-2021 онд Үнэт цаас гаргагчийн нийт зээлийн багц жилд дунджаар 9.7 хувиар өсөж 2021 оны байдлаар 3.5 их наяд төгрөгийн зээлийн багцтай болсон. 2018 онд эдийн засгийн өсөлт болон Монголбанкны хэрэгжүүлж буй мөнгөний зөөлөн бодлогын нөлөөгөөр Голомт банкны зээлийн багцын өсөлт хамгийн өндөр түвшин буюу 39.1 хувиар өссөн бөгөөд энэхүү өсөлтийн 63 хувийг иргэд болон жижиг дунд бизнес эрхлэгчдэд олгосон зээл бүрдүүлж байсан.

2019 онд хэрэглээний зээлийн хязгаарлалт болон банкуудын өөрийн хөрөнгийн хүрэлцээний шаардлага нэмэгдсэний улмаас зээлийн өсөлтийн хэмжээ саарч эхэлсэн байна.

2020 онд Ковид-19 цар тахлын нөлөөгөөр эдийн засаг удааширсны улмаас зээлийн эрэлт буурч, нийт зээлийн багц өмнөх оноос 6.9 хувиар багассан байна. Ковид-19 цар тахлын нөлөө үргэлжилсэн хэвээр байгаа ч эдийн засгийг сэргээх бодлогын хүрээнд шат дараалсан арга хэмжээ авснаар 2021 оны байдлаар Үнэт цаас гаргагчийн нийт зээлийн багц 9.7 хувиар өсч 3.5 их наяд төгрөгт хүрсэн.


Харин зээлийн бүтцийг задалж үзвэл 2017 онд иргэдэд олгосон зээл (хэрэглээ болон орон сууцны зээл) нийт зээлийн 34 хувь, жижиг дунд бизнес эрхлэгчдэд олгосон зээл 22 хувийг тус тус эзэлж, иргэд болон жижиг дунд бизнес эрхлэгчдэд олгосон зээл нийт зээлийн багцын 56 хувийг эзэлж байсан бол сүүлийн жилүүдэд Үнэт цаас гаргагч нь иргэд болон жижиг дунд бизнесийн салбарт зээл олголтыг дэмжих бодлогыг хэрэгжүүлж, зээлийн төвлөрлийг амжилттай бууруулснаар 2021



оны жилийн эцсийн байдлаар иргэд болон жижиг дунд бизнес эрхлэгчдэд олгосон зээлийн нийт зээлд эзлэх хэмжээ 65 хувь болж өссөн байна.

График 13. Нийт зээлийн үлдэгдэл/тэрбум төгрөг/

График 14. Нийт зээлийн бүтэц



Эх сурвалж: Үнэт цаас гаргагчийн тооцоолол

2017-2021 онд Үнэт цаас гаргагчийн чанаргүй зээлийн хувь 4.1-6.4 хувийн түвшинд хэлбэлзэж байсан. 2020 онд цар тахлын нөхцөл байдал банкны зээлийн чанарт сөргөөр нөлөөлж, чанаргүй зээлийн хэмжээ нэмэгдсэн.


Үнэт цаас гаргагч нь зээлийн чанарт анхааран ажиллаж, зээлийн чанарыг сайжруулах бодлогын дагуу 2021 оны байдлаар чанаргүй зээлийн хувь өмнөх оны эцэстэй харьцуулахад 1.1 нэгж хувиар буурсан байна. Зээлийн эрсдэл буюу зээл төлөгдөхөд учирч болзошгүй алдагдал, доголдлоос сэргийлэх зорилгоор Үнэт цаас гаргагч нь активын чанарын үнэлгээний шаардлагын дагуу зээлийн эрсдэлийн санг тогтмол байгуулж ажилладаг ба 2021 оны жилийн эцсийн байдлаар Үнэт цаас гаргагч нийт чанаргүй зээлийн 88 хувийг хаах хэмжээний 161 тэрбум төгрөгийн үнийн дүн бүхий эрсдэлийн сан байгуулсан нь эрсдэл даах түвшин сайн байгааг илэрхийлж байна.



График 15. Чанаргүй зээлийн үлдэгдэл /тэрбум төгрөг/



График 16. Зээлийн эрсдэлийн сан /тэрбум төгрөг/




Эх сурвалж: Үнэт цаас гаргагчийн тооцоолол

Өмчлөх бусад хөрөнгө

Өмчлөх бусад хөрөнгөд зээлийн өр төлбөрт тооцон банкны өмчлөлд шилжүүлсэн хөрөнгүүд багтдаг. Тус хөрөнгө нь 2017-2021 онд нийт хөрөнгийн 1-3 хувийг эзэлж байна.

2017-2020 онд өмчлөх бусад хөрөнгө жилд дунджаар 55 тэрбум төгрөгөөр өсч 211 тэрбум төгрөг хүрсэн бол 2021 оны жилийн эцсийн байдлаар өмнөх үеэс 49 хувиар буурч 107 тэрбум төгрөг хүрч сайжирсан байна.

График 17. Өмчлөх бусад хөрөнгө /тэрбум төгрөг/



Эх сурвалж: Үнэт цаас гаргагчийн тооцоолол




Үндсэн хөрөнгө, биет бус хөрөнгө

Үнэт цаас гаргагч нь санхүүгийн үйлчилгээ явуулдаг учир үйлдвэрлэлийн салбарын байгууллагатай харьцуулахад үндсэн хөрөнгө, биет бус хөрөнгийн хэлбэлзэл харьцангуй бага байдаг. Банкны үндсэн хөрөнгөд барилга байшин, оффис тоног төхөөрөмж, тавилга, тээврийн хэрэгсэл, дуусаагүй барилга, ашиглах эрхтэй хөрөнгө, биет бус хөрөнгө зэрэг багтдаг.

2017-2021 онд Үнэт цаас гаргагчийн үндсэн болон биет бус хөрөнгө жилд дунджаар 4.1 хувиар өсч, 2021 оны байдлаар 181 тэрбум төгрөгт хүрсэн. Үүнээс үндсэн хөрөнгө 90 хувийг, биет бус хөрөнгө 10 хувийг эзэлж байна.

График 18. Биет, биет бус хөрөнгө /тэрбум төгрөг/



Эх сурвалж: Үнэт цаас гаргагчийн тооцоолол


Нийт өр төлбөр

2017-2021 онд нийт өр төлбөр жилд дунджаар 11.1 хувиар өссөн. 2021 оны байдлаар Үнэт цаас гаргагчийн нийт өр төлбөр 7.3 их наяд төгрөгөөр хэмжигдэж байна.

Үүнээс 74 хувийг харилцагчдаас татсан эх үүсвэр болох харилцах хадгаламж, 21 хувийг төслийн зээл болон гадаадын банк санхүүгийн байгууллагаас татсан эх үүсвэр, 3 хувийг бусад банкуудын байршуулсан хөрөнгө, 2 хувийг бусад өр төлбөр бүрдүүлж байна.



График 19. Нийт өр төлбөр /тэрбум төгрөг/



Эх сурвалж: Үнэт цаас гаргагчийн тооцоолол


Харилцагчдаас татсан эх үүсвэр

2017-2021 онд Үнэт цаас гаргагчийн харилцагчдаас татсан эх үүсвэр буюу харилцах, хадгаламжийн хэмжээ жилд дунджаар 12.1 хувиар өсөж 2021 оны байдлаар 5.5 их наяд төгрөгт хүрсэн. Харилцагчдаас татсан эх үүсвэрийн 52 хувийг хугацаатай хадгаламж, 33 хувийг харилцах данс, 15 хувийг хугацаагүй хадгаламж бүрдүүлж байна.

График 20. Харилцагчдаас татсан эх үүсвэр /сегментээр/



График 21. Харилцагчдаас татсан эх үүсвэр бүтэц /тэрбум төгрөг/



Эх сурвалж: Үнэт цаас гаргагчийн тооцоолол



2017 онд нийт харилцагчдаас татсан эх үүсвэрийн 65 хувийг иргэдийн харилцах, хадгаламж эзэлж байсан бол 2018 оноос эхлэн эх үүсвэрийн бүтэц тэнцвэржиж эхэлсэн байна. 2021 оны байдлаар нийт харилцагчаас татсан эх үүсвэрийн 60 хувийг иргэдийн, 40 хувийг аж ахуй нэгж, байгууллагын эх үүсвэр эзэлж байна.

График 22. Иргэд болон бусад эх үүсвэр /тэрбум төгрөг/





График 23. ААН-ийн харилцах, хадгаламж /тэрбум төгрөг/



Эх сурвалж: Үнэт цаас гаргагчийн тооцоолол

2017-2021 онд Үнэт цаас гаргагчид байршуулсан аж ахуй нэгж байгууллагын харилцах, хадгаламж жилд дунджаар 16.2 хувиар өсөж 2021 оны жилийн эцсийн байдлаар 2.2 их наяд төгрөгт хүрсэн. Аж ахуй нэгж байгууллагын харилцах, хадгаламж нь эдийн засгийн өсөлттэй он жилүүд болох 2018-2019 онд огцом өсөж 2.2 их наяд төгрөгт хүрч байсан бол Ковид-19 цар тахлаас үүдэлтэй эдийн засгийн хүндрэлийн улмаас 2020 онд 1.5 хувиар буурсан.

Иргэдээс болон бусад эх үүсвэрээс татсан харилцах, хадгаламж 2017-2021 онд жилд дунджаар 9.8 хувиар өсөж, 2021 оны жилийн эцсийн байдлаар 3.3 их наяд төгрөгт хүрсэн.

Бусад банк санхүүгийн байгууллагаас татсан эх үүсвэр, зээлсэн эх үүсвэр

Бусад банк, санхүүгийн байгууллагын байршуулсан хөрөнгөд дотоодын болон гадаадын банкуудын харилцах данс болон хадгаламж багтдаг. Тус эх үүсвэрийн нийт өр төлбөрт эзлэх хувь 2017 онд 9 хувь байсан бол 2021 оны байдлаар 3 хувь болж буурсан нь Монгол Улсын Хөгжлийн банкны эх үүсвэр буурсантай холбоотой.

Бусад зээлийн эх үүсвэрт Монгол Улсын Засгийн Газар, Хөгжлийн банкнаас хэрэгжүүлж буй тусгай зориулалттай эх үүсвэр, гадаадын банк санхүүгийн байгууллагаас авсан зээлийн эх үүсвэр, худалдааны зээлийн эх үүсвэр багтдаг.



2017-2021 онд Үнэт цаас гаргагчийн бусад зээлийн эх үүсвэр жилд дунджаар 18.8 хувиар өсөж 2021 оны байдлаар 1.5 их наяд төгрөгт хүрсэн. Үүнд гадны томоохон банк, санхүүгийн байгууллагаас дунд хугацааны, өртөг багатай татсан зээлийн эх үүсвэрийн өсөлт болон худалдааны санхүүжилтийн эх үүсвэрийн өсөлт голлох нөлөө үзүүлсэн. Энэ нь гадны байгууллагуудын Үнэт цаас гаргагчид итгэх итгэл өндөр байгааг харуулж байна.

График 24. Бусад зээлийн эх үүсвэр /тэрбум төгрөг/



График 25. БСБ-аас татсан эх үүсвэр, репо хэлцэл /тэрбум төгрөг/



Эх сурвалж: Үнэт цаас гаргагчийн тооцоолол

Нийт эздийн өмч (өөрийн хөрөнгө)

2017-2021 онд Үнэт цаас гаргагчийн өөрийн хөрөнгө жилд дунджаар 13.9 хувиар өссөн. 2018 онд Үнэт цаас гаргагч нь нэмж хувьцаа гаргаснаар өөрийн хөрөнгө нь 137 тэрбум төгрөгөөр өссөн.

2019 онд Үнэт цаас гаргагч нь өөрийн хөрөнгөд бүртгэлтэй байсан 50 тэрбум төгрөгийн нэрлэсэн үнийн дүн бүхий давуу эрхтэй хувьцааг хоёрдогч өглөг рүү хөрвүүлсэн. 2020 онд нийт 172 тэрбум төгрөгийн хоёрдогч өглөгийг 1 дүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө рүү шилжүүлснээр Үнэт цаас гаргагчийн өөрийн хөрөнгө 632 тэрбум төгрөгт хүрсэн байна.

2021 оны байдлаар Үнэт цаас гаргагчийн өөрийн хөрөнгө 659 тэрбум төгрөгөөр хэмжигдэж байна. Өөрийн хөрөнгийн 37 хувийг хуримтлагдсан ашиг, 26 хувийг



График 28. Хүүгийн орлого /тэрбум төгрөг/




График 29. Хүүгийн орлогын бүтэц



Эх сурвалж: Үнэт цаас гаргагчийн тооцоолол

Хүүгийн зардал


2017-2021 онд Үнэт цаас гаргагчийн хүүгийн зардал жилд дунджаар 1.3 хувиар буурсан үзүүлэлттэй байна. 2018-2019 онд банкны эх үүсвэр нэмэгдсэнтэй холбогдон хүүгийн зардал өссөн бол 2020 онд өмнөх онтой ижил түвшинд хадгалагдсан.

2021 оны байдлаар Үнэт цаас гаргагчийн хүүгийн зардал нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 25.4 хувиар буурч, 273 тэрбум төгрөгт хүрсэн. Үүнд, хугацаагүй хадгаламжийн хүү тэглэлт, гадны байгууллагаас бага өртөгтэй эх үүсвэр татсан зэрэг нь нөлөөлсөн байна. Хүүгийн зардлын 80 хувийг харилцагчийн эх үүсвэрийн хүүгийн зардал, 20 хувийг бусад эх үүсвэрийн хүүгийн зардал эзэлж байна.

График 30. Хүүгийн зардал /тэрбум төгрөг/



График 31. Хүүгийн зардлын бүтэц




Эх сурвалж: Үнэт цаас гаргагчийн тооцоолол



Цэвэр хүүгийн орлого

Үнэт цаас гаргагчийн цэвэр хүүгийн орлого 2017 оноос хойш тасралтгүй өсч 2019 оны эцэст 211.9 тэрбум төгрөгт хүрсэн. 2020 он гарснаар цар тахлын нөлөөтэй зээлийн эргэн төлөлт удааширсан, бодлогын хүү буурсан зэрэг хүчин зүйлсийн нөлөөнд цэвэр хүүгийн орлого 4 хувиар буурсан ч 2021 оны эцэст цэвэр хүүгийн орлого 282.0 тэрбум төгрөгт хүрч өмнөх оны мөн үеийн үзүүлэлтээс 38.0 хувиар өссөн байна.

График 32. Цэвэр хүүгийн орлого /тэрбум төгрөг/



Эх сурвалж: Үнэт цаас гаргагчийн тооцоолол


Цэвэр хүүгийн бус орлого

Цэвэр хүүгийн бус орлогод шимтгэл, хураамжийн орлого, арилжааны орлого, своп хэлцлүүдийн бодит үнэ цэнийн олз/гарзын бүртгэл болон бусад орлогууд багтдаг. 2017-2021 онд Үнэт цаас гаргагчийн цэвэр хүүгийн бус орлого жилд дунджаар 56.6 хувиар өсч 2021 оны байдлаар 49 тэрбум төгрөгт хүрсэн. Үүнд своп хэлцлүүдийн бодит үнэ цэнийн олз/гарзын бүртгэл голлох нөлөө үзүүлсэн байна.

Тус хугацаанд Үнэт цаас гаргагчийн цэвэр шимтгэл хураамжийн орлого жилд дунджаар 12.1 хувиар өсч, 2021 оны байдлаар 41 тэрбум төгрөгт хүрсэн.



График 33. Цэвэр хүүгийн бус орлого /тэрбум төгрөг/




Эх сурвалж: Үнэт цаас гаргагчийн тооцоолол

Үйл ажиллагааны зардал

Үнэт цаас гаргагч нь үйл ажиллагааны зардлыг үйл ажиллагааны орлоготой уялдуулан удирдаж, зардал орлогын харьцааг зохистой түвшинд буюу 50 хувиас доогуур түвшинд тогтмол хадгалдаг. 2020 оны байдлаар Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагааны зардал 121 тэрбум төгрөг байсан буюу нийт үйл ажиллагааны орлогын 42 хувийг эзэлж байна.

2021 оны жилийн эцсийн байдлаар Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагааны зардал 137 тэрбум төгрөг байна. Үүнээс 37 хувийг хүний нөөцийн зардал, 22 хувийг мэдээлэл, мэргэжлийн үйлчилгээний зардал, 17 хувийг элэгдэл хорогдлын зардал, 24 хувийг бусад зардал бүрдүүлж байна.

График 34. Үйл ажиллагааны зардал /тэрбум төгрөг/




Эх сурвалж: Үнэт цаас гаргагчийн тооцоолол



Эрсдэлийн сан, үнэлгээний зардал (цэвэр)

Үнэт цаас гаргагчийн эрсдэлийн сангийн зардал 2018-2019 онд өмнөх үеийн чанаргүй зээлээс үүдэлтэйгээр өссөн бөгөөд 2020 онд Ковид-19 цар тахлын нөхцөл байдлын улмаас бизнесүүдийн үйл ажиллагаа тасалдаж, иргэдийн орлогын эх үүсвэр буурсан нь зээлийн чанаргүйдлийн түвшинг нэмэгдүүлж, улмаар Үнэт цаас гаргагчийн эрсдэлийн сангийн зардал 143 тэрбум төгрөгт хүрсэн байна. 2021 оны байдлаарх эрсдэлийн сангийн зардал 141 тэрбум төгрөг байна.

График 35. Эрсдэлийн сан, үнэлгээний зардал /тэрбум төгрөг/



Эх сурвалж: Үнэт цаас гаргагчийн тооцоолол


Татварын зардал

Үнэт цаас гаргагч нь татварын тухай хууль тогтоомжид заасан үүргээ бүрэн биелүүлж татвар төлдөг бөгөөд 2020 онд 120 тэрбум төгрөгийн, 2021 онд 137 тэрбум төгрөгийн татвар төлж, улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

Цэвэр ашиг

2017-2021 онд Үнэт цаас гаргагчийн цэвэр ашиг жилд дунджаар 128 хувиар өсөж, 2021 оны байдлаар 26 тэрбум төгрөгт хүрсэн байна.

График 36. Цэвэр ашиг /тэрбум төгрөг/



Эх сурвалж: Үнэт цаас гаргагчийн тооцоолол



Мөнгөн урсгалын тайлан, шинжилгээ

Үйл ажиллагааны мөнгөн урсгал

2018-2019 онд Үнэт цаас гаргагчийн үндсэн үйл ажиллагааны мөнгөн урсгал сөрөг дүнтэй байсан нь зах зээлийн тэлэлт хийж, зээл олголт өндөр байсантай холбоотой. 2020 онд Ковид-19 цар тахлын улмаас олон удаагийн хөл хорио тогтоосон тул аж ахуй нэгж, бизнесийн үйл ажиллагаа тасалдаж, зээл олголт буурч, харилцах, хадгаламжийн эх үүсвэр тогтвортой хэмжээнд өсөж, үндсэн үйл ажиллагааны мөнгөн урсгал эерэг үзүүлэлттэй гарсан.

Хөрөнгө оруулалтын мөнгөн урсгал

Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн урсгал 2018-2019 онд эерэг үзүүлэлттэй байсан нь Үнэт цаас гаргагч нь үнэт цаасаарх хөрөнгө оруулалтыг худалдан борлуулж, зээл олголтыг нэмэгдүүлж байсантай холбоотой.

Харин 2020 онд эдийн засгийн нөхцөл байдлын улмаас зээл олголт буурсан тул илүүдэл мөнгөн хөрөнгийг үнэт цаасаарх хөрөнгө оруулалтад байршуулж, хөрөнгө оруулалтын цэвэр мөнгөн урсгал 2020 болон 2021 оны байдлаар сөрөг утгатай гарсан байна.

Санхүүгийн мөнгөн урсгал

2018 онд энгийн хувьцаа болон давуу эрхийн хувьцааг нэмэгдүүлсэн, репо хэлцэл, гадны банк санхүүгийн байгууллагаас авсан зээлийн хэмжээ өссөнөөр санхүүжилтийн мөнгөн урсгал өндөр байсан. 2019-2020 онд гадны банк, санхүүгийн байгууллагаас зээлийн эх үүсвэр, төслийн зээл нэмж авсан учраас эерэг мөнгөн урсгалтай байсан.

2021 оны байдлаар репо хэлцэл болон зээлсэн эх үүсвэр нэмэгдсэнтэй холбоотой эерэг үзүүлэлттэй гарсан.

Цэвэр мөнгөн урсгал

2017 оноос хойших банкны нийт цэвэр мөнгөн урсгал эерэг үзүүлэлттэй байсан нь санхүүжилтийн мөнгөн урсгал эерэг байсан болон 2020 оноос эхлэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн урсгал эерэг болсонтой холбоотой.

Цэвэр мөнгөн урсгалыг тооцоолохдоо үйл ажиллагаа, хөрөнгө оруулалт, санхүүжилтийн мөнгөн урсгалуудын нийлбэрээр тооцоолдог.



График 37. Цэвэр мөнгөн урсгал /тэрбум төгрөг/



Эх сурвалж: Үнэт цаас гаргагчийн тооцоолол

Харьцаа үзүүлэлтийн шинжилгээ

Цэвэр хүүний ахиуц (Net Interest Margin)

Цэвэр хүүний ахиуц ашиг нь цэвэр хүүгийн орлогыг зээл, үнэт цаас зэрэг хүүгийн орлого олдог хөрөнгөд харьцуулснаар, банк орлого олдог хөрөнгөнөөс хэр хэмжээний ашиг хүртэж буйг илтгэдэг. Үнэт цаас гаргагчийн хувьд цэвэр хүүний ахиуц нь 2018 оноос хойш тогтвортой хэмжээнд байгаа нь үндсэн үйл ажиллагааны ашигт ажиллагаа активын өөрчлөлтийг даган тогтвортой хэмжээнд хадгалагдсаар байгааг илэрхийлж байна.

График 38. Цэвэр хүүний ахиуц




Эх сурвалж: Үнэт цаас гаргагчийн тооцоолол



Цэвэр ашгийн ахиуц (Net Profit Margin)

Цэвэр ашгийн ахиуц нь нийт хүүний орлогын хэдэн хувийг цэвэр ашиг болгон хувиргаж байгааг илтгэдэг. 2018 онд цэвэр ашиг өндөр өсөлт үзүүлсэн учраас тус хугацаанд цэвэр ашгийн ахиуц хамгийн өндөр түвшинд буюу 11 хувьд хүрсэн. Үүнээс хойш Үнэт цаас гаргагч нь активын чанарыг удирдах бодлогын хүрээнд эрсдэлийн сан, үнэлгээний зардлыг нэмэгдүүлснээр цэвэр ашиг буурч, 2020 оны байдлаар 2 хувь, 2021 оны байдлаар 5 хувьд тус тус хүрсэн байна.

График 39. Цэвэр ашиг /тэрбум төгрөг/, цэвэр ашгийн ахиуц



Эх сурвалж: Үнэт цаас гаргагчийн тооцоолол

Эздийн өмчийн өгөөж (Return on Equity)

Эздийн өмчийн өгөөжийг тооцоолохдоо тайлант жилийн ашгийг дундаж өөрийн хөрөнгөд харьцуулсан болно. Үнэт цаас гаргагчийн цэвэр ашиг түүхэн дээд түвшинд хүрсэн хугацаанд буюу 2018 онд эздийн өмчийн өгөөж 16.1 хувьд хүрсэн. 2020 оны байдлаар эздийн өмчийн өгөөж 2.5 хувь байна. Бууралтын гол шалтгааныг ашигт ажиллагаа, хөрөнгийн үр ашигт байдал болон санхүүгийн хөшүүргээс хамааруулан Дупонт шинжилгээгээр үзэхэд цэвэр ашгийн ахиуц буюу ашигт ажиллагааны түвшин буурсан нь голлох нөлөө үзүүлсэн байна.

График 40. Эздийн өмч, нийт хөрөнгийн өгөөж





График 41. Ду-Понт шинжилгээ



Эх сурвалж: Үнэт цаас гаргагчийн тооцоолол

Нийт хөрөнгийн өгөөж (Return on Assets)


2017-2021 онд Үнэт цаас гаргагчийн нийт хөрөнгийн өгөөж дунджаар 0.1-0.3 хувийн түвшинд тогтвортой байна. Энэ нь Үнэт цаас гаргагч нь санхүүгийн үйлчилгээ үзүүлдэг байгууллага тул өндөр хөшүүрэгтэй үйл ажиллагаа явуулдагтай холбоотой. Нийт хөрөнгийн өгөөж гэхээсээ илүүтэйгээр өөрийн хөрөнгийн өгөөж чухал үзүүлэлт болно.

Зардал орлогын харьцаа (Cost to Income)

Зардал орлогын харьцаа нь үйл ажиллагааны зардлын түвшин үйл ажиллагааны орлоготой харьцуулахад ямар түвшинд байгааг илтгэдэг ашигт ажиллагааны үзүүлэлт юм. 2018 оноос хойш Үнэт цаас гаргагчийн ашигт ажиллагаа сайжирч, зардал орлогын харьцаа 36 хувьд хүрсэн.

Энэ нь банкны үйл ажиллагааны зардал нийт үйл ажиллагааны орлогын 36 хувьтай тэнцэх хэмжээнд байгааг харуулж байна. 2021 оны байдлаар тус харьцаа 41 хувьд хүрсэн нь цар тахлын нөхцөл байдлаас үүдэлтэйгээр банкны үйл ажиллагааны орлого буурсантай холбоотой.

График 42. Зардал орлогын харьцаа



Эх сурвалж: Үнэт цаас гаргагчийн тооцоолол

Зохистой харьцааны шалгуур үзүүлэлт

Монголбанкнаас банк санхүүгийн байгууллагын тогтвортой байдлыг хангах, харилцагчдын мөнгөн хөрөнгийг хамгаалах зорилгоор банкны өдөр тутмын үйл ажиллагаанд Basel-III олон улсын стандартын дагуу өндөр шаардлага тавьдаг.

Үүнд, банкны хөрвөх чадварын эрсдэлээс хамгаалах, капиталыг зохистой түвшинд байлгах зорилгоор өөрийн хөрөнгийн хүрэлцээ, нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгийн хүрэлцээ, гадаад валютын эрсдэлээс сэргийлэх зорилгоор нийт гадаад валютын позиц, нэгж гадаад валютын позицын хязгаарлалт, төлбөр төлөх



чадварын тогтвортой түвшинд хангах зорилгоор төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцааг тогтмол хянадаг.

Үнэт цаас гаргагч нь түүхэн хугацаанд тус шалгуур үзүүлэлтүүдийг тогтмол хангаж ирсэн. Энэ нь Үнэт цаас гаргагчийг санхүүгийн хувьд тогтвортой болохыг илтгэж байна.


Хүснэгт 25. Зохистой харьцаан үзүүлэлт

Зохистой харьцааны үзүүлэлтүүд	2017	2018	2019	2020	2021
ӨХ-н хүрэлцээ >12% (2019 оноос өмнө >14%)	14.4%	15.4%	14.9%	15.5%	15.4%
1-р зэрэглэлийн ӨХ хүрэлцээ >9% (нөөц: +1%)	9.5%	12.5%	10.1%	15.1%	15.0%
Гадаад валютын эрсдэлийн үзүүлэлтүүд:					
Нийт гадаад валютын позиц < +/-30% (2019:<+/-40%)	-15.3%	-5.5%	-12.7%	23.2%	12.6%
Нэгж гадаад валютын позиц < +/-15%	-11.1%	-2.0%	-0.8%	11.7%	10.0%
Том зээлдэгчийн харьцаа < 20%	16.8%	15.3%	15.0%	16.2%	13.3%
Холбоотой этгээдийн харьцаа < 5%	4.2%	3.8%	4.4%	4.0%	1.3%
Холбоотой этгээдийн харьцаа-Нийт < 20%	17.9%	16.6%	15.0%	13.2%	3.6%
Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцаа > 25%	44.5%	36.6%	32.7%	40.0%	41.1%

Эх сурвалж: Үнэт цаас гаргагчийн тооцоолол

График 43. Өөрийн хөрөнгийн хүрэлцээний харьцаа үзүүлэлт

Өөрийн хөрөнгийн хүрэлцээ



Эх сурвалж: Үнэт цаас гаргагчийн тооцоолол

Монголбанкнаас банкны өөрийн хөрөнгийн хэмжээ нь зээл болон бусад эрсдэл өндөр хөрөнгийн хэмжээтэй харьцуулахад эрсдэл даах хэмжээнд буюу 12 хувьд байхыг шаарддаг.

Үнэт цаас гаргагч нь үүсгэн байгуулагдсан цагаасаа тогтмол өөрийн хөрөнгийн зохистой хэмжээнд үйл ажиллагаа явуулсаар ирсэн. Тодруулбал, 2021 оны




байдлаар Үнэт цаас гаргагчийн өөрийн хөрөнгийн хүрэлцээний харьцаа 15.4 хувьд буюу зохистой харьцаанаас 3.4 нэгж хувиар өндөр байна.

Нөөц интервалын суурь хэсгийг 2022 оны 7-р сарын 1-ний өдрөөс 2 нэгж хувиар тогтоох буюу нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгийн хүрэлцээний шаардлага нь нөөц шаардлагыг оруулснаар 13 хувьд хүрч нэмэгдэнэ.

Төлбөр түргэн гүйцэтгэх чадвар

График 44. Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцаа үзүүлэлт




Эх сурвалж: Үнэт цаас гаргагчийн тооцоолол

Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцаа нь банк мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө буюу хөрвөх чадвар өндөртэй хөрөнгөөр богино хугацаат өр төлбөрийг төлж чадах эсэхийг харуулдаг.

Үнэт цаас гаргагч нь түүхэн хугацаанд шаардлагатай зохистой харьцааг тогтмол давуулан биелүүлж байсан нь төлбөрийн чадварын эрсдэл бага байгааг илэрхийлж байна. Тухайлбал, Монголбанкнаас уг харьцааг 25 хувьд байхыг шаарддаг бол 2021 оны байдлаар Үнэт цаас гаргагчийн төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцаа 41.1 хувь буюу 16.1 нэгж хувиар өндөр байна.

Нийт болон нэгж гадаад валютын позиц

График 45. Гадаад валютын позицын харьцаа үзүүлэлт




Эх сурвалж: Үнэт цаас гаргагчийн тооцоолол



Монголбанкнаас банкны нийт гадаад валютын позицыг нийт актив, пассивын 30 хүртэлх хувь, нэгж гадаад валютын позицыг 15 хувиас хэтрэхгүй байхыг шаарддаг бөгөөд энэ нь тухайн банкыг гадаад валютын ханшийн эрсдэлийг хянахад гол үзүүлэлт болдог. Үнэт цаас гаргагчийн нийт гадаад валютын позицын хэмжээ 2021 оны байдлаар 12.6 хувь, нэгж гадаад валютын позиц 10.0 хувьтай байгаа нь валютын эрсдэл бага байгааг илэрхийлж байна.

Зээлийн төвлөрөл

График 46. Зээлийн төвлөрлийн харьцаа үзүүлэлт



Эх сурвалж: Үнэт цаас гаргагчийн тооцоолол

Банкны зээлийн эрсдэлийг бага байлгах үүднээс Монголбанкны зүгээс зээлийн төвлөрлийн хэмжээнд хязгаарлалт тавин ажилладаг. Тухайлбал, нэг зээлдэгч түүнд холбогдох этгээдэд олгосон зээл нь нийт өөрийн хөрөнгийн 20 хувиас хэтэрч болохгүй. 2021 оны байдлаар Үнэт цаас гаргагч нь зээлийн төвлөрлийн зохистой харьцааны дагуу зээл олголтын үйл ажиллагааг явуулж байна.



ДӨРӨВ.

ҮНЭТ ЦААС
ГАРГАГЧИЙН
ЗАХ ЗЭЭЛИЙН
ТУХАЙ



4 ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ТУХАЙ

4.1 Монгол Улсын эдийн засгийн төлөв байдал

2020 онд Монгол Улсын эдийн засаг Ковид-19 цар тахлын нөлөөгөөр 1992 оны шилжилтийн үеэс хойших хамгийн том уналтыг үзүүлж, 4.6 хувиар агшин, эрэлт, нийлүүлэлт саарснаар экспорт 0.6 хувиар, импорт 14 хувиар буурсан. Харин гадаад худалдааны тэнцэл 2.3 тэрбум ам.доллар, төлбөрийн тэнцэл 722.3 сая ам.долларын ашигтай гарлаа.

2021 оны жилийн эцсийн байдлаар дэлхийн зах зээл дээрх түүхий эдийн ханш өссөн боловч Хятадын тэг ковид бодлоготой холбоотой экспортын гарц буурч, нэг дүгээр хагас жилд өмнөх оны мөн үетэй харьцуулахад 45 хувиар өсөөд байсан экспорт 22.5 хувь болж саарсан бол 33 хувийн өсөлттэй байсан импорт мөн оны эцсээр 29 хувь болжээ. Улмаар гадаад худалдааны тэнцэл 2,432.8 сая ам.доллар, төлбөрийн тэнцэл 221.6 сая ам.долларын алдагдалтай гарсан.

Монголбанкнаас цар тахлын үеийн эдийн засгийг дэмжих зорилгоор мөнгөний зөөлөн бодлогыг хэрэгжүүлснээр бодлогын хүү түүхэн доод төвшин буюу 6 хувьд, мөнгөний нийлүүлэлт 27.9 их наяд төгрөгт хүрэв. Энэ нь өмнөх оны мөн үеэс 13.8 хувиар нэмэгдсэн үзүүлэлт юм.

Монгол Улсын Засгийн газар иргэдийн эрүүл мэнд, орлогыг хамгаалахад чиглэсэн төсвийн тэлэх бодлогыг хэрэгжүүлснээр 2021 онд төсвийн алдагдал 3 их наяд төгрөгт хүрсэн.

2021 оны түүхий эдийн ханшны өсөлтийг бүрэн ашиглаж чадалгүй Хятад руу нийлүүлэх нүүрсний экспорт 45 хувиар буурсан нь уул уурхайн салбар 1.7 хувь, нийт эдийн засаг 1.4 хувь өсөхөд голлон нөлөөлөв. Ийнхүү Монгол Улсын импортын голлох бүтээгдэхүүний үнэ олон улсын зах зээлд өссөнөөр нийлүүлэлтийн инфляц бий болж, 2021 оны жилийн эцсээр инфляц 13.4 хувьд хүрэв.

Монгол Улсын Засгийн газар 2022 онд төлөгдөх Чингис бонд, 2023 онд төлөгдөх Гэрэгэ бондын нийт 1 тэрбум ам.долларын төлөлтийг дахин санхүүжүүлснээр дунд хугацаанд валютын гадагшлах урсгал буурч, богино хугацаанд төгрөгийн ам.доллартой харьцах ханшийн тогтвортой байдал хангагдах суурь тавигдсан.

Цаашид Монгол Улсын эдийн засгийн төлөв байдал дотоодод тархсан Ковид-19 цар тахлыг хяналтад оруулах хугацаа, хэрэгжүүлэх арга хэмжээнүүд болон саяхан үүсээд буй Орос-Украины нөхцөл байдлаас хамаарах бөгөөд олон улсын шинжээчид Монгол Улсын эдийн засгийг 2022 онд дунджаар 2 хувь, 2023 онд 6 хувиар өснө хэмээн таамаглаж байна.



Хүснэгт 26. Эдийн засгийн голлох үзүүлэлтүүд

Үзүүлэлт	Нэгж	2017	2018	2019	2020	2021
1. Бодит сектор						
ДНБ, оны үнээр	Тэр.төг.	24,546	26,447	27,928	26,655	27,034
ДНБ өсөлт	%	5.6	7.7	5.6	-4.6	1.4
Нэг хүнд ногдох ДНБ, оны үнээр	Сая төг.	7.9	8.4	8.8	8.3	8.2
Ажилгүйдлийн төвшин	%	7.3	6.6	8.1	7.6	8.1
2. Хүүгийн төвшин						
Бодлогын хүү	%	11.0	11.0	11.0	6.0	6.0
Инфляцын жилийн дундаж төвшин	%	6.4	8.1	5.2	2.3	13.4
Зээлийн хүү жилийн, ЖД	%	19.0	16.9	16.9	14.8	14.3
Хадгаламжийн хүү жилийн, ЖД	%	13.0	11.2	10.5	8.4	5.8
3. Төсвийн сектор						
Төсвийн тэнцэл	Тэр.төг.	-1,744	-1,605	-628	-5,481	-3,000
Төсвийн орлого	Тэр.төг.	7,275	9,226	10,802	9,422	12,689
Төсвийн зарлага	Тэр.төг.	9,019	10,831	11,429	14,903	15,689
4. Мөнгөний сектор						
Мөнгөний нийлүүлэлт	Тэр.төг.	15,861	19,475	21,064	24,481	27,863
Нийт хадгаламж	Тэр.төг.	9,616	12,188	13,375	17,244	18,374
Нийт харилцах	Тэр.төг.	3,872	5,323	5,431	5,190	7,311
Нийт зээлийн үлдэгдэл	Тэр.төг.	13,506	17,082	17,932	17,034	20,667
Хугацаа хэтэрсэн зээл	Тэр.төг.	819	843	816	1,265	932
Нийт чанаргүй зээл	Тэр.төг.	1,148	1,778	1,819	2,002	2,073
Чанаргүй зээлийн хувь	%	8.5	10.4	10.1	11.8	10.0
5. Гадаад сектор						
Экспортын хэмжээ	Сая ам.дол.	6,200	7,013	7,619	7,576	9,281
Импортын хэмжээ	Сая ам.дол.	4,337	5,875	6,128	5,294	6,849
Гадаад худалдааны тэнцэл	Сая ам.дол.	1,863	1,138	1,491	2,282	2,433
Төлбөрийн тэнцэл	Сая ам.дол.	1,460	-142	453	788	-222
Гадаад валютын албан нөөц	Сая ам.дол.	3,008	3,550	4,349	4,534	4,366
Гадаад өрийн хэмжээ	Сая ам.дол.	27,493	28,715	30,702	32,362	33,190
Төгрөгийн ам.доллартой харьцах ханш	Төг.	2,427	2,644	2,734	2,850	2,849

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо, Монголбанк



Бодит сектор

Дотоодын нийт бүтээгдэхүүн


Монгол Улсын эдийн засгийн өсөлт, бууралт нь экспортын голлох нэрийн бүтээгдэхүүний үнийн өөрчлөлт, гадаадын шууд хөрөнгө оруулалт, стратегийн ач холбогдолтой төсөл хөтөлбөрийн хэрэгжилтээс шууд хамаардаг.

Монгол Улс зах зээлийн эдийн засгийн тогтолцоонд шилжсэнээс хойших буюу 1991 оноос хойш нэг хүнд ногдох дотоодын нийт бүтээгдэхүүн бодитоор 3 дахин өссөн. Улмаар 2015 онд Монгол Улс дэлхийн банкны ангиллаар дунджаас бага орлоготой орнуудын эгнээнд шилжсэн юм.

Эдийн засгийн өсөлт хөгжлийг түүхэн хугацаагаар нь авч үзвэл үндсэн зургаан дэд хэсэгт хуваагддаг. Үүнд:

- 1990-1994 он буюу зах зээлийн шилжилтийн үе;
- 1995-2008 он буюу эдийн засгийн дахин сэргэлтийн үе;
- 2009 он буюу эдийн засгийн огцом хямралын үе;
- 2010-2012 он буюу уул уурхайн салбарын огцом өсөлтөөс хамаарсан хурдацтай боловч тогтворгүй өсөлтийн үе;
- 2013-2016 он буюу гадаад худалдааны нөхцөл, гадаадын шууд хөрөнгө оруулалтын гэнэтийн цочрол болон төсвийн бодлогын дутагдалтай байдлаас үүдсэн эдийн засгийн засгийн хүндрэлийн үе;
- 2017-2019 он буюу эдийн засгийн өсөлтийн сэргэлт ба тогтворжилтын үед хуваагддаг.

График 47. Нэрлэсэн ДНБ /их наяд төгрөг/, өсөлт



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо



2011 онд экспортын гол нэрийн бүтээгдэхүүн болох нүүрсний үнэ дэлхийн зах зээлд нэмэгдэхэд Монгол Улсын эдийн засаг түүхэн дээд төвшин болох 17.3 хувийн өсөлтийг үзүүлж байсан. Гэвч уул уурхайн экспорт аажмаар буурч, гадаад өрийн дарамт ихэссэнээр эдийн засаг уналтын мөчлөгт орсон юм.

2017 онд Монгол Улс нь Олон Улсын Валютын Сан (ОУВС)-ийн санхүүжилтийн хөтөлбөрийг хэрэгжүүлж, олон улсын зах зээлд зэс, нүүрсний үнэ өссөнөөр эдийн засаг аажмаар сэргэж эхэлсэн.

Гэвч 2020 онд Ковид-19 цар тахлын нөлөөгөөр эдийн засаг 4.6 хувиар агшсан нь 1992 оны шилжилтийн үеэс хойш тохиосон хамгийн том уналт болж байна.

2021 он гарсаар вакцинжуулалт эхэлж, дэлхийн эдийн засагт аажим сэргэлт ажиглагдсан боловч Монгол дахь хамгийн том ковидын давалгаа 2021 оны хоёр дугаар хагаст тохиолдож, мөн Хятад улс тэг ковид хэрэгжүүлснээр сэргэж байсан эдийн засаг эргэн унаж оны эцсээр өсөлт 1.4 хувь гарсан билээ. Үүний 1.7 хувийг уул уурхайн салбар, 0.32 хувийг боловсруулах үйлдвэр, 9.34 хувийг бөөний болон жижиглэн худалдааны салбарын өсөлт бүрдүүлж байна.

Монгол Улсын ДНБ нь уул уурхай, хөдөө аж ахуйн салбараас өндөр хамааралтай байдаг. 2021 оны байдлаар ДНБ-ний 24 хувийг уул уурхайн салбар, 13 хувийг ХАА-н салбар, 10 хувийг бөөний болон жижиглэн худалдааны салбар бүрдүүлсэн байна.

График 48. Нэрлэсэн ДНБ, Салбараар /их наяд төгрөг/



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

Монгол Улсын 2022-2023 оны эдийн засаг нь Ковид-19 цар тахлын нөхцөл байдал болон хариу арга хэмжээний үр дүн, БНХАУ-ын тэг ковид бодлогын хэрэгжилт, хилийн хориг арга хэмжээг дагасан уул уурхайн бүтээгдэхүүний экспорт, шинээр үүсээд буй геополитийг мөргөлдөөн зэргээс хамаарч өсөлттэй байх эсэх нь шалтгаална.



Дэлхийн банк, ОУВС, АХБ-ны шинжээчид Монгол Улсын эдийн засгийг 2021 онд дунджаар 4.8 хувь, 2022 онд 6.2 хувиар сэргэнэ гэж таамаглаж байна.

Хүснэгт 26. Бодит ДНБ-ний өсөлтийн төсөөлөл, хувиар

	2022Т	2023Т	2024Т	2025Т	2026Т
Дэлхийн банк	2.5%	5.8%	6.8%		
АХБ	2.3%	5.6%			
ОУВС	1.0%	6.0%	7.0%	6.0%	5.5%
Дундаж	1.9%	5.8%	6.9%	6.0%	5.0%

Эх сурвалж: Дэлхийн банк, АХБ, ОУВС

Инфляц

2011-2013 онд гадаадын шууд хөрөнгө оруулалтаас шалтгаалсан эдийн засгийн хурдацтай өсөлт, төсвийн тэлэлтийн үр дүнд инфляц 14 хувьд хүрсэн.

2012 оны сонгуулийн өмнө төсвийн тэлэлт нэмэгдсэн нь инфляцийг өдөөсөн бөгөөд эрэлтээс гадна нийлүүлэлтийн шинжтэй хүчин зүйлс хүчтэй нөлөөлсөн юм. Тус хугацаанд инфляцийг зорилтот төвшинд барихын тулд Монголбанк бодлогын хүүгийн хэрэгслээр дамжуулан инфляцийг удирдах арга хэмжээг авсан.

2016 онд эдийн засгийн хүндрэл, хэт их зээл олголтоос айл өрхүүдийн хэрэглээ багассан зэргээс шалтгаалан инфляц 1 хувь руу орсон нь бодлогын хүүг 4.5 хувиар огцом нэмэгдэхэд хүргэсэн. 2017-2019 онд Монголбанк эдийн засгийг сэргээх, тогтворжуулах бодлогыг хэрэгжүүлснээр инфляцын төвшинг зорилтод төвшин болох 8 хувиас бага хэмжээнд барьж чадсан.

График 49. Бодлогын хүү болон инфляц



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо



2020 онд цар тахлын нөхцөл байдлаас үүдсэн эдийн засгийн хүндрэл, тээврийн болон амралт, чөлөөт цаг, соёлын бараа, үйлчилгээ зэрэг эрэлтүүд буурсан зэрэг шалтгаанаас үүдэн инфляцын төвшин 2.6 хувьд хүрч буурсан.

2021 оны жилийн эцсийн байдлаар тээвэр ложистикийн хүндрэл, Орос-Украины мөргөлдөөнтэй холбоотой олон улсын зах зээл дэх нефтийн үнэ болон өргөн хэрэглээний бараа, хүнсний бүтээгдэхүүний үнэ өссөн зэргээс шалтгаалан Монгол Улсын хэмжээнд инфляцын төвшин 13.4 хувьд хүрсэн билээ.

Олон улсын байгууллагын эдийн засгийн шинжээчид 2022 оны эцэс гэхэд Монгол Улсад инфляцын төвшин 10 хувиас дээш хэвээр байна гэж таамаглаж байна. Бодлогын хүүний өсөлттэй холбоотой инфляцын өсөлт саарч эхэлсэн ч олон улсын нөхцөл байдал, шатахууны үнийн шок зэргийг харгалзан үзвэл инфляц тийм ч хурдан зорилтот төвшин хүртэл буурахгүй харагдаж байна.

Монголбанк, Дэлхийн банк, ОУВС, АХБ-ны шинжээчид инфляцын түвшнийг 2022 онд дунджаар 12.4 хувь, 2023 онд дунджаар 8.5 хувьд хүрнэ гэж таамаглаж байгаа нь инфляц богино хугацаандаа буурах магадлалтайг харуулж байна.

Хүснэгт 27. Инфляцын төсөөлөл, хувиар

	2022Т	2023Т	2024Т	2025Т	2026Т
Дэлхийн банк	10.5%	7.5%	6.8%		
АХБ	12.4%	9.3%			
Монголбанк	12.3%	6.5%	7.0%		
ОУВС	14.2%	10.5%	8.7%	7.7%	7.0%
Дундаж	12.4%	8.5%	7.5%	7.7%	7.0%


Эх сурвалж: Дэлхийн банк, АХБ, ОУВС

Хөдөлмөр эрхлэлт ба ажилгүйдэл

Сүүлийн 5 жилийн үзүүлэлтээс харвал Монгол Улсын нийт хөдөлмөрийн насны хүн амын дунджаар 60 гаруй хувийг ажиллах хүчин эзэлж байна. 2019-2020 онд хөдөлмөр эрхлэгчдийн тоо эрчимтэй буурснаар ажиллах хүчний тоо болон оролцооны төвшин буурсан.




График 50. Монгол Улсын ажиллах хүчний тоо /сая хүн/



■ Ажиллах хүч (сая хүн)
- - - - - ● - - - - - Өсөлтийн хувь

График 51. Ажиллах хүчний оролцооны төвшин %




Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

Монгол Улсын ажилгүйдлийн дундаж төвшин сүүлийн 5 жилийн дунджаар 7.5 хувьтай байна. Эдийн засгийн хямралаас үүдэлтэйгээр ажилгүйдлийн төвшин 2016 онд хамгийн өндөр буюу 8.6 хувьд хүрч байсан.


Засгийн газраас ажлын байраар дамжуулан иргэдийн амьжиргааг сайжруулах, эдийн засгийг сэргээх бодлогыг хэрэгжүүлснээр иргэдийг ажлын байранд зуучлах, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаар дамжуулан ажлын байрыг нэмэгдүүлэх, бизнесийн төсөл, хөтөлбөрийг эхлүүлэх зэрэг арга хэмжээг авсан.

График 52. Ажилгүйдлийн тэтгэмжийн хэмжээ /тэрбум төгрөг/



■ Ажилгүйдлийн тэтгэмж авсан хүний тоо (мянган хүн)
- - - - - ● - - - - - Ажилгүйдлийн тэтгэмжид олгосон мөнгөн дүн, (тэрбум төг.)

График 53. Хөдөлмөр эрхлэлт, ажилгүйдлийн төвшин



■ Хөдөлмөр эрхлэлтийн төвшин, %
- - - - - ● - - - - - Ажилгүйдлийн төвшин, %

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо



Улмаар ажилгүйдлийн төвшин 2018 онд 6.6 хувь болж, өмнөх оны мөн үеэс 0.7 нэгжээр буурсан юм. 2019 онд ажиллах хүчний тоо багасаж, ажилгүйдлийн төвшин өссөн бол 2020 онд цар тахлын нөхцөл байдал, эдийн засгийн уналтын улмаас ажил идэвхтэй хайж буй иргэдийн тоо багасаж, ажилгүйдлийн төвшин буурсан байна.

2020 онд ажилгүйдлийн тэтгэмжийн дүн өмнөх онтой харьцуулахад 15.4 хувиар өссөн нь цар тахлын нөхцөл байдлаас үүдэн татан буугдсан аж ахуйн нэгж болон ажлын байрны цомхтголоос шалтгаалсан ажилгүйдэл нэмэгдсэнийг харуулж байна.

Мөнгөний сектор

Бодлогын хүү

Монголбанк нь үнийн тогтвортой байдлыг хангах зорилгоор бодлогын хүүгээр дамжуулан мөнгөний бодлогыг хэрэгжүүлэх үүрэгтэй. 2016 оны эдийн засгийн хүндрэлийн үед төгрөгийн ханшийг хамгаалах, эдийн засгийн дунд хугацааны тогтвортой байдлыг хангах зорилгоор Монголбанк бодлогын хүүг 4.5 хувиар огцом нэмж, 15 хувьд хүргэсэн нь түүхэн дэх хамгийн өндөр бодлогын хүүний төвшин байсан.

Үүнээс хойш 2019 онд гарсан цар тахлын улмаас импортын хэрэглээ огцом буурч, иргэдийн орлого, зээл олголт багассанаас шалтгаалж инфляц дахин 1 хувьд хүрсэн тул Монголбанк эдийн засгийг дэмжих мөчлөг сөрсөн бодлогыг хэрэгжүүлж, бодлогын хүүг жилийн дотор 5 нэгжээр бууруулан 6 хувьд хүргэсэн нь түүхэн дэх хамгийн бага бодлогын хүүний төвшин байв.

График 54. Бодлогын хүү



Эх сурвалж: Монголбанк

Монгол Улсын Улсын Их Хурал (УИХ)-аас Зээлийн хүүг бууруулах үндэсний стратегийг 2020 оны 8-р сарын 28-ны өдөр баталсан. Тус стратеги нь санхүүгийн эх үүсвэр нэмэгдэх, хүү буурах суурь орчин бүрдэх, санхүүгийн зах зээлийн хөгжил, хууль эрх зүйн орчин, банкны эрсдэл даах чадвар, засаглал, үр ашигт байдлыг



сайжруулах, зээлдүүлэгчийн эрх баталгаажин, зээлийн гэрээнд заасан талуудын үүргийн гүйцэтгэл хангагдах суурь нөхцөлийг бүрдүүлсэн зэрэг ач холбогдолтой юм.

Мөнгөний нийлүүлэлт

Ковид-19 цар тахлын нөлөөгөөр дэлхийн улс орнууд мөнгөний зөөлөн бодлогыг хэрэгжүүлж, бодлогын хүүг бууруулан эдийн засгийг сэргээх шат дараалсан арга хэмжээнүүдийг авч байна.

Монгол Улсын Засгийн газраас эдийн засгийг сэргээх 10 их наяд төгрөгийн цогц төлөвлөгөөг батлан, тодорхой төслүүдэд бага хүүтэй зээл олгон, нийгмийн халамжид чиглэсэн үйл ажиллагаанд зарцуулснаар 2021 оны жилийн эцсийн мөнгөний нийлүүлэлт өмнөх оны мөн үетэй харьцуулахад 14 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

График 55. Мөнгөний секторын үзүүлэлт /их наяд төгрөг/



Эх сурвалж: Үндэсний Статистикийн Хороо

Эдийн засгийн тодорхой бус байдлаас үүдэн банкууд 2020 онд зээл олголтыг хумьсан ч эдийн засгийг дэмжих, эрэлтийг нэмэгдүүлэх бодлогын хүрээнд зах зээл дээрх мөнгөний нийлүүлэлт нэмэгдсэнээр 2021 онд хадгаламж өмнөх оны мөн үеэс 3.3 их наяд төгрөг буюу 14.5 хувиар, зээл олголт 3.6 их наяд төгрөг буюу 21.3 хувиар өсжээ.

Эрүүл мэндээ хамгаалж, эдийн засгаа сэргээх цогц хөтөлбөрийн хүрээнд 2021 оны 10-р сарын байдлаар нийт 1.9 их наяд төгрөгийг ажлын байрыг хадгалахад зориулж, 869 тэрбум төгрөгийг ипотекийн зээлд, 337 тэрбум төгрөгийг хөдөө аж ахуйн салбарыг дэмжихэд олгосон байна.



График 56. Хадгаламж болон зээлийн хэмжээ /их наяд төгрөг/



Эх сурвалж: Монголбанк

Валютын ханш

Гадаад валютын нөөц 2015 оноос хойш өсөхөд үнэт металлын худалдан авалт голлон нөлөөлжээ. Тодруулбал, сүүлийн 5 жилийн хугацаанд 100 тонны үнэт металл худалдан авсан нь гадаад валютын нөөцийг 3.7 тэрбум ам.доллараар өсгөхөд голлох нөлөө үзүүлсэн. Энэ нь 9 сарын импортын төлбөрийн хэрэгцээг хангахуйц хэмжээ юм. Мөн Ковид-19 цар тахлын нөлөөгөөр хил гааль хаалттай байж, импорт буурсан нь урсгал дансны алдагдлыг бууруулж, валютын гадагшлах урсгалыг сааруулсан байна. Ийнхүү 2020 онд гадаад валютын албан нөөц (ГВАН) 4.5 тэрбум, улмаар 2021 оны 4-р сард 4.9 тэрбум ам.доллар хүрсэн нь түүхэн дээд хэмжээнд хүрсэн үзүүлэлт болов. Гэвч 2021 оны хоёр дугаар хагас жилээс Хятадын тэг ковид бодлоготой холбоотой хилийн хориг, экспортын бууралт нь ГВАН-г бууруулахад хүргэж 2021 оны жилийн эцсийн байдлаар 4.3 тэрбум ам.долларт хүрлээ.

График 57. Гадаад валютын албан нөөц /сая ам.доллар/ төгрөгийн эсрэг ам.долларын албан ханш



Төгрөгийн эсрэг ам.долларын ханш 2020 он гарснаас хойш харьцангуй тогтворжсон нь цар тахалтай холбоотой импортын эрэлт буурч, төлбөрийн тэнцлийн алдагдал буурсан, нөгөөтэйгүүр 2021 оны эхний хагас жилд экспорт сайн хийж байсантай холбоотой гадаад валютын албан нөөц ихэссэн зэрэг шалтгаанууд нөлөөлсөн. 2021 оны хоёр дугаар хагаст экспорт буурч ГВАН буурч, импортын эрэлт өсөж эхэлсэн ч Монголбанкнаас зах зээлд валют хангалттай нийлүүлж байсан тул оны эцэс хүртэл ханш тогтвортой хадгалагдлаа.

Төсвийн сектор

Төсвийн тэнцэл

Монгол Улсын төсвийн орлогын дийлэнх хувийг татварын орлого, дийлэнх зарлагыг урсгал зарлага түүн дотор бараа үйлчилгээний зардал эзэлдэг. Монгол Улсын нийт төсвийн алдагдал 2016 онд 3.7 их наяд төгрөг буюу ДНБ-ний 15.3 хувьд, 2021 онд 3.0 их наяд төгрөг буюу ДНБ-ний 7 хувьд хүрсэн.

2020 онд Ковид-19 цар тахлын нөхцөл байдал хүндэрч, түүхий эдийн экспортын хэмжээ буурсан, эдийн засгийг сэргээх арга хэмжээ авсан, тэтгэвэр тэтгэмж нэмэгдсэн зэрэг нь төсвийн алдагдал өсөхөд голлох нөлөө үзүүлсэн.

2021 онд “Эрүүл мэндээ хамгаалж, эдийн засгаа сэргээх 10 их наядын цогц төлөвлөгөө” баталж төсвөөс эдийн засгийн дэмжих хөнгөлөлттэй зээл, иргэдийн орлогыг дэмжих халамж зэрэг сангийн тэлэх бодлого авч хэрэгжүүлсэн ба төсвийн алдагдал 15.7 их наяд төгрөгт хүрсэн байна.

График 58. Төсвийн тэнцэл /их наяд төгрөг/



Эх сурвалж: Монголбанк



Монгол Улсын урсгал тэнцлийн данс сүүлийн 11 жилийн турш алдагдалтай явж ирсэн бөгөөд гадаадын шууд хөрөнгө оруулалт болон гадаад өрөөр тус алдагдлыг санхүүжүүлж ирсэн юм.

2008-2011 онд урсгал дансны алдагдлыг гадаадын шууд хөрөнгө оруулалтаар нөхөж байсан бол 2012 оноос Чингис бонд, томоохон уул уурхайн салбарын мега төслийн хөрөнгө оруулалтаар нөхөж, 2013 оноос хойш арилжааны шинжтэй гадаад өр бондоор санхүүжүүлсэн.

График 59. Төлбөрийн тэнцэл /сая ам.доллар/



Эх сурвалж: Монголбанк

Засгийн газрын өр

Монгол Улсын нийт гадаад өрийн хэмжээ 2010 онд 7 тэрбум ам.доллар байсан бол 2021 онд 33 тэрбум ам.долларт хүрсэн. Тодруулбал, гадаад өрийн хэмжээ жилд дунджаар 16.8 хувиар өссөн. 2021 онд Засгийн газрын өр 8.4 тэрбум ам.долларт хүрснээр нийт гадаад өрийн 25.6 хувьтай, ДНБ-ний 56.2 хувьтай тэнцэж байна.

Гадаад өрийн хэмжээ огцом өсөх болсон шалтгаан нь дотоод дахь үйлдвэрлэлийн өсөлт нь өрийн өсөлтийг давахгүйд хүрсэн, зөв зохистой өрийн удирдлагын менежментийг хэрэгжүүлж чадаагүйд оршино.



График 60. Монгол Улсын гадаад өрийн хэмжээ /сая ам.доллар/



Эх сурвалж: Монголбанк

Монгол Улс 2020-2023 онд эргэн төлөгдөх бондыг бага зардалтай эх үүсвэрээр амжилттай дахин санхүүжүүлж байгаа ч гадаад өрийн хэмжээ буурахгүй хэвээр байна. 2020 онд эргэн төлөгдөх байсан Мазаалай бондын зарим хэсгийг Номад бондоор, 2022 онд эргэн төлөгдөх Чингис бондыг Сентури бондоор бага өртгөөр урт хугацаатайгаар дахин санхүүжүүлж чадсанаар тулгамдсан өрийн дарамтыг хойшлуулж, гадаад валютын нөөц, олон улс дахь зээлжих зэрэглэлийг тогтвортой барих, төлбөрийн чадварын эрсдэлээс сэргийлэхэд дэмжлэг болсон. Цаашид Засгийн газрын нийт өрийн нэрлэсэн ДНБ-нд эзлэх хувь 2022 онд 55.4 хувь, 2023 онд 50.1 хувьтай байхаар хүлээлттэй байна.

Хүснэгт 28. Монгол Улсын гадаад зах зээлд арилжаалагдаж буй Засгийн газрын бондууд

Үнэт цаасны нэр	Валют	Дүн	Огноо	Нэрлэсэн хүү	Хугацаа
Монгол 2022 (Чингис 10Ү)	Сая ам.доллар	1,000	2012.05	5.125%	10 жил
Монгол 2024 (Хуралдай)	Сая ам.доллар	600	2017.03	8.75%	7 жил
Монгол 2023 (Гэрэгэ)	Сая ам.доллар	800	2017.10	5.625%	5.5 жил
Монгол 2026 (Номад)	Сая ам.доллар	600	2020.10	5.125%	5.5 жил
Монгол 2027 (Century)	Сая ам.доллар	500	2021.07	3.5%	6 жил
Монгол 2031 (Century)	Сая ам.доллар	500	2021.07	4.45%	10 жил

Эх сурвалж: Монголбанк

Монгол Улс 1991 оноос хойш олон улсын санхүүгийн байгууллагуудад гишүүнээр элсэж, тэдгээрийн тусламж дэмжлэгийг тогтмол авч ирсэн. Анх 1991 оны 10-р сард ОУВС-ийн Стенд-бай хөтөлбөрийг хэрэгжүүлснээс хойш 6 удаагийн хөтөлбөрт хамрагдсан.



Хамгийн сүүлд 2017 оны 5-р сард 3 жилийн хугацаанд өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөрийг хэрэгжүүлж, олон улсын байгууллагууд болон хандивлагч орнуудаас нийт 5.5 тэрбум ам.долларын хөнгөлөлттэй санхүүжилтийг авч амжилттай дуусгасан байна.


Гадаад сектор

Гадаад худалдааны тэнцэл

Монгол Улсын эдийн засаг нь уул уурхайн бүтээгдэхүүний экспортын орлого, хөрш орнуудын эдийн засгийн нөхцөл байдлаас өндөр хамааралтай буюу гадаад хүчин зүйлийн нөлөөлөлд мэдрэг шинж чанартай.

Монгол Улсын гадаад худалдааны тэнцэл 2014 оноос хойш ашигтай гарсан бөгөөд сүүлийн 3 жилд дунджаар нийт экспортын 85 хувийг, нийт импортын 35 хувийг БНХАУ дангаар эзэлж байна.

График 61. Гадаад худалдааны тэнцэл /тэрбум төгрөг/



Эх сурвалж: Үндэсний Статистикийн Хороо

2020 онд гадаад худалдааны нийт бараа эргэлт 12.9 тэрбум ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 6 хувиар буурсан. Тухайлбал, экспорт 0.6 хувиар буюу 43 сая ам.доллараар, импорт 14 хувиар буюу 834 сая ам.доллараар буурсан. Эдийн засгийн гадаад худалдааны идэвхжилт буурснаар 2020 онд гадаад худалдааны тэнцэл 2.3 тэрбум ам.доллар, төлбөрийн тэнцэл 722.3 сая ам.долларын ашигтай гарсан юм.

2021 оны жилийн эцсийн байдлаар гадаад худалдааны тэнцэл 2.4 тэрбум долларын ашигтай гарсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 6.6 хувиар өссөн үзүүлэлт юм.



Хэдий БНХАУ-н тэг ковид бодлоготой холбоотой гол түүхий эдийн экспортын тоо хэмжээний өсөлт оны эцсээр уналттай гарсан ч олон улсын зах зээл дэх уул уурхайн түүхий эдийн үнэ өссөн нь ийнхүү ашигтай гарахад голчлон нөлөөлсөн.


Импорт

Цар тахалтай холбоотойгоор 2020 онд иргэд аж ахуйн нэгжийн үйл ажиллагаа доголдож, худалдаа үйлчилгээний салбарууд зогсож, боомтууд дээр ачаа тээвэр гацах зэргээс үүдэн импорт 2019 онтой харьцуулахад 13.6 хувиар буурсан үзүүлэлттэй байв.

Үүнд Орос болон Саудын Арабын хооронд үүссэн үнийн дайнтай холбоотойгоор газрын тос, шатахууны үнэ 2020 оны 1 дүгээр улиралд 65 хувиар буурсан нь түлхэц үзүүлсэн байна.

Гэвч шатахууны үнийн бууралт нь удаан үргэлжлээгүй ба үнийн дайн болсноос нэг жилийн дараа буюу 2021 онд үнэ буцаад дайны өмнөх төвшиндөө хүрсэн юм. Ийнхүү дэлхийн тээвэр ложистикийн хямрал, түүхий эдийн үнийн өсөлттэй холбоотой импортын бараа бүтээгдэхүүний үнэ 2021 онд өссөн импорт өмнөх оны мөн үеэс 29.3%-н өсөлттэй гарахад нөлөөлжээ. Өөрөөр бол эдийн засгийн эрэлт тиймч хүчтэй өсөөгүй боловч үнийн өсөлттэй холбоотой импорт ийнхүү өсчээ.

График 62. Импорт, хэрэглээний зориулалтаар



Эх сурвалж: Монголбанк

Монгол Улсын импортын 17 хувийг нефтийн бүтээгдэхүүн, 40 хувийг хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүн буюу барилгын материал болон уул уурхайн тоног төхөөрөмж, 11 хувийг аж үйлдвэрлэлийн орц, 32 хувийг түргэн болон удаан эдэлгээт бараа бүтээгдэхүүний импорт тус тус эзэлж байна.



Экспорт

Сүүлийн 7 жилийн дунджаар нийт экспортын 89 хувийг түүхий эдийн экспорт бүрдүүлж байгаагаас 75 хувийг зэс, нүүрс, төмрийн экспорт бүрдүүлж байна.

2020 онд дэлхийн эдийн засагт тодорхойгүй нөхцөл байдал үүсэж, улс орнууд эдийн засгийг сэргээх мөнгөний зөөлөн бодлогыг хэрэгжүүлсний үр дүнд ам.долларын өгөөж буурч, хөрөнгө оруулагчдыг алт худалдан авахад хүргэсэн. Тодруулбал, 2020 онд алтны үнэ 18.3 хувиар өссөн нь Монгол Улсын нийт экспортыг өндөр бууралт үзүүлэхээс сэргийлсэн юм.

Дэлхийн томоохон зэс экспортлогч орнууд болох Чили болон Перу улсад цар тахалтай холбоотойгоор нийлүүлэлт буурсан нь зэсийн үнийг тогтвортой хадгалагдахад дэм болж Монгол Улсын экспортод эерэгээр нөлөөлжээ.

Хүснэгт 29. Гол түүхий эдийн экспортолсон хэмжээ

Гол түүхий эд	Нэгж	2016	2017	2018	2019	2020	2021
Зэсийн баяжмал	мян.тонн	1,562	1,447	1,437	1,404	1,396	1,283
Нүүрс	мян.тонн	25,714	33,990	35,758	36,467	28,587	15,708
Алт	тонн	19.2	14.6	3.4	9.1	30.5	17.2

Эх сурвалж: Монголбанк

2020 оны цар тахалтай холбоотой дэлхийн улс орнууд хилээ хааж, агаарын тээвэр зогсож дэлхийн худалдааны хурд саарсан. Бараа материалыг зөөвөрлөх нь хүндрэлтэй болсон тул улс орнуудад түүхий эдийн нийлүүлэлт огцом буурсан. Гэвч энэ үед мөн түүхий эдийн эрэлт хөл хориотой холбоотой өндөр биш байв. Харин 2021 гарснаар дэлхийн эдийн засаг сэргэх хандлагатай болж бизнесүүд үйл ажиллагаагаа бага багаар нээхийн хирээр түүхий эдийн эрэлт сэргэж эхэлсэн. Гэвч энэ үед тээвэр ложистикийн хорио үргэлжилсэн хэвээр байсан нь нийлүүлэлгийн өсгөөгүй тул гол аж үйлдвэрийн түүхий эдийн үнүүд огцом өссөн. Олон улсын зах зээл дэх нүүрсний үнэ 2020 онд цар тахлын нөлөө, БНХАУ-ын эдийн засгийн бууралтаас үүдэн 24.6 хувиар унасан бол 2021 онд өмнөх оны эцэстэй харьцуулахад 130.7 хувиар өссөн байна.



График 63. Нүүрсний дундаж үнэ, ам.доллар/тонн





График 64. Зэсийн үнэ, ам.доллар/тонн



Эх сурвалж: ОУВС

Хэдий 2021 онд өмнөх оны мөн үетэй харьцуулахад Монгол Улсын нүүрсний экспорт тоо хэмжээгээрээ 45 хувиар буурсан боловч энэхүү түүхий эдийн үнийн өсөлт нь экспорт үнийн дүнгээрээ 30 хувиар өсөхөд гол нөлөө үзүүлжээ.

Дэлхийн тээвэр ложистикийн хямрал болон сэргээгдэх эрчим хүч, цахилгаан авто машины эрэлт өссөн зэрэг нь зэсийн үнэ 2021 онд 50.9 хувиар өсөхөд нөлөөлсөн ба Монгол Улсын зэсийн экспортыг 63 хувиар өсөхөд нөлөөлжээ.

Дэлхийн эдийн засаг, хөрөнгийн зах зээлийн нөхцөл байдлаас шалтгаалан алт нь хамгийн эрсдэл багатай хөрөнгө оруулалт болж эрэлт өссөн тулд алтны үнэ 2020 онд 27 хувь, 2021 оны байдлаар 1.7 хувиар өссөн байна.

Монгол Улсын хувьд сувд, үнэт ба хагас үнэт чулуу, үнэт металл, гоёлын зүйлс, зоос хэсэгт багтах барааны экспортын дийлэнхийг алтны экспорт эзэлдэг. 2020 онд экспортолсон алтны хэмжээ өмнөх онтой харьцуулахад 1,370 сая ам.доллараар нэмэгдсэн бол гадаад валютын албан нөөцөө бүрдүүлэх зорилгоор 2021 онд алт харьцангуй бага экспортлосон ба өмнөх оноос экспортын хэмжээ 783 сая ам.доллараар буурсан байна.

Зээлжих зэрэглэл

Монгол Улсын Сангийн Яам болон Монголбанкны зүгээс Монгол Улсын зээлжих зэрэглэлийг 1999 оноос хойш олон улсад нэр хүндтэй, бие даасан зээлжих зэрэглэл тогтоогч Стандарт энд Пүүрс (Эс энд Пи), Фитч рейтингс (Фитч) болон Мүүдис Инвесторс Сервис (Мүүдис) агентлагуудаар тогтоолгож эхэлсэн.

Эс энд Пи агентлаг нь 2007-2013 онд Монгол Улсын зээлжих зэрэглэлийг түүхэн дэх хамгийн өндөр буюу "BB-" төвшинд үнэлж байсан бол 2016-2017 онд Мүүдис агентлаг түүхэн дэх хамгийн муу буюу "Саа1" төвшинд үнэлж байв.



2021 оны 5-р сарын 25-нд Fitch агентлаг Монгол Улсын зээлжих зэрэглэлийг В, төлөвийг тогтвортой хэвээр үлдээсэн талаар мэдээлсэн. Фитч агентлагаас Монгол Улс нь түүхий эдээс өндөр хамааралтай орны хувьд Ковид-19 тахлын нөлөөгөөр ДНБ болон экспортын өсөлт огцом саарч, төсвийн санхүүжилт тасалдан, гадаад нөөц муудсан ч гадаадын хөрөнгө оруулагч донор байгууллагаас ирэх санхүүжилтийн урсгал нэмэгдэх хүлээлттэй байгааг харгалзаж үзэн үнэлгээг В хэвээр үлдээсэн талаар онцолсон юм.

2021 оны 3-р сарын 16-нд Moody's агентлаг Монгол Улсын зээлжих зэрэглэлийг В3 хэвээр хадгалж, төлөвийг тогтвортой болгож ахиулсан. Энэ нь (i) Монгол Улсаас 2020 онд авч хэрэгжүүлсэн арга хэмжээг улсын төсвөөс гадна донор байгууллагын эх үүсвэрээр хамтран санхүүжүүлснээр дахин зээл авах хэрэгцээ буурсан, (ii) 2020 оны 9-р сард авч хэрэгжүүлсэн гадаад өрийн дахин санхүүжилтийн арга хэмжээ нь 2021 онд төлөгдөх гадаад өрийн дарамтыг бууруулсан, (iii) төсвийн гүйцэтгэл сайжирсан нь дахин зээл авах эрэлт хэрэгцээг багасгахад дэмжлэг болсон зэрэг шалтгаанаас үүдэлтэй. Мөн БНХАУ-ын эдийн засаг сэргэснээр Монгол Улсын уул уурхайн салбарын экспортын орлого сэргэнэ гэж үзсэн байна.

2021 оны 7-р сарын 29-нд S&P агентлаг Монгол Улсын зээлжих зэрэглэлийг В хэвээр үлдээж, хэтийн төлөвийг тогтвортой гэж үзсэн. Монголын түүхий эдэд суурилсан эдийн засаг нь Ковид-19 цар тахлын улмаас саарч байгаа ч хэтийн төлөвийг тогтвортой үлдээсэн нь цар тахлаас үүдэлтэй эдийн засгийн цочрол түр зуур үргэлжилж, өсөлт ирэх 12 сарын хугацаанд бий болно гэж үзсэнтэй холбоотой.

Үүнээс үзэхэд олон улсын зээлжих зэрэглэлийг тогтоогч томоохон агентлагууд цар тахлын улмаас дэлхийн улс орнуудыг эдийн засаг уналттай байгаа ч Монгол Улсын зээлжих зэрэглэлийг хэвээр үлдээж, төлөвийг ахиулсан нийтлэг шинжтэй байгаа нь Монгол Улсын эдийн засгийн талаар эерэг хүлээлттэй байгаагийн дохио юм.

Эдийн засгийн хэтийн төлөв

2020 оны цар тахал, 2021 оны БНХАУ-н тэг ковид бодлого нь Монгол Улсын эдийн засгийн өсөлтийг сааруулж эдийн засагт тодорхой бус байдлыг бий болгосон билээ. Тэгвэл 2022 онд Орос-Украины хооронд үүссэн нөхцөл байдал Монгол Улсаас гадна дэлхийн олон улсад шатахуун, эрчим хүч болон хүнсий хомсдол бий болгож байгаа нь тодорхой бус байдлыг нэмэгдүүлж, эдийн засгийн өсөлтийг улам удаашруулж байна. Тиймээс 2022 он болон цаашдын эдийн засгийн нөхцөл байдал эдгээр гадаад хүчин зүйлс хэрхэн өрнөхөөс ихээхэн шалтгаалах төлөвтэй байна.

2021 оны байдлаар Монгол улсын нийт импортын 29% нь ОХУ-с хамааралтай байна. Энэхүү импортын гол хэсэг нь шатахуун юм. Монгол Улс нь нийт шатахууны хэрэглээнийхээ 95 орчим хувийг ОХУ-с олон улсын зах зээлийн ханшаар худалдан авалт хийдэг тул дэлхийн түүхий нефтийн үнэ өсөхөд нэг сарын дараа Монгол Улсын



худалдан авах шатахууны үнэ мөн өсдөг билээ. Орос нь дэлхийн нийт нефтийн үйлдвэрлэлийн 12 хувь, нийт байгалийн хийн үйлдвэрлэлийн 16.6 хувийг эзэлдэг тул энэхүү үүсээд буй Орос Украины мөргөлдөөн нь дэлхийн түүхий эдийн үнэ, тэр дундаа нефть, байгалийн хий, үр тарианы үнийг нилээдгүй өсгөөд байна. Энэхүү өсөлт нь Монгол улсад шатахууны зардал өсөх, дагаад тээврийн зардал, инфляц өндөр хадгалагдах суурь нөхцөлийг бий болгож байна. Шатахуунаас гадна уул уурхай болон газар тариалалтад ашигладаг гол түүхий эд болох азот, мөн улаан буудай, ургамлын тос, өндөг, цахилгаан зэрэг олон нэр төрлийн бүтээгдэхүүнийг ОХУ-с импортлон авдаг. ОХУ үүсээд буй нөхцөл байдалтай холбоотой стратегийн гол бүтээгдэхүүнүүдийг экспортлохыг хориглосон, мөн ОХУ-н 10 гаруй банкуудыг олон улсын SWIFT төлбөрийн системээс хассан зэрэг үйл явдлууд нь эдгээр бараа бүтээгдэхүүний импортод сөргөөр нөлөөлж, үнэ өсөх нөхцөл байдлыг бий болгож байна.

Орос Украины мөргөлдөөний нөхцөл байдлыг дэлхий нийт цаг алдалгүй анхааралтай ажиглаж байгаа ба хэзээ дуусах нь анхаарлын төвд байна. Олон улсын хэвлэл мэдээлэл, эдийн засагчдын таамаглаж байгаагаар дайн нь 2022 онд дуусахгүй, үргэлжлэх хандлагатай байгааг хэлж байна. Ингэснээр шатахуун болон бусад бараа бүтээгдэхүүний үнэ 2022 онд буурах хүлээлт ажиглагдахгүй байна.

Шатахуун болон хүнсний бүтээгдэхүүний үнийн өсөлттэй холбоотой инфляц Монголбанкны зорилтот төвшингөөс өндөр, он дуустал хоёр оронтой тоон дээр хадгалагдах хүлээлттэй байгаа тул Монголбанк дунд хугацаанд инфляцыг бууруулахын тулд бодлогын хүүг өсгөнө. Бодлогын хүү нь эрэлтийн гаралтай инфляцыг удирдах хэрэгсэл тул бодлогын хүүний өсөлт нь богино хугацаанд буюу 2022 онд инфляцыг зорилтод төвшин хүртэл буулгаж чадахгүй ба 2023 оноос хойш гадаад хүчин зүйлээс хамааралтай нийлүүлэлтийн гаралтай инфляц буурсны дараа зорилтот төвшинд хүрэх хүлээлттэй байна.

Нөгөө талаас Хятадын тэг ковид бодлого 2022 он дуустал үргэлжлэх хандлагатай байна. Учир нь 2022 оны эцсээр Хятадын коммунист намын ардын 20-р их хурал болох ба энэхүү хуралдаанаар Хятадын ирэх 5 жилийн макро эдийн засгийн бодлогын чиглэлийг тодорхойлно. Уг чиглэлийн дагуу тэг ковид бодлогыг зогсоох үгүй шийдвэр гарах хандлагатай байгаа тул тэг ковид бодлого он дуустал үргэлжлэх хүлээлттэй байна. Гэсэн хэдий ч Хятадад нүүрсний эрэлт өндөр байгаатай холбоотой Гашуунсухайт, Шивээхүрэн боомтуудаар тээвэрлэх нүүрсний гарц ирэх саруудад нэмэгдэх хандлагатай байгаа тул Монгол Улсын нүүрсний экспорт 2022 оны хоёр дугаар хагас жилээс сайжрахаар харагдаж байна.

Ийнхүү 2022 онд Хятадын тэг ковид бодлого, Орос-Украины нөхцөл байдал үргэлжлэх хандлагатай, мөн Монголбанкнаас бодлогын хүүг өсгөж, энэ нь эдийн засгийн өсөлтийг сааруулах нөлөөтэй тул 2022 онд Монгол Улсын бодит эдийн засгийн өсөлт 2 хувь байх хүлээлттэй байна. Харин 2023 оноос хилийн нөхцөл



байдал сайжирч, Орос-Украины нөхцөл байдал шийдэгдвэл эдийн засаг сэргэх боломжтой юм. Учир нь Монгол Улсад хэрэгжиж буй томоохон мега төслүүд 2022-2023 онуудад дуусахаар төлөвлөгөөтэй байна. Тухайлбал, Тавантолгой төмөр зам 2022 оны 7-р сард ашиглалтанд орох төлөвлөгөөтэй байгаа бол Оюутолгой далд уурхайн бүтээн байгуулалт бүрэн хүчин чадлаараа 2023 оны нэг дүгээр хагас жилд орохоор хүлээгдэж байна. Эдгээр төслүүд нь хэрэгжснээр Монгол улсын экспортын орлого нэмэглэх ба энэ нь эдийн засгийн өсөлтөд сайн нөлөөтэй юм.

2022 онд Монгол Улсын бодит эдийн засгийн өсөлтийн төсөөллийг ОУВС 1 хувь, Дэлхийн банк 2.5 хувь, АХБ 2.3 хувь буюу дунджаар 1.9 хувиар таамаглаж байгаа бол 2023 оны өсөлтийн төсөөллийг ОУВС 6 хувь, Дэлхийн банк 5.8 хувь, АХБ 5.6 хувь, дунджаар 5.8 хувиар тус тус таамаглаж байна.

Хүснэгт 301. Макро эдийн засгийн таамаглал

Үзүүлэлт	Нэгж	2021	2022Т	2023Т
ДНБ өсөлт	%	1.4	2.1	6.1
Бодлогын хүү	%	6.0	12.0	10.0
Жилийн инфляц /оны эцэс/	%	13.4	11.3	6.1

Эх сурвалж: Үнэт цаас гаргагчийн тооцоолол

4.2 Монгол Улсын хөрөнгийн зах зээлийн төлөв байдал

Өнөөгийн нөхцөл байдал

Монгол Улс нь 1990 онд зах зээлийн эдийн засгийн тогтолцоонд шилжсэн он жилүүд буюу 1991 оны 1-р сарын 18-ны өдөр Монголын Хөрөнгийн Бирж (МХБ)-ийг үүсгэн байгуулснаар хөрөнгийн зах зээл хөгжих суурийг тавьсан. Тус хугацаанд 8.2 тэрбум төгрөгийн үнийн дүн бүхий 475 компанийн 96.1 сая ширхэг хувьцааг 1.3 сая иргэдэд цэнхэр, ягаан тасалбараар тарааж анхны өмч хувьчлалыг хийсэн түүхтэй.

2021 оны эцсийн байдлаар МХБ-д албан ёсоор идэвхтэй үйл ажиллагаа явуулдаг 54 гишүүн үнэт цаасны компани, 179 хувьцаат компани бүртгэлтэй байна.

Хүснэгт 31. Хөрөнгийн зах зээлийн голлох үзүүлэлтүүд

Үзүүлэлт	Нэгж	2017	2018	2019	2020	2021
Зах зээлийн үнэлгээ	Их наяд төг	2.43	2.5	2.7	3.0	5.97
ҮЦК-иудын нийт хөрөнгө	Тэр.төг	92.8	81.2	86.2	86.6	114.4
Арилжааны тоо ширхэг	Сая ширхэг	114.3	667.2	450.4	403.0	818.5
Арилжааны дүн	Тэр.төг	859.2	244.1	143.2	65.3	1414.2
Хувьцаа	Тэр.төг	76.4	210.0	133.5	53.9	304.9



Бонд	Тэр.төг	782.7	34.1	9.7	6.4	1052.4
Хамтын сан	Тэр.төг	-	-	-	5.1	56.8

Эх сурвалж: Монголын Хөрөнгийн Бирж

Өнгөрсөн он жилүүдэд Монгол Улсын санхүүгийн зах зээл нь банк төвтэй, хөгжлийн ганц тулгууртай байсан. Тодруулбал, 2020 оны байдлаар банкны салбар санхүүгийн салбарын нийт хөрөнгийн 86.6 хувийг бүрдүүлж байсан.

2021 оны жил эцсийн байдлаар банкны хөрөнгийн хэмжээ өмнөх оны эцэстэй харьцуулахад 4.3 их наяд төгрөгөөр өссөн ч банкны салбарын санхүүгийн салбарт эзлэх хувь 81.3 болж буурсан. Нөгөө талаас хөрөнгийн зах зээлийн санхүүгийн салбарт эзлэх хувь 11.8 хувьд хүрч, өмнөх оноос 4.63 хувиар өссөн нь хөрөнгийн зах зээл идэвхжиж байгааг илэрхийлж байна.

Уул уурхайн салбарын өсөлт, эдийн засгийн идэвхжил болон гадаадын шууд хөрөнгө оруулалтын нөлөөгөөр 2011 онд Монголын хөрөнгийн зах зээл ДНБ-ий 16.5 хувьтай тэнцэж байсан ч тасралтгүй буурсан юм. 2017 онд хөрөнгийн зах зээлд шинэ бүтээгдэхүүнүүд гарч, хөрөнгө оруулагчдын эрэлт нэмэгдсэнээр хөрөнгийн зах зээл эргэн идэвхэжсэн.


2017 оноос хойш Монголын хөрөнгийн зах зээл дээр олон нийтэд хувьцаагаа санал болгож бүртгүүлэх компанийн тоо эрс нэмэгдэж, нийт 13 компани болон хамтын хөрөнгө оруулалтын сан 130.2 тэрбум төгрөгийг хөрөнгийн зах зээлд татан төвлөрүүлсэн. Үүнээс 79 хувийг санхүүгийн салбарын компаниуд бүрдүүлж байна.

2020 оны байдлаар Монгол Улсын хөрөнгийн зах зээлийн үнэлгээ ДНБ-ий 8.2 хувь буюу 3.0 их наяд төгрөгөөр хэмжигдэж байсан бол 2021 оны байдлаар 5.97 их наяд төгрөгт хүрч, 2020 оны ДНБ-тэй харьцуулахад 13.9 хувийг бүрдүүлж байна.

Энэ нь өмнөх оны эцэстэй харьцуулахад 97.5 хувиар өссөн үзүүлэлт юм. Хөрөнгийн зах зээлийн үнэлгээний 50 хувийг бүрдүүлэгч томоохон хувьцаат компаниудын үнэлгээ 2021 оны байдлаар өмнөх оны мөн үетэй харьцуулахад 5 хүртэлх дахин өссөн нь голлох нөлөө үзүүлсэн байна.



График 65. Хөрөнгийн зах зээлийн үнэлгээ ДНБ-нд эзлэх хувь, хэмжээ




Эх сурвалж: ҮСХ, МХБ

2021 оны эцсийн байдлаар МХБ-д арилжаалагддаг хөрвөх чадвар болон зах зээлийн үнэлгээгээр тэргүүлэгч 20 хувьцааны хөдөлгөөнийг харуулдаг ТОП-20 индекс өмнөх оны эцэстэй харьцуулахад 130 хувиар өссөн.

Түүнчлэн хувьцааны бүртгэлийн II дугаар ангиллын хувьцаануудыг илэрхийлдэг MSE-B индекс 61 хувь, хувьцааны бүртгэлийн I дүгээр ангиллын хувьцаануудыг илэрхийлдэг MSE-A индекс 69 хувийн өсөлтийг тус тус үзүүлсэн.

График 66. МХБ-ийн индексүүд, оны эхэн үетэй харьцуулахад (оны эхнээс)



Эх сурвалж: МХБ

TOP-20 индексийг бүрдүүлж буй 20 хувьцаат компани нь нийт хөрөнгийн зах зээлийн 73.1 хувийг бүрдүүлж буй нь зах зээлд эзлэх төвлөрөл өндөр байгааг илтгэж байна.



2021 оны байдлаар TOP-20 хувьцааны 18.5 хувь буюу 806.4 тэрбум төгрөгийг санхүүгийн үйл ажиллагаа явуулж буй 8 компанийн үнэлгээ бүрдүүлж байгаа нь санхүүгийн салбарын компаниуд хөрөнгийн зах зээлд амжилттай байгааг илтгэж байна.

2021 онд хөрөнгийн зах зээлийн арилжаа идэвхжиж, 4-р сард арилжааны хэмжээ түүхэн дээд хэмжээ болох 34 тэрбум төгрөгт хүрсэн нь өмнөх оны мөн үеэс 14 дахин өссөн үзүүлэлт юм.

2021 оны 2 дугаар улирлаас эхлэн арилжаа буурч 2021 оны 6-р сарын байдлаар хувьцааны хоёрдогч зах зээлийн өдрийн дундаж арилжаа 357 сая төгрөгт хүрсэн.

График 67. Хөрөнгө оруулалтын хэрэгслүүд арилжааны дүнгээр






График 68. Өдрийн дундаж арилжаа /сая төгрөг/



Эх сурвалж: МХБ

2020 онд өдрийн дундаж арилжаа 263 орчим сая төгрөг байсан бол 2021 он гарснаас хойш арилжааны идэвх өмнөх оноос 22 дахин нэмэгдсэн байна. Тодруулбал, хувьцааны арилжаа 2020 онд 53.9 тэрбум төгрөгт хүрсэн нь ДНБ-ний 0.15 хувьтай тэнцэж байв. 2021 оны эцсийн байдлаар нийт 1414.19 тэрбум төгрөгийн арилжаа явагдсанаас компанийн бонд 74 хувийг, хувьцаа 22 хувийг бүрдүүлж, ДНБ-ний 0.7 хувийг бүрдүүлж байна.

График 69. Хувьцааны арилжааны ДНБ-нд эзлэх хувь, хэмжээ



Хөрөнгийн зах зээлийн хэтийн төлөв

Монгол Улсын хөрөнгийн зах зээл хөгжлийн эхэн үе шатанд явж байна. Дэлхийн банкнаас гаргасан ангиллын дагуу Монгол Улсын хөрөнгийн зах зээлийг дунджаас бага орлоготой орнуудын үзүүлэлттэй харьцуулахад frontier market буюу хөгжиж эхэлж буй ангилалд багтаж буй орнуудтай ижил түвшинд байна.

График 70. ДНБ-д харьцуулсан хөрөнгийн зах зээлийн үнэлгээ /олон улс/




График 71. ДНБ-д харьцуулсан хөрөнгийн зах зээлийн арилжаа



Эх сурвалж: Дэлхийн банк

Хөрөнгийн зах зээлийн хөгжлийн ангиллаар emerging буюу хөгжиж буй зах зээлд багтдаг Энэтхэгийн хувьд хөрөнгийн зах зээлийн үнэлгээ ДНБ-тэй нь тэнцүү байхад Монгол Улсын хувьд ДНБ-ний 13 хувийг бүрдүүлж байна. Арилжааны хэмжээ буюу хөрвөх чадвар нь Энэтхэгийн ДНБ-ний 74 хувьтай тэнцүү байхад Монголд 1 хүрэхгүй хувьтай байна.

Шри-Ланка, Нигери зэрэг хөрөнгийн зах зээлийн хөгжлөөр frontier буюу зах зээл нь дөнгөж хөгжиж буй орнуудын үзүүлэлт Монгол Улстай ойролцоо түвшинд байна. Энэ нь Монголын хөрөнгийн зах зээл цаашид хөгжих зах зээлийн бүрэн боломж байгааг илтгэж байна.

Монгол улсын хөрөнгийн зах зээл эрэлт нэмэгдэхэд Ковид-19 цар тахлын нөлөөгөөр мөнгөний зөөлөн бодлого хэрэгжиж, Монголбанк бодлогын хүүг шат дараатайгаар бууруулж, түүхэн доод хэмжээ болох 6 хувьд хүргэсэн, нийлүүлэлтийн шинж чанартай инфляц бий болсон зэргээс үүдэн хадгаламжийн бодит өгөөж буурсан нь ихээхэн нөлөө үзүүлсэн.



Банкны салбарын IPO

2021 оны 1-р сарын 29-нд УИХ-аас Банкны тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулснаар системийн нөлөө бүхий 5 банк 2022 оны 6-р сарын 30-ны дотор нээлттэй хувьцаат компани болж, нийтэд хувьцааг санал болгох (IPO) үүрэг хүлээсэн. Түүнчлэн 2023 оны 12-р сарын 31-ний дотор тус банкуудын нэг хувьцаа эзэмшигчид ногдох эзэмшлийн хувь 20 хувиас ихгүй байхаар хуульчилсан юм.

2021 оны жил эцсийн байдлаар банкны салбарын нийт хөрөнгө 40.9 их наяд төгрөг, өөрийн хөрөнгө 4.0 их наяд төгрөг байна. Нийт хөрөнгийн 93.4 хувийг системийн нөлөө бүхий 5 банк бүрдүүлж байна.

Системийн нөлөө бүхий 5 банк IPO хийснээр хөрөнгийн зах зээлд шинэ бүтээгдэхүүн бий болох, институциональ хөрөнгө оруулагчид нэмэгдэх, улмаар хөрөнгийн зах зээлийн эрэлт нэмэгдэх суурь нөхцөл бүрдэх учраас цаашид хөрөнгийн зах зээл идэвхжиж, олон тулгуурт санхүүгийн зах зээл хөгжих суурь шалтгааны нэг болж байна.



Тухайлбал, 2021 онд БНХАУ-ын банкуудын нийт хөрөнгө 42.9 их наяд ам.долларт хүрч, өмнөх оноос 11.7 хувиар буюу 3.4 их наяд ам доллараар өссөн үзүүлэлттэй байна.

АНУ-ын банкны салбар

АНУ-ын банкуудын ашиг 2020 онд цар тахлын нөхцөл байдлын улмаас 36.5 хувиар буурч, 147.1 тэрбум ам.долларын ашигтай ажилласан. 2020 оны 4 дүгээр улиралд банкны ашигт ажиллагаа сэргэсэн ч энэ нь үйл ажиллагааны орлогын өсөлтөөс бус зээлийн эрсдэлийн сангийн бууралтаас үүдэлтэй байсан.

2021 оны байдлаар АНУ-ын банкуудын цэвэр ашиг 279.1 тэрбум ам.долларт хүрч өмнөх онтой харьцуулахад 132 тэрбум буюу 88%-иар өссөн байна. Энэ нь 2021 онд эдийн засгийн идэвхжил сэргэсэн болон эрсдлийн сангийн зардал 163.3 тэрбум доллараар буурсан нь голлох нөлөөллийг үзүүлсэн байна.

ИБУИНВУ-ын банкны салбар

2020 онд Ковид-19 цар тахлын нөхцөл байдал банкуудын ашигт ажиллагаанд сөргөөр нөлөөлснөөр Их Британи Умард Ирландын Нэгдсэн Вант Улс (ИБУИНВУ)-ын банкны салбарын нийт хөрөнгө 13.1 их наяд ам.долларт хүрчээ.

Тухайлбал, тус улсын хамгийн том банк болох HSBC банкны цэвэр ашиг өмнөх оноос 30 хувиар буурч 6.1 тэрбум ам.долларт хүрсэн байна. Хэдийгээр үйл ажиллагааны зардлыг танаж чадсан ч зээлийн эрсдэлийн сангийн зардал төлөвлөж байснаас өндөр гарсан нь ашигт ажиллагааг бууруулахад хүргэсэн бөгөөд эдийн засгийн хүнд нөхцөл байдал, Төв банкнаас банкуудын хүүг бууруулж сөрөг төвшин рүү оруулах шахалт үзүүлсэн нь банкуудын ашигт ажиллагаанд дарамт учруулсан байна.

2021 оны байдлаар Их Британи Умард Ирландын Нэгдсэн Вант Улсын банкнуудын хүү татварын өмнөх ашиг 502.8 тэрбум ам.доллар хүрч өмнөх оноосоо 454.3 ам доллараар өссөн үзүүлэлттэй байна. Мөн тус улсын цэвэр хүүгийн ашгийн маржин 2.13 хувь болж өмнөх оноосоо 0.29 нэгж хувиар өссөн нь иргэд, аж ахуй нэгжийн идэвхи сэргэж эдийн засаг сайжирсантай холбоотой.

Бодлогын хүү


2020 оноос дэлхийн ихэнх улс орнууд цар тахлын нөхцөл байдлаас эдийн засгаа хамгаалах, учирч болох сөрөг үр дагаврыг бууруулах зорилгоор мөнгөний зөөлөн бодлогыг хэрэгжүүлж, бодлогын хүүг бууруулсан. АНУ 2019 оны эцэст 1.6 хувь байсан бодлогын хүүг бууруулж, 2021 оны жилийн эцсийн байдлаар 0.1 хувьд хүргэв. ОХУ 2020 онд 6.2 хувьд байсан бодлогын хүүг 2 нэгж хувиар бууруулж 4.2 хувьд хүргэсэн ч 2021 оны 3-р сараас аажмаар нэмэгдүүлж, 12-р сард 8.5 хувьд хүргэсэн.



2021 онд ИБУИНВУ бодлогын хүүг 0.2 нэгж хувиар нэмэгдүүлж 0.3 хувьд, БНХАУ 0.1 нэгж хувиар бууруулж 3.8 хувьд тогтоов.

Бодлогын хүү нь банкуудын зээл болон хадгаламжийн хүүд нөлөөлж, цаашлаад зээлийн нийлүүлэлтийг нэмэгдүүлж, эдийн засгийн эргэлтийг дэмжих зорилготой байдаг. Ойрын хугацаанд улс орнууд эдийн засгийн нөхцөл байдлаас хамаарч бодлогын хүүг тогтвортой барих төлөвтэй байна.

График 73. Улс орнуудын бодлогын хүү



Эх сурвалж: Bank for International Settlements




Монгол Улсын банк санхүүгийн салбарын өнөөгийн нөхцөл байдал

Банкны салбарын зах зээлд эзлэх байр суурь

Сүүлийн жилүүдэд санхүү, даатгалын салбарын ДНБ-д эзлэх хэмжээ тогтвортой өсөн нэмэгдэж байна. Тодруулбал, 2021 оны байдлаар Монгол Улсын ДНБ 43.0 их наяд төгрөгт хүрснээс 4.8 хувь буюу 2.1 их наяд төгрөгийг санхүү, даатгалын салбар бүрдүүлсэн.

График 74. ДНБ-д санхүүгийн салбарын эзлэх хувь хэмжээ



Эх сурвалж: УСХ

Санхүү, даатгалын салбар нь эдийн засгийн бусад салбаруудтай харьцуулахад ДНБ-ий өсөлттэй зэрэгцэн харьцангуй тогтвортой өссөөр ирсэн. Хэдийгээр уул уурхай, ХАА-н салбарын ДНБ-д эзлэх хувь санхүү, даатгалын салбартай харьцуулахад өндөр байдаг ч сүүлийн 4 жил дэх өсөлт, бууралт нь ДНБ-ий өөрчлөлтөөс хамаарч хэлбэлзэл ихтэй байна.

Банкны салбар нь Монгол Улсын санхүүгийн салбарын гол тулгуур багана болж ирсэн. Тодруулбал, 2017 оноос хойш санхүүгийн салбарын 87-оос дээш хувь, 2021 оны жил эцсийн байдлаар 81 хувийг бүрдүүлж байна. 2021 оны жил эцсийн байдлаар банкны салбарын нийт хөрөнгийн хэмжээ 41.0 их наяд төгрөгт хүрсэн.

Хүснэгт 32. Санхүүгийн салбарын нийт хөрөнгө, тэдгээрийн эзлэх хувь /тэрбум төгрөг/

	2017		2018		2019		2020		2021	
	дүн	хувь	дүн	хувь	дүн	хувь	дүн	хувь	дүн	хувь
ХЗХ	153.1	0.5%	200.2	0.5%	222.6	0.5%	256.0	0.6%	291.2	0.6%
ББСБ	969.2	3.0%	1,284.9	3.4%	1,738.8	4.3%	2,006.9	4.7%	2,709.9	5.4%
Даатгал	244.7	0.8%	331.9	0.9%	365.8	0.9%	382.1	0.9%	425.4	0.8%
Үнэт цаас	2,440.2	7.5%	2,511.2	6.7%	2,693.1	6.6%	3,029.7	7.2%	5,982.9	11.9%
Банк	28,772.9	88.3%	33,053.3	88.4%	35,859.3	87.7%	36,685.5	86.6%	41,011.7	81.3%



Эх сурвалж: Монголбанк, СЗХ-ны тайлан /Татан буугдсан банкууд орсон дүн/

2021 онд хөрөнгийн зах зээл идэвхэжсэнээр 2021 оны жил эцсийн байдлаар хөрөнгийн зах зээлийн үнэлгээ 5.9 их наяд төгрөгт хүрч, санхүүгийн салбарын 11.9 хувийг эзэлж байна.

Тус хугацаанд ББСБ-ын нийт хөрөнгө 2.7 их наяд төгрөгт хүрснээр санхүүгийн зах зээлийн 5.4 хувь, даатгалын салбарын нийт хөрөнгө 425.4 тэрбум төгрөгт хүрснээр санхүүгийн зах зээлийн 0.8 хувь, хадгаламж зээлийн хоршоодын нийт хөрөнгө 291.2 тэрбум төгрөгт хүрснээр санхүүгийн салбарын 0.6 хувийг бүрдүүлж байна.

График 75. Банк, үнэт цаас, даатгалын салбарын өсөлт




Эх сурвалж: ҮСХ

Монгол Улсын санхүүгийн салбарын тулгын гурван чулуу болох банк, хөрөнгийн зах зээл, даатгалын салбарын 2017-2021 оны хөрөнгийн өсөлтийг харьцуулбал банкны салбарын өсөлт тогтвортой өндөр хувиар өссөн байна.

2021 оны жил эцсийн байдлаар санхүүгийн салбарын цэвэр ашгийн 68 хувийг банк, 27 хувийг ББСБ, 3 хувийг даатгалын салбар тус тус бүрдүүлжээ. Тус хугацаанд банкны салбарын цэвэр ашгийн хэмжээ 542 тэрбум төгрөгт хүрсэн нь өмнөх оны мөн үеэс 276.6 тэрбум төгрөг буюу 1 дахин өссөн үзүүлэлт юм.



График 76. Санхүүгийн салбарын цэвэр ашгийн хэмжээ /тэрбум төгрөг/



Эх сурвалж: YCX

Банкны салбарын голлох үзүүлэлтүүд

Монгол Улсад хоёр шатлалт банкны тогтолцоо 1991 онд үүссэнээс хойших 30 жилийн хугацаанд банк, санхүүгийн салбарын менежмент сайжирч, санхүүгийн секторын нөхцөл байдал тогтворжиж, иргэдийн банканд итгэх итгэл нэмэгдсэнээр санхүүгийн зуучлалын үйлчилгээний чанар, цар хүрээнд ахиц дэвшил хурдацтай гарсаар байна.

Хүснэгт 33. Банкны салбарын голлох үзүүлэлтүүд

Нэгж		2017	2018	2019	2020	2021
Ерөнхий үзүүлэлт						
Банкуудын тоо	Ширхэг	14	14	13	12	11
Салбарын тоо	Ширхэг	1,511	1,512	1,413	1,402	1,393
Ажилчдын тоо	Мян. хүн	15.2	16.1	16.3	16.0	15.9
Зээлдэгчдийн тоо	Мян. хүн	1,015	1,222	1,395	1,308	1,452
Харилцах дансны тоо	Мян. хүн	5,176	4,425	4,751	5,473	6,110
Хадгаламжийн дансны тоо	Мян. хүн	3,003	3,155	3,247	3,517	3,533
Санхүүгийн үзүүлэлт						
Нийт хөрөнгө (актив)	Их наяд төг	25.0	29.8	32.5	36.7	41.0
Өөрийн хөрөнгө	Их наяд төг	3.2	3.3	3.1	3.1	3.4
Өр төлбөр	Их наяд төг	21.8	26.5	29.4	33.6	37.6
Цэвэр ашиг	Тэр.төг	249.1	-96.8	32.7	265.4	542.0


Эх сурвалж: Монголбанк

Монгол Улсын банкны салбарт 12 арилжааны банк 1,390 салбартайгаар үйл ажиллагаа явуулж байсан бол 2021 оны 7-р сард Кредит банк, Тээвэр хөгжлийн банк нэгдэж 11 болсон. Үйл ажиллагаа явуулж буй банкуудын нийт хөрөнгө нь санхүүгийн салбарын 81.3 хувь, ДНБ-ийн 95 хувийг тус тус эзэлж байгаа нь банкны салбар нь



Монгол Улсын санхүүгийн салбарын хөгжил дэвшил, түүхтэй салшгүй холбоотой гэдгийг харуулж байна.

График 77. Банкны салбарын нийт актив ба ДНБ-д эзлэх хувь



Эх сурвалж: Монголбанк, УСХ

Банкуудын тоо цөөрсөн, системийн хэмжээнд шинэчлэл хийгдсэнээр банкны салбарын тоо 2017 оноос хойш 100 гаруй салбараар буурсан ч тус салбарт ажиллагсдын тоо харьцангуй тогтвортой байна. Харин зээлдэгч болон хадгаламж эзэмшигчдийн тоо жилд дунджаар 9 хувиар өссөн байна.

Хөрөнгийн (активын) бүтэц

2021 оны жил эцсийн байдлаар банкны системийн нийт хөрөнгийн 47 хувийг дотоодын цэвэр зээл, 21 хувийг төв банкны үнэт цаас, 11 хувийг банкны нөөц, 21 хувийг бусад актив болох үндсэн хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага зэрэг хөрөнгүүд бүрдүүлж байна.

Цар тахлын нөлөөгөөр зээл олголт буурч, илүүдэл мөнгөн хөрөнгө бий болсноор банкууд Төв банкны үнэт цаас (ТБҮЦ)-д байршуулж, банкуудын ТБҮЦ-ны худалдан авалт түүхэн дээд хэмжээнд буюу нийт активын 21 хувьд хүрсэн байна.

Монголбанк мөнгөний зөөлөн бодлого баримталж бодлогын хүүг 6 хувь хүртэл буулгасан ч цар тахалтай холбоотойгоор хил гаалийн хэвийн үйл ажиллагаа доголдсон, ачаа тээврийн эргэлт буурсан, хөл хорионы улмаас ажил эрхлэлт буурч, бизнесийн үйл ажиллагаа тасалдсаны улмаас 2020 онд зээлийн нийлүүлэлт буурсан бол 2021 онд эргэн сэргэж, зээлийн нийлүүлэлт өссөн байна.



График 78. Банкны салбарын активын бүтэц



Эх сурвалж: Монголбанк, банкуудын нэгдсэн тайлан

Нийт зээл

Банкны салбарын нийт зээлийн хэмжээ 2017 оноос хойш 7.2 их наяд төгрөгөөр нэмэгдэж, 2021 оны байдлаар 20.7 их наяд төгрөгт хүрсэн. Үүнээс 86 хувь буюу 17.7 их наяд төгрөгийг хэвийн зээл, 4 хувь буюу 0.9 тэрбум төгрөгийн хугацаа хэтэрсэн зээл, 10 хувь буюу 2.1 их наяд төгрөгийг чанаргүй зээл эзэлж байна.

Мөн нийт зээлийн 9.7 хувь, чанаргүй зээлийн 95 хувьтай тэнцэх хэмжээний 2.0 их наяд төгрөгийн зээлийн эрсдэлийн санг банкны системийн хэмжээнд байгуулсан бол үлдсэн 90.3 хувийг хэвийн зээл эзэлж байна.

Хүснэгт 34. Зээлийн үлдэгдэл, чанарын ангиллаар

Үзүүлэлт	Нэгж	2017	2018	2019	2020	2021
Нийт зээл	Их наяд төг	13.5	17.1	17.9	17.0	20.7
Хэвийн	Их наяд төг	11.5	14.5	15.3	13.8	17.7
Хугацаа хэтэрсэн	Их наяд төг	0.8	0.8	0.8	1.3	0.9
Чанаргүй	Их наяд төг	1.1	1.8	1.8	2.0	2.1
Чанаргүй зээлийн эзлэх хувь (NPL)	Хувь	8.5%	10.4%	10.1%	11.8%	10.0%
Зээлийн эрсдэлийн сан	Их наяд төг	1.0	1.6	1.6	1.9	2.0

Эх сурвалж: Монголбанк, банкуудын зээлийн тайлан

Цэвэр зээл

2017 оноос хойш банкуудын цэвэр зээл дунджаар 11 хувиар өссөн ч 2020 онд цар тахлын нөлөөгөөр 6 хувиар буурч 15.8 их наяд төгрөгт хүрчээ. 2021 оны байдлаар эдийн засгийг сэргээх бодлогын хүрээнд банкны салбарын цэвэр зээл эргэн өсөж 19.2 их наяд төгрөгт хүрсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 22 хувиар өссөн үзүүлэлт юм.




2021 оны жил эцсийн байдлаар нийт олгогдсон зээлийн 49.1 хувийг иргэдийн, 49.4 хувийг байгууллагын зээл бүрдүүлж байна. 2017-2021 оны дунджаас үзэхэд иргэдийн зээл олголт нийт зээлийн 30 хувиас хэтэрдэггүй байсан бол ажлын байрыг дэмжих бага хүүтэй зээл олголтын хүрээнд иргэдэд 1.5 их наяд төгрөгийн зээлийг олгож нийлүүлэлтийг нэмэгдүүлснээр 1.4 дахин нэмэгдсэн байна.

Чанаргүй зээл

Чанаргүй зээлийн хэмжээ 2012 оноос хойших хугацаанад зээл олголтын тэлэлттэй зэрэгцэн өссөөр ирсэн. 2020 онд Ковид-19 цар тахлын улмаас бизнесүүд зогсонги байдалд орж, иргэдийн орлого буурснаар чанаргүй зээлийн хэмжээ түүхэн дээд түвшинд буюу 2.0 их наяд төгрөгт, чанаргүй зээл 11.7 хувьд хүрсэн. 2021 оны байдлаар эдийн засаг сэргэж эхэлснээр зээлийн чанарын үзүүлэлт сайжирч, чанаргүй зээлийн хувь 10 хувь руу буурсан байна.

График 82. Чанаргүй зээлийн хэмжээ /их наяд төгрөг/



Эх сурвалж: Монголбанк

2021 оны байдлаар чанаргүй зээл уул уурхайн салбарын зээлийн 27 хувийг, боловсруулах үйлдвэрлэлийн салбарын 23 хувийг, барилгын салбар 18 хувийг, хэрэглээний зээл 6 хувийг (цалингийн, малчны, автомашины зээл), хөдөө аж ахуйн салбар 23 хувийг, жижиглэн болон бөөний худалдааны салбар 3 хувийг, бусад салбарууд 7 хувийг тус тус бүрдүүлж байна. 2021 оны жил эцсийн байдлаар хөдөө аж ахуй, үйлдвэрлэл болон худалдааны салбар идэвхэжсэнээр тус салбарын чанаргүй зээлийн эзлэх хэмжээ буурсан байна.



График 83. Чанаргүй зээлийн хувь салбараар



Эх сурвалж: Монголбанк

Төв банкны үнэт цаас

Банкны салбарын нийт хөрөнгийн 20 гаруй хувийг Төв банкны үнэт цаас бүрдүүлж байна. 2016-2017 онд Төв банкнаас бодлогын хүүг огцом нэмж 15 хувьд тогтоосноор банкуудын эзэмшиж буй төв банкны үнэт цаас нэмэгдсэн. 2020 онд бодлогын хүү түүхэн доод түвшинд буюу 6 хувьд хүрсэн ч Ковид-19 цар тахлын нөлөө, эдийн засгийн нөхцөл байдлаас шалтгаалан банкууд зээлийн хумих бодлого хэрэгжүүлснээр банкуудын төв банкны үнэт цаасад оруулсан хөрөнгийн хэмжээ нэмэгдэж 2021 оны жилийн эцсийн байдлаар 8.6 их наяд төгрөгт хүрсэн. Энэ нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 12 хувиар өссөн үзүүлэлт юм.

График 84. Төв банкны үнэт цаас /их наяд төгрөг/



Эх сурвалж: Монголбанк



Банкны нөөц

Монголбанкны мөнгөний зөөлөн бодлогын хүрээнд 2020 оны 11-р сард банкуудын заавал байлгах нөөцийн хэмжээг 4.5 нэгж хувиар бууруулсан. Тус шийдвэр нь эдийн засагт долларжилтыг бууруулж, банкуудын зээлийн эх үүсвэрийг нэмэгдүүлж, санхүүгийн зуучлалын үйлчилгээг дэмжих зорилготой байв. 2019 он хүртэл банкуудын нөөц нийт хөрөнгийн 17 орчим хувийг бүрдүүлж байсан бол тус шийдвэрийн үр дүнд 2021 оны жилийн эцсийн байдлаар 4.5 их наяд төгрөг буюу нийт хөрөнгөд эзлэх хувь 11 хувь болж буурсан байна.

Гадаад актив

Банкны салбарын гадаад активын хэмжээ 2020 онд 3.1 их наяд төгрөгт хүрч, өмнөх оноос 54 хувиар өссөн. Харин 2021 оны жилийн эцсийн байдлаар гадаад активын хэмжээ 2.8 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны эцэстэй харьцуулахад 10 хувиар буурсан байна. Энэ нь ам.долларын дансны хязгаарлалт, ам.долларын эрэлт буурсан зэрэг хүчин зүйлс нөлөөлсөн байна.

Бусад актив

Бусад активт бусад байгууллагад байршуулсан харилцах хадгаламж, биет, биет бус хөрөнгө, үнэт металл, Засгийн газрын авлага, үнэт цаас багтдаг. 2019 онд банкны бусад актив 4.2 их наяд төгрөгт хүрч, нийт активын 12 хувийг бүрдүүлж байсан. 2021 оны жилийн эцсийн байдлаар 3.1 их наяд төгрөг болон буурч, нийт активын 8 хувийг бүрдүүлж байна.

Өр төлбөр (пассивын) бүтэц

График 85. Банкны салбарын пассивын бүтэц



Эх сурвалж: Монголбанк, банкуудын нэгдсэн тайлан



2015 оноос хойш банкны салбарын эх үүсвэрт дотоодын эх үүсвэр давамгайлж, гадаад эх үүсвэр буурсан. 2021 оны жил эцсийн байдлаар банкны салбарын нийт эх үүсвэрийн 63 хувийг харилцах хадгаламж, 10 хувийг гадаад эх үүсвэр, 8 хувийг өөрийн хөрөнгө, 19 хувийг бусад өр төлбөр бүрдүүлж байна.

Харилцах хадгаламж

2017-2020 онд банкны салбарын нийт өр төлбөрийн 15-20 хувийг иргэд, байгууллагын харилцах эзэлж байгаагаас 75 орчим хувийг байгууллагын харилцах бүрдүүлж байна. 2021 оны жил эцсийн байдлаар нийт харилцахын хэмжээ 7.3 их наяд төгрөгт хүрч өмнөх оны мөн үетэй харьцуулахад 40 хувиар өссөн байна.

График 86. Банкны салбарын нийт хадгаламж /их наяд төгрөг/



График 87. Банкны салбарын нийт харилцах /их наяд төгрөг/



Эх сурвалж: Монголбанк

Банкны салбарын нийт өр төлбөр буюу эх үүсвэрийн 50 орчим хувийг бүрдүүлж буй хадгаламжийн эх үүсвэрийн 89 хувийг иргэдийн хадгаламж бүрдүүлж байна. 2021 оны жилийн эцсийн байдлаар банкны хадгаламж 18.4 их наяд төгрөгт хүрч өмнөх оны жилийн эцсээс 7 хувиар өссөн. Энэ нь Монголбанкны мөнгөний зөөлөн бодлогын хүрээнд эдийн засагт мөнгөний нийлүүлэлт нэмэгдсэнтэй шууд холбоотой юм.

Гадаад эх үүсвэр

Банкны салбарын гадаад эх үүсвэр 2019 онд 5.3 их наяд төгрөгт хүрч, нийт хөрөнгийн 15 хувийг бүрдүүлж байсан. Сүүлийн жилүүдэд гадаад эх үүсвэрийн хэмжээ тогтмол буурснаар 2021 оны жилийн эцсийн байдлаар 3.9 их наяд төгрөгт хүрч, нийт өр төлбөрийн 10 хувийг бүрдүүлж байна.



Бусад өглөг

Бусад өглөгт бусад байгууллага, Засгийн газар, төв банк, бусад банканд төлөх өглөгүүд багтдаг. Бусад өглөгийн хэмжээ 2019 оноос хойш аажмаар буурсан хэдий ч 2021 оны жил эцсийн байдлаар 6.2 их наяд төгрөгт хүрсэн нь өмнөх оны эцэстэй харьцуулахад 14 хувиар өссөн үзүүлэлт юм.

Өөрийн хөрөнгө

2017 оноос хойш банкны өөрийн хөрөнгө тогтвортой букуу 10-12 хувийн төвшинд байна. 2021 оны жилийн эцсийн байдлаар банкны салбарын өөрийн хөрөнгө 3.4 их наяд төгрөгт хүрсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 12 хувиар өссөн үзүүлэлт юм.

Орлогын бүтэц

2020 онд банкны салбарын нийт орлого 4.0 их наяд төгрөгт хүрсэн. Харин 2021 оны жилийн эцсийн байдлаар 3.7 их наяд төгрөгт хүрсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 14 хувиар буурсан үзүүлэлт юм. Үүнд, Ковид-19 цар тахлын нөлөөгөөр зээл олголт буурч, хүүгийн орлого 10 хувиар, бусад орлого 31 хувиар тус тус буурсан нь нөлөөлсөн байна.

Ковид-19 цар тахлаас урьдчилан сэргийлэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн хэрэгжилтийн дагуу иргэд, хуулийн этгээд хоорондын гүйлгээг үндэсний мөнгөн тэмдэгтээр гүйцэтгэх шийдвэр болон макро эдийн засгийн бусад нөхцөл байдлаас шалтгаалж банкны ханшийн тэгшитгэлийн орлого буурсан байна.

График 88. Банкны салбарын нийт орлого /их наяд төгрөг/



График 89. Нийт орлогын өсөлт



Эх сурвалж: Банкуудын улирлын тайлан



2018-2021 онд банкны салбарын нийт орлого жилд дунджаар 4.0 хувиар өссөн. Үүнээс хүүний орлого жилд дунджаар 8.3 хувиар өссөн бол бусад орлого 5.5 хувиар буурсан байна. Банкны салбарын нийт орлогын 80 орчим хувийг хүүний орлого эзэлдэг. Үлдсэн 20 хувийг эзлэх бусад орлогод арилжааны орлого, ханшийн тэгшитгэлийн орлого, бусад санхүүгийн хэрэгсэл үйлчилгээний орлого багтдаг.

Монгол Улс нь валютын ханшийн өндөр савлагаатай орон учир банкууд валютын ханшийн эрсдэлийг бууруулах зорилгын үндсэн дээр гадаад позиц бүрдүүлдгээс үүдэн валютын ханшийн тэгшитгэлийн орлого өндөр хэлбэлзэлтэй байдаг.

Зардлын бүтэц

2020 онд банкны салбарын нийт зардал 3.1 их наяд төгрөгт хүрч, өмнөх оноос 23 хувиар буурсан. Ийнхүү зардал буурахад Ковид-19 цар тахлаас сэргийлэх хөл хориог тогтоосноор салбарын үйл ажиллагааны зардал буурсан, харилцах дансанд хүү тооцохгүй болсноор хүүгийн зардал буурсан зэрэг хүчин зүйлс нөлөөлжээ.

Монголбанкнаас активыг ангилах, активын эрсдэлийн сан байгуулж зарцуулах журамд өөрчлөлт оруулсан, зээлийн багцын чанар сайжирч эхэлснээр эрсдэлийн сангийн зардал 2021 оны жилийн эцсийн байдлаар өмнөх оны мөн үетэй харьцуулахад 49 хувиар буурсан.

График 90. Зардлын өсөлт



График 91. Банкны салбарын нийт зардал /их наяд төгрөг/



Эх сурвалж: Банкуудын улирлын тайлан

Банкны салбарын зардлыг хүүгийн зардал болон бусад зардал, эрсдэлийн сангийн зардал голчлон бүрдүүлдэг. 2017-2021 онд нийт зардлын 50-60 хувийг хүүгийн зардал, 30-40 хувийг бусад зардал болох арилжааны зардал, ханшийн тэгшитгэлийн зардал, 20-30 хувийг эрсдэлийн сангийн зардал эзэлдэг.



График 93. Иргэдийн харилцах, хадгаламжийн хүү




График 94. Иргэдийн харилцах, хадгаламжийн дүн /их наяд төгрөг/



Эх сурвалж: Монголбанк


Монгол Улсын банкны системийн хэмжээнд иргэдийн зээл болон хадгаламжийн хүү 2017 оноос аажмаар буурсан үзүүлэлттэй байна. Шинээр татсан иргэдийн төгрөгийн хадгаламжийн жинлэсэн дундаж жилийн хүү 2017 онд 12.7 хувьтай байсан. 2021 оны жилийн эцсийн байдлаар 6.4 хувь болж 6.3 нэгжээр, валютын хадгаламжийн жинлэсэн жилийн дундаж хүү 5.7 хувь байсан бол 3.6 хувь болж 2.1 нэгжээр буурсан байна. Төгрөгийн зээлийн жилийн жинлэсэн дундаж хүү 19.4 хувиас 15.2 хувь болж 4.2 нэгжээр, валютаар илэрхийлэгдэх зээлийн жинлэсэн дундаж хүү 13.6 хувиас 4.6 хувь болж 9 нэгжээр буурсан байна.

2021 оны жилийн эцсийн байдлаар иргэдэд олгосон зээл өмнөх оны эцэстэй харьцуулахад 4.5 их наяд төгрөг буюу 47 хувиар, эргэн төлөлт 1.7 их наяд төгрөг буюу 17 хувиар, зээлийн үлдэгдэл 1.9 их наяд төгрөг буюу 22 хувиар тус тус өссөн үзүүлэлттэй байна.

Цар тахлын нөлөөгөөр иргэдийн орлого буурч, зээл төлөх чадвар муудсанаар 2020 онд иргэдийн чанаргүй зээлийн түвшин огцом өссөн. Гэсэн хэдий ч иргэдийн чанаргүй зээлийн хувь системийн түвшнээс бага буюу иргэдийн зээлийн багцын чанар бусад зээлийн багцтай харьцуулахад сайн байна.




График 95. Иргэдийн зээлийн үлдэгдэл /их наяд төгрөг/, чанаргүй зээлийн хувь



Эх сурвалж: Монголбанк

2021 оны жил эцсийн байдлаар иргэдийн зээлийн үлдэгдлийн 49 хувийг бизнесийн зээл, 51 хувийг хэрэглээний зээл тус тус бүрдүүлж байна. Үүнд хэрэглээний зээлийн 2.7 их наяд төгрөг буюу 51 хувийг цалингийн зээл, 954.7 тэрбум төгрөг буюу 18 хувийг малчны зээл, 795.6 тэрбум төгрөг буюу 15 хувийг хадгаламж барьцаалсан зээл бүрдүүлж байна.

График 96. Зээлийн үлдэгдэл төрлөөр



Эх сурвалж: УСХ

Монгол Улсад орон сууцны санхүүжилт 2000 оноос хойш хувийн хэвшилд тулгуурлан хөгжиж ирсэн. Орон сууцны зээлийн нийлүүлэлтийн санхүүжилтийг өөрийн хөрөнгө, захиалагчдын урьдчилгаа болон банкны зээлээр, эрэлтийн санхүүжилтийг иргэдийн хадгаламж, гэр бүлийн дэмжлэг, ипотекийн зээлээр шийдвэрлэж ирсэн.



2021 оны жил эцсийн байдлаар нийт 104.4 мянган зээлдэгч 5.7 их наяд төгрөгийн орон сууцны зээлийн үлдэгдэлтэй байгаагаас 21 хувь буюу 1.2 их наяд төгрөгийг банкуудын, 53 хувь буюу 3.0 их наяд төгрөгийг Монголын Ипотекийн Корпорацийн, 1.0 их наяд төгрөг буюу 18 хувийг хөтөлбөрийн, үлдсэн 8 хувийг бусад эх үүсвэрээс бүрдүүлж байна.

Хүснэгт 35. Ипотекийн зээлийн үзүүлэлт

Үзүүлэлт	Нэгж	2017	2018	2019	2020	2021
Олгосон зээлийн дүн	Тэр.төг	443.1	706.9	748.1	825.8	1,514.0
Төлөгдсөн зээлийн дүн	Тэр.төг	303.3	533.2	549.2	533.9	781.0
Зээлийн үлдэгдэл	Тэр.төг	4,253.2	4,430.2	4,629.0	4,919.2	5,654.5
Нийт зээлдэгчдийн тоо	Мян. хүн	93.1	93.9	96.7	100.5	104.4
Чанаргүй зээл	Сая төг	1.75%	1.79%	1.86%	2.92%	2.18%

Эх сурвалж: Монголбанк

Ковид-19 цар тахлын нөхцөл байдал хүндэрсэнтэй холбогдуулан Засгийн газраас 10 их наяд төгрөгийн цогц хөтөлбөрийг баталсан. Үүнд эхний ээлжинд Улаанбаатар хотод барих Залуус I, II, III хорооллын дэд бүтэц, газар олгох, орон сууцыг нэг маягийн зургаар барих, ипотекийн хөнгөлөлттэй зээл олгоход 3 их наяд төгрөг төлөвлөсөн.

2021 оны жилийн эцсийн байдлаар ипотекийн зээл олголтын хэмжээ 1.5 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 688.2 тэрбум төгрөг буюу 83 хувиар, зээл төлөлт 781 тэрбум төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 247.1 тэрбум төгрөг буюу 46 хувиар, зээлийн үлдэгдэл 5.7 их наяд төгрөгт хүрч өмнө оны мөн үеэс 735.3 тэрбум төгрөг буюу 15 хувиар өссөн байна. Орон сууцны зээлийн чанаргүй зээлийн үлдэгдэл өмнөх оны эцэстэй харьцуулахад 0.74 нэгж хувиар буурч, 2.18 хувийн төвшинд хүрсэн байна.

Байгууллагын банкны зах зээл

Монгол Улсын хэмжээнд байгууллагын нийт хадгаламж 2021 оны жилийн эцсийн байдлаар 6.8 их наяд төгрөгт хүрч, 2020 оны эцэстэй харьцуулахад 19 хувиар өссөн үзүүлэлттэй байна. Нийт хадгаламжийн 65 хувийг төгрөгийн хадгаламж, 35 хувийг валютын хадгаламж бүрдүүлж байна.

2017 оноос эхлэн байгууллагын зээлийн болон хадгаламжийн хүү тогтвортой буурсан. Шинээр татсан байгууллагын төгрөгийн хадгаламжийн жинлэсэн дундаж жилийн хүү 2017 онд 9.4 хувиас 2021 оны жилийн эцсийн байдлаар 4.5 хувьд хүрч




4.9 нэгжээр, валютын хадгаламжийн жинлэсэн дундаж жилийн хүү 3.1 хувиас 1.5 хувьд хүрч 1.6 нэгжээр буурсан.

Шинээр татсан байгууллагын төгрөгийн зээлийн жинлэсэн дундаж жилийн хүү 2017 онд 18 хувь байсан бол 2021 оны жилийн эцсийн байдлаар 10.2 хувьд хүрч 7.8 нэгжээр, валютын зээлийн жинлэсэн дундаж жилийн хүү 11.5 хувиас 9.0 хувь хүрч 2.5 нэгжээр буурсан үзүүлэлттэй байна. Байгууллагын төгрөгийн хадгаламж, зээлийн хүүгийн зөрүү дунджаар 7.1 хувьтай, валютын хадгаламж зээлийн хүүгийн зөрүү дунджаар 6.9 хувьтай байна.

График 97. Байгууллагын харилцах, хадгаламжийн дүн /их наяд төгрөг/



График 98. Байгууллагын харилцах хадгаламжийн хүү




Эх сурвалж: Монголбанк

2021 оны жилийн эцсийн байдлаар байгууллагын зээл олголт 2020 оны эцэстэй харьцуулахад 4.5 их наяд төгрөг буюу 51 хувиар, эргэн төлөлт 2.2 их наяд төгрөг буюу 24 хувиар, зээлийн үлдэгдэл 1.8 их наяд төгрөг буюу 21 хувиар өссөн үзүүлэлттэй байна. Цар тахлын үед иргэд аж ахуйн нэгжүүдийн бизнесийн үйл ажиллагааг дэмжих зорилготой Монголбанкнаас репо санхүүжилтийг арилжааны банкуудад олгосноор зээлийн нийлүүлэлт нэмэгдэж, 2021 онд зээл олголтын өсөлтөд нөлөөлсөн байна.



График 99. Байгууллагын зээлийн дүн /их наяд төгрөг/, чанаргүй зээлд эзлэх хувь



Эх сурвалж: Монголбанк


Иргэдийн зээлтэй харьцуулахад байгууллагын зээлийн чанар харьцангуй муу буюу 15 хувийн чанаргүйдлийн түвшинд байна. 2020 онд цар тахлын нөлөөгөөр банкууд зээлийн хумих бодлого хэрэгжүүлснээр зээлийн үлдэгдэл 1.7 хувиар буурсан ч 2021 онд эдийн засаг аажим сэргэснээр байгууллагын зээлийн үлдэгдэл 10.4 их наяд төгрөгт хүрсэн байна.

Монгол Улсын жижиг дунд үйлдвэрлэлийг (ЖДҮ) дэмжих зээлийн үлдэгдэл 2021 оны жил эцсийн байдлаар 5.6 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны эцэстэй харьцуулахад 2.0 их наяд төгрөгөөр буюу 56 хувиар өссөн. Жижиг дунд үйлдвэрлэлийн зээлийн 59 хувийг байгууллагын, 41 хувийг иргэдэд олгосон зээлийн үлдэгдэл бүрдүүлж байна. Жижиг дунд байгууллагын зээлийн үлдэгдлийн 14 хувь, иргэдэд олгосон зээлийн 6 хувь нь тус тус чанаргүй зээл байна.

График 100. ЖДҮ зээлд эзлэх хувь, 2021 он салбараар



График 101. ААН, Иргэдийн зээлийн үлдэгдэл, NPL



Байгууллагын зах зээлийн үлдэгдлийг салбараар нь ангилж үзвэл худалдааны салбар 39 хувь, боловсруулах үйлдвэрлэлийн салбар 11 хувь, барилга 11 хувь, бусад салбар 39 хувийг бүрдүүлж байна.

Үнэт цаас гаргагчийн зах зээлд эзлэх байр суурь

Голомт банк нь 1995 оноос банкны салбарт үйл ажиллагаа явуулж эхэлснээс хойш сүүлийн 26 жилийн туршид өргөжин тэлж, тогтвортой үйл ажиллагаа явуулж, банкны салбарын системийн нөлөө бүхий банк болсон. 2021 оны жилийн эцсийн байдлаар Үнэт цаас гаргагч нь банкны салбарын нийт хөрөнгийн 19.5 хувийг, нийт зээлийн 16.5 хувийг, нийт харилцах хадгаламжийн 18.9 хувийг бүрдүүлж байна.

Системийн нөлөө бүхий банк

Монгол Улсын Банкны тухай хуулийн нэмэлт өөрчлөлтийн хүрээнд тус хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.20 дахь заалтад банкны системд нөлөө бүхий банкыг хөрөнгө, өр төлбөрийн хэмжээ, төлбөрийн систем дэх гүйлгээний нийт дүнд эзлэх хувь, банкны үндсэн үйл ажиллагаа, санхүүгийн тогтолцооны хамаарал зэрэг шалгуурыг үндэслэл болгон тодорхойлж, Монголбанк нь системийн нөлөө бүхий банкыг тогтоохоор заасан.

Монголбанкны Ерөнхийлөгчийн 2021 оны 4-р сарын 19-ний өдрийн А-105 дугаар тушаалаар Голомт, Хаан, Худалдаа хөгжил, Хас, Төрийн банкуудыг системийн нөлөө бүхий банкаар тодорхойлсон.

График 102. Үнэт цаас гаргагчийн нийт хөрөнгө, зах зээлд эзлэх хувь



График 103. Үнэт цаас гаргагчийн нийт зээл, зах зээлд эзлэх хувь



График 104. Үнэт цаас гаргагчийн нийт харилцах хадгаламж, зах зээлд эзлэх



Эх сурвалж: Банкуудын 2021 оны жилийн эцсийн тайлан, Монголбанкны тайлан



2021 оны жилийн эцсийн байдлаар системийн нөлөө бүхий 5 банк нь банкны салбарын нийт хөрөнгийн 93 хувийг, нийт зээлийн 91 хувийг, харилцах хадгаламжийн 91 хувийг тус тус бүрдүүлж буй нь банкны салбарт томоохон байр суурийг эзэлж буйг илэрхийлж байна.

Байгууллагын зах зээлд тэргүүлэгч

Нийт банкны салбарын эх үүсвэрийн 66 хувийг иргэдийн харилцах, хадгаламж эзэлдэг бол 2021 оны байдлаар байгууллагын харилцах, хадгаламж нийт банкны салбарын харилцах, хадгаламжийн 34 хувийг эзэлж байна. 2021 оны жилийн эцсийн байдлаар байгууллагын харилцах, хадгаламж 9.8 их наяд төгрөгт хүрч өмнөх оны мөн үетэй харьцуулахад 3 хувиар өссөн. Үүнээс Үнэт цаас гаргагч нь байгууллагын зах зээлд тэргүүлж, банкны салбарын байгууллагын эх үүсвэрийн 22 хувийг дангаараа бүрдүүлж байна.

Банкны салбарын нийт хөрөнгийн 47 хувийг цэвэр зээл эзэлж байгаагаас байгууллагын зээл 51 хувийг эзэлж байна. 2021 оны жилийн эцсийн байдлаар байгууллагын зах зээлийн 17 хувийг Үнэт цаас гаргагч нь дангаар эзэлж буй нь байгууллагын зах зээл дэх тэргүүлэх байр суурийг бататгаж байна.

График 103. Үнэт цаас гаргагчийн байгууллагын зээлийн зах зээлд эзлэх хувь



График 104. Үнэт цаас гаргагчийн байгууллагын харилцах, хадгаламжийн зах зээлд эзлэх хувь



Эх сурвалж: Монголбанк, Голомт банкны МБ-д тайлагнасан 2021 оны жилийн эцсийн тайлан

Иргэдийн банкны зах зээлд гол тоглогч

Банкны салбарын эх үүсвэрийн 66 хувийг иргэдийн харилцах, хадгаламж бүрдүүлж байна. 2021 оны жилийн эцсийн байдлаар нийт иргэдээс татсан эх үүсвэр 19.0 их наяд төгрөгт хүрч өмнөх оны мөн үетэй харьцуулахад 13 хувиар өссөн. Үүнээс Үнэт



цаас гаргагч нь 17 хувийг дангаараа бүрдүүлсэн нь иргэдийн банкны зах зээлд гол тоглогч болохыг илтгэж байна.

2021 оны жилийн эцсийн байдлаар банкны салбарын иргэдэд олгосон зээлийн үлдэгдэл өмнөх оны мөн үеэс 22 хувиар өсч, 10.4 их наяд төгрөгт хүрсэн. Үүнээс Үнэт цаас гаргагчийн иргэдэд олгосон зээлийн үлдэгдэл иргэдийн зээлийн зах зээлийн 15.3 хувийг дангаараа бүрдүүлж байна.

Голомт банк нь орон сууцны зах зээл дэх тэргүүлэгч банк юм. 2021 оны жилийн эцсийн байдлаар банкны системийн хэмжээн дэх орон сууцны зээлийн 24.4 хувийг бүрдүүлж тэргүүлж байна.

График 105. Үнэт цаас гаргагчийн иргэдийн эх үүсвэрийн зах зээлд эзлэх хувь




График 106. Үнэт цаас гаргагчийн иргэдийн зээлийн зах зээлд эзлэх хувь



График 107. Үнэт цаас гаргагчийн орон сууцны зээлийн зах зээлд эзлэх хувь



Эх сурвалж: Монголбанк, Голомт банкны МБ-д тайлагнасан тайлан

Санхүүгийн үзүүлэлт

Нийт хөрөнгө (актив)

2017-2021 онд Үнэт цаас гаргагчийн нийт хөрөнгө жилд дунджаар 11 хувиар өссөн. Тус хугацаанд Хаан банкны нийт хөрөнгө 17 хувиар, Худалдаа Хөгжлийн банк 9 хувиар, Төрийн банк 13 хувиар, Хас банк 4 хувиар тус тус өссөн байна. Энэ нь системийн нөлөө бүхий бусад банкуудтай харьцуулахад Голомт банкны нийт хөрөнгө ижил түвшинд өссөн болохыг илтгэж байна.

2017-2021 онд Үнэт цаас гаргагчийн цэвэр зээл жилд дунджаар 10 хувиар өссөн. Энэ нь системийн нөлөө бүхий бусад банкны дундаж өсөлтийн хувьтай ижил түвшинд байна.



График 108. Топ-5 банкны хөрөнгийн өсөлт



График 109. Топ-5 банкны цэвэр зээлийн өсөлт



Эх сурвалж: Банкуудын тайлан

Нийт өр төлбөр ба өөрийн хөрөнгө (пассив)

2017-2021 онд Үнэт цаас гаргагчийн харилцах, хадгаламж жилд дунджаар 12 хувиар өссөн байна. Тус хугацаанд системийн нөлөө бүхий банкуудын харилцах, хадгаламж жилд дунджаар 18 хувиар өссөн байна.

Системийн нөлөө бүхий банкуудын өөрийн хөрөнгө 2017-2021 онд жилд дунджаар 4-18 хувиар өссөн. Тайлант хугацаанд Үнэт цаас гаргагчийн өөрийн хөрөнгө жилд дунджаар 14 хувиар өсч, 2021 оны жилийн эцсийн байдлаар 659 тэрбум төгрөгт хүрсэн байна.

График 110. Нийт харилцах хадгаламж, өсөлт



График 111. Өөрийн хөрөнгө, өсөлт



Ашигт ажиллагаа

2017-2021 онд Үнэт цаас гаргагчийн хүүгийн орлого системийн нөлөө бүхий банкуудын дундаж өсөлттэй харьцуулахад өндөр өсөлтийг бий болгосон байна. Тодруулбал, тус хугацаанд системийн нөлөө бүхий банкуудын хүүгийн орлого хамгийн ихдээ 9 хувь, дунджаар 5 хувиар өссөн бол Үнэт цаас гаргагчийн хувьд 8 хувиар өссөн нь дундаж өсөлтөөс 1.6 дахин өндөр өсөлт юм. Зээлийн багцын хэмжээ, зээлийн бодлогоос хамаарч банкуудын эрсдэлийн сангийн зардал харилцан адилгүй байдаг тул эрсдэлийн сангийн өмнөх үйл ажиллагааны ашгийн хэмжээгээр банкуудын үйл ажиллагааны ашигт ажиллагааг харьцуулан авч үзвэл үнэт цаас гаргагч нь 2017-2021 онуудад дунджаар 46 хувиар өсч өсөлтийн түвшингээр хоёрт эрэмбэлэгдэж байна.

График 112. Хүүгийн орлого, өсөлт



График 113. Эрсдэлийн сангийн зардлын өмнөх үйл ажиллагааны ашиг



Эх сурвалж: Банкуудын тайлан

Банкуудын цэвэр ашгийн хэмжээгээр Хаан банк, Худалдаа Хөгжлийн банк тэргүүлж байгаа бол 2017-2021 онуудын цэвэр ашгийн өсөлтөөр Үнэт цаас гаргагч тэргүүлж байна. Тодруулбал, тус хугацаанд үнэт цаас гаргагчийн цэвэр ашгийн хэмжээ жилд дунджаар 57 хувиар өссөн бол, Төрийн банк 39 хувиар, Хас банк 39 хувиар, Хаан банк 20 хувиар, Худалдаа Хөгжлийн банк 9 хувиар тус тус өссөн үзүүлэлттэй байна.



График 114. Банкуудын цэвэр ашиг, ашгийн өсөлт



Эх сурвалж: Банкуудын тайлан

Зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүд

Банкны системийн найдвартай, тасралтгүй ажиллагааг хангахын тулд Монголбанкнаас арилжааны банкуудад зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүдийг мөрдүүлж, хяналт тавин ажилладаг. 2021 оны жилийн эцсийн байдлаар системийн нөлөө бүхий банкууд бүгд Монголбанкны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг хангаж ажилласан байна.

Хүснэгт 36. Зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүд

Зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүд	Байвал зохих	Голомт банк	Хаан банк	ХХБ	Хас банк	Төрийн банк
Нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө болон эрсдэлээр жигнэсэн активын зохистой харьцаа	> 9%	15.0%	15.6%	13.0%	17.4%	15.5%
Өөрийн хөрөнгө болон эрсдэлээр жигнэсэн активын зохистой харьцаа	>12%	15.4%	15.6%	13.0%	17.4%	15.5%
Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын үзүүлэлт	>20%	41.1%	46.9%	40.6%	44.3%	31.7%
Гадаад валютын нээлттэй позиц болон өөрийн хөрөнгийн харьцаа (нэгж валютаар)	<±15%	10.0%	-1.9%	-10.5%	-1.1%	9.5%
Гадаад валютын нээлттэй позиц болон өөрийн хөрөнгийн харьцаа (нийт)	<±30%	12.6%	-2.2%	-15.3%	-2.2%	10.8%



Эх сурвалж: Банкуудын вебсайт

4.4 Монгол Улсын банкны салбарын хэтийн төлөв, багтаамж


Банкны салбарын хэтийн төлөв, чиг хандлага

Монгол Улсын банкны салбар өсөх потенциал өндөр байна

Монгол Улс зах зээлийн тогтолцоонд шилжсэнээс хойш банкны салбар эдийн засгийн мөчлөгийн олон үе шатыг амжилттай давж, 2021 оны жилийн эцсийн байдлаар банкны салбарын нийт хөрөнгийн хэмжээ Монгол Улсын нийт ДНБ-ний 95 хувийг эзэлж байна.

2020 оны байдлаар банкны салбарын нийт хөрөнгийн ДНБ-д эзлэх хувь БНХАУ болон Австрали улсад 300 орчим, Япон улсад 200 орчим, АНУ болон Европт 100 орчим хувь байна. Энэ нь Монгол Улс дэлхийн хөгжингүй орнуудын жишгийг даган хөгжихөд одоогийн байгаа түвшнээс 1.1-3.5 дахин тэлэх потенциалтайг харуулж байна.

График 115. Банкны нийт активын ДНБ-д эзлэх хувь



Эх сурвалж: АНУ-ын Хадгаламжийн даатгалын корпорац, Европын Төв банк, БНХАУ-ын Банк, даатгалын салбарыг зохицуулах хороо, Япон улсын Төв банк, Австралийн статистикийн товчоо, Монголбанк

Цар тахлын нөлөөлөл ба бодлогын дэмжлэгээс үүдэн банкны салбар өсөх хүлээлттэй байна

Ковид-19 цар тахалтай холбоотойгоор хил гаалийн хэвийн ажиллагаа алдагдсан, хөл хорионы улмаас ажил эрхлэлт буурсан, ажилгүйдлийн түвшин нэмэгдсэн зэрэг сөрөг нөлөө нь банкны салбарт зээлийн чанаргүйдлийн түвшинг нэмэгдүүлэх, зээл олголтыг хумих, ашигт ажиллагааг бууруулах, цаашлаад эдийн засгийн идэвхжил сулрах зэрэг эрсдэлийг бий болгосон. Иймд Монголбанк болон Засгийн Газрын зүгээс тухай бүр макро зохистой бодлогыг авч хэрэгжүүлж байна.



Монголбанк нь цар тахлын сөрөг нөлөөг хязгаарлах, санхүүгийн тогтвортой байдлыг хангах, эдийн засгийн идэвхжлийг дэмжих зорилгоор дараах арга хэмжээг хэрэгжүүлж байна. Үүнд:

- Бодлогын хүүг 6 хувь хүртэл бууруулах замаар мөнгөний зөөлөн бодлого хэрэгжүүлсэн.
- Төгрөгийн заавал байлгах нөөцийг 4.5 нэгж хувиар буулгаж 6 хувь болгож бууруулсан.
- 2022 он дуустал цар тахлын нөхцөл байдлын улмаас доголдсон хэрэглээний зээлийн хугацааг 12 хүртэлх сараар сунгах боломжийг олгов.
- Орон сууцны ипотекийн зээлийн хүү болон үндсэн төлбөрийг хойшлуулав.
- Активыг ангилах, активын эрсдэлийн сан байгуулж, зарцуулах журмын зарим зохицуулалтуудыг сулруулав.
- Банкны төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцааны шаардлагыг 25 хувиас 20 хувь болгож сулруулав.
- Банкны эрсдэл даах чадварыг хамгаалах зориулалт бүхий нөөц интервал бүрдүүлэх хугацааг 2022 оны 7-р сарын 1-ны өдөр (2 хувь) болгож хойшлуулав.

Монгол Улсын Засгийн газрын зүгээс эдийн засгийн сэргэлтийг түргэвчлэх зорилгоор иргэдийн вакцинжуулалтын арга хэмжээг цаг алдалдалгүй зохион байгуулж, 2021 оны эхний хагас жилийн байдлаар нийт хүн амын 66 хувийг II тунгийн вакцинжуулалтад хамруулсан байна.

Түүнчлэн Засгийн газрын 2021 оны 2-р сарын 17-ны өдрийн 42 дугаар тогтоолоор 2024 он хүртэл хэрэгжих Эрүүл мэндээ хамгаалж, эдийн засгаа сэргээх 10 их наядын цогц төлөвлөгөө батлагдаж, эдийн засагт дэмжлэг үзүүлж байна.

Дээрх арга, хэмжээ хөтөлбөрийг тогтвортой хэрэгжүүлж, банкны салбарт төвлөрсөн эх үүсвэрийг тасралтгүй эргэлдүүлэх нь банкуудыг эрсдэхээс сэргийлэх чухал ач холбогдолтой. Түүнчлэн экспортыг дэмжих, хөгжлийн томоохон төслүүдийг эрчимжүүлэх, Монгол Улсын Хөгжлийн банкны үйл ажиллагааг сайжруулах, улмаар ажлын байрыг нэмэгдүүлэх зорилго бүхий Цар тахлын үеийн эдийн засгийг сэргээх хууль нь дотоодын эдийн засаг болоод банкны салбарт сэргэлтийг авчрах хүлээлттэй байна.

Эдийн засгийн өсөлтөөс үүдэж зээлийн эрэлт нэмэгдэх төлөвтэй байна

Банкны салбар нь эдийн засгийн өсөлтийг бий болгоход чухал нөлөө үзүүлэгч санхүүгийн системийн тулгуур салбар юм. 2011-2020 онд ДНБ-ний өсөлт, банкны салбарын зээлийн өсөлтийн өгөгдлийг шинжилж үзэхэд 77 хувийн эерэг хамааралтай гарсан нь эдийн засгийн өсөлт болон банкны зээлийн өсөлт нь өндөр хамааралтай болохыг илтгэж байна. Тодруулбал, эдийн засгийн өсөлт саарсан



хугацаанд буюу 2014-2015 болон 2020 онд банкны зээлийн хэмжээ мэдэгдэхүйц хэмжээгээр буурсан байна.

График 116. Эдийн засгийн өсөлт болон зээлийн хамаарал



Эх сурвалж: Үндэсний Статистикийн Хороо, Шинжээчийн тооцоолол

2020 онд Ковид-19 цар тахлын нөхцөл байдлаас үүдэн Монгол Улсын эдийн засаг 4.6 хувиар агшсан ч 2021 оны байдлаар гадаад худалдааны таатай нөхцөл, экспортын эрэлтийн өсөлтөөс үүдэн эдийн засаг аажмаар сэргэж байна.

Дунд хугацаанд цар тахлын эрсдэлт нөхцөл байдал сайжирч, дэлхийн эдийн засгийн сэргэлтүүдээс үүдэн Монгол Улсын эдийн засгийн өсөлт хурдасч, АХБ, ОУВС, Дэлхийн банкны шинжээчдийн зүгээс 2021 онд Монгол Улсын эдийн засаг дунджаар 4.8 хувиар, 2022 онд 6.2 хувиар өснө гэж таамаглаж байна.

Хөгжиж буй эдийн засагтай Монгол Улсын хувьд эдийн засгийн өсөлт нь зээлийн эрэлтэд шууд нөлөөлдөг тул дунд хугацаанд банкны салбарын зээлийн эрэлт нэмэгдэж, орлого өсөх хандлагатай байна.

Дижитал шилжилт хурдасч, дижитал бүтээгдэхүүний эрэлт нэмэгдсээр байна

Дэлхий дахинд тулгамдаад буй Ковид-19 цар тахал нь дижитал шилжилтийн үйл явцыг хурдасгалаа. Энэ нь банкуудын цаашдын стратегид хүчтэй нөлөөлж, ажилчдыг зайнаас ажиллуулах, харилцагчдад хүргэх хөдөлгөөнт банкны үйлчилгээг эрчимжүүлэх техникийн нөхцөлийг бүрдүүлэх, гамшгийн менежмент буюу давагдашгүй хүчин зүйлийн тохиолдолд банкны удирдлагыг зохион байгуулах зэрэг олон сорилтыг бий болгосон.



Тодруулбал, McKinsey компанийн судалгаагаар цар тахлаас үүдэлтэйгээр олон улсын хэмжээнд банкуудын 60 хувь нь биет салбарыг хааж, ажиллах цагыг богиносгож, дижитал сувгаар үйлчилгээ үзүүлж эхэлсэн байна. Техник, технологийн хурдацтай өсөлтөөс үүдэн банкны харилцагчдын зан төлөв хэрэглээнд өөрчлөлт гарч олон төрлийн үйлчилгээг нэг дороос авах хандлагатай болсон нь хүртээмжтэй үйлчилгээ санал болгож буй банк санхүүгийн байгууллага нь зах зээлд тэргүүлэх хандлагыг үүсгэх төлөвтэй байна.

Монгол Улсын хувьд 2021 жилийн эцсийн байдлаар хөдөлгөөнт банк буюу цахим хуудас, гар утасны аппликейшн, мобайл хандалт, телефон банкны үйлчилгээг ашиглан хийгдсэн гүйлгээний дүн өмнөх оны мөн үеэс 74 хувиар өсөж 61.1 их наяд төгрөгт, гүйлгээний тоо өмнөх оны мөн үеэс 60.0 хувиар өсөж 172.4 сая ширхэгт хүрсэн.

2021 оны жилийн эцсийн байдлаар нийт 3.2 сая интернэт хандалтын эрхтэй хэрэглэгч байгаа нь өмнөх оны мөн үеэс 23 хувиар өссөн үзүүлэлт юм. Түүнчлэн 3 ба түүнээс дээш удаа гүйлгээ хийдэг идэвхтэй хэрэглэгчийн тоо өмнөх оны мөн үеэс 31 хувиар өсч 1.7 саяд хүрсэн.

Ковид-19 цар тахлын улмаас Монгол Улсын хэмжээнд хатуу хөл хорио тогтоосон нь 2021 оны жилийн эцсийн бэлэн бус гүйлгээний тоо өмнөх оны мөн үеэс 41 хувиар, бэлэн гүйлгээ өмнөх оны мөн үеэс 0.4 хувиар буурахад нөлөөлсөн гол хүчин зүйл болсон.

Бэлэн бус төлбөрийн хэрэгслийн хэрэглээ 2017 оноос хойш тасралтгүй нэмэгдэж, бэлэн бус төлбөр 2017 онд нийт картын гүйлгээний тооны 73.7 хувийг эзэлж байсан бол 2021 оны жилийн эцсийн байдлаар 88.0 хувьд хүрсэн. Тус хугацаанд бэлэн мөнгөний хэрэглээ 26.3 хувиас 12.0 хувь болж буурсан байна.

Ковид-19 цар тахлаас үүдсэн хөл хорионы нөлөөгөөр дижитал шилжилт түргэссэн нь цаашид ч хөдөлгөөнт банк болон төлбөрийн системийн үйлчилгээ өсөх, бэлэн гүйлгээний хэрэглээ буурч, бэлэн бус гүйлгээний хэрэглээ нэмэгдэх хандлагыг илэрхийлж байна.

Түүнчлэн банкны харилцагчдын зан төлөвт өөрчлөлт орж, дижитал хэрэглээ өссөнөөр цаашид банкны үйл ажиллагаанд дижитал шилжилт эрчимжих төлөвтэй байна.


Байгаль орчин, нийгэм эдийн засагт эерэг нөлөөтэй төслийг санхүүжүүлэх ногоон зээлийн бүтээгдэхүүн эрчимжих төлөвтэй байна

Дэлхий дахинд тулгамдаж буй уур амьсгалын өөрчлөлт, байгаль орчны асуудлаас үүдэн ногоон зээлийн бүтээгдэхүүнүүд санхүүгийн салбарт хурдацтай өсөж байна.



Олон улсын банкны салбарын ногоон зээл олголт 2017 оноос хойш хурдацтай өсөж байсан ч 2020 оны цар тахлын нөхцөл байдлаас үүдэн буурч 16.7 тэрбум ам.долларт хүрсэн. Харин 2021 оноос эхлэн сэргэж, зээл олголт эргэн нэмэгдэх төлөвтэй байна. 2021 оны байдлаар банкны салбарын ногоон зээлийн үлдэгдэл 256.0 тэрбум төгрөгт хүрч, нийт зээлийн 0.3 хувийг бүрдүүлж байна.

График 117. Нийт олгосон ногоон зээлийн хэмжээ /тэрбум ам.доллар/, олон улс



Эх сурвалж: Greenfinanceportal

Сүүлийн жилүүдэд уур амьсгалын огцом өөрчлөлт, орлогын тэгш бус хувиарлалт, арьс өнгөний ялгаварлал зэрэг олон нийгмийн асуудлууд гарч байгаа нь банкуудыг үйл ажиллагаандаа байгаль орчин, нийгэм, эдийн засгийн асуудлыг авч үзэхээс өөр аргагүй байдалд хүргээд байгааг McKinsey зөвлөх үйлчилгээний байгууллагаас онцолсон.

Тухайлбал, байгаль орчин, нийгэм эдийн засгийн хүчин зүйлүүд нь өөрийн хөрөнгийн өгөөжтэй эерэг хамааралтай байгааг онцолж, банкууд өөрсдийн харилцан хамаарал бүхий экосистемийг тодорхойлж, харилцагчдад учирч болох эрсдэлийг тооцоолон тухайн эрсдэлийг бууруулахад хувь нэмрээ оруулснаар өрсөлдөөний давуу талыг бий болгох боломжтой талаар дурдсан байна.

Банкны салбарын багтаамж

Хүснэгт 37. Банкны салбарын голлох үзүүлэлтүүдийн таамаглал /тэрбум төгрөг/

Үзүүлэлт	2021	2022Т	2023Т	2024Т	2025Т	2026Т
Нийт хөрөнгө	41,012	43,690	47,044	51,294	55,962	60,871
Зээл	21,205	23,578	24,785	26,209	27,709	29,362
Харилцах, хадгаламж	28,860	29,654	32,144	35,234	38,678	42,310

Эх сурвалж: Үнэт цаас гаргагчийн тооцоолол



2010 оноос хойших банкны салбарын түүхэн үзүүлэлтүүд, ирээдүйн эдийн засгийн голлох төсөл хөтөлбөрүүд, эдийн засгийн нөхцөл байдал, түүхий эдийн үнэ зэрэгт үндэслэн банкны салбарын голлох үзүүлэлтийг дунд хугацаанд тодорхойллоо. Дунд хугацааны төсөөлөл нь дараах голлох таамаглалуудад үндэслэсэн. Үүнд:

Оюутолгой гүний уурхайн төсөл хөтөлбөрийн нөлөө: Оюутолгой гүний уурхайн төсөл нь Монгол улсын ДНБ-нд шууд нөлөөлж байдаг. Тодруулбал, Монгол улсын нийт экспортын 25-30 хувийг Оюутолгойн зэсийн экспорт эзэлж байна. Иймд, 2022-2023 онд Оюутолгой гүний уурхайн бүтээн байгуулалт нь гадаадын шууд хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлж эдийн засгийн өсөлтийг дэмжинэ гэж тооцсон.

Дэлхийн зах зээл дээрх түүхий эдийн үнийн хэтийн төлөв: Фитч агентлаг болон Кэй Пи Эм Жи олон улсын судалгааны байгууллагуудаас гаргасан 2026 он хүртэлх зэс болон нүүрсний үнийн хэтийн төлөв дээр суурилсан түүхий эдийн үнийн өсөлт нь уул уурхайн түүхий эдийн экспортод эерэг нөлөө үзүүлэх замаар өсөлтийг бий болгоно гэж тооцсон.

Гадаад өрийн эргэн төлөлт: Монгол улсын засгийн газрын гадаад өрийн эргэн төлөгдөх хугацаа, түүнээс үүдэх их хэмжээний гадаад валютын гарах урсгал зэрэгт үндэслэн банкны салбарт үзүүлэх сөрөг нөлөөг тооцоололд авч үзсэн.

Цар тахлын нөхцөл байдал: Дэлхийн банкнаас гаргасан дэлхийн эдийн засгийн төлөв байдлын судалгаанд үндэслэн цар тахлын нөхцөл байдлаас үүдэн 2022 онд банкны салбарын өсөлт буурах бол 2023 оноос эхлэн цар тахлын нөхцөл байдал сайжирч аажмаар өснө гэж таамагласан.

Тавантолгой төмөр замын бүтээн байгуулалт: Тавантолгой төмөр замын бүтээн байгуулалт нь 2022 он хүртэл гадаадын шууд хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлж, 2023 оноос эхлэн тээвэр, логистикийн дэд бүтцийг сайжруулж нүүрс болон бусад түүхий эдийн тээвэрлэлтийг нэмэгдүүлэх төлөвтэй байна.

Дээрх таамаглалаас дүгнээд Монгол Улсын банкны салбарын нийт хөрөнгө 2021-2026 онд дунджаар 4.9 хувиар өсөж 51.3 их наяд төгрөгт, зээлийн хэмжээ дунджаар 7.7 хувиар өсөж, 29.2 их наяд төгрөгт, харилцах, хадгаламжийн хэмжээ дунджаар 7.7 хувиар өсөж 42.3 их наяд төгрөгт хүрэх хүлээлттэй байна.



4.5 Дунд хугацааны стратеги, бизнес төлөвлөгөө

Үнэт цаас гаргагч нь хувьсан өөрчлөгдөж буй харилцагчдын хэрэгцээ шаардлага, хурдацтай хөгжиж буй техник технологийн дэвшил, дэлхий даяарх дижитал шилжилтэд нийцүүлэн бүтээгдэхүүн үйлчилгээний хөгжүүлэлтийг нэвтрүүлж, Дэлхийн жишиг Монголын банк болохоор зорин ажиллаж байна.

Тус зорилтын хүрээнд Үнэт цаас гаргагч нь харилцагч төвтэй банк стратегийг үргэлжлүүлэн хэрэгжүүлж, үйл ажиллагааны нэгдсэн удирдлагын тогтолцоог сайжруулж, тогтвортой хөгжлийн бодлогыг зарчим болгон ажиллана. Үнэт цаас гаргагч нь дунд хугацааны бизнес төлөвлөгөөнд өрсөлдөөний давуу тал бий болгох дараах гол зорилтуудыг тодорхойлсон. Үүнд:

- Банкны бизнесийн үйл ажиллагааны бүтээмжийг сайжруулах, дижитал шилжилтийг эрчимжүүлэх;
- Актив, пассивын оновчтой бүтцийг барих, төлбөрийн чадварын харьцааг үр ашигт хэмжээнд барих;
- Зээлийн судалгааны чанар, процессыг сайжруулж, шийдвэр гаргалтыг мэргэжлийн өндөр түвшинд байлган зээлийн багцын чанарыг сайжруулах;
- Банкны бүтээгдэхүүн, үйлчилгээний үр ашиг, хүртээмжийг дээшлүүлж, чанарыг сайжруулахад төвлөрөх, шинийг санаачлагч түүчээлэгч байх;
- Харилцагчийн санхүүгийн боловсролыг дээшлүүлэх, санхүүгийн зөв зуршилд сургах, хөдөлмөрийн зах зээлд жишиг ажил олгогч байх;
- Байгаль орчинг хамгаалах, ногоон хөгжлийг дэмжихэд чиглэсэн тогтвортой хөгжлийн бодлого, үйл ажиллагаагаар тэргүүлэгч банк байх.

Дээрх дунд хугацааны бизнес төлөвлөгөөг амжилттай хэрэгжүүлснээр Үнэт цаас гаргагч нь үйл ажиллагааны үр ашгийг нэмэгдүүлж, өрсөлдөөний давуу талыг бий болгох боломжтой.

Үнэт цаас гаргагч нь хувьцаагаа анх удаа нийтэд санал болгон анхдагч зах зээлд арилжаалах замаар татан төвлөрүүлсэн хөрөнгөөр өөрийн хөрөнгөө нэмэгдүүлж, зээл болон активаа нэмэгдүүлэх боломж бүрдүүлэх юм. Банкны өөрийн хөрөнгийн хэмжээ 103 тэрбум төгрөгөөр нэмэгдсэнээр зээл зэрэг эрсдэлээр жинлэсэн активаа 790 гаруй тэрбум төгрөгөөр нэмэгдүүлэх боломж бий болох бөгөөд Банкны менежментийн багийн төлөвлөгөөний дагуу ийнхүү активын хэмжээг нэмэгдүүлэх нь ашигт ажиллагааг нэмэгдүүлж, цаашид өөрийн хөрөнгийн өгөөжийг нэмэгдүүлэхээр төсөөлсөн байна.

Банкны үндсэн орлогын эх үүсвэр болох зээлийн багцыг нэмэгдүүлэх санхүүжилтийг шийдвэрлэж, тус эх үүсвэрийг оновчтой байршуулах үйл ажиллагааны бодлогыг хэрэгжүүлснээр Үнэт цаас гаргагч нь дунд хугацаанд зах зээлд эзлэх байр суурийг тэлж, үйл ажиллагааг өргөжүүлнэ.



Банкны бизнесийн үйл ажиллагааны бүтээмжийг сайжруулах, дижитал шилжилтийг эрчимжүүлэх

Техник, технологийн өндөр дэвшил, хүмүүсийн амьдралын хэв маяг, гар утасны хэрэглээ, цар тахлын нөхцөл байдал зэргээс үүдэн эдийн засгийн бүхий л салбаруудад дижитал шилжилт явагдаж байна. Санхүүгийн салбарт техникийн шинэчлэлийг хослуулах замаар санхүүгийн үйлчилгээг хүргэх финтек санхүүгийн байгууллагууд хурдацтай нэмэгдэж байна.

Үнэт цаас гаргагч нь үүссэн нөхцөл байдлыг үнэлж, түүхэн хугацаанд дижитал банкны үйлчилгээг зах зээлд нэвтрүүлж анхдагч болсоор ирсэн. Цаашид, зах зээлд тэргүүлэх байр сууриа хадгалах, дижитал шилжилтийн хурдтай хөл нийлүүлэн бүтээгдэхүүн үйлчилгээний хөгжүүлэлтийг хийж, харилцагчдад орчин үеийн техник технологийн давуу талыг ашиглах боломж олгож тэдгээрийн цаг завьг хэмнэх, хялбар хэрэглээг бий болгох зорилгоор дараах стратегийг хэрэгжүүлнэ. Үүнд:

Дижитал банк, дижитал бүтээгдэхүүн үйлчилгээгээр тэргүүлэх

- Дижитал шилжилтийн гол технологиуд болох их өгөгдөл, хиймэл оюун ухаанд суурилсан интернет банк, смарт банк болон бусад дижитал бүтээгдэхүүн, үйлчилгээг тогтмол сайжруулна. Харилцагчийн зан төлөвт суурилсан бүтээгдэхүүн үйлчилгээ, шинэлэг, уян хатан сонголтыг олгодог түүчээлэгч байр суурийг хадгална.
- Дижитал салбарын хэрэглээ, шийдлийг гуравдагч байгууллагатай хамтран хэрэгжүүлж биет үйлчилгээний цэгийн тоог нэмэгдүүлснээр харилцагчдын үнэт цагийг хэмнэнэ.
- Дижитал сувгийн үнийн ялгаатай байдлыг бий болгож, харилцагчид энгийн хялбар, зардал цаг хугацааг хэмнэсэн, гэр бүлийн гишүүдийн бүхий л хэрэгцээг нэг дор хангах шийдлүүдийг санал болгох замаар харилцагчдын сэтгэл ханамжийг нэмэгдүүлж, дижитал сувгийн харилцагчдын бааз суурийг өргөжүүлнэ.
- SocialPay аппликейшний илүү уян хатан, шинэлэг боломжуудыг агуулсан шинэчилсэн хувилбарыг нэвтрүүлнэ.

Нээлттэй банкны (Open banking) үйлчилгээгээр тэргүүлэх

- Финтек болон технологид суурилсан бизнесүүдтэй хамтран харилцагчдын өдөр тутмын төлбөр тооцоо болон банкны бусад бүтээгдэхүүн, үйлчилгээг энгийн, хурдан, хялбар байдлаар шийдэх боломжтой Retail Gateway хөгжүүлж, хамтран ажиллана.



- Платформ бизнесийн загвар хурдацтай хөгжиж байгаатай уялдуулан онлайн худалдааны платформ, маркет-плейс платформуудтай хамтран банкны үйлчилгээ авах шийдлүүдийг нэвтрүүлнэ.

Дижитал шилжилтийг бүх төрлийн харилцагчтай хамтран хэрэгжүүлэх

- Хамтын ажиллагааг сайжруулж, байгууллагын санхүүгийн хэрэгцээг хангах, үйл ажиллагааны бүтээмжийг нэмэгдүүлэхээс гадна тухайн байгууллагын ажилчдын санхүүгийн хэрэгцээг нэг дор хангасан дэвшилтэт шийдлийг нэвтрүүлнэ.
- Тогтвортой санхүүжилтийг хэрэгжүүлэгч банкны хүрээнд байгаль орчинд ээлтэй технологид суурилсан бүтээгдэхүүн үйлчилгээг нэвтрүүлнэ.
- SocialPay банкны платформын хэрэглээг байгууллагын хэрэгцээ шаардлагад нийцүүлэн илүү төгөлдөржүүлнэ.
- Хамтарсан лоялти хөтөлбөр, гуравдагч байгууллагуудын лоялтиг нэгтгэх зэрэг шинэлэг үйлчилгээг нэвтрүүлнэ.

Зээлийн судалгааны чанар, процессыг сайжруулж, шийдвэр гаргалтыг мэргэжлийн түвшинд гүйцэтгэж зээлийн багцын чанарыг сайжруулах

Үнэт цаас гаргагчийн ашигт ажиллагаа, санхүүгийн тогтвортой байдал нь зээлийн багцын чанартай салшгүй холбоотой байдаг. Иймд дунд хугацаанд Үнэт цаас гаргагч нь чанартай, тогтвортой, үр ашигт зээлийн багц бүрдүүлэх, зээлийн үйл ажиллагааны оновчтой бодлогыг баримтлах, уян хатан системийг хөгжүүлэх, тасралтгүй сайжруулах зорилтын хүрээнд дараах багц ажлуудыг авч хэрэгжүүлнэ. Үүнд:

- Зээлийн багцын чанарыг зорилтод түвшинд барих, зээлийн судалгааны скоринг болон рейтингийн моделийг техник технологийн шинэчлэлтэд үндэслэн тогтмол сайжруулна.
- Зээл олгох процессыг тасралтгүй сайжруулж, мэдээллийн технологийн шинэлэг технологиуд болох хиймэл оюун ухаан, машин сургалт, роботик процесс автоматжуулалт, процессын оновчтой загварчлал, шийдэл зэргийг ашиглан зээлийн шийдвэр гаргалтын хурдыг нэмэгдүүлж, харилцагчдад илүү хурдан хугацаанд, хялбар байдлаар зээл авах боломжийг бүрдүүлнэ.
- Дижитал зээлийн бүтээгдэхүүний сувгийг тэлж, дижитал зээл олголтыг нэмэгдүүлнэ.
- Харилцагчийн зан төлөвт суурилсан зээлийн автомат скорингийн шийдлийг сайжруулснаар онлайн зээлийн үйлчилгээг улам төгөлдөржүүлнэ.
- ААН, иргэдийн санхүүгийн хэрэгцээг хангах, бизнесийн тасралтгүй байдлыг хангах, үйл ажиллагааг өргөжин тэлэхэд санхүүжилтийн эх үүсвэрийг түлхүү олгож, хамтран ажиллана.



Банкны бүтээгдэхүүн, үйлчилгээний үр ашиг, хүртээмжийг дээшлүүлж, чанарыг сайжруулахад төвлөрөх, шинийг санаачлагч түүчээлэгч байх

Үнэт цаас гаргагч нь харилцагчийн бүхий л сегмент (корпорэйт, жижиг дунд байгууллага болон иргэдийн сегмент) бүрийн хувьд банкны бүтээгдэхүүн үйлчилгээг нэгдсэн стандартын дагуу чанартай, үр ашигт байдлаар хүргэж, хүртээмжийг дээшлүүлж, урт хугацааны тогтвортой харилцааг бий болгож харилцагчийн зах зээлийн нэвчилтийг нэмэгдүүлэхээс гадна кросс борлуулалт, нийлүүлэлтийн гинжин хэлхээ, бизнес хоорондын синержи үүсгэх болон хүүгийн бус орлогыг нэмэгдүүлэх бүтээгдэхүүн үйлчилгээний хөгжүүлэлтийг хийхээр зорин ажиллана.

Төлбөр тооцооны бүтээгдэхүүн үйлчилгээ

Үнэт цаас гаргагч нь 1999 онд банкны салбарт анхны картын бүтээгдэхүүнийг нэвтрүүлсэн анхдагч банк юм. Түүхэн хугацаанд харилцагчдын хэрэгцээ шаардлагад нийцсэн картын бүтээгдэхүүнийг улам төрөлжүүлж, карт болон төлбөр тооцооны зах зээлд тэргүүлэх байр суурийг хадгалсаар ирсэн. Иймд дунд хугацаанд картын болон төлбөр тооцооны бизнест технологийн дэвшил, харилцагчдийн зан төлөвд үндэслэсэн бүтээгдэхүүн хөгжүүлэлтийг хийж тэргүүлэгч байр суурийг хадгалах зорилттой ажиллана. Үүнд:

- Харилцагчдын зан төлөв, сегментэд суурилсан картын тусгай болон багц бүтээгдэхүүн, урамшуулалт үйлчилгээг тасралтгүй санал болгоно.
- Лоялти үйлчилгээний төрөл, хэрэглээ, урамшууллын лоялти сүлжээг нэмэгдүүлнэ.
- QR, NFC Технологид суурилсан шинэ бүтээгдэхүүн үйлчилгээг нэвтрүүлнэ.
- Төлбөр тооцооны Wechat, Alipay, 9Pay зэрэг олон улсын төлбөр тооцоо болон дотоодын төлбөр тооцоо, мөнгөн шилжүүлгийг хялбаршуулах нэмэлт шийдлүүдийг нэвтрүүлнэ.

Үнэт цаас гаргагч нь олон улсын банкны санхүүгийн байгууллагын стандартын дагуу гадаадад байгаа харилцагчдад зориулсан бүтээгдэхүүн үйлчилгээг дунд хугацаанд дэлхийн жишигт нийцүүлэн хөгжүүлэх төлөвлөгөөтэй байна. Үүний үр дүнд гадаадад байгаа Монголчууд гадны банкны өндөр шимтгэлгүйгээр эх орноосоо мөнгөн шилжүүлэг хийх, хүлээн авах бүх төрлийн төлбөр тооцоог хийх боломжтой болно.

Зээлийн бүтээгдэхүүн үйлчилгээ

Зээлийн бүтээгдэхүүн нь Үнэт цаас гаргагчийн орлогыг бүрдүүлэгч үндсэн бүтээгдэхүүн юм. Үнэт цаас гаргагч нь сүүлийн жилүүдэд өөрийн хөрөнгийн хүрэлцээний хязгаарлалтын улмаас зээлийн багцыг төлөвлөгөөт түвшинд нэмэгдүүлэх нь хязгаарлагдмал байсан. Улмаар олон нийтэд нээлттэй хувьцаат



компани болж, өөрийн хөрөнгийг 103 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлснээр Монголбанкны шалгуур үзүүлэлтийг хангах түвшинд зээлийн багц 790 тэрбум төгрөгөөр нэмэгдэх боломжтой.

Түүнчлэн өөрийн хөрөнгийн хүрэлцээ сайжирснаар Үнэт цаас гаргагч нь зөвхөн зээлийн багцыг нэмэгдүүлэхээс гадна бизнесийг өргөжүүлж, баталгаа, батлан даалт, аккредитивын бүтээгдэхүүний хэмжээг өсгөн ашигт ажиллагааг нэмэгдүүлэх боломж бүрдэж байна.

Дунд хугацаанд Үнэт цаас гаргагч нь бизнесийн зээлийн өсөлтийг боловсруулах үйлдвэрлэл, худалдаа, барилга, бүтээн байгуулалт, эрүүл мэндийн салбарт бий болгож, ногоон зээлийн бүтээгдэхүүнийг эрчимжүүлэх төлөвлөгөөтэй байна. Түүнчлэн орон сууцны зээл болон харилцагчийн эрэлт хэрэгцээнд нийцсэн бусад хэрэглээний зээл олголтыг нэмэгдүүлнэ.

Харилцах, хадгаламжийн бүтээгдэхүүн үйлчилгээ

Банкны харилцах, хадгаламжийн хэмжээ нь харилцагчдын банканд итгэх итгэл, найдвартай байдлыг илтгэх гол үзүүлэлт юм. Харилцах, хадгаламжийн бүтээгдэхүүн нь зээлийн багцыг нэмэгдүүлэх үндсэн эх үүсвэр болж, цаашилбал банкны ашигт ажиллагаа, үйл ажиллагааны тогтвортой байдалд чухал нөлөө үзүүлдэг.

2021 оны жилийн эцсийн байдлаар Үнэт цаас гаргагчийн харилцах, хадгаламжийн хэмжээ 5.5 их наяд төгрөгт хүрсэн. Үнэт цаас гаргагч нь дунд хугацаанд харилцах хадгаламжийн бүтээгдэхүүнийг төрөлжүүлэх, зах зээлд эзлэх байр суурийг хадгалах, харилцагчийн мөнгөн хөрөнгийг үр ашигтай удирдах, хадгалах зорилттой ажиллана.

Гадаад худалдааны санхүүжилтийн үйлчилгээ

Үнэт цаас гаргагч нь үүсгэн байгуулагдсан цагаас хойш олон улсын нэр хүнд бүхий банк, санхүүгийн байгууллагуудтай хамтран ажиллаж урт хугацаат, өртөг багатай санхүүжилтийн эх үүсвэрийг татаж, харилцагчдад хямд өртөгтэй зээлийн бүтээгдэхүүнийг санал болгож, олон төрлийн төсөл хөтөлбөрийг санхүүжүүлсээр ирсэн. Үнэт цаас гаргагч нь дунд хугацаанд олон улсын банк, санхүүгийн байгууллагуудтай хамтын ажиллагааг тэлж, урт хугацаат санхүүжилт болон тогтвортой зээлийн шугамыг нэмэгдүүлэн ажиллахаар зорьж байна. Үүнд:

- Гадаадын банк санхүүгийн байгууллагад шинээр худалдааны санхүүжилтийн болон депозитын шугам, барьцаагүй зээлийн шугам батлуулах, өрсөлдөхүйц нөхцөлтэй шууд зээл татна.
- Монгол Улсын жижиг, дунд бизнесийг дэмжих, хөгжүүлэх болон байгаль орчинд ээлтэй төслүүдийг түлхүү дэмжих стратегийн ач холбогдол бүхий



төслүүдэд хөгжлийн санхүүжилтийн байгууллагаас өрсөлдөхүйц нөхцөлтэй зээлийн санхүүжилт татна.

- Гадны банканд шинээр ностро данс нээх замаар дотоодын зах зээлд эрэлт нэмэгдэх хандлагатай валютыг хэрэглээнд шинээр нэвтрүүлнэ.
- Ам.доллар болон еврогийн гадаад төлбөр тооцоог илүү өргөн сонголттойгоор хийгдэх боломжийг нэмэгдүүлнэ.
- Бизнесийн хэрэгцээ шаардлагад үндэслэн корреспондент банк, зээл, худалдааны санхүүжилт, арилжааны чиглэлээр шинэ банкуудтай харилцаа тогтоон хамтын ажиллагааны цар хүрээг улам тэлж ажиллана.

Валют, түүхий эдийн арилжааны бүтээгдэхүүн, үйлчилгээ

2017 оноос хойш Үнэт цаас гаргагч нь алт арилжааны зах зээлд тэргүүлэх байр суурийг эзэлж байна. Үнэт цаас гаргагч нь дунд хугацаанд алт арилжааны зах зээлд тэргүүлэгч байр суурийг хадгалах, алтны кассуудын үйл ажиллагааг сайжруулах, харилцагчдийг тогтмол судалгаа, мэдээллээр хангах үйл ажиллагааг авч хэрэгжүүлнэ.

Мөнгөний менежментийн дүрмийг сайжруулж, арилжаа бүрээс ашиг олох системийг сайжруулах замаар маржин арилжааны ашгийг нэмэгдүүлэх зорилттой ажиллана. Үнэт цаас гаргагч нь харилцагчдын бизнесийн өдөр тутмын үйл ажиллагаанд тулгарч буй ханшийн эрсдэл, зах зээлийн эрсдэлийг бууруулах зорилгоор хеджинг бүтээгдэхүүнийг зах зээлд санал болгож төрөлжүүлэх зорилттой байна.

Актив, пассивын оновчтой бүтцийг барих, төлбөрийн чадварын харьцааг үр ашигт хэмжээнд барих

2021 оны жилийн эцсийн байдлаар Үнэт цаас гаргагчийн харилцагчдаас татсан нийт эх үүсвэрийн 33 хувийг харилцах, 67 хувийг хадгаламж эзэлж байна. Харилцах дансанд байршиж буй эх үүсвэрийн эзлэх хувь өндөр байх нь банкны эх үүсвэрийн өртгийг бууруулахад ач холбогдолтой.

Цаашид Үнэт цаас гаргагч нь өртөг багатай эх үүсвэрийг нэмэгдүүлэх зорилгоор харилцах болон хугацаагүй хадгаламжийн бүтээгдэхүүнийг бусад санхүүгийн үйлчилгээтэй хослуулан амар хялбар байдлаар санхүүгийн бүтээгдэхүүн үйлчилгээг авах боломжийг олгох багц ажлыг хэрэгжүүлнэ.

Харилцагчийн санхүүгийн боловсролыг дээшлүүлэх, санхүүгийн зөв зуршилд сургах, хөдөлмөрийн зах зээлд жишиг ажил олгогч байх

Харилцагчийн санхүүгийн дархлааг нэмэгдүүлэх, санхүүгийн боловсрол олгох, санхүүгийн сахилга батыг бий болгох зорилтын хүрээнд Монгол Улсын иргэн бүрт



хуримтлал үүсгэх зуршлыг бий болгох хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлж, үндэсний хуримтлалын хөтөлбөрийг сайжруулах төлөвлөгөөтэй байна.

Байгаль орчинг хамгаалах, ногоон хөгжлийг дэмжихэд чиглэсэн тогтвортой хөгжлийн бодлого, үйл ажиллагаагаар тэргүүлэгч банк байх

Үнэт цаас гаргагч нь тогтвортой бизнесийн үйл ажиллагаа явуулах, нийгэм, байгаль орчны асуудлуудад хувь нэмрээ оруулах, сэтгэл ханамжтай ажлын байрыг бий болгох стратегийн хүрээнд үйл ажиллагаа явуулдаг. Тус стратегийн хүрээнд Голомт банк нь дунд хугацаанд дараах ажлыг хийж гүйцэтгэнэ. Үүнд:

- Голомт банкны зээлийн багцын түвшинд хүлэмжийн хийн ялгарлыг тооцоолох, жил бүр бууруулах зорилт тавин ажиллана.
- Ногоон зээлийн багцын хэмжээг жил бүр 5 хувиар нэмэгдүүлнэ. Үүнд харилцагчдын хэрэгцээнд нийцсэн, байгаль орчин, нийгмийн эерэг нөлөөтэй ногоон зээлийн бүтээгдэхүүнийг санал болгож, ногоон төсөл хөтөлбөрийн санхүүжилтийн боломжуудыг нэмэгдүүлнэ.
- Үнэт цаас гаргагч нь тогтвортой хөгжлийн санаачилгуудыг идэвхийлэн дэмжиж, хамтын ажиллагаагаа өргөжүүлэн НҮБ-ын Байгаль орчны хөтөлбөрийн Санхүүгийн санаачилгыг зарлан тунхагласан олон улсын анхдагч банкуудын нэг болсон. Иймд тус санаачилгыг Ази Номхон далайн бүс нутагт манлайлан хэрэгжүүлж, ногоон эдийн засгийг Монгол Улсад бэхжүүлэх чиглэлээр идэвхтэй ажиллана.
- Уур амьсгалын ногоон сангийн үндэсний итгэмжлэгдсэн байгууллагад элсэнэ.



4.6 Санхүүгийн төсөөлөл

Үнэт цаас гаргагч нь 2022-2026 оны буюу дунд хугацааны санхүүгийн төсөөллийг бизнес, бүтээгдэхүүн үйлчилгээний онцлог, эдийн засгийн хэтийн төлөв байдал, зах зээлийн нөхцөл байдал зэрэг хүчин зүйлст тулгуурлан Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартын дагуу боловсруулсан.

Банкны удирдлага ҮЦТ-д багтсан санхүүгийн мэдээллийг бэлтгэсэн бөгөөд энэхүү мэдээлэлтэй холбоотой үүргийг хүлээнэ. Мөн, энэхүү ҮЦТ-д тусгагдсан ирээдүйн төсөөллүүд нь таамаглал, үнэлгээнд суурилсан бөгөөд Хөрөнгө оруулагч нь тухайн төсөөллийн биелэлтэд өөрийн үнэлгээг хийж шийдвэрээ гаргах ёстой. Банкны СТОУС дагуу тайлагнасан санхүүгийн тайлангуудад ПрайсуотерхаусКуперс Аудит ХХК, мөн Мэдээлэл Аудит ХХК болон ПрайсуотерхаусКупер ХХН-ийн хамтарсан консорциум аудит хийж гүйцэтгэсэн бөгөөд ирээдүйн төсөөлөл, таамаглалуудтай холбоотойгоор ямар нэг аудит, нягтлах ажил болон аливаа ажилбар хийж гүйцэтгээгүй. Тиймээс, энэхүү танилцуулгад багтсан санхүүгийн ирээдүйн төсөөлөл, таамаглалуудтай холбоотойгоор ямар нэг дүгнэлт гаргаагүй.

Хөндлөнгийн үнэлгээний байгууллага болох Кэй Пи Эм Жи Аудит ХХК нь Үнэт цаас гаргагчийн бизнесийн үнэлгээг гүйцэтгэхдээ санхүүгийн төсөөллийг Монголбанкны тайлагналын стандартын дагуу боловсруулсан учир санхүүгийн байдлын төсөөлөл Үнэт цаас гаргагчийн СТОУС-аар бэлтгэсэн санхүүгийн байдлын төсөөллөөс бага зэрэг зөрж байгааг анхаарна уу.

Санхүүгийн байдлын тайлангийн төсөөлөл

Хүснэгт 38. Үнэт цаас гаргагчийн санхүүгийн байдлын тайлангийн төсөөлөл 2022-2026 /тэрбум төгрөг/

	2022Т	2023Т	2024Т	2025Т	2026Т
Бэлэн мөнгө, банкин дахь хөрөнгө	2,430.4	2,258.1	2,074.2	1,843.8	2,004.0
Хөрөнгө оруулалт	2,594.5	2,879.8	3,143.8	3,243.1	3,423.3
Цэвэр зээл	3,694.1	4,110.7	4,566.0	5,053.8	5,551.6
Бусад хөрөнгө	286.6	237.5	196.7	176.6	148.0
Үндсэн хөрөнгө	191.3	197.2	201.3	204.5	207.1
Нийт актив	9,196.9	9,683.4	10,181.9	10,521.7	11,334.0
Харилцах, хадгаламж	6,449.7	7,024.2	7,625.1	8,082.6	8,692.5
Банк, СБ-с татсан эх үүсвэр	1,846.6	1,631.6	1,402.3	1,159.4	1,234.1
Бусад өр төлбөр	107.0	115.3	123.9	130.8	139.7
Нийт өр төлбөр	8,403.4	8,771.1	9,151.3	9,372.8	10,066.2
Дүрмийн сан ба НТК	483.8	483.8	483.8	483.8	483.8
Хуримтлагдсан ашиг	301.7	420.7	539.2	664.7	780.3
Бусад ӨХ	8.0	7.8	7.6	0.4	3.7
Нийт өөрийн хөрөнгө	793.5	912.3	1,030.6	1,148.9	1,267.8
Нийт өр төлбөр ба өөрийн хөрөнгө	9,196.9	9,683.4	10,181.9	10,521.7	11,334.0



Эх сурвалж: Үнэт цаас гаргагчийн санхүүгийн төсөөлөл

Нийт хөрөнгө (актив)

2022-2026 онд Үнэт цаас гаргагчийн нийт хөрөнгө жилд дунджаар 5.4 хувиар өсч, 2026 оны эцэст 11.3 их наяд төгрөгт хүрэх төлөвтэй байна. Энэ нь 2017-2020 оны түүхэн жилийн нийлмэл өсөлтөөс 2.2 дахин бага үзүүлэлт юм. Үүнд цэвэр зээл жилд дунджаар 11 хувиар өсч нийт хөрөнгийн 49 хувийг, хөрөнгө оруулалт жилд дунджаар 7.2 хувиар өсч нийт хөрөнгийн 30 хувийг, мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө нийт хөрөнгийн 18 хувийг, үндсэн хөрөнгө болон бусад актив нийт хөрөнгийн 3 хувийг бүрдүүлэх төлөвтэй байна.

График 118. Үнэт цаас гаргагчийн нийт хөрөнгө, хөрөнгийн бүтэц /тэрбум төгрөг/



Эх сурвалж: Үнэт цаас гаргагчийн санхүүгийн төсөөлөл

Бэлэн мөнгө, бусад банкин дахь хөрөнгө

2021 оны байдлаар бэлэн мөнгө ба бусад банкин дахь хөрөнгө Үнэт цаас гаргагчийн нийт хөрөнгийн 25 хувийг эзэлж байсан бол 2026 онд 18 хувь болж буурч байна. Үүнд, 1-рт, Үнэт цаас гаргагчийн гадны банк, санхүүгийн байгууллагад байршуулсан томоохон дүнтэй урт хугацаат хадгаламжийн хугацаа дуусч, 2-рт, банкны актив, пассивын оновчтой бүтцийг барих, төлбөрийн чадварын харьцааг үр ашигт хэмжээнд барих дунд хугацааны төлөвлөгөөний дагуу бэлэн мөнгөний үлдэгдлийг үр ашигтай зохион байгуулснаар бэлэн мөнгө, банкин дахь хөрөнгийн хэмжээ буурч, 2026 онд 2.0 их наяд төгрөгт хүрэхээр байна.



Хөрөнгө оруулалт

Үнэт цаас гаргагч нь Монголбанкнаас гаргасан шалгуур үзүүлэлтийн дагуу нийт хөрөнгийн 20 орчим хувийг хөрөнгө оруулалтын зорилгоор үнэт цаасанд байршуулах боломжтой. Ирэх жилүүдэд нийт хөрөнгийн өсөлтөөс үүдэн хөрөнгө оруулалтын хэмжээ өсч 2026 онд үнэт цаасаарх хөрөнгө оруулалт 3.4 их наяд төгрөгт хүрэх төлөвтэй байна. Нийт хөрөнгө оруулалтын дийлэнх хувийг ТБҮЦ эзэлнэ.

Зээл

Эдийн засгийн өсөлт, зах зээлд эзлэх байр суурийн өсөлт, өөрийн хөрөнгийн өсөлтөөс хамаарч банкны бүтээгдэхүүн, үйлчилгээний үр ашиг, хүртээмжийг дээшлүүлж, чанарыг сайжруулахад төвлөрөх дунд хугацааны бизнес төлөвлөгөөний хүрээнд Үнэт цаас гаргагчийн зээлийн багц жилд дунджаар 10.7 хувиар өсөх төлөвтэй байна. Энэ нь өөрийн хөрөнгийн хязгаарлалттай байсан үе болох 2017-2020 оны түүхэн жилийн нийлмэл өсөлт болох 9.7 хувьтай харьцуулахад боломжит түвшин юм. Улмаар 2026 онд Үнэт цаас гаргагчийн зээлийн багц 5.6 их наяд төгрөгт хүрч, зах зээлийн 19.5 хувийг эзлэх төлөвтэй байна. Зээлийн багцын өсөлтийг бүтээгдэхүүн тус бүрээр задлан харуулбал дараах байдалтай байна. Үүнд:

Хүснэгт 39. Үнэт цаас гаргагчийн зээлийн багцын өсөлт 2022-2026

	2022Т	2023Т	2024Т	2025Т	2026Т
Бизнесийн зээл - Корпорейт ААН	10.8%	10.5%	10.7%	9.6%	9.2%
Бизнесийн зээл - ЖДҮ ААН, Иргэд	13.2%	12.3%	11.3%	11.1%	10.0%
Хэрэглээний зээл	11.6%	11.0%	10.6%	10.2%	9.2%
Орон сууцны зээл	12.3%	11.7%	10.9%	10.8%	9.5%
Нийт зээл	11.8%	11.3%	10.9%	10.3%	9.5%
Зах зээлд эзлэх хувь	16.9%	17.5%	18.0%	18.9%	19.5%

Эх сурвалж: Үнэт цаас гаргагчийн санхүүгийн төсөөлөл


2021 оны эцсийн байдлаар Үнэт цаас гаргагч нь 5.2 хувийн чанаргүй зээлийн түвшинтэй, үүнээс 88 хувийг хаах хэмжээний эрсдэлийн сан байгуулсан байсан. 2013 оноос хойш чанаргүйдсэн зээлүүд эрсдэлийн сангийн хүрээнд хаагдан дуусгавар болж байгаа, нөгөө талаас зээлийн бодлогын зохистой удирдлагыг хэрэгжүүлж, чанарын удирдлагыг сайжруулснаар шинээр олгох зээлийн чанаргүйдлийг бууруулах арга хэмжээ авч байгаа зэргээс үүдэн Үнэт цаас гаргагчийн зээлийн багцын чанаргүйдлийн түвшин 2026 онд 5.1 хувь болж буурах төлөвтэй байна.

Мөн Үнэт цаас гаргагч нь активын чанарын удирдлагыг сайжруулах зорилгоор, чанаргүй зээлд байгуулах эрсдэлийн сангийн хэмжээг нэмэгдүүлж, 2026 онд нийт



чанаргүй зээлийн 90 хувийг хамгаалах түвшинд эрсдэлийн санг байгуулах төсөөлөлтэй байна.

График 119. Үнэт цаас гаргагчийн нийт зээл /тэрбум төгрөг/



Эх сурвалж: Үнэт цаас гаргагчийн санхүүгийн төсөөлөл


Цэвэр зээлийн нийт хөрөнгөд эзлэх хувь нь 2021 оны байдлаар 42 хувь байсан. Банкны бизнесийн өсөлт, эдийн засгийн өсөлт, мөн өөрийн хөрөнгө нэмэгдсэнтэй холбогдуулан зээл олголт идэвхэжсэнээр нийт хөрөнгөд эзлэх цэвэр зээлийн хувь өсч, 2026 онд 49 хувьд хүрэх төлөвлөгөөтэй байна.

Зээл болон харилцах, хадгаламжийн харьцаа нь харилцагчдаас татсан хадгаламжийн эх үүсвэрийн хэдэн хувь нь зээлийн санхүүжилтээр олгогдсон байгааг харуулдаг. 2021 оны байдлаар нийт харилцах хадгаламжийн 61 хувьтай тэнцэх цэвэр зээлийг олгосон бол тус харьцаа ирэх жилүүдэд тогтвортой өсч 2026 онд 64 хувьд хүрэх төлөвтэй байна.

Энэ нь Үнэт цаас гаргагчийн зээлийн багцын өсөлтөд харилцагчдаас татсан эх үүсвэрийн өсөлтөөс гадна олон нийтэд нээлттэй хувьцаат компани болсноор бий болох өөрийн хөрөнгийн өсөлт голлох нөлөө үзүүлж байгааг илтгэж байна.



График 120. Үнэт цаас гаргагчийн зээлийн харьцаан үзүүлэлт



Эх сурвалж: Үнэт цаас гаргагчийн санхүүгийн төсөөлөл

Бусад хөрөнгө

Бусад хөрөнгөд үүсмэл санхүүгийн хэрэглүүртэй холбоотой санхүүгийн хөрөнгө, өмчлөх бусад болон түүнтэй адилтгах хөрөнгө, компани болон хүмүүсээс авах авлага багтдаг. Үнэт цаас гаргагчийн бусад хөрөнгийн хэмжээ нь авлага цуглуулалт, өмчлөх бусад хөрөнгийн борлуулалтын төлөвлөгөө болон үүсмэл санхүүгийн хэрэглүүрийн хэрэгжилттэй холбоотойгоор 2026 онд 148 тэрбум төгрөг болж буурахаар байна.

Үндсэн хөрөнгө

Банкны үйл ажиллагааг тогтвортой явуулах, шаардлагатай бизнесийн тэлэлт хийхтэй холбогдон Үнэт цаас гаргагч нь жил бүр шаардлагатай хөрөнгө оруулалтыг хийснээр банкны үндсэн хөрөнгө жилд дунджаар 2.0 хувиар өсч 2026 онд 207.1 тэрбум төгрөгт хүрэх төлөвлөгөөтэй байна. Энэ нь 2017-2020 оны түүхэн жилийн нийлмэл өсөлтөөс 1.5 нэгж хувиар бага үзүүлэлт юм. Үндсэн хөрөнгийн хөрөнгө оруулалтад тоног төхөөрөмж, систем, програм хангамж болон барилга байгууламжийн капитал засвар зэрэг биет ба биет бус хэлбэрийн хөрөнгө оруулалт багтана.

Нийт өр төлбөр (пассив)

2022-2026 онд Үнэт цаас гаргагчийн нийт өр төлбөр жилд дунджаар 4.6 хувиар өсч, 2026 онд 10.1 их наяд төгрөгт хүрэх төлөвтэй байна. Энэ нь 2017-2020 оны түүхэн жилийн нийлмэл өсөлтөөс 2.5 дахин бага үзүүлэлт юм. Үүнд харилцах хадгаламж жилд дунджаар 7.7 хувиар өсч нийт өр төлбөрийн 86 хувийг, банк санхүүгийн байгууллагаас татсан эх үүсвэр 12 хувийг, бусад өр төлбөр 1 хувийг бүрдүүлэх төлөвтэй байна.



График 121. Үнэт цаас гаргагчийн нийт өр төлбөр, өр төлбөрийн бүтэц /тэрбум төгрөг/




Эх сурвалж: Үнэт цаас гаргагчийн санхүүгийн төсөөлөл, шинжээчдийн тооцоолол

Харилцах, хадгаламж

Үнэт цаас гаргагчийн дунд хугацааны бизнес төлөвлөгөө, бүтээгдэхүүний ялгарал, зах зээлд эзлэх байр суурь, эдийн засгийн эерэг хэтийн төлөв байдалд үндэслэж Үнэт цаас гаргагчийн харилцагчдаас татах эх үүсвэр буюу харилцах, хадгаламжийн хэмжээ 2022-2026 онд жилд дунджаар 7.7 хувиар өсч 2026 онд 8.7 их наяд төгрөгт хүрч, зах зээлийн 19.7 хувийг эзлэх төлөвтэй байна. Энэ нь 2017-2020 оны түүхэн жилийн нийлмэл өсөлтөөс 6.6 нэгж хувиар бага үзүүлэлт юм.

График 122. Үнэт цаас гаргагчийн харилцах хадгаламжийн хэмжээ /тэрбум төгрөг/



Эх сурвалж: Үнэт цаас гаргагчийн санхүүгийн төсөөлөл



Дээрх өсөлт нь банкны системийн өсөлт, зээл болон бусад хөрөнгө оруулалтын төлөвлөлт, төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцааг оновчтой түвшинд байлгах зэрэг зорилтуудтай уялдан бий болж буй өсөлт юм. Харилцах хадгаламжийн өсөлтийг тус бүрээр задлан харуулбал дараах байдалтай байна. Үүнд:

Хүснэгт 40. Үнэт цаас гаргагчийн харилцах, хадгаламжийн өсөлт

	2022Т	2023Т	2024Т	2025Т	2026Т
Харилцах	5.3%	9.0%	8.6%	5.9%	7.6%
Хадгаламж	15.6%	8.9%	8.5%	6.0%	7.5%
НИЙТ	12.4%	8.9%	8.6%	6.0%	7.5%
Зах зээлд эзлэх байр суурь	19.4%	19.4%	19.5%	19.5%	19.5%

Эх сурвалж: Үнэт цаас гаргагчийн бизнес төсөөлөл


Банк, санхүүгийн байгууллагаас татсан эх үүсвэр

Үнэт цаас гаргагчийн бусад банк, санхүүгийн байгууллагуудын татсан эх үүсвэрийн хэмжээ 2023-2025 онд буурч, 2026 онд 1.2 их наяд төгрөгт хүрэх төлөвтэй байна. Үүнд тус хугацаанд төлөгдөх гадаадын банкнаас авсан 300 сая ам.долларын зээлийн эргэн төлөлт нөлөөлж байна.

Нийт эзэмшигчдийн өмч (өөрийн хөрөнгө)

2022-2026 онд Үнэт цаас гаргагчийн өөрийн хөрөнгө жилд дунджаар 12.4 хувиар өсөх төсөөлөлтэй байна. Үнэт цаас гаргагч нь 2022 онд анх удаа хувьцааг нийтэд санал болгох замаар 100 тэрбум төгрөгөөр өөрийн хөрөнгийг нэмэгдүүлэх хүлээлттэй байна. Улмаар цаашид жил бүрийн цэвэр ашгаас ногдол ашиг хуваарилж, үлдэгдэл мөнгөн хөрөнгөөр өөрийн хөрөнгө тогтмол өсч 2026 онд 1.3 их наяд төгрөгт хүрэхээр байна.

График 123. Үнэт цаас гаргагчийн эздийн өмч, эздийн өмчийн бүтэц /тэрбум төгрөг/



Эх сурвалж: Үнэт цаас гаргагчийн санхүүгийн төсөөлөл



Орлогын тайлангийн төсөөлөл

Хүснэгт 41. Үнэт цаас гаргагчийн орлогын тайлангийн төсөөлөл 2022-2026 /тэрбум төгрөг/

	2022T	2023T	2024T	2025T	2026T
Хүүгийн орлого	697.4	807.8	895.5	932.3	984.5
Хүүгийн зардал	374.0	441.2	491.8	520.9	549.6
Цэвэр хүүгийн орлого	323.4	366.6	403.7	411.4	434.9
Нийт хүүгийн бус орлого	20.3	41.8	54.2	99.3	113.8
Хүүгийн бус орлого	95.7	105.3	114.2	123.9	134.3
Своп хэлцлүүдийн бодит үнэ цэнийн олз/гарз	(75.4)	(63.5)	(60.0)	(24.6)	(20.5)
Хүүгийн бус зардал	24.2	25.6	27.0	27.9	30.6
Цэвэр хүүгийн бус орлого	(3.9)	16.2	27.2	71.4	83.2
Үйл ажиллагааны орлого	319.5	382.8	430.8	482.8	518.1
Үйл ажиллагааны зардал	161.1	176.2	189.8	203.6	219.5
Үйл ажиллагааны ашиг	158.4	206.6	241.1	279.2	298.6
Эрсдэлийн сан, үнэлгээний зардал	59.1	41.0	39.8	38.0	32.8
Татварын өмнөх цэвэр ашиг	99.3	165.5	201.2	241.2	265.8
Орлогын албан татвар	24.4	39.3	45.0	53.5	56.5
Цэвэр ашиг	74.9	126.2	156.2	187.7	209.3

Эх сурвалж: Үнэт цаас гаргагчийн санхүүгийн төсөөлөл

Хүүгийн орлого

2022-2026 онд Үнэт цаас гаргагчийн хүүгийн орлого жилд дунджаар 9.0 хувиар өсч 2026 онд 985 тэрбум төгрөгт хүрэх төлөвлөгөөтэй байна. Энэ нь 2017-2020 оны түүхэн жилийн нийлмэл өсөлт болох 11.7 хувьтай харьцуулахад 2.7 нэгж хувиар бага үзүүлэлт юм.

График 124. Үнэт цаас гаргагчийн хүүгийн орлогын төсөөлөл /тэрбум төгрөг/



Эх сурвалж: Үнэт цаас гаргагчийн санхүүгийн төсөөлөл



Хүүгийн орлогын өсөлт нь дараах үндсэн 3 шалтгаантай.

Нэгдүгээрт, өөрийн хөрөнгө нэмэгдсэнээр нийт зээлийн багц өсч, хүүгийн орлогыг нэмэгдүүлэх боломжтой. Монголбанкнаас шаарддаг зохистой харьцааны дагуу банкны өөрийн хөрөнгө нь нийт эрсдэлээр жигнэсэн активын 13 хувьтай тэнцүү байх шаардлагатай. Зохистой харьцаанд үндэслэн тооцвол олон нийтээс татан төлөврүүлсэн хөрөнгийн өсөлт нь нийт зээлийн багцыг 790 гаруй тэрбум төгрөгөөр нэмэгдүүлэх боломжтой байна.


Монголбанкнаас шаарддаг зохистой харьцааны дагуу банкны өөрийн хөрөнгө нь нийт эрсдэлээр жигнэсэн активын 13 хувьтай тэнцүү байх шаардлагатай. Зохистой харьцаанд үндэслэн тооцвол олон нийтээс татан төлөврүүлсэн хөрөнгийн өсөлт нь нийт зээлийн багцыг 790 гаруй тэрбум төгрөгөөр нэмэгдүүлэх боломжтой байна.

Хоёрдугаарт, эдийн засгийн хэтийн эерэг төлөв нь зээлийн эрэлтийг нэмэгдүүлэхийн сацуу Монголбанк, Засгийн Газраас хэрэгжүүлж буй эдийн засгийг сэргээх бодлогын хүрээнд зээл олголт ирэх жилүүдэд нэмэгдэх төлөвтэй байна. Гуравдугаарт, Үнэт цаас гаргагч нь зээлийн судалгааны чанар, процессыг сайжруулж, шийдвэр гаргалтыг мэргэжлийн өндөр түвшинд байлгах бизнес төлөвлөгөөний хүрээнд зээлийн багцын чанарыг сайжруулж, хүүгийн орлого нэмэгдэх төлөвтэй байна.

Хүүгийн зардал

Үнэт цаас гаргагчийн хүүгийн зардал жилд дунджаар 10.1 хувиар өсч 2026 онд 550 тэрбум төгрөгт хүрэх төлөвлөгөөтэй байна. Энэ нь 2017-2020 оны түүхэн жилийн нийлмэл өсөлтөөс 1.7 нэгж хувиар их үзүүлэлт юм. Тус өсөлтөд Үнэт цаас гаргагчийн харилцах, хадгаламжийн эх үүсвэр 7.7 хувиар өсч буй нь голлох нөлөө үзүүлж байна. Харилцах, хадгаламжийн бодит хүүгийн өртгийг Монголбанкны бодлогын хүүгийн таамаглалтай уялдуулан тооцсон.

График 125. Үнэт цаас гаргагчийн хүүгийн зардлын төсөөлөл /тэрбум төгрөг/




Эх сурвалж: Үнэт цаас гаргагчийн санхүүгийн төсөөлөл



Цэвэр хүүгийн орлого

2022-2026 онд Үнэт цаас гаргагчийн цэвэр хүүгийн орлого жилд дунджаар 7.7 хувиар өсч 435 тэрбум төгрөгт хүрэх төлөвлөгөөтэй байна. Энэ нь 2017-2020 оны түүхэн жилийн нийлмэл өсөлтөөс 11.0 нэгж хувиар бага үзүүлэлт юм. Цэвэр хүүгийн өсөлт нь хүүгийн орлогын 9.0 хувийн өсөлт болон цэвэр хүүгийн зардлын 10.1 хувийн өсөлтөөс тус тус хамааралтай байна.

График 126. Үнэт цаас гаргагчийн цэвэр хүүгийн орлогийн төсөөлөл /тэрбум төгрөг/



Эх сурвалж: Үнэт цаас гаргагчийн санхүүгийн төсөөлөл


Хүүгийн бус орлого

2022-2026 оны хооронд Үнэт цаас гаргагчийн хүүгийн бус орлого /свопын нөлөөгүй/ жилд дунджаар 8.8 хувиар өсч, 134 тэрбум төгрөгт хүрэх төлөвлөгөөтэй байна. Энэ нь 2017-2020 оны түүхэн жилийн нийлмэл өсөлт болох 9.4 хувьтай харьцуулахад 0.6 нэгж хувиар бага түвшинд байна.

Тодруулбал, Голомт банкны бүтээгдэхүүн үйлчилгээний хөгжүүлэлт, сайжруулалт, бизнесийн тэлэлт зэргээс үүдэлтэйгээр шимтгэл хураамжийн орлого 2022-2026 онд жилд дунджаар 9.4 хувиар өсч 90.0 тэрбум төгрөгт, арилжааны цэвэр орлого жилд дунджаар 6.0 хувиар өсч, 34 тэрбум төгрөгт хүрэх төлөвтэй байна.



График 127. Үнэт цаас гаргагчийн хүүгийн бус орлогийн төсөөлөл (своп хэлцлүүдийн нөлөө ороогүй) /тэрбум төгрөг/



Эх сурвалж: Үнэт цаас гаргагчийн санхүүгийн төсөөлөл


Своп хэлцлүүдийн бодит үнэ цэнийн олз/гарз

Үнэт цаас гаргагч нь гадаадын банк, санхүүгийн байгууллагаас татсан урт хугацаат ам.долларын санхүүжилтээс үүсэх ханшийн эрсдэлээс хамгаалах зорилгоор своп хэлцлүүд хийсэн. Своп хэлцлүүдийн бодит үнэ цэнийг тайлант хугацаа бүрт үнэлж, өөрчлөлтийг бодит үнэ цэнийн олз/гарзаар бүртгэдэг. Макро эдийн засгийн гол үзүүлэлтүүдийн таамаглал, ханшийн таамаглал, өмнөх жилүүдийн бодит гүйцэтгэл зэрэгт үндэслэхэд своп хэлцлүүдийн бодит үнэ цэнийн гарз 2022 онд 75 тэрбум төгрөг, 2026 онд 21 тэрбум төгрөгт хүрэх төсөөлөлтэй байна.

Хүүгийн бус зардал

Хүүгийн бус зардалд хураамж болон шимтгэлийн зардал, ханш үнэлгээний тэгшитгэлийн зардал, бусад эрсдэлийн сангийн зардал зэрэг багтана. Хүүгийн бус зардал нь 2022-2026 онд жилд дунджаар 6.0 хувиар өсч 2026 оны эцэст 31 тэрбум төгрөгт хүрч Үнэт цаас гаргагчийн нийт зардлын 3.4 хувийг эзлэх төлөвтэй байна.

График 128. Үнэт цаас гаргагчийн хүүгийн бус зардлын төсөөлөл /тэрбум төгрөг/




Эх сурвалж: Үнэт цаас гаргагчийн санхүүгийн төсөөлөл



Цэвэр хүүгийн бус орлого

2022-2026 онд Үнэт цаас гаргагчийн цэвэр хүүгийн бус орлого тогтвортой өсч 83.2 тэрбум төгрөгт хүрэх төлөвтэй байна. Цэвэр хүүгийн бус орлогын өсөлт нь хүүгийн бус орлогын 8.8 хувийн өсөлт болон хүүгийн бус зардлын 6.0 хувийн өсөлтөөс хамааралтай байна.

График 129. Үнэт цаас гаргагчийн цэвэр хүүгийн бус орлогийн төсөөлөл /тэрбум төгрөг/



Эх сурвалж: Үнэт цаас гаргагчийн санхүүгийн төсөөлөл

Үйл ажиллагааны зардал

2022-2026 онд Үнэт цаас гаргагчийн нийт үйл ажиллагааны зардлын 33 орчим хувийг хүний нөөцтэй холбоотой зардлууд, 19 орчим хувийг элэгдэл хорогдлын зардал, 11 орчим хувийг даатгал, мэргэжлийн үйлчилгээний зардал, 9 орчим хувийг автоматжуулалт сүлжээний зардал, 28 орчим хувийг үйл ажиллагааны бусад зардал бүрдүүлэхээр байна.

Үнэт цаас гаргагчийн бизнесийн тэлэлт, үйл ажиллагааны сайжруулалт зэрэгтэй холбогдон үйл ажиллагааны зардал 2022-2026 онд жилд дунджаар 8.0 хувиар өсч 2026 онд 220 тэрбум төгрөгт хүрэх төлөвтэй байна.

Эрсдэлийн сан, үнэлгээний зардал (цэвэр)

Зээлийн судалгааны чанар, процессыг сайжруулж, шийдвэр гаргалтыг мэргэжлийн өндөр түвшинд байлган зээлийн багцын чанарыг сайжруулах бизнес төлөвлөгөөний хүрээнд 2022-2026 онд Үнэт цаас гаргагч нь банкны зээлийн оновчтой бодлого, олон улсын стандартад нийцүүлж шинэчлэн сайжруулсан зээлийн скоринг болон рейтинг



модель зэргийг хөгжүүлж, зээлийн багцын чанарыг сайжруулж, чанаргүй зээлийн хувь хэмжээг бууруулах зорилт тавин ажиллаж байна.

Тус зорилтын хүрээнд Үнэт цаас гаргагч нь нийт багцын чанаргүй зээлийг 7.9-5.1 хувийн түвшинд хүрч буурахаар тооцсон. Нөгөө талаас, зээлийн эрсдэлээс сэргийлэх зорилгоор тус чанаргүй зээлүүдэд эрсдэлийн сан байгуулах хэмжээг 90 хувийн түвшинд болгон нэмэгдүүлсэн. Дээрх тооцооллын үр дүнд Үнэт цаас гаргагчийн эрсдэлийн сангийн зардал ирэх жилүүдэд дараах байдалтай байна

Хүснэгт 42. Эрсдэлийн сангийн зардлын төсөөлөл /тэрбум төгрөг/

	2022Т	2023Т	2024Т	2025Т	2026Т
Зээлийн эрсдэлийн сангийн зардал	59	41	40	38	33

Татварын зардал

2022-2026 онд Үнэт цаас гаргагч нь дунджаар татварын өмнөх ашгийн 23 хувьтай тэнцэх хэмжээний татварын зардал улсын төсөвт татан төвлөрүүлэх төлөвтэй байна. Тодруулбал, Үнэт цаас гаргагч нь нийт 219 тэрбум төгрөгийн татварын зардлыг ирэх 5 жилийн хугацаанд төлөх хүлээлттэй байна.

Цэвэр ашиг

Үнэт цаас гаргагчийн цэвэр ашгийн хэмжээ 2022-2024 онд жилд дунджаар 44.4 хувиар өсч 2024 онд 156 тэрбум төгрөгт хүрэх төлөвтэй байна. Энэ нь ашигт ажиллагааг буурахад гол нөлөө үзүүлсэн 2013 оноос бий болсон чанаргүй зээлийн эрсдэлийн сангийн зардал 2021 онд дуусгавар болсон, зээлийн бодлого төлөвлөлт сайжирснаар шинээр олгогдох зээлийн чанаргүйдлийн түвшин болон эрсдэлийн сангийн зардал буурах, мөн сүүлийн жилүүдэд зээлийн төвлөрлийг амжилттай бууруулж, иргэдийн болон жижиг дунд бизнес эрхлэгчдэд зээл олгон хүртээмжийг сайжруулж, зээлийн тараан байршуулалтыг эрчимжүүлэх төлөвлөгөөтэй холбоотой.

2025-2026 онд Үнэт цаас гаргагчийн цэвэр ашгийн өсөлт тогтворжиж, 2026 оны эцэст цэвэр ашгийн хэмжээ 209 тэрбум төгрөгт хүрэх хүлээлттэй байна.



Харьцаа үзүүлэлтийн шинжилгээ

Хүснэгт 43. Үнэт цаас гаргагчийн харьцаан үзүүлэлт 2022-2026

	2022Т	2023Т	2024Т	2025Т	2026Т
Цэвэр хүүгийн ахиуц	4.1%	4.1%	4.3%	4.4%	4.3%
Цэвэр ашгийн ахиуц	10.4%	14.9%	16.4%	18.2%	19.1%
Зардал орлогын харьцаа	50.4%	46.0%	44.0%	42.2%	42.4%
Өөрийн хөрөнгийн өгөөж	11.5%	15.7%	17.0%	18.0%	18.0%
Нийт хөрөнгийн өгөөж	0.9%	1.3%	1.6%	1.8%	1.9%

Эх сурвалж: Монголбанкны тайлагналын стандартын дагуух тооцоолол

Цэвэр хүүгийн ахиуц

Үнэт цаас гаргагчийн цэвэр хүүгийн ахиуц 2017 оны байдлаар 3.3 хувь байсан бол актив пассивын оновчтой удирдлагыг хэрэгжүүлэн тогтмол ахиулж, 2021 оны эцсийн байдлаар 4.6 хувьд хүрсэн. Цаашид актив, пассивын оновчтой бүтцийг барих дунд хугацааны бизнес төлөвлөгөөний хүрээнд Үнэт цаас гаргагч нь цэвэр хүүний ахиуцыг тогтмол сайжруулж, 2026 онд 4.3 хувьд хүргэх төлөвтэй байна.

Цэвэр ашгийн ахиуц

Зээлийн эрсдэлийн сангийн зардлаас үүдэлтэй банкны ашигт ажиллагаа өнгөрсөн жилүүдэд бага байсан. Цаашид зээлийн судалгааны чанар, процессыг сайжруулж, шийдвэр гаргалтыг мэргэжлийн өндөр түвшинд байлган зээлийн багцын чанарыг сайжруулах төлөвлөгөөний хүрээнд эрсдэлийн сангийн зардал буурч, 2026 онд цэвэр ашгийн ахиуц 19.1 хувьд хүрэх хүлээлттэй байна.

Зардал орлогын харьцаа

Зардал орлогын харьцаагаар Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагааны зардлыг үйл ажиллагааны орлогод харьцуулах замаар үйл ажиллагааны ашигт ажиллагааг тодорхойлдог ба 2022-2026 онд үнэт цаас гаргагчийн ашигт ажиллагаа сайжирснаар зардлын харьцаа буурч 2026 онд 42.4 хувьд хүрэх төлөвтэй байна.

Нийт хөрөнгийн өгөөж

Үнэт цаас гаргагчийн нийт хөрөнгийн өгөөж буюу цэвэр ашгийг нийт хөрөнгөд харьцуулсан харьцаа 2022-2026 онд тогтвортой өсөж 1.9 хувьд хүрэх ба энэ нь 2021 оны үзүүлэлтээс 1.5 нэгж хувиар өссөн үзүүлэлт юм. Тус өсөлт нь Үнэт цаас гаргагчийн ашигт ажиллагааны өсөлт, нийт хөрөнгийн өсөлтөөс өндөр буюу банк нийт хөрөнгийг үр ашигтай эргэлдүүлж байгааг илтгэж байна.



Монголбанкнаас арилжааны банкны үйл ажиллагаа, санхүүгийн салбарын тогтвортой байдлыг хангах, харилцагчдын мөнгөн хөрөнгийг хамгаалах, эрсдэлийг бууруулах үүднээс зохистой шалгуур үзүүлэлтүүдийг хязгаарлалт болгон тогтоосон байдаг. Үнэт цаас гаргагчийн дунд хугацааны буюу 2022-2026 оны бизнес болон санхүүгийн төлөвлөгөө нь Монголбанкнаас тогтоосон дээрх шалгуур үзүүлэлтийг бүрэн хангахуйц түвшинд байна.

Өөрийн хөрөнгө болон нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгийн хүрэлцээ

Үнэт цаас гаргагчийн өөрийн хөрөнгийн хүрэлцээ буюу нийт өөрийн хөрөнгийг эрсдэлээр жинлэсэн активд харьцуулсан харьцаа нь 2022-2026 онд 14.8-17.2 хувийн хооронд буюу зохистой түвшнээс 2.8-5.2 нэгж хувиар илүү байгаа нь Үнэт цаас гаргагчийн өөрийн хөрөнгийн хэмжээ эрсдэл даахуйц хэмжээнд байгааг илтгэж байна.

Нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгийг нийт эрсдэлээр жигнэсэн активд харьцуулсан харьцаа нь 2022-2026 онд 14.8-17.2 хувьд байна. Үнэт цаас гаргагчийн өөрийн хөрөнгийн бүрэлдэхүүнээс хоёрдугаар зэрэглэлийн өөрийн хөрөнгө болох хоёрдогч өглөг, давуу эрхийн хувьцаа, дахин үнэлгээний сан зэрэг нь 2022 оноос эхлэн хасагдсанаар тус 2 харьцаа нь ижил түвшинд байна.

Төлбөр түргэн гүйцэтгэх чадвар

Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын үзүүлэлт нь бусдаас татан төвлөрүүлсэн хөрөнгийг харилцагчийн анхны шаардлагаар буцаан олгох чадварыг илэрхийлэх бөгөөд түргэн борлогдох активын дүнг бусдаас татан төвлөрүүлсэн хөрөнгийн дүнд харьцуулж тооцдог. Үнэт цаас гаргагчийн төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцаа 2022-2026 онд 48.7-49.4 хувьд байна. Энэ нь зохистой шалгуур үзүүлэлтээс 23.7-24.4 нэгж хувиар илүү байгаа нь Үнэт цаас гаргагчийн төлбөрийн чадварын эрсдэл бага түвшинд байхыг илэрхийлж байна.





ТАВ.

ҮНЭТ ЦААСНЫ
ТУХАЙ



5 ҮНЭТ ЦААСНЫ ТУХАЙ

5.1 Нийтэд санал болгох үнэт цаасны тухай

Үнэт цаас гаргагч нь Банкны тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2.1, 29.2.2, 29.2.4 дэх заалт, 36 дугаар зүйлийн 36.1, 36.3 дах заалт, Банкны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх тухай журмын 4 дүгээр зүйл; Компанийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1 дэх хэсэг, 18 дугаар зүйлийн 18.1 дэх хэсэг, 23 дугаар зүйл, 31 дүгээр зүйлийн 31.2.2 дахь заалт, 38 дугаар зүйлийн 38.8 дахь хэсэг, 42 дугаар зүйлийн 42.1 дэх хэсэг, 61 дүгээр зүйлийн 61.1.5, 61.1.7 дахь заалт, 62 дугаар зүйлийн 62.1.1, 62.1.2, 62.1.3, 62.1.4 дэх заалт, 68 дугаар зүйлийн 68.1 дэх хэсэг, 69 дүгээр зүйлийн 69.1 дэх хэсэг, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсэг, 11 дүгээр зүйлийн 11.1 дэх хэсэг, Үнэт цаас гаргагчийн дүрмийн 5 дугаар зүйлийн 5.6.2 дахь заалт, 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсэг, 9 дүгээр зүйлийн 9.5.1, 9.5.2, 9.5.4, 9.5.15 дахь заалт, Хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэрт үндэслэн нийт хувьцааны 10.09 хувь буюу 80,402,743 ширхэг хувьцааг нэмж гарган Монголын Хөрөнгийн Биржийн I ангиллаар анх удаа нийтэд санал болгон арилжихаар шийдвэрлэсэн.

Хүснэгт 45. Үнэт цаасны мэдээлэл

Үнэт цаас гаргагч	Голомт Банк ХХК
Үнэт цаасны төрөл	Энгийн хувьцаа
Нийт эргэлтэд гаргасан энгийн хувьцааны тоо ширхэг	716,194,152*
Нэгж хувьцааны нэрлэсэн үнэ	250
Нийтэд санал болгох эзэмшлийн хувь	10.09%
Стратегийн хөрөнгө оруулагчдад санал болгох нөхцөл	Нэмж гаргах хувьцааны 80 хүртэлх хувийг захиалга бүрэн биелэх нөхцөлөөр
Олон нийтэд санал болгох нөхцөл	Нэмж гаргах хувьцааны үлдсэн хэсэг буюу 20 болон түүнээс дээш хувийг хувь тэнцүүлэн хуваарилах нөхцөлөөр
Нэмж гаргах хувьцааны тоо ширхэг	80,402,743
Нэмж гаргасны дараах хувьцааны тоо ширхэг	796,596,895
Нэгж хувьцааны үнэ	1,285
Олон нийтээс татан төвлөрүүлэх дүн	103,317,524,755
Татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалт	Үйл ажиллагаа өргөжүүлэх
Хувьцааг арилжаалах арга	Тогтоосон үнийн арга



* Үнэт цаас нийтэд санал болгох үеийн байдлаар

- 258 -



5.2 Хувь нийлүүлсэн хөрөнгийн өөрчлөлт

Үнэт цаас гаргагч нь нэг бүр нь 250 төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий нийт 800,000,000 ширхэг зарласан, 716,194,152 ширхэг гаргасан энгийн хувьцаатай байх бөгөөд нэмж 80,402,743 ширхэг энгийн хувьцаа буюу олон нийтэд санал болгосны дараах хувь эзэмшлийн 10.09 хувьтай тэнцэх энгийн хувьцааг нийтэд нээлттэй санал болгон арилжаална. Үнэт цаас гаргагч нь хувьцаа нэмж гарган, нийтэд нээлттэй санал болгон арилжаалсны дараа дараах хувьцаа эзэмшлийн бүтэцтэй болно.

Хүснэгт 46. Үнэт цаас гаргагчийн хувьцаа эзэмшигчдийн бүтэц

Хувьцаа эзэмшигчид	Хувьцаа гаргахаас өмнө		Хувьцаа гаргасны дараа	
	Эзэмшиж буй хувьцааны тоо	Эзэмшлийн хувь	Нэмж хувьцаа гаргасны дараах	Эзэмшлийн хувь
Голомт Файнэншил Групп	624,240,527	87.16%	624,240,527	78.36%
Свисс-Мо Инвестмент	42,120,816	5.88%	42,120,816	5.29%
Голомт Инвестмент Лимитэд	20,800,000	2.90%	20,800,000	2.61%
Голомт банкны ажилтанууд	1,371,312	0.19%	1,371,312	0.17%
Бодь Интернэшнл	27,661,497	3.86%	27,661,497	3.47%
Олон нийт	-	-	80,402,743	10.09%
Нийт	716,194,152	100%	796,596,895	100%

5.3 Нийтэд санал болгох үнэ тогтоосон үндэслэл

Үнэт цаасны зах зээлд оролцогч этгээдэд үйлчилгээ үзүүлэх эрх бүхий олон улсын нэр хүнд бүхий хөндлөнгийн үнэлгээний байгууллага болох Кэй Пи Эм Жи Аудит ХХК нь Үнэт цаас гаргагчийн бизнесийн үнэлгээг гүйцэтгэж, үр дүнг 2021 оны 12 сарын 17-ний өдрийн Хараат бус бизнесийн үнэлгээний тайлангаар хүргүүлсэн.

Үнэлгээний байгууллага нь Үнэт цаас гаргагчийн хувьцааг нийтэд анх удаа санал болгох үйл ажиллагаанд зориулж 100 хувь бизнес өмчлөлийн зах зээлийн үнэ цэнийг 2021 оны 06 сарын 30-ны өдрийн байдлаар тодорхойлсон ба Үнэлгээний Олон Улсын Стандарт болон Монгол Улсын Хөрөнгийн Үнэлгээний Тухай Хууль болон бусад холбогдох журам тогтоолын дагуу зах зээлийн үнэ цэнийн суурийг сонгож, Үнэт цаас гаргагчийн бизнесийг зах зээлийн харьцуулалтын, орлогын болон хөрөнгөд суурилсан хандлагын аргуудаар үнэлсэн.

Зах зээлийн харьцуулалтын аргаарх үнэлгээ

Үнэт цаас гаргагчийн бизнес өмчлөлийн үнэ цэнийг Зах зээлийн харьцуулалтын хандлагаар тооцоолоход харьцуулах компаниар авч ашиглах ижил төстэй, итгэл



үнэмшил төрүүлэхүйц, найдвартай мэдээлэлтэй дотоодын нээлттэй компани одоогоор байхгүй гэж хөндлөнгийн үнэлгээний байгууллага үзсэн байна.

Иймд Зах зээлийн харьцуулалтын хандлагаарх үнэлгээг ижил төстэй зах зээлийн нөхцөл байдалд үйл ажиллагаа явуулдаг, хөгжиж буй орны, ижил төрлийн зээлийн багцтай олон улсын банкуудын үзүүлэлтийг ашиглан хийж гүйцэтгэсэн. Ингэхдээ олон улсад түгээмэл ашиглагддаг, нээлттэй арилжаалагддаг компанийн хувьцааны Жишиг компанийн харьцуулалтын арга болон Жишиг хэлцлийн аргыг хослуулан ашигласан.

Жишиг компанийн харьцуулалтын аргын хүрээнд Зүүн Европ болон Зүүн Өмнөд Азийн бүс нутгуудад үйл ажиллагаа явуулж буй 21 банкиг жишиг болгон сонгож харьцуулалтыг хийсэн. Эдгээр жишиг банкуудыг сонгохдоо тухайн банкны үйл ажиллагаа явуулж буй улсын эдийн засгийн өсөлт, зах зээлийн нөхцөл байдал, өөрийн хөрөнгийн болон нийт активын хэмжээ, зээлийн багцын бүтэц болон бусад санхүүгийн үзүүлэлтүүд нь Үнэт цаас гаргагчтай ижил төстэй байх шалгуурыг тавьсан. Жишиг хэлцлийн аргын хүрээнд мөн Зүүн Европ болон Зүүн Өмнөд Азийн бүс нутгуудад 2016 оноос 2021 оны хооронд явагдсан нийт 14 хэлцлүүдийг сонгон авч ашигласан бөгөөд хэлцэл явагдсан улс орнуудын эдийн засгийн өсөлт, зах зээлийн нөхцөл байдал гэх мэт шалгуурыг хэлцлийн сонголтод ашиглан сонгосон хэлцлүүд дээр хувь оролцооны хэмжээг жигдлэж, хяналттай урамшууллыг тохируулах гэх мэт арга хэмжээг авсан. Зах зээлийн хандлагын хүрээнд авч ашигласан жишиг банкууд болон жишиг хэлцлүүд дээр нийт хөрөнгийн өгөөж, эдийн өмчийн өгөөж, зардал орлогын харьцаа, эрсдэлийн өртөг, цэвэр хүүгийн орлогын маржин гэх мэт KPI үзүүлэлтүүдийг мөн харгалзан үзсэн.

Үнэт цаас гаргагчийн Post-Money бизнесийн үнэлгээ буюу хувьцааг олон нийтэд санал болгон санхүүжилт татсаны дараах 100 хувийн хувь оролцооны дундаж үнэлгээг нээлттэй арилжаалагддаг ижил төстэй олон улсын банкуудын дундаж P/B үржүүлэгч болон сүүлийн 5 жилийн хугацаанд хийгдсэн нэгдэн нийлэлтийн хэлцлийн дундаж P/B үржүүлэгчийг ашиглан тус тус тооцоолоход Монгол улстай ойролцоо зах зээлийн, арилжааны банкуудын үнэлгээний дундажыг үржүүлэгч нь P/B 1.58x буюу 1,025,227 байна. Гэвч хөндлөнгийн үнэлгээний байгууллага нь тус үржүүлэгчийг ашиглан бизнесийн үнэлгээг тооцох нь банкны ирээдүйн бизнесийн өсөлт, санхүүгийн байдлын үзүүлэлтийг авч үзэхгүй байгаагаас гадна олон улсын нээлттэй арилжаалагддаг банкуудын үйл ажиллагааны сегментчилэл, нийт хөрөнгийн хэмжээ, үйл ажиллагааны орчин нөхцөлөөс хамаарч харьцуулалт хийхэд учир дутагдалтай гэж үзэн харьцуулалтын аргыг үнэлгээнд ашиглаагүй байна.

Гэвч хөндлөнгийн үнэлгээний байгууллага нь тус үржүүлэгчийг ашиглан бизнесийн үнэлгээг тооцох нь банкны ирээдүйн бизнесийн өсөлт, санхүүгийн байдлын үзүүлэлтийг авч үзэхгүй байгаагаас гадна олон улсын нээлттэй арилжаалагддаг банкуудын үйл ажиллагааны сегментчилэл, нийт хөрөнгийн хэмжээ, үйл



ажиллагааны орчин нөхцөлөөс хамаарч харьцуулалт хийхэд учир дутагдалтай гэж үзэн харьцуулалтын аргыг үнэлгээнд ашиглаагүй байна.

Орлогын хандлагын аргаарх үнэлгээ

Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагааны онцлог, бизнесийн мөчлөг болон санхүүгийн загварт дүн шинжилгээ хийсний үндсэн дээр олон нийтээс хөрөнгө татсаны дараах үеийн Орлогын хандлагаар хийсэн үнэлгээ (Post-Money valuation) нь үнэлгээний ажлын зорилго болон үнэлгээний даалгавартай нийцнэ гэж Хөндлөнгийн үнэлгээний байгууллага дүгнэсэн байна.

Орлогын хандлагын аргуудаас банкны бизнес төлөвлөгөө, санхүүгийн төсөөлөлд үндэслэн ирээдүйд хувьцаа эзэмшигчдэд бий болох мөнгөн урсгалыг хамгийн оновчтой бөгөөд тогтвортой байдлаар илтгэх үзүүлэлтийг ногдол ашиг байна гэж үзсэн. Иймд орлогын хандлагын Хорогдуулсан ногдол ашгийн загварын аргыг (Dividend Discount Model) үнэлгээнд ашигласан.

Хөндлөнгийн үнэлгээний байгууллага нь банкны үндсэн үйл ажиллагааны үзүүлэлт болох зээлийн багцын өсөлт, харилцах хадгаламжийн эх үүсвэрийн өсөлтийг нийт банкны салбарын зах зээлд эзлэх хувийн 20 хувьд хүрнэ, мөн чанаргүй зээлийн хувийг Үнэт цаас гаргагчийн түүхэн чанаргүй зээлийн хувь, шинэчлэгдсэн зээлийн бодлого, скорингийн үнэлгээ зэрэгт үндэслэн нийт чанаргүй зээлийн хувийг 5.1 хувьд, зээлийн эрсдэлийн санг нийт чанаргүй зээлийн 90 хувьтай дүйцэхүйц хэмжээнд байна гэсэн Үнэт цаас гаргагчийн төсөөллийг үндэслэлтэй гэж үзэн тооцоололд ашигласан.

Үнэт цаас гаргагчийн өөрийн хөрөнгийн өртгийг (cost of equity) тооцоолохдоо Тохируулсан капиталын хөрөнгийн үнэ тогтоох загвар (modified CAPM)-ыг ашигласан бөгөөд эрсдэлгүй хүүг 10 жилийн хугацаатай АНУ-ын засгийн газрын бондын хүүгээр (1.5%, US 10-year Treasury Bond), бета хувьсагчийг АНУ-ын банкны салбарын дундаж бета коэффициентоор (0.64, Damodaran Publishing), зах зээлийн эрсдэлийн урамшууллыг АНУ-ын урт хугацааны дундаж зах зээлийн эрсдэлийн урамшууллаар (5.5%, US Market Risk Premium) тус тус тооцож, Монгол Улсын эрсдэлийн урамшууллыг тооцон нэмж (3%, Монгол Улсын ЗГ-ын 10 жилийн хугацаатай Century бонд ба АНУ-ын ЗГ-ын 10 жилийн хугацаатай бондын хүүгийн зөрүү) гарсан үр дүнг хоёр орны зорилтот инфляцийн түвшний зөрүүгээр ам.доллараас төгрөгт шилжүүлсэн. Үнэлгээний олон улс дахь сайн жишгээр Капиталын хөрөнгийн үнэ тогтоох загварыг АНУ-ын зах зээлийн мэдээлэлд суурилан бэлтгэж байгаа нөхцөлд үнэлж буй компанийн хэмжээг АНУ-ын зах зээл дэх компаниудтай харьцуулж зохих нэмэгдүүлгээр тохируулдаг тул компанийн хэмжээний нэмэгдэл болох 3.67 хувиар (Duff & Phelps) нэмэгдүүлсэн. Эдгээр тооцооллын үр дүнд Хорогдуулсан ногдол ашгийн загварын аргад ашигласан



өөрийн хөрөнгийн өртгийг хөндлөнгийн үнэлгээний байгууллага 15.9% гэж авч үзжээ.

Урт хугацааны бизнесийн өсөлтийг тооцоолохдоо аливаа бизнесийн урт хугацааны өсөлт нь тухайн үйл ажиллагаа явуулж буй улсын урт хугацааны эдийн засгийн өсөлтөөс илүүгүй байна гэсэн зарчимд үндэслэн Монгол Улсын эдийн засгийн урт хугацааны өсөлтийн таамаглал болох 5%-ийг уг өсөлтийн хувьд тооцсон.

Дээрх үндсэн таамаглалуудад үндэслэн Үнэт цаас гаргагчийн 100 хувийн хувь оролцооны зах зээлийн үнэ цэнийг 2021 оны 06 сарын 30-ны өдрийн байдлаар 980,137 сая төгрөг байхаар тогтоосон байна. Энэ нь Үнэт цаас гаргагчийн олон нийтээс санхүүжилт татаж эздийн өмчийг нэмэгдүүлсний дараах үед хамаарах үнэлгээ (Post-Money valuation) болно.

Хөрөнгөд суурилсан үнэлгээ

Хөрөнгөд суурилсан хандлага нь аж ахуйн нэгж, бизнесийн бүх бүрэлдэхүүн хэсгүүдийг нөхөн сэргээх өртгөөс ихгүй үнэ цэнтэй байна гэсэн зарчимд үндэслэдэг. Хөндлөнгийн үнэлгээний байгууллага нь хөрөнгөд суурилсан хандлагын Тохируулсан цэвэр хөрөнгийн аргыг ашиглан бизнесийг үнэлэхдээ нийт хөрөнгө болон өр төлбөрийн үзүүлэлтүүдийг зах зээлийн үнэ цэн, эсвэл тухайн үеийн зохистой үнэ цэнээр илэрхийлж бизнесийн цэвэр хөрөнгийн үнэ цэнийг тодорхойлсон байна.

Уг үнэлгээний аргын хүрээнд Хөндлөнгийн үнэлгээний байгууллага нь Үнэт цаас гаргагчийн эзэмшлийн тухайлсан үл хөдлөх хөрөнгүүдийг үнэлж өнөөгийн үнэ цэнийг тодорхойлоход санхүүгийн тайлан дээрх дүнгээс 11,642 сая төгрөгөөр илүү үнэлэгдсэн байна. Мөн Үнэт цаас гаргагчийн 2021 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн байдлаар аудитлагдсан санхүүгийн тайлангийн тодруулгад тусгасан зээл болон хадгаламжийн дансны бодит үнэ цэнийн тооцооллын дагуу уг данснуудад тохируулга хийсэн. Үүний үр дүнд зээлийн дансанд 80,142 сая төгрөг, хадгаламжийн дансанд (56,736) сая төгрөгийн тохируулгуудыг тус тус хийсэн байна. Санхүүгийн тайлан дээрх хөрөнгө болон өр төлбөрүүдийн дүнг 2021 оны 6 сарын 30-ний өдрөөрх аудитлагдсан санхүүгийн тайлангийн дүн дээр нэмэлт тохируулгуудыг хийн үнэлэхэд Үнэт цаас гаргагчийн цэвэр хөрөнгийн хэмжээ нь 797,399 сая төгрөг байна.

Хөрөнгөд суурилсан хандлагын арга нь тухайн бизнесийн орлого олох чадварыг харуулж чаддаггүй тул тасралтгүй байх зарчмаар үйл ажиллагаа нь үргэлжилж буй бизнесийн үнэлгээнд ашиглахад тохиромжгүй болно.

Үнэлгээний үр дүн

Хөндлөнгийн үнэлгээний байгууллага нь Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагааны онцлог, бизнес хөгжүүлэлтийн өнөөгийн нөхцөл байдал, үнэлгээний ажлын



зорилготой уялдуулан үнэлгээний эцсийн үр дүнг Орлогын хандлагын Хорогдуулсан ногдол ашгийн аргаар хийж гүйцэтгэсэн үр дүнгээр авсан болно.

Хүснэгт 47. Хөндлөнгийн үнэлгээний Үнэлгээний үр дүн

Үнэлгээний хандлага	Үнэлгээний арга	Бизнесийн үнэ цэн, сая төгрөгөөр
Зах зээлийн харьцуулалтын хандлага	Жишиг компани, Жишиг хэлцлийн аргууд	696,359 – 1,095,340
Орлогын хандлага	Хорогдуулсан ногдол ашгийн арга	980,137
Хөрөнгөд суурилсан хандлага	Цэвэр хөрөнгийн өртгийн арга	797,339
Эцсийн үнэлгээ		980,137

Үнэт цаасны танилцуулга бэлтгэх үеийн байдлаар Үнэт цаас гаргагч нь 716,194,152 ширхэг энгийн хувьцаатай байгаа бөгөөд нэгж хувьцааг хувааж, нийтэд санал болгон арилжаалах хувьцааг нэмж гаргаснаар нийт 796,596,895 ширхэг энгийн хувьцаатай болно.

Хөндлөнгийн үнэлгээний байгууллагын тооцоолсон бизнесийн үнэлгээний үр дүнгээр нэгж энгийн хувьцааны зах зээлийн үнэ цэн 1,298.3 төгрөг байхаар тогтоогдсон байх ба Үнэт цаас гаргагчийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2021 оны 12 сарын 27-ны өдрийн хурлын 00/29 тоот тогтоолоор нэгж хувьцааны үнийг 1,285 төгрөгөөр нийт үнээр нийтэд санал болгохоор шийдвэрлэсэн.

5.4 Үнэт цаас гарган татан төвлөрүүлэх хөрөнгийн зарцуулалт

Үнэт цаас гаргагч нь нийт 80,402,743 ширхэг энгийн хувьцааг нэг бүр нь 1,285 төгрөгөөр олон нийтэд санал болгон арилжих бөгөөд нийт 103,317,524,755 төгрөгийн санхүүжилт татан төвлөрүүлнэ. Нийт татан төвлөрүүлсэн санхүүжилтийн дүнгээр банкны өөрийн хөрөнгийг 103,317,524,755 төгрөгөөр нэмэгдүүлж, эрсдэл даах чадамжийг бэхжүүлэн үйл ажиллагаагаа өргөжүүлэхээр төлөвлөж байна.

Банкны өөрийн хөрөнгийг нэмэгдүүлснээр өөрийн хөрөнгө, эрсдэлээр жигнэсэн активын харьцаа үзүүлэлт сайжирч эрсдэлээр жигнэсэн актив буюу зээлийн багцын хэмжээг ойролцоогоор 790 гаруй тэрбум төгрөгөөр өсгөх боломж бүрдэж, ирээдүйн бизнесийн тогтмол өсөлтийг бий болгох гол суурь болно.

Үнэт цаас гаргагч нь нийтэд хувьцааг санал болгох замаар татан төвлөрүүлэх 103,317,524,755 төгрөгөөс үнэт цаас гаргахтай холбоотой шууд зардлыг хассан цэвэр дүнгээр банкны үндсэн бүтээгдэхүүн болох зээл олголтыг Хүснэгт 48-ийн



дагуу санхүүжүүлэхэд зарцуулахаар төлөвлөсөн. Үнэт цаас гаргахтай холбоотой шууд зардлуудыг татан төвлөрүүлсэн хөрөнгөнөөс зарцуулна.

Хүснэгт 48. Зээл олголтын төлөвлөгөө

Зээлийн төрөл	Эзлэх хувь /%/
Бизнесийн зээл - ААН	37.3%
Бизнесийн зээл - ЖДҮ ААН болон иргэд	26.0%
Хэрэглээний зээл (Автомашин, Цалин, Кредит карт, Бусад)	20.7%
Орон сууцны зээл	16.0%
Нийт	100.0%

Татан төвлөрүүлэх хөрөнгийн ашиглалт болон банкны өөрийн хөрөнгийг нэмэгдүүлснээр бий болох бизнесийн өсөлт, эдийн засгийн үр өгөөжийг Дунд хугацааны бизнес төлөвлөгөө (Бүлэг 4.5)-ний дагуу боловсруулсан Санхүүгийн төсөөлөл (Бүлэг 4.6) хэсгээс харна уу.

5.5 Үнэт цаасаар гэрчлэгдэх үүрэг

Үнэт цаас эзэмшигчийн эрх

Үнэт цаас гаргагчийн хувьцаа эзэмшигч нь Монгол Улсын Компанийн тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Компанийн засаглалын кодекс, Компанийн дүрэм болон хувьцаат компанийн дүрмийн төсөлд зааснаар дараах эрхүүдийг эдэлнэ. Үүнд:

- Хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцож, хурлаар хэлэлцэж байгаа асуудлаар эзэмшиж байгаа хувьцааны тоотой хувь тэнцүү санал өгөх;
- Эзэмшиж буй хувьцааны хувь хэмжээгээр ногдол ашиг авах;
- Компанийн талаарх бүх мэдээллийг авах, санхүүгийн болон бусад баримт бичигтэй танилцах;
- Компанийг татан буулгах үед Компанийн тухай хуулийн 28 дугаар зүйлд заасан журмын дагуу үлдсэн эд хөрөнгийг худалдсанаас олсон орлогоос хувь хүртэх;
- Компанийн тухай хуулийн 38 дугаар зүйл болон Компанийн дүрэмд заасны дагуу Компаниас нэмж гаргах хувьцаа, түүнд хамаарах үнэт цаасыг өөрийн эзэмшиж байгаа хувьцаанд хувь тэнцүүлэн тэргүүн ээлжид худалдан авах.

Хувьцаа эзэмшигч нь компаниас доорх мэдээллийг шаардан авах эрхтэй. Үүнд:

- Компанийн анхан шатны болон нягтлан бодох бүртгэлийн тайлан, гүйцэтгэх удирдлагын хурлын тэмдэглэл, тушаал шийдвэр болон хууль тогтоомжоор



нийтэд мэдээлэхийг хориглосноос бусад баримт бичигтэй танилцах, үнэ төлбөртэй хуулбарлан авах;

- Компанийн жилийн санхүүгийн болон үйл ажиллагааны тайлан, компанийн нэгдмэл сонирхолтой этгээдийн нэр, тэдгээрийн эзэмшлийн хувьцааны төрөл, тоо болон Санхүүгийн Зохицуулах Хороо, Монголын Хөрөнгийн Биржийн дүрэм журмаар тогтоосон бусад мэдээлэлтэй танилцах;
- Компанийн бусад энгийн хувьцаа эзэмшигчдийн эцэг/эхийн нэр, өөрийн нэр, оршин суугаа газрын хаяг, түүний эзэмшлийн хувьцааны тоо зэргийг агуулсан бүртгэлийг шаардах эрхтэй бөгөөд үүнтэй холбогдон гарах зардлыг шаардлага гаргасан хувьцаа эзэмшигч хариуцна;
- Хууль тогтоомж болон Компанийн дүрмээр тогтоосон бусад эрх багтана.

Үнэт цаас эзэмшигчийн үүрэг

Үнэт цаас гаргагчийн хувьцаа эзэмшигчид дараах үүргийг хүлээнэ. Үүнд:

- Өөрийн нэр, оршин суугаа газрын хаяг болон эзэмшиж байгаа үнэт цаасны тоог Компанийн үнэт цаас эзэмшигчдийн бүртгэл хөтлөх этгээдэд мэдээлэх, түүнчлэн эдгээрт орсон нэмэлт, өөрчлөлтийг тухай бүрд нь мэдэгдэх;
- Нийт гаргасан хувьцааны гуравны нэг болон түүнээс дээш хувийг дангаараа эсхүл нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамтран худалдан авч эзэмшихийг хүссэн этгээд Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд заасны дагуу тендер санал зарлах;
- Нийт гаргасан хувьцааны таваас дээш хувийг дангаараа болон нэгдмэл сонирхолтой этгээдтэйгээ хамтран эзэмшсэн этгээд өмчлөх эрх үүссэнээс хойш ажлын 3 хоногийн дотор энэ тухай Компанид бичгээр мэдэгдэх;
- Компанийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.4, 9.5 заалтад зааснаас бусад тохиолдолд өөрийн эзэмшлийн хувьцааныхаа хэмжээгээр хариуцлага хүлээх;
- Хууль тогтоомж болон Компанийн дүрмээр тогтоосон бусад үүрэг орно.



5.6 Ногдол ашгийн бодлогын төсөл

Үнэт цаас гаргагч нь ногдол ашгийн бодлогыг Банкны тухай хууль, Компанийн тухай хууль, Монголбанкны Ерөнхийлөгчийн 2019 оны 5-р сарын 23-ны өдрийн А-138 тоот тушаалаар батлагдсан Банкны үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тогтоох, түүнд хяналт тавих журам, Санхүүгийн зохицуулах хорооны 2014 оны 5-р сарын 07-ны өдрийн 162 дугаар тогтоолоор батлагдсан Компанийн засаглалын кодекс, Санхүүгийн зохицуулах хорооны 2021 оны 6-р сарын 11-ний өдрийн 225 дугаар тогтоолоор батлагдсан Үнэт цаасны бүртгэлийн журам болон холбогдох бусад хууль тогтоомж, Голомт банкны дүрэмд үндэслэн баталсан.

Голомт банкны ногдол ашгийн бодлого нь нэг талаас банкны ашгийг зохистой хэмжээнд хувьцаа эзэмшигчдэд шууд хуваарилах, нөгөө талаас банкны үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүдийг ханган, байгууллагын ирээдүйн өсөлтийг бий болгох гэсэн хоёр үндсэн зорилтын тэнцвэртэй байдлыг хангахад чиглэсэн.

Хэдийгээр ногдол ашгийн хуваарилах шийдвэр нь тухайн жилийн санхүүгийн үр дүнгээс шууд хамааралтай боловч энэ нь мөн зохицуулагч байгууллагаас гаргасан шийдвэр, хууль тогтоомж болон тэдгээрт нийцүүлэн гаргасан заавал дагаж мөрдөх шинжтэй дүрэм журмууд зэрэг зохицуулалтаар хязгаарлагддаг.

Нэр томъёоны тодорхойлолт

Энэхүү бодлогод дурдагдсан нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно. Үүнд:

Ногдол ашиг – татварын дараах ашгийн тодорхой хэсгийг банкны энгийн болон давуу эрхийн хувьцаа эзэмшигчийн эзэмшиж буй хувьцааны тоо хэмжээтэй харьцуулж хуваарилах явцад компанийн хувьцаа эзэмшигчдийн хүлээн авч буй орлого

Бүртгэл – Банкны хувьцаа эзэмшигчдийн бүртгэл

Бүртгэгч – Хөрөнгийн зах зээлийн мэргэжлийн оролцогч, гэрээний дагуу компанийн үнэт цаас эзэмшигчдийн бүртгэл хөтлөхтэй холбоотой үйл ажиллагаа эрхэлдэг, энэ төрлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй хуулийн этгээд

Бүртгэлийн өдөр – бүртгэлийн өдрийг ТУЗ, Хувьцаа эзэмшигчдийн хурлыг хуралдуулах тухай шийдвэр гаргах үед тогтоох бөгөөд энэ өдөр нь хурал хуралдуулах тухай шийдвэр гарсан өдрөөс өмнө байж болохгүй

Ногдол ашиг тооцох зарчим

Ногдол ашгийг тооцоход дараах зарчмыг баримтална. Үүнд:



- Хувьцаа эзэмшигчдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах;
- Компанийн засаглалын стандартыг дагаж мөрдөх;
- Ногдол ашгийн тооцоо, төлбөрийн ил тод байдлыг хангах;
- Хувьцаа эзэмшигчдийн богино хугацааны болон урт хугацааны ашиг сонирхлын зохистой тэнцвэрийг хадгалах;
- Банкны хөрөнгө оруулалтын сонирхол, үнэ цэнийг нэмэгдүүлэхэд анхаарах;
- Ногдол ашиг банканд хөрөнгө оруулалт татах гол үзүүлэлтүүдийн нэг гэдгийг хүлээн зөвшөөрөх.

Банк ногдол ашиг хуваарилахад дараах хүчин зүйлсийг тооцно. Үүнд:

- Хууль тогтоомж болон зохицуулагч байгууллагын шаардлага;
- Тухайн жилийн болон хүлээгдэж буй санхүүгийн гүйцэтгэл;
- Бизнесийн өсөлт болон хөрөнгө оруулалтын төлөвлөгөө;
- Тухайн үеийн болон хүлээгдэж буй өөрийн хөрөнгийн хүрэлцээ цаашид дагаж мөрдөх зохицуулалт ба өсгөх шаардлага.

Банк нь дараах нөхцөлүүдийг хангасан тохиолдолд ногдол ашиг хуваарилах боломжтой. Үүнд:

- Ногдол ашиг төлсний дараа банк нь төлбөрийн чадвартай байх;
- Банк нь ногдол ашиг хуваарилсны дараа Монголбанкнаас тогтоосон зохистой харьцааны үзүүлэлтүүдийг бүрэн хангаж байх.

Нэг төрлийн хувьцаанд ногдох ногдол ашгийн хэмжээ нь ижил байх бөгөөд тухайн төрлийн нийт хувьцаанд хуваарилахаар тооцогдсон ногдол ашгийн дүнг тухайн төрлийн хувьцааны нийт тоонд хуваасантай тэнцүү байна.

Банкны эзэмшдэг (халаасны) хувьцаанд болон Монгол Улсын холбогдох хуульд заасан бусад тохиолдолд ногдол ашиг хуваарилахгүй, төлөхгүй болно.

Ногдол ашиг хуваарилах, шийдвэр гаргах

Ногдол ашиг хуваарилах тухай шийдвэрийг Банкны Төлөөлөн удирдах зөвлөл санхүүгийн жил дууссанаас хойш 50 хоногийн дотор гаргаж, Хувьцаа эзэмшигчдэд танилцуулна. Уг шийдвэрт хувьцаа бүрд ногдох ашгийн хэмжээ, ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах өдөр болон ногдол ашиг хуваарилах өдөр зэргийг заана. Ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчийг бүртгэлийн өдрөөр тасалбар болгон тодорхойлно.

Банк нь ногдол ашиг хуваарилахаар зарласнаас хойш тараах хүртэл хугацаандаа тодорхой хувьцаа эзэмшигчдэд давуу эрх олгохгүй.



Хувьцаа эзэмшигчийн мэдээлэл өөрчлөгдсөн тохиолдолд хувьцаа эзэмшигч энэ талаар Бүртгэгч болон Банканд даруй мэдэгдэх шаардлагатай. Тийнхүү мэдэгдээгүйгээс Банк ногдол ашгийг цаг тухайд нь төлөөгүйтэй холбоотой учирсан хохирлыг Банк эсхүл Бүртгэгч хариуцахгүй.

Хэрэв зарласан ногдол ашиг Банкнаас хамаарахгүй шалтгаанаар хувьцаа эзэмшигчид төлөгдөөгүй (төлөгдөөгүй ногдол ашиг) бол Банк эдгээр ногдол ашгийг Монгол Улсын хууль тогтоомжид заасны дагуу нөхөн төлнө. Төлөгдөөгүй ногдол ашигт хүү тооцохгүй.

Төлөөлөн удирдах зөвлөл нь ногдол ашиг хуваарилалтын тайланг Хувьцаа эзэмшигчдийн дараагийн хуралд тайлагнана.

Ногдол ашгаас тооцогдох татвар

Ногдол ашгаас Монгол Улсын татварын тухай холбогдох хууль тогтоомж, олон улсын гэрээнд заасан журмын дагуу татвар ногдуулна.

Банк хувьцаа эзэмшигчид ногдол ашгийг олгохдоо холбогдох хууль тогтоомж, олон улсын гэрээнд заасан хэмжээ, журам, хугацаанд суутгах татварыг дүнг хасч олгоно.

Хэрэв хувьцаа эзэмшигч татварын хөнгөлөлт эдлэх эрхтэй бол хувьцаа эзэмшигч нь энэхүү хөнгөлөлт эдлэх эрхтэй болохыг баталгаажуулсан баримт бичгийг татварын албанд гаргаж өгч болно.

Хэрэв ногдол ашиг хуваарилах хугацаанд татварын хууль, тогтоомжид нэмэлт, өөрчлөлт орсон бол Банк нь ногдол ашгаа олгохдоо тухайн төлбөр хийх үеийн Монгол Улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа татварын хууль тогтоомжийн дагуу зохих татварыг тооцоолж өөрчлөлт оруулна.

Мэдээллийн нээлттэй байдал

Банк өөрийн албан ёсны цахим хуудаст холбогдох мэдээллийг нийтэд мэдээлэх замаар ногдол ашгийн бодлогын ил тод байдлыг хангана.

Банкны цахим хуудаст байршуулах мэдээлэлд энэхүү ногдол ашгийн бодлого, түүнд оруулсан нэмэлт, өөрчлөлт, ногдол ашиг олгох тухай Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын шийдвэрийн талаарх мэдээлэл, түүний дотор төлбөрийн хэмжээ, хугацаа, хэлбэр, журмыг багтаасан дэлгэрэнгүй мэдээллийг тусгана.

Хүчинтэй хугацаа ба нэмэлт өөрчлөлт оруулах

Ногдол ашгийн бодлогыг Банкны ТУЗ-ийн шийдвэрээр баталж, нэмэлт өөрчлөлт оруулна.



Ногдол ашгийн бодлоготой холбоотой асуудлыг ТУЗ-ийн хурлаар хэлэлцэх эсэхийг тухай бүр шийдвэрлэнэ.

5.7 Анхдагч зах зээлд байршуулах төлөвлөгөө


Үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжаа нь МХБ-ийн ТУЗ-ийн 2018 оны 1-р сарын 25-ны өдрийн 2018/01 дугаар тогтоолоор баталсан Үнэт цаасны бүртгэлийн журам, СЗХ-ны 2021 оны 6-р сарын 11-ны өдөр баталсан Үнэт цаасны бүртгэлийн журам болон МХБ-ийн ТУЗ-ийн 2018 оны 10-р сарын 26-ны өдрийн 15 тоот тогтоолоор баталсан Үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжааны журмын дагуу явагдана.

Үнэт цаас гаргагч нь МХБ-ийн Гүйцэтгэх Захирлын зөвшөөрлөөр МХБ-ийн хувьцааны бүртгэлийн I ангиллын шалгуурын дагуу Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 9.1-д заасны дагуу хувьцааг нийтэд санал болгон арилжаална.

Үнэт цаас гаргагчийн 2021 оны 12 сарын 27-ны өдрийн ТУЗ-ийн 00/29 тоот тогтоолын дагуу нийтэд санал болгох хувьцааны нэгжийн үнийг 1,285 төгрөгөөр тогтоосон бөгөөд МХБ-ийн анхдагч зах зээлийн арилжааны тогтоосон үнийн аргыг ашиглан санал болгохоор шийдвэрлэсэн.

Үнэт цаас гаргагчийн олон нийтэд санал болгож буй 80,402,743 ширхэг энгийн хувьцааг олон нийтэд танилцуулах үйл ажиллагааг МХБ болон СЗХ үнэт цаасыг бүртгэсэн өдрөөс хойш ажлын 10 хоногийн дотор, анхдагч зах зээлийн арилжааны захиалгыг ажлын 5 хоногийн дотор хүлээн авна.

Схем 8. Анхдагч зах зээлийн арилжааны төлөвлөгөө



МХБ болон СЗХ-д үнэт цаасыг бүртгүүлэх

Үнэт цаасыг бүртгүүлж, холбогдох зөвшөөрөл авах

Үнэт цаас гаргагч нь нийтэд санал болгох үнэт цаасыг бүртгэлд бүртгүүлэх хүсэлтийг СЗХ болон МХБ-д гаргах бөгөөд эдгээр эрх бүхий байгууллагуудаас үнэт цаасыг бүртгэхийг зөвшөөрснөөр үнэт цаасыг нийтэд санал болгон арилжаалах боломжтой болно.

Олон нийтэд танилцуулах

Үнэт цаасыг анхдагч зах зээлд санал болгох, арилжаалах зөвшөөрөл гарсны дараа үнэт цаасыг нийтэд санал болгон танилцуулах аяныг зохион байгуулна. Үүнд хөрөнгийн зах зээлийн мэргэжлийн оролцогч, олон нийт болон стратегийн хөрөнгө оруулагчдад зориулсан танилцуулга уулзалт болон олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр үнэт цаасыг танилцуулах мэдээ мэдээлэл зэрэг нь багтана.

Анхдагч зах зээлийн арилжааны захиалга хүлээн авах

Үнэт цаас гаргагч болон Үндсэн андеррайтер нь олон нийтэд хувьцаагаа сурталчилж эхлэхээс ажлын 3-с доошгүй хоногийн өмнө анхдагч зах зээлийн арилжааг эхлүүлэх хүсэлтийг СЗХ-нд гаргах бөгөөд тус зөвшөөрөл олгогдсоноор олон нийтэд сурталчлах ажиллагааг эхлүүлж, анхдагч зах зээлийн арилжааны захиалгыг хүлээн авах болно. Стратегийн хөрөнгө оруулагчдаас анхдагч зах зээлийн захиалгыг Үнэт цаас гаргагчийн андеррайтерууд, олон нийтээс анхдагч зах зээлийн захиалгыг Биржийн гишүүн бүх үнэт цаасны компаниар дамжуулан тус тус авна.


Анхдагч зах зээлийн арилжааны хуваарилалт хийх

Үнэт цаасны анхдагч зах зээлийн хуваарилалт хийх үйл ажиллагааг Үндсэн болон Туслах андеррайтер нь Үнэт цаас гаргагчтай зөвшилцөн, МХБ-ийн Үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжааны журмын дагуу гүйцэтгэнэ. Үнэт цаас гаргагч нь олон нийтэд тогтоосон үнийн аргаар үнэт цаасыг санал болгоно.

МХБ-н Үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжааны журмын 3.3 дах заалтыг үндэслэн үнэт цаас гаргагчаас дараах хязгаарлалтын нөхцөлийг тогтоосон. Үүнд:

- Жижиг хөрөнгө оруулагчдын 10 ширхэг хүртэлх хувьцааны захиалгыг бүрэн биелнэ.

Андеррайтер нь анхдагч зах зээлийн арилжаа явагдаж дууссанаас хойш ажлын 3 өдөрт багтаан арилжааны тайланг СЗХ-нд хүргүүлнэ. СЗХ нь уг тайланг хүлээн авч анхдагч зах зээлийн арилжааг амжилттай явагдсанд тооцвол Үнэт Цаасны



Төвлөрсөн Хадгаламжийн Төв ХХК-д өмчлөх эрхийн бүртгэл хийх болон арилжаа эрхлэх байгууллагад үнэт цаасны хоёрдогч зах зээлийн арилжааг эхлүүлэх зөвшөөрлийг тус тус ажлын 3 өдөрт багтаан хүргүүлнэ.

Тогтоосон үнээр санал болгох арилжааны арга

МХБ-ийн Үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжааны журмын 10-р зүйлд заасны дагуу тогтоосон үнээр санал болгон арилжих арга гэдэгт Үнэт цаас гаргагч нь үнэт цаасны үнийг тодорхойлж, хөрөнгө оруулагч нь үнэт цаас худалдан авах захиалгыг зөвхөн тогтоосон үнээр өгөх бөгөөд энэ аргыг ашиглах үед үнийн болон цаг хугацааны ахлах дараалал үйлчилдэггүй.

Үнэт цаас гаргагчийн хувьд зөвхөн тогтоосон үнээр буюу нэг үнийн түвшинд арилжааг явуулах ба худалдан авах захиалгын тоо ширхэг худалдах захиалгын тоо ширхгээс илүү гарсан тохиолдолд хувь тэнцүүлэх аргыг ашиглана. Хувь тэнцүүлэх аргаар хуваарилалт хийхэд захиалгын үнийн болон цаг хугацааны ахлах дараалал үйлчлэхгүй.

Greenshoe option буюу хувьцаа нэмж гаргах

Анхдагч зах зээлд хувьцааны захиалгын эрэлтийн хэмжээ нийлүүлэлтийн хэмжээнээс давсан тохиолдолд Үнэт цаас гаргагч болон Андеррайтер нь нийтэд санал болгон гаргаж буй хувьцааны 15 хүртэлх хувьтай тэнцэх хэмжээний хувьцааг Санхүүгийн Зохицуулах Хорооны холбогдох журмын дагуу нэмж гаргаж болно.

Хуваарилалт

Анхдагч зах зээлд хувьцааны захиалгын эрэлтийн хэмжээ нь санал болгож буй хувьцааны тооноос давсан тохиолдолд Үнэт цаас гаргагч болон Андеррайтер нь "Greenshoe option"-ийг хэрэгжүүлэх эсэхээс хамааран хувьцааны хэмжээг тооцож, захиалгын хэмжээнд хувь тэнцүүлэх аргаар үнэт цаасны хуваарилалт хийнэ.

Стратегийн хөрөнгө оруулагч

МХБ-ийн Үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжааны журмын 3.4 дэх хэсэгт тодорхойлсноор Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд давуу талыг бий болгох, үнэт цаасыг 6-аас доошгүй сарын хугацаанд тусгаарлуулах үүрэгтэй хөрөнгө оруулагчийг стратегийн хөрөнгө оруулагчид тооцдог. Үнэт цаас гаргагч нь дараах хөрөнгө оруулагчдыг стратегийн хөрөнгө оруулагч гэж үзнэ. Үүнд:

- Үнэт цаасны хоёрдогч зах зээлийн арилжаа нээгдсэнээс хойш 6-аас доошгүй сарын хугацаанд хувьцааг тусгаарлах;


Хөрөнгө оруулалтын дүн 200,000,000 (хоёр зуун сая) төгрөг ба түүнээс дээш байх.



Үнэт цаас гаргагч нь нийтэд санал болгож буй хувьцааны 80 хүртэлх хувийг стратегийн хөрөнгө оруулагчдад хуваарилна.

Үнэт цаасны анхдагч арилжаанд оролцох заавар

Схем 9. Үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжаанд оролцох заавар



Үнэт цаас худалдан авах сонирхолтой хөрөнгө оруулагч нь анхдагч зах зээлийн арилжаанд дараах зааврын дагуу оролцоно.

Мөнгөн хөрөнгө байршуулах

Үнэт цаас худалдан авах хүсэлтэй хөрөнгө оруулагч нь өөрийн үйлчлүүлж буй үнэт цаасны компанийн зааварчилгааны дагуу мөнгөн хөрөнгө байршуулна.

Арилжааны шимтгэл

Үнэт цаасанд хөрөнгө оруулагч нь гүйлгээний үнийн дүнгийн тодорхой хувиар тооцсон үйлчилгээний хөлс буюу шимтгэлийг өөрийн сонгосон үнэт цаасны компанид төлөх ба уг шимтгэлд зохицуулагч байгууллагуудын болон үнэт цаасны компаниудын шимтгэлийн нийт дүн багтсан байна. Үнэт цаасны компаниудын шимтгэл нь харилцан адилгүй болохыг анхаарна уу.

Албан татвар

Үнэт цаасанд хөрөнгө оруулагч Монгол Улсад байрладаг хувь хүн нь Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 16.1.3-т заасан орлого (ногдол ашгийн орлого)-ын нийт дүнгээс, 17.1.3-т заасан орлого (хувьцаа, үнэт цаас борлуулсны орлого)-оос худалдаж авсан үнийг хассан зөрүүгээс тус хуулийн 21.5-т заасан 5 хувийн хэмжээгээр татвар төлнө.

Үнэт цаасанд хөрөнгө оруулагч Монгол Улсад байрладаг хуулийн этгээд буюу аж ахуйн нэгж нь Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 18.6.2-т заасан (ногдол ашгийн орлого) нийт дүнгээс, 18.3-т заасан (хувьцаа, үнэт цаас



борлуулсны орлого) худалдаж авсан үнийг хассан зөрүүгээс тус хуулийн 20.2.5-т заасан 5 хувийн хэмжээгээр татвар төлнө.

Гадаад улсын иргэн, хуулийн этгээд нь холбогдох хууль тогтоомжид заасны дагуу татвар төлөх үүрэг хүлээх бөгөөд тухайн харьяаллын улстай давхар татварын гэрээ байгуулсан эсэх болон гэрээний нөхцөлийг судлан үзсэний үндсэн дээр хөрөнгө оруулахыг зөвлөж байна.

Үнэт цаасны хоёрдогч зах зээлийн арилжаа



Үнэт цаасыг анх удаа нийтэд санал болгох ажиллагаа амжилттай болсон тохиолдолд МХБ-ийн журмын дагуу СЗХ-ны зөвшөөрлөөр үнэт цаасны хоёрдогч зах зээлийн арилжааг эхлүүлнэ. Үнэт цаасны хоёрдогч зах зээлийн арилжаа эхэлснээр хувьцааг анхдагч зах зээлээс худалдан авсан хөрөнгө оруулагчид хувьцаагаа бусдад худалдаалах эрх нээлттэй болно.

5.8 Үнэ тогтворжуулах хөтөлбөр

Үндсэн андеррайтер Инвескор Капитал ҮЦК ХХК болон туслах андеррайтер Голомт Капитал ҮЦК ХХК нь хамтран хувьцааны үнэ тогтворжуулах хөтөлбөрийг Үнэт цаас гаргагчийн хувьцааны үнийн хэт өндөр өсөлт, бууралтаас хамгаалах, хөрвөх чадварыг нэмэгдүүлэх, үнийн тогтвортой байдлыг хангах зорилгоор Үнэт цаас гаргагчийн нийтэд анх удаа санал болгосон хувьцааны хоёрдогч зах зээлийн арилжаа эхэлсэн өдрөөс хойш 6 сарын хугацаанд хэрэгжүүлнэ.

Мөн андеррайтер нь хувьцааны хоёрдогч зах зээлийн арилжааны идэвхийг нэмэгдүүлэх, хувьцааны үнийг зах зээлд бодитоор тогтоход дэмжлэг үзүүлэх зорилгоор Үнэт цаас гаргагчийн цаг үеийн болон онцгой үйл явдлын мэдээлэл, хувьцааны хөндлөнгийн судалгаа, шинжилгээг олон нийт болон хөрөнгө оруулагчдад нийтийн цахим сүлжээ, бусад холбогдох мэдээллийн сувгуудаар дамжуулан тогтмол хүргэж ажиллах болно. Мөн Андеррайтерууд нь үнэт цаас гаргагчийн хувьцааны үнийн хэт өндөр өсөлт, бууралтаас хамгаалах, хөрвөх чадварыг нэмэгдүүлэх, үнийн тогтвортой байдлыг хангах зорилгоор үнэт тогтворжуулах хөтөлбөрийг хэрэгжүүлнэ. Үнэ тогтворжуулахтай холбоотой ажиллагаа дууссанаас хойш Андеррайтер нь тогтворжуулалтын чиглэлээр хийсэн гүйлгээний тайланг ажлын 3 өдрийн дотор СЗХ ба МХБ-д хүргүүлж ажиллана.

Хүснэгт 49. Үнэт цаас гаргагчийн хувьцааг үнэ тогтворжуулах хөтөлбөрийг хэрэгжүүлэх нөхцөл

№	Нөхцөл	Хязгаарлалт
	- 273 -	

1	Үнэ анх гаргасан үнээс 20 хувь болон түүнээс дээш хэмжээнд унахад	Үнэ тогтворжуулах нөхцөл үүссэн гэж үзэж үнэ тогтворжуулах хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.
2	Багцын арилжаа	Багц арилжааны хэлцэл нь энэхүү хөтөлбөрт хамаарахгүй.
3	Үнэ тогтворжуулах хөтөлбөр хэрэгжих хугацаа	Хувьцааны хоёрдогч зах зээлийн арилжаа эхэлснээс хойш 6 сарын хугацаанд

Хувьцааны үнэ тогтворжуулах хөтөлбөр нь хувьцааны хоёрдогч зах зээлийн арилжаа эхэлснээс 6 сарын хугацаанд хэрэгжинэ. Хувьцааны үнэ тогтворжуулах үйл ажиллагаанаас гарах зардал нь Үнэт цаас гаргагчийн олон нийтээс татан төвлөрүүлсэн хөрөнгөөс суутгагдахгүй бөгөөд Хувьцааны үнэ тогтворжуулах хөтөлбөрийн нэрийн дор Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 80 дугаар зүйлд заасан хэлбэрээр зах зээлийг урвуулан ашиглахгүй.

5.9 Ажилтанд хувьцаа эзэмшүүлэх хөтөлбөр

Үнэт цаас гаргагч нь ажилтнуудын идэвх оролцоог нэмэгдүүлэх зорилгоор банкны ажилтнуудад хувьцааг опционоор эзэмшүүлэх хөтөлбөрийг хэрэгжүүлэхээр шийдвэрлэсэн.

Ажилтнуудад хувьцаа эзэмшүүлэх хөтөлбөрийн зорилго нь ажилтнуудын ашиг сонирхлыг хувь нийлүүлэгчдийн ашиг сонирхолтой нэгтгэх, тэднийг тогтвор суурьшилтай, үр бүтээлтэй ажиллуулж, улмаар Үнэт цаас гаргагчийн ашгийг болон Ажилтнуудын өгөөжийг нэмэгдүүлэх, зах зээлд өрсөлдөх чадварыг сайжруулах юм.

Опционы давуу тал нь:

- Опцион нь урьдчилан тогтоосон үнээр хувьцааг ирээдүйд худалдан авах эрх /үүрэг биш/ юм;
- Ажилтнууд опцион хүлээн авахдаа хувьцааны төлбөрийг шууд төлөх шаардлагагүй;
- Опцион хэрэгжих үед хувьцааны зах зээлийн үнэ урьдчилан тогтоосон опционы үнээс өндөр байх тохиолдолд ашиг хүртэх боломжтой.

Ажилтнуудад хувьцаа эзэмшүүлэх хөтөлбөр нь ажилтнууд болон хувьцаа эзэмшигчийн хоорондох заагийг багасгаж, хувьцааны үнийн өсөлтөд эерэг нөлөө авчирдаг тул олон улсад түгээмэл ашиглагддаг.

Үүний нэгэн тод жишээ нь Үнэт цаас гаргагчийн 2011 оноос анх хэрэгжүүлсэн ажилтнуудад хувьцаа эзэмшүүлэх хөтөлбөр юм. Уг хөтөлбөрийн хүрээнд нийт 507 ажилтан опционы гэрчилгээ хүлээн авснаас 32 хувь нь буюу 162 ажилтан эрхээ



хэрэгжүүлж Голомт банкны хувьцааг худалдан авсан байдаг. Өнөөдрийн байдлаар 2011 болон 2012 онд хэрэгжүүлсэн опционы хөтөлбөрөөс 55 ажилтан банкны хувьцаа эзэмшигч болж нийт гаргасан хувьцааны 0.2 хувийг эзэмшиж байна.

Хувьцаа эзэмшсэн ажилтнуудын хувьд банканд 10-аас дээш жил тогтвор суурьшилтай ажиллаж, банкны ашигт ажиллагааг хангасан бөгөөд нэгж хувьцааны үнийн өсөлтөөс дунджаар 300 гаруй хувийн өгөөж хүртсэн байна. Үнэт цаас гаргагчийн ирээдүйн бизнесийн өсөлт, компанийн үнэ цэнэ нь хүний нөөцийн мэдлэг чадвар үүрэг оролцооноос шууд хамааралтай байдаг. Иймд ирээдүйн бизнесийн төлөвлөгөөг амжилттай хэрэгжүүлэх бизнесийн үнэ цэнийг өсгөх үндсэн зорилгын хүрээнд банкны менежментийн баг, үндсэн ажилтнуудыг зөв механизмаар урамшуулж ажиллах нь чухал юм. Иймд "Ажилтанд хувьцаа эзэмшүүлэх хөтөлбөр"-ийн үр өгөөжийг үргэлжлүүлэн үнэт цаас гаргагч нь **2025 он гэхэд нийт хувьцааныхаа 1 хувийг ажилтнууддаа эзэмшүүлэх** зорилго тавьж байгаа бөгөөд 2021 онд ажилтнуудад хувьцааг опционоор эзэмшүүлэх хөтөлбөрийг дараах байдлаар хэрэгжүүлсэн.

Хувьцааны опцион олгох нөхцөл, шалгуурыг холбогдох журмаар зохицуулсан ба энэхүү журмын шалгуурыг хангасан ажилтнуудад 2021 оны 12 сард 2,548,958 ширхэг хувьцааны опцион эзэмшүүлэхээр шийдвэрлэсэн. Опцион эзэмшигч нь опцион хүлээн авснаас хойш 11 сарын дараа (vesting period – опционы эрх хязгаарлагдмал хугацаа) хувьцаагаа худалдан авах эрхээ хэрэгжүүлэх ба Үнэт цаас гаргагч нь зарласан хувьцааныхаа хүрээнд нэмж хувьцаа гарган ажилтнуудад арилжаална.

Хүснэгт 50. Үнэт цаас гаргагчийн хувьцаа нэмж гарган ажилтнууддаа опцион хэлбэрээр эзэмшүүлэх нөхцөл

Шалгуур

Банкны үндсэн ажилтан байх

Ахлах ажилтнаас дээших бүх албан тушаалтнууд

Банканд 3 ба түүнээс дээш жил ажилласан бусад бүх ажилтнууд

Дээрх шалгуурыг хангасан ажилтнууд нь опционыг авснаас хойш 11 сарын хугацаа өнгөрч, опционы эрх нээгдсэнээс хойш 1 сар хүртэлх (опционы эрх нээлттэй хугацаа) хугацаанд опционоо хэрэгжүүлэн хувьцаагаа худалдан авах боломжтой болно.

Опцион хэрэгжсэний дараах буюу **2022 оны 12 сарын байдлаар үнэт цаас гаргагчийн хувьцааны 0.5 хувийг ажилтнууд эзэмшсэн байна.**

Монголын Хөрөнгийн Биржийн Үнэт цаасны бүртгэлийн журмын 16-р зүйлийн 16.1 дэх хэсэгт "Биржийн үнэт цаасны бүртгэлд бүртгэгдсэн үнэт цаас гаргагч нь ажиллагсад хувьцаа эзэмшүүлэх хөтөлбөр хэрэгжүүлэх, хувьцаа худалдан



авах эрхийн опцион гаргах зорилгоор хаалттай хүрээнд нэмж хувьцаа, өрийн бичиг гаргах тохиолдолд үнэт цаасны бүртгэлд өөрчлөлт оруулах бөгөөд уг өөрчлөлтийг Биржийн бүртгэлд бүртгүүлнэ” гэж заасны дагуу Үнэт цаас гаргагч нь хаалттай хүрээнд хувьцаа гарган ажилтнуудад эзэмшүүлэх боломжтой байна.



ГОЛОМТ БАНК
Сайн сайхны санхүүжүүлэгч

Үнэт цаасны танилцуулга

ГОЛОМТ БАНК
Сайн сайхны санхүүжүүлэгч

ЗУРГАА.

ҮНЭТ ЦААС ГАРГАХ
АЖИЛЛАГААНД
ОРОЛЦСОН
БАЙГУУЛЛАГУУД



- 277 -



6 ҮНЭТ ЦААС ГАРГАХ АЖИЛЛАГААНД ОРОЛЦСОН БАЙГУУЛЛАГУУД

6.1 Үндсэн андеррайтерийн танилцуулга, гэрээний тухай

Үндсэн андеррайтерийн тухай

Хүснэгт 51. Үндсэн андеррайтерийн товч танилцуулга


Компанийн нэр	"ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК" ХХК
Улсын бүртгэлийн дугаар	9011741137
Регистрийн дугаар	6317839
Хаяг	Монгол улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 2-р хороо, Сөүлийн гудамж 10/1, Твин Тауэр-1, 13 давхар
Утас	+976-7709 0077 /2/
И-Мэйл	info@icapital.mn
Веб хуудас	www.icapital.mn

Инвескор Капитал ҮЦК ХХК нь Монгол Улсын хөрөнгийн зах зээлд шинэлэг бүтээгдэхүүн үйлчилгээг бий болгох, гадаадын хөрөнгө оруулалтыг татах замаар хөрөнгийн зах зээлийн эргэлтийг нэмэгдүүлэхэд хувь нэмрээ оруулах, дотоодын хөрөнгө оруулагчдад олон улсын хөрөнгийн зах зээлээс өгөөж хүртэх боломжийг нэмэгдүүлэх зорилгоор 2018 онд үүсгэн байгуулагдсан үнэт цаасны компани юм. Тус компани нь Хорооноос үнэт цаасны брокерын үйл ажиллагаа, үнэт цаасны дилерийн үйл ажиллагаа, үнэт цаасны андеррайтерийн үйл ажиллагаа, хөрөнгө оруулалтын зөвлөхийн үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрөл авсан бөгөөд банк, санхүүгийн салбар, хөрөнгийн зах зээл, хууль эрх зүй, өмгөөллийн салбарт ажиллаж байсан чадварлаг хамт олноор багаа бүрдүүлсэн. Биржийн болон Биржийн бус зах зээлд үнэт цаас гаргах үйл ажиллагааг зохион байгуулах, үнэт цаасны арилжаанд зах зээл үүсгэгчээр оролцох, M&A болон хөрөнгө оруулалт, хөрөнгийн удирдлагын чиглэлээр мэргэшсэн туршлагатай.

Инвескор Капитал ҮЦК ХХК-ийн андеррайтерийн үйлчилгээний хүрээнд хийж гүйцэтгэсэн ажлуудаас дурдвал:

- 2019 онд Инвескор ББСБ ХК-ийн хувьцааг Монголын Хөрөнгийн Биржээр дамжуулан олон нийтэд санал болгож, гаргах ажиллагаанд туслах андеррайтераар оролцож нийт 18.6 тэрбум төгрөгийг амжилттай татан төвлөрүүлсэн.

2021 онд Монголын анхны нээлттэй хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас "Инвескор Актив ХБҮЦ"-ыг Монголын Хөрөнгийн биржээр дамжуулан гаргах



ажиллагаанд андеррайтераар ажиллаж нийт 4 тэрбум төгрөгийг амжилттай татан төвлөрүүлсэн. Уг үнэт цаас гаргах ажиллагаанд анхны үүрэг гүйцэтгүүлэгч буюу хөрөнгө худалдагчаар Инвекор ББСБ ХК, Микро Кредит ББСБ ХХК оролцсон.

- 2021 онд хувийн хэвшлийн анхны өрийн хэрэгслийн хөтөлбөр болох Инвекор ББСБ ХК-ийн нийт 20.0 тэрбум төгрөг хүртэлх үнийн дүн бүхий Инвекор Бонд өрийн хэрэгслийн хөтөлбөрийг гаргасан бөгөөд 100% борлуулж дуусгасан.
- Биржийн Бус Зах Зээлд 2021 онд Кэй Эй Майнинг ХХК-ийн нийт 10.0 тэрбум төгрөг хүртэлх үнийн дүн бүхий “Хишиг Бонд 2022 15%” өрийн хэрэгслийн хөтөлбөрийг гаргаж байгаа бөгөөд үүнээс Транч 1 хөтөлбөрийг 11 сард амжилттай борлуулж 3.2 тэрбум төгрөгийг амжилттай татан төвлөрүүлсэн.

Үндсэн андеррайтерийн үйлчилгээ үзүүлэх гэрээний тухай


Үнэт цаас гаргагч Голомт банк ХХК нь Инвекор Капитал ҮЦК ХХК-тай 2021 оны 12-р сарын 16-ны өдөр АУГ_211216/01 тоот Андеррайтерийн болон зөвлөх үйлчилгээний гэрээг байгуулсан.

Тус гэрээгээр Үнэт цаас гаргагчийн нийтэд санал болгон үнэт цаасаа гаргах ажиллагаанд Үндсэн андеррайтер нь Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Санхүүгийн Зохицуулах Хороо болон Монгол Банк, Монголын Хөрөнгийн Биржээс гаргасан холбогдох журам, холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн хийж гүйцэтгэхтэй холбогдон үүсэх талуудын харилцааг зохицуулсан.

Үндсэн андеррайтер нь Үнэт цаас гаргагчийн Үнэт цаасыг нээлттэй хүрээнд стратегийн хөрөнгө оруулагчид болон нийтэд анх удаа санал болгох (IPO) ажлыг зохион байгуулж, хувьцааг анхдагч зах зээлд байршуулж худалдахаар тохиролцсон ба туслах андеррайтер Голомт Капитал ҮЦК ХХК-тай Хамтын ажиллагааны гэрээ байгуулж ажиллахаар заажээ.

Үндсэн андеррайтерийн эрх үүрэг

- Андеррайтер нь тус гэрээний дагуу гүйцэтгэвэл зохих үүрэг болон үзүүлэх үйлчилгээг Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Хороо болон Монголын хөрөнгийн биржийн Бүртгэлийн журам болон хувьцаа гаргах бэлтгэл ажлыг хангахад дагаж мөрдөх шаардлагатай холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн мэргэжлийн өндөр түвшинд зохион байгуулах үүрэгтэй;
- Андеррайтер нь Үнэт цаас гаргагчаас нийтэд санал болгон гаргах хувьцаанаас арилжаалагдаагүй үлдсэн хэсгээс хамгийн багадаа 5,000,000,000 (таван) тэрбум төгрөгийн Үнэт цаасыг нийтэд санал болгосон үнээр худалдан авах үүрэгтэй;
- Андеррайтер нь Үнэт цаас гаргагчийн хувьцааны үнийн хэт өндөр өсөлт, бууралтаас хамгаалах, хөрвөх чадварыг нэмэгдүүлэх, үнийн тогтвортой байдлыг хангах зорилгоор хувьцааны үнийг тогтворжуулах ажиллагааг



- хоёрдогч зах зээлийн арилжаа эхэлсэн өдрөөс хойш 6 сарын хугацаанд гүйцэтгэх үүрэгтэй;
- Гэрээ болон үйлчилгээтэй холбоотой ямарваа нэгэн асуудлаар ямагт Үнэт цаас гаргагчийн зөвлөхийн хувиар хандан ажиллаж, гуравдагч этгээдтэй харилцах аливаа харилцаанд Үнэт цаас гаргагчийн хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах үүрэгтэй;
 - Гэрээг хэрэгжүүлэхтэй холбогдуулан олж авсан Үнэт цаас гаргагчийн аливаа мэдээллийн нууцлалыг хадгалах, энэхүү үүргээ зөрчсөнөөс Үнэт цаас гаргагч болон аливаа гуравдагч этгээдэд учирсан бодит хохирлыг бүрэн хариуцах үүрэгтэй;
 - Андеррайтер, зөвлөхийн үйлчилгээг үр дүнтэй, шуурхай хэрэгжүүлэхэд шаардлагатай байж болох зааварчилгаа, удирдамжийг Үнэт цаас гаргагчаас томилсон ажилтан болон удирдлагад гарган өгөх эрхтэй;
 - Тус гэрээнд заасны дагуу Үнэт цаас гаргагч, түүний эрх бүхий этгээд нь нийтэд санал болгох үнэт цаасны үнийг үндэслэлгүйгээр тогтоосон эсхүл тус үнэ нь хувьцаа гаргах үйл ажиллагааг амжилтгүй болгоход хүргэнэ гэж үндэслэл бүхий тайлбар нотолгоонд суурилан үзсэн тохиолдолд Андеррайтерийн үйлчилгээ үзүүлэхээс татгалзах эрхтэй;
 - Үнэт цаас гаргагчаас Үйлчилгээний хөлсийг Гэрээнд заасны дагуу төлөхийг шаардах эрхтэй.

Үнэт цаас гаргагчийн эрх үүрэг

- Үнэт цаас гаргагч нь Андеррайтерт ажил, үүргээ гүйцэтгэхэд шаардах аливаа зөвшөөрөл, түүнчлэн үйлчилгээ үзүүлэхэд шаардлагатай гэж үзсэн Үнэт цаас гаргагчийн эрх бүхий этгээдийн тогтоол шийдвэр, мэдээ мэдээлэл, баримт бичгүүдийг Андеррайтераас санал болгосон хугацаанд түргэн шуурхай, бүрэн гүйцэд гаргаж өгөх бөгөөд Андеррайтерийг гагцхүү үнэн зөв мэдээллээр хангах үүрэг хүлээнэ;
- Үнэт цаас гаргагч нь үнэт цаас гаргах үйл ажиллагааны маркетинг сурталчилгаа, танилцуулах аяны ажлыг Андеррайтертэй хамтран боловсруулсан маркетингийн төлөвлөгөөний дагуу саадгүй явуулах бүх шаардлагатай нөхцөлийг хангах үүрэгтэй;
- Андеррайтер нь Үйлчилгээг доголдолтой гүйцэтгэсэн бол доголдлыг өөрийн зардлаар арилгахыг шаардах эрхтэй;
- Гэрээг хэрэгжүүлэх явцад Андеррайтерт өгсөн аливаа мэдээллийг жагсаалтын дагуу буцаан авах, Андеррайтерийн авч үлдэх боломжтой мэдээллийг бие даан шийдвэрлэх эрхтэй.

Дээрх гэрээний эрх үүргийн хүрээнд Үндсэн андеррайтер нь Туслах андеррайтер болох Голомт Капитал ҮЦК ХХК-тай 2021 оны 12-р сарын 16-ны өдөр ХАГ 211216/01 тоот КоХамтын ажиллагааны гэрээг Хорооны Үнэт цаасны бүртгэлийн журмын 2.6 дахь хэсэгт заасны дагуу байгуулсан.



6.2 Туслах андеррайтерийн танилцуулга, гэрээний тухай

Туслах андеррайтерийн тухай

Туслах андеррайтер болох Голомт Капитал ҮЦК ХХК нь 2011 онд Голомт Банк ХХК-ийн 100 хувийн хөрөнгө оруулалттайгаар байгуулагдсан. Туслах андеррайтер нь СЗХ-оос 2011 онд брокерын үйлчилгээ, 2014 онд хөрөнгө оруулалтын зөвлөх үйлчилгээ, 2015 онд андеррайтерийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийг тус тус авч иргэд, аж ахуйн нэгжүүдэд хөрөнгө оруулалтын цогц үйлчилгээг үзүүлж байна.

Хүснэгт 52. Туслах андеррайтерийн товч танилцуулга

Компанийн нэр	“ГОЛОМТ КАПИТАЛ ҮЦК” ХХК
Улсын бүртгэлийн дугаар	9011287134
Регистрийн дугаар	5481589
Хаяг	Монгол улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо Чингисийн өргөн чөлөө, Парк Плэйс оффис, 4 давхар, 403 тоот
Утас	+976-7012 1530
Факс	+976-7011 0549
И-Мейл	info@golomtcapital.com
Веб хуудас	www.golomtcapital.com

Голомт Капитал ҮЦК ХХК нь 2018 онд Торонтогийн Хөрөнгийн Биржид бүртгэлтэй Эрдэнэ Ресурс Девелопмент Корпорэйшн ХК-ийн давхар бүртгэлийн (FPO) хамтран андеррайтераар, даатгалын зах зээлд тэргүүлэгч Мандал Даатгал ХК-ийн IPO үндсэн андеррайтераар, 2019 онд шувууны аж ахуйн салбарт тэргүүлэгч Түмэн Шувуут ХК-ийн IPO үндсэн андеррайтераар, эрүүл мэндийн шингэн хүнсний үйлдвэрлэлийн зах зээлд тэргүүлэгч Монос Хүнс ХК-ийн IPO үндсэн андеррайтераар, 2021 онд конвiniес дэлгүүрийн зах зээлд тэргүүлэгч Сэнтрал Экспресс Си Ви Эс ХК-ийн IPO үндсэн андеррайтераар ажилласан IPO андеррайтерийн зах зээлд тэргүүлэгч компани юм.

Түүнчлэн Голомт Капитал ҮЦК ХХК нь 2015 онд Монголын анхны даатгагдсан бонд болох Эрчим бонд, 2017 онд анхны нээлттэй бонд болох Сүү бонд, 2020 онд анхны хайбрид бонд болох Мастер бонд, анхны банкны баталгаат бонд болох Нөмөр бонд, 2021 онд анхны биржийн бус зах зээлийн бонд болох Монкон бондын андеррайтераар тус тус ажилласан туршлагатай хамт олон юм.



Туслах андеррайтерийн үйлчилгээ үзүүлэх гэрээний тухай

Голомт Капитал ҮЦК ХХК нь 2021 оны 12-р сарын 16-ны өдөр 21/82 тоот Хамтын ажиллагааны гэрээг Үндсэн андеррайтер Инвескор Капитал ҮЦК ХХК-тай байгуулсан. Тус гэрээний хүрээнд Үнэт цаас гаргагчид хувьцааг нийтэд анх удаа санал болгох замаар хөрөнгийн зах зээлээс хөрөнгө татан төвлөрүүлэхэд андеррайтерийн үйлчилгээ үзүүлэх, шаардагдах тооцоолол, судалгаа, бэлтгэл ажлуудыг гүйцэтгэх, зөвлөгөө өгөх, Үнэт цаасны танилцуулгыг боловсруулах, хөрөнгө оруулагч нарт Үнэт цаас гаргагч болон гаргаж буй үнэт цаасыг танилцуулах, санал болгох, санхүүжилт татах үйлчилгээ үзүүлэхээр тусгасан.

Түүнчлэн Туслах андеррайтер нь Үнэт цаас гаргагчид нээлттэй хүрээнд санхүүжилт татахад СЗХ болон МХБ-ээс гаргасан Үнэт цаасны бүртгэлийн журмын дагуу үнэт цаас гаргах төлөвлөгөөг бэлтгэн, тухайн хамтарсан төлөвлөгөөний дагуу оролцогч талуудын үйл ажиллагаанд хяналт тавих, үнэт цаасны бүртгэлийн шалгуурыг хангахад зөвлөгөө өгөх, үнэт цаасны танилцуулга материалыг бэлтгэхэд шаардлагатай удирдлагаар хангах, санал зөвлөмжийг өгөх, стратегийн хөрөнгө оруулагч нарт хувьцааны танилцуулгыг компанийг төлөөлөн танилцуулах үүрэг хүлээсэн.

Үнэт цаас гаргагч нь Туслах андеррайтерт гэрээнд заасан үйлчилгээг үзүүлэхэд нь шаардлагатай үнэн зөв, бодит мэдээлэл, бичиг баримт болон материалуудын эх хувь эсвэл баталгаажсан хуулбарыг Туслах андеррайтераас шаардсан цаг тухайд нь бүрэн гаргаж өгөх үүрэг хүлээнэ.



6.3 Аудитын байгууллагын танилцуулга, гэрээний тухай

Аудитын байгууллагын тухай

Хүснэгт 53. Аудитын байгууллагын товч танилцуулга

Компанийн нэр	“Прайсуотерхаускуперс Аудит” ХХК
Улсын бүртгэлийн дугаар	9019050116
Регистрийн дугаар	5357128
Хаяг	Монгол улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, Централ Тауэр, 6 давхарт, 601 тоот
Утас	+976-7000 9089
Факс	+976-11-322-068
Веб хуудас	www.pwc.com/mn

ПрайсуотерхаусКуперс Аудит ХХК (цаашид “PwC” гэх) компани нь 2010 оны 4-р сард Монгол Улсад үүсгэн байгуулагдаж үйл ажиллагаагаа эхлүүлсэн.

Үнэт цаас гаргагчийн 2019 болон 2021 оны жилийн эцсийн СТОУС-н дагуу бэлтгэгдсэн санхүүгийн тайланд ПрайсуотерхаусКуперс Аудит ХХК аудит хийн дүгнэлт гаргасан. Эдгээр аудитлагдсан тайлангуудыг энэхүү ҮЦТ-ын Хавсралт №4 хэсэгт хавсаргасан болно.

Аудитын баг “ACCA” (Олон улсын Мэргэшсэн нягтлан бодогчдын холбоо) жинхэнэ гишүүн, оюутан болон Олон улсын Мэргэшсэн нягтлан бодогч “CPA” болон “CISA” Кибер аюулгүй байдал, дэд бүтцийн аюулгүй байдлын газрын баталгаажуулалт, Монголын мэргэшсэн нягтлан бодогчийн цолтой, аудит болон баталгаажуулах үйлчилгээг үзүүлэх эрхийн батламжтай ажилтнууд багтана.

Прайсуотерхаускуперс Аудит ХХК нь Санхүүгийн Зохицуулах Хорооны 2014 оны 1 дүгээр сарын 29-ний өдрийн 23 тоот тогтоолоор Үнэт цаасны зах зээлд үйлчилгээ үзүүлэх аудитын компаниар бүртгэгдсэн.

Аудитын байгууллагын үйлчилгээ үзүүлэх гэрээний тухай

Прайсуотерхаускуперс Аудит ХХК нь Сангийн сайдын 2019 оны 11 тоот тушаалаар Аудитын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлөө 2025 оны 1 дүгээр сарын 23-ны өдрийг хүртэл 3 жилээр сунгасан. Мөн Санхүүгийн Зохицуулах Хорооны 2012 оны 8-р сарын 8-ны өдрийн 259 тоот тогтоолоор Үнэт цаасны зах зээлд үйлчилгээ үзүүлэх аудитын компаниар бүртгэгдсэний дагуу Үнэт цаас гаргагчтай 2020 оны 9 сарын 23-ны өдрийн MN010-Assurance-48030049-A023-2021 тоот 2021 оны 12 сарын 31-ны өдрөөрх СТОУС-н дагуу бэлтгэгдсэн санхүүгийн тайланд аудитын үйлчилгээ үзүүлэх гэрээг байгуулсан байна.



6.4 Хуулийн байгууллагын танилцуулга, гэрээний тухай

Хуулийн байгууллагын тухай

Хүснэгт 54. Хуулийн компанийн товч танилцуулга

Компанийн нэр	"ӨМГӨӨЛЛИЙН САНХҮҮГИЙН ХУУЛИЙН ЗӨВЛӨХ" ХХК
Улсын бүртгэлийн дугаар	9028001007
Регистрийн дугаар	5908183
Хаяг	Монгол улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 4 дүгээр хороо, Барилгачдын талбай, Макс тауэр 3 давхар 306 тоот
Утас	+976-7000 6967
Үйл ажиллагааны чиглэл	Хууль зүйн зөвлөгөө, туслалцаа, өмгөөллийн үйл ажиллагаа /6910/
И-Мейл	info@flc.mn

Өмгөөллийн Санхүүгийн Хуулийн Зөвлөх ХХК нь 2014 онд Өмгөөллийн Финаншэл Лав консалтинг нэртэйгээр 3 гишүүнтэй, Хязгаарлагдмал хариуцлагатай нөхөрлөл хэлбэрээр үүсгэн байгуулагдсан. Үйл ажиллагаа явуулж эхэлснээс хойш компани, банк санхүү, хөдөлмөрийн эрх зүй, үнэт цаас, үл хөдлөх хөрөнгө, оюуны өмч, даатгал болон бусад чиглэл, эрх зүйн орчны талаар хууль эрх зүйн зөвлөгөө өгөх, шинжилгээ хийх, хууль зүйн дүгнэлт өгөх, иргэн, захиргаа, эрүүгийн чиглэлээр, өмгөөлөл, төлөөллийн үйлчилгээ болон төлбөр барагдуулах үйл ажиллагааг эрхлэн явуулж ирсэн болно.

Тус компани нь:

- 2016 онд Үнэт цаасны зах зээлд оролцогчид хууль зүйн зөвлөгөө үзүүлэх хуулийн этгээдээр бүртгэгдсэн;
- 2017 онд оноосон нэрийг өөрчилж Өмгөөллийн Санхүүгийн Хуулийн Зөвлөх ХХН болгон өөрчилсөн;
- 2020 онд байгууллагын хэлбэрийг Хязгаарлагдмал хариуцлагатай компани болгон өөрчилсөн.

Өнөөдрийн байдлаар улсын дээд шүүхэд бүртгэлтэй өмгөөллийн үйл ажиллагаа эрхлэх 6 хуульч, санхүү бүртгэлийн чиглэлээр мэргэшсэн 2 эдийн засагч, туслах хуульчдын хамт нийт 13 хүний бүрэлдэхүүнтэйгээр үйл ажиллагаа явуулж байна.



Өмгөөллийн Санхүүгийн Хуулийн Зөвлөх ХХК нь үнэт цаас гаргах үйл ажиллагаа, зээлийн хөрөнгө, зээлийн материалд хуулийн зөвлөх үйлчилгээ үзүүлж байсан өргөн туршлагатай бөгөөд тухайлбал, Монгол Базальт ХХК-ийн анх удаа хувьцаагаа нийтэд санал болгох ажилд хууль зүйн зөвлөх үйлчилгээ, хууль зүйн дүгнэлт гаргах, Монголын Ипотекийн Корпораци ОССК ХХК-ийн Ипотекийн зээлээр баталгаажсан бонд гаргах 9, 10, 13, 14, 15, 16, 18, 27 дугаар ээлжийн хэлцэлд хуулийн хөндлөнгийн шинжээч, зөвлөх үйлчилгээ үзүүлэх ажлыг хийж гүйцэтгэсэн туршлагатай.

Хууль зүйн үйлчилгээ үзүүлэх гэрээний тухай

Өмгөөллийн Санхүүгийн Хуулийн Зөвлөх ХХК нь Үнэт цаас гаргагчтай 2021 оны 6-р сарын 30-ны ХЗҮҮГ/21/05 дугаартай Хууль зүйн үйлчилгээ үзүүлэх гэрээг байгуулсан байх бөгөөд энэхүү гэрээ нь талууд гэрээнд заасан ажлыг бүрэн гүйцэтгэж дуусах хүртэлх хугацаатай байгуулагдсан. Тус хууль зүйн үйлчилгээ үзүүлэх гэрээний агуулга нь Үнэт цаасны тухай хууль, Санхүүгийн зохицуулах хороо, Монголын хөрөнгийн бирж нарын Үнэт цаасны бүртгэлийн журамд заасны дагуу хууль зүйн хөндлөнгийн дүн шинжилгээ хийж, дүгнэлт гаргах ажил байна.

Гэрээний хугацаанд үйлчилгээ үзүүлэгч хуулийн компани нь ажлаа тохирсон хугацаанд чанарын өндөр түвшинд гүйцэтгэх, гүйцэтгэж байгаа ажлын явцын талаар үйлчлүүлэгч талд мэдээлэх, үйлчилгээ үзүүлэх явцад олж мэдсэн, авсан эсхүл боловсруулсан судалгааны материал, гуравдагч этгээдийн санал, зөвлөмж зэрэг үйлчлүүлэгчийн нууцыг чандлан хадгалах үүргийг хүлээхээр гэрээнд тусгасан байна.

Үнэт цаас гаргагч талаас энэхүү гэрээний дагуу хуулийн компанид гэрээнд заасан ажил үүргийг хэрэгжүүлэхэд шаардлагатай мэдээ, мэдээлэл, баримт материалаар хугацаа алдалгүй хангах, тохиролцсон хугацаанд үйлчилгээний хөлсийг төлөх, гэрээнд заасан ажил үүргийн хэрэгжилт үйл ажиллагаатай танилцах санал хүсэлт өгөх, тайлан гаргуулах зэрэг хууль зүйн үйлчилгээ үзүүлэхэд шаардлагатай дэмжлэг туслалцаа үзүүлэх үүргийг хүлээлгэсэн.



6.5 Үнэлгээний байгууллагын танилцуулга, гэрээний тухай

Үнэлгээний байгууллагын тухай

Хүснэгт 55. Үнэлгээний байгууллагын товч мэдээлэл

Компанийн нэр	"Кэй Пи Эм Жи Аудит" ХХК
Регистрийн дугаар	5543495
Хаяг	Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Блю ская таур, 602 тоот
Утас	+976 – 7011 8101
И-Мейл	mn-fm-info@kpmg.com
Веб хуудас	https://www.kpmg.com/mn

Кэй Пи Эм Жи Аудит ХХК (цаашид "Үнэлгээний компани" гэх) нь аудит, нягтлах ажил, бусад баталгаажуулах ажил болон зөвлөх үйлчилгээ үзүүлэх тусгай зөвшөөрлийн хүрээнд 2012 оноос эхлэн үйл ажиллагаагаа явуулж байгаа бөгөөд гадаад дотоодын мэргэжилтнүүдээс бүрдсэн нийт 90 гаруй ажилтантай. Нийт ажилтнуудын 70 хувь нь аудитор болон аудиторын туслахаар ажиллаж байна. Аудитын ажлын хүрээнд Монголын томоохон төрийн болон хувийн өмчит байгууллагуудын санхүүгийн тайлангийн аудитын үйлчилгээг Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт (СТОУС)-ын дагуу болон Сангийн яамнаас баталсан заавар, журмын дагуу баталгаажуулж байгаа билээ. Кэй Пи Эм Жи Аудит ХХК нь Санхүүгийн зохицуулах хорооны (цаашид "СЗХ" гэх) 2013 оны 1-р сарын 23-ны өдрийн 31 тоот тогтоолоор Үнэт цаас гаргагчид үйлчилгээ үзүүлэх үнэлгээний компаниар анх бүртгэгдсэн.

Кэй Пи Эм Жи Аудит ХХК-ийн томоохон харилцагчдаас дурдвал: Оюу Толгой ХХК, Улаанбаатар Төмөр Зам ХНН, М-Си-Эс Групп, Шунхлай Групп, АПУ Групп, Капитал Групп, Монгол Улсын Хөгжлийн Банк, Худалдаа Хөгжлийн Банк, Ачит Ихт ХХК, Трансвест Монголиа ХХК, Энержи Ресурс ХХК зэрэг болно.

Монголбанк, Голомт Банк, Хаан Банк, Монголын ОУИТБС, Үндэсний аудитын газар, Азийн Хөгжлийн Банк зэрэг томоохон банк, санхүүгийн байгууллагуудад зөвлөх үйлчилгээ үзүүлж байсан.

Үнэлгээний үйлчилгээ үзүүлэх гэрээний тухай

Кэй Пи Эм Жи Аудит ХХК 2013 оны 1-р сарын 23-ны өдөр Санхүүгийн зохицуулах хорооны 31 тоот тогтоолоор авсан "Үнэт цаас зах зээлд оролцогчид хөрөнгийн үнэлгээний үйлчилгээ үзүүлэх" тусгай зөвшөөрлийн хүрээнд 2021 оны 7-р сарын 28-ны өдөр Үнэт цаас гаргагчтай байгуулсан "Хөрөнгийн болон бизнесийн үнэлгээ"



хийх гэрээ"-ний дагуу олон нийтэд нээлттэй хүрээнд энгийн хувьцаа санал болгох үйл ажиллагаанд үнэлгээний компаниар оролцож байна.

Тус гэрээний зорилго нь Үнэлгээний компани нь Монгол Улсын холбогдох хууль тогтоомж, стандарт болон дүрэм, журмын дагуу Үнэт цаас гаргагчийн бизнесийн болон хөрөнгийн үнэлгээг Санхүүгийн зохицуулах хороо болон Монголын хөрөнгийн биржээс баталсан дүрэм, журамд нийцүүлэн, тэдгээр байгууллагаас тавигдсан шаардлагын дагуу мэргэжлийн өндөр түвшинд гүйцэтгэхэд оршино.

Энэхүү гэрээний хүрээнд талууд дараах үүргийг хүлээнэ. Үүнд:

- Үнэлгээний компани нь Үнэт цаас гаргагчаас гаргаж өгсөн мэдээлэл, баримт материалд үндэслэн өөрийн сонгосон аргачлалын дагуу Монгол улсын үнэт цаасны зах зээлд шинээр хувьцаа гаргах албан хэрэгцээнд шийдвэр гаргах үйл ажиллагаанд холбогдох хууль тогтоомжийн дагуу мэргэжлийн үнэлгээчнээр оролцох, Олон улсын үнэлгээний стандарт, Хөрөнгийн үнэлгээний тухай хууль болон бусад холбогдох хууль, дүрэм, журмын дагуу Үнэт цаас гаргагчийн бизнесийн болон хөрөнгийн үнэлгээг хийх, тайлан гаргах үйлчилгээг гүйцэтгэх;
- Үнэт цаас гаргагч нь Үнэлгээний компанитай бүх талаар хамтран ажиллаж шаардлагатай бүхий л мэдээллийг гаргах үүргийг хүлээнэ.

Үнэт цаас гаргах ажиллагаанд оролцогч байгууллагууд нь холбогдох хууль тогтоомжид заасны дагуу Үнэт цаас гаргагчтай холбоотой үүсэж болзошгүй аливаа сонирхлын зөрчлөөс сэргийлэх тухай мэдэгдэл гаргаж, тус тусын тодорхойлох захидал, дүгнэлт тайлангуудад тусгасан болно.



ҮНЭТ ЦААС ГАРГАГЧ "ГОЛОМТ БАНК" ХХК

Улаанбаатар хот,
2021 оны 12 сарын 27

Улаанбаатар хот,
2021 оны 12 сарын 27

Улаанбаатар хот,
2021 оны 12 сарын 27

ТУЗ-ийн дарга

Ч.Мөнхцэцэг

Гүйцэтгэх захирал

Норихико Като

Санхүү удирдлагын
газрын захирал

С.Мөнхтуяа



ҮНДСЭН АНДЕРРАЙТЕР "ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК" ХХК

Улаанбаатар хот,
2021 оны 12 сарын 27

Гүйцэтгэх захирал

Г.Уянгахишиг



ТУСЛАХ АНДЕРРАЙТЕР "ГОЛОМТ КАПИТАЛ ҮЦК" ХХК

Улаанбаатар хот,
2021 оны 12 сарын 27

Гүйцэтгэх захирал

С.Ган-Эрдэнэ



ҮНЭТ ЦААС ГАРГАГЧ НЬ 2021 ОНЫ ХАГАС ЖИЛИЙН САНХҮҮГИЙН АУДИТЛАГДСАН ТАЙЛАНД СУУРИЛСАН ҮНЭТ ЦААСНЫ ТАНИЛЦУУЛГЫГ САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРОО БОЛОН МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖИД 2021 ОНЫ 12-Р САРЫН 28-НЫ ӨДӨР ХҮЛЭЭЛГЭН ӨГСӨН БА ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ӨӨРЧЛӨЛТ БУЮУ ТАЛУУДААС ҮЛ ХАМААРАХ БУСАД ШАЛТГААНААР ХУГАЦАА УДААШИРСАНТАЙ УЯЛДУУЛАН ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧ НАРТ ШИНЭЧЛЭГДСЭН МЭДЭЭЛЛИЙГ ӨГӨХ ҮҮДНЭЭС ҮНЭТ ЦААС ГАРГАГЧ БОЛОН АНДЕРРАЙТЕРУУД НЬ ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН 2021 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН АУДИТЛАГДСАН ТАЙЛАНД СУУРИЛАН ҮНЭТ ЦААСНЫ ТАНИЛЦУУЛГАД 2022 ОНЫ 06-Р САРЫН 30-НЫ ӨДРИЙН БАЙДЛААР ӨӨРЧЛӨЛТИЙГ ТУСГАН ШИНЭЧЛЭН ХҮРГҮҮЛСЭН.

ТУС ӨӨРЧЛӨЛТТЭЙ ХОЛБООТОЙГООР 2022 ОНЫ 08-Р САРЫН 12-НЫ ӨДӨР ШИНЭЧЛЭН ГАРГАСАН ХУУЛЬ ЗҮЙН ДҮГНЭЛТ БОЛОН ТҮҮНТЭЙ НИЙЦҮҮЛЭН ҮНЭТ ЦААСНЫ ТАНИЛЦУУЛГА БОЛОН ТҮҮНИЙ ХАВСРАЛТАД ОРСОН ӨӨРЧЛӨЛТИЙГ 2022 ОНЫ 08-Р САРЫН 28-НЫ ӨДӨР БАГЦЛАН ЭЦЭСЛЭВ.

ҮНЭТ ЦААС ГАРГАГЧ "ГОЛОМТ БАНК" ХХК

Улаанбаатар хот,
2022 оны 08 сарын ___

Гүйцэтгэх захирал

Норихико Като



ҮНДСЭН АНДЕРРАЙТЕР "ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК" ХХК

Улаанбаатар хот,
2022 оны 08 сарын ___

Гүйцэтгэх захирал

Г.Уянгахишиг



ТУСЛАХ АНДЕРРАЙТЕР "ГОЛОМТ КАПИТАЛ ҮЦК" ХХК

Улаанбаатар хот,
2022 оны 08 сарын ___

Гүйцэтгэх захирал

С.Ган-Эрдэнэ

